

МОНГОЛ УЛС  
АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ

# НИСЭХИЙН ИНЖЕНЕРИЙН АЛБАНЫ ДҮРЭМ

УЛААНБААТАР ХОТ  
2018 ОН



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ  
ЖАНЖИН ШТАБЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/93

Улаанбаатар хо

Дүрэм батлах тухай

"Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 01 дүгээр зарлигаар батлагдсан Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.1.2.6 дахь дэд заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын нисэхийн инженерийн албаны дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.
2. "Улсын нисэхийн инженерийн албаны дүрэм"-ийг 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА  
ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ



Д.ДАВАА

# УЛСЫН НИСЭХИЙН ИНЖЕНЕРИЙН АЛБАНЫ ДҮРЭМ УЛСЫН НИСЭХИЙН ИНЖЕНЕРИЙН АЛБАНЫ ДҮРМИЙН БҮТЭЦ

**Нэгдүгээр бүлэг.** Нийтлэг үндэслэл

**Хоёрдугаар бүлэг.** Нисэхийн техникийн ашиглалт

**Гуравдугаар бүлэг.** Нисэхийн инженерийн албанд тавигдах нэмэлт шаардлага

**Дөрөвдүгээр бүлэг.** Нисэхийн зэвсэглэл, цахилгаан, тусгай болон радиоэлектрон тоноглолын ашиглалтын онцлог

**Тавдугаар бүлэг.** Шилжин байрлах үеийн нисэхийн инженерийн албаны зохион байгуулалт

**Зургаадугаар бүлэг.** Нисэхийн техникийн засвар

**Долоодугаар бүлэг.** Аэродром дээрх нисэхийн техникийн байрлал, хамгаалалт, галын аюулгүйн арга хэмжээ

**Наймдугаар бүлэг.** Нисэхийн техникийг хүлээн авах, хүлээлгэж өгөх

**Есдүгээр бүлэг.** Нисэхийн техникийн бүртгэл тооцоо, түүнийг данснаас хасах, задлах

**Аравдугаар бүлэг.** Бие бүрэлдэхүүний инженер техникийн бэлтгэл

**Арваннэгдүгээр бүлэг.** Нисэхийн инженерийн албаны албан тушаалтны эрх, үүрэг гэсэн нийт 11 бүлэгтэй.

## АГУУЛГА

### **Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Нисэхийн инженерийн албаны зорилго, үүрэг;
- 1.2. Нисэхийн техникийн эвдрэл гэмтэлгүй, байлдааны бэлэн байдал;
- 1.3. Нисэхийн инженерийн албыг удирдах;
- 1.4. Хээрийн сургалт, дадлагад бэлтгэх, явуулах үеийн НИА-ны бие бүрэлдэхүүний ажиллагаа.

### **Хоёрдугаар бүлэг. Нисэхийн техникийн ашиглалт**

- 2.1. Бие бүрэлдэхүүнд нисэхийн техник дээр ажиллах эрх олгох;
- 2.2. Нисэхийн техникийг хуваарилж, хариуцуулах ;
- 2.3. Нисэхийн техникийг нислэгт гаргах ;
- 2.4. Онгоц/нисдэг тэрэг/-ыг агаарт шалгах нислэг;
- 2.5. НИА-ны бие бүрэлдэхүүний нисэхийн техник дээр хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулах;
- 2.6. Нисэхийн техник дээр ажиллах ерөнхий журам;
- 2.7. Ашиглалтын хяналтын хэрэгслийг хэрэглэх, бэлэн байлгах;
- 2.8. Тусгай зориулалтын автомашиныг хэрэглэх, хадгалах;
- 2.9. Багаж, түлхүүрийг хэрэглэх, хадгалах;
- 2.10. Нисэхийн техник дээр ажиллах үеийн аюулгүйн арга хэмжээ
- 2.11. Нисэхийн техникийг нислэгт бэлтгэх;
- 2.12. Хэвшүүлэх ажлууд

### **Гуравдугаар бүлэг. Нисэхийн инженерийн албанд тавигдах нэмэлт шаардлага**

- 3.1. Цэргийн тээврийн нисэх;
- 3.2. Галын дэмжлэгийн нисэх.

### **Дөрөвдүгээр бүлэг. Нисэхийн зэвсэглэл, цахилгаан, тусгай болон радиоэлектрон тоноглолын ашиглалтын онцлог**

- 4.1. Ерөнхий шаардлага;
- 4.2. Нисэхийн зэвсэглэлийн ашиглалт;

- 4.3. Нисэхийн цахилгаан, тусгай тоноглолын ашиглалт;
- 4.4. Радиоэлектрон тоноглолын ашиглалт.

### **Тавдугаар бүлэг. Шилжин байрлах үеийн нисэхийн инженерийн албаны зохион байгуулалт**

- 5.1. НИА-ны хүч хэрэгслийг агаарын тээврээр шилжүүлэн байрлуулах;
- 5.2. НИА-ны хүч хэрэгслийг авто тээврээр шилжүүлэн байрлуулах;
- 5.3. НИА-ны хүч хэрэгслийг төмөр замын тээврээр шилжүүлэн байрлуулах;

### **Зургаадугаар бүлэг. Нисэхийн техникийн засвар**

- 6.1. Ерөнхий ойлголт;
- 6.2. Нисэхийн техникийн найдвартай ажиллагааг хангах;
- 6.3. Нисэхийн техникийн гүйцээж хийх ажил.

### **Долоодугаар бүлэг. Аэродром дээрх нисэхийн техникийн байрлал, хамгаалалт, галын аюулгүйн арга хэмжээ**

- 7.1. Аэродром дээрх нисэхийн техникийн байрлал;
- 7.2. Нисэхийн техникийг хамгаалах нуувч /ангар/-ийг ашиглах, бэлэн байлгах;
- 7.3. Онгоц /нисдэг тэрэг/-ны хамгаалалт;
- 7.4. Галын аюулаас хамгаалах.

### **Наймдугаар бүлэг. Нисэхийн техникийг хүлээн авах, хүлээлгэж өгөх**

- 8.1. Нисэхийн техникийг “үйлдвэрлэгч-нийлүүлэгч”/завод/ болон засварын газраас хүлээн авах, хүлээлгэн өгөх
- 8.2. Сэлбэг хэрэгсэл, зарцуулалтын материалыг авах, эргүүлж өгөх, зарлагадах.

### **Есдүгээр бүлэг. Нисэхийн техникийн бүртгэл тооцоо, түүнийг данснаас хасах, задлах**

- 9.1. Нисэхийн техникийн бүртгэл, тооцоо;
- 9.2. Нисэхийн техникийг данснаас хасах;
- 9.3. Данснаас хасагдсан нисэхийн техникийг задлах, ашиглах.

## **Аравдугаар бүлэг. Бие бүрэлдэхүүний инженер техникийн бэлтгэл**

10.1. Инженер, техникийн бэлтгэл.

## **Арваннэгдүгээр бүлэг. Нисэхийн инженерийн албаны албан тушаалтны эрх, үүрэг**

11.1. Анги /байгууллага/-ийн ерөнхий инженер /эскадрилийн инженер/;

11.2. Төрөл мэргэжлийн ахлах инженер /инженер/;

11.3. Техник ашиглалтын ангийн дарга /засварын газрын дарга/;

11.4. Техник ашиглалтын хэсгийн дарга буюу хэсгийн техникч;

11.5. Бүлгийн дарга;

11.6. Онгоц /нисдэг тэрэг/-ны ахлах техникч /техникч/;

11.7. Үйлчилгээний бүлгийн болон хэвшүүлэх ажлын бүлгийн ахлах техникч /техникч/;

11.8. Ахлах механикч /механикч/;

11.9. Жижүүрийн инженер;

11.10. Нислэгийн ахлах инженер.

## **Арванхоёрдугаар бүлэг Хавсралтууд**

1. Нисэхийн техникийн баримт бичгийг хөтлөх, хадгалах, сэргээх журам;

2. Нисэхийн техникийн нислэгийн бэлэн байдалд тавих хяналт, үзлэгийн хэм хэмжээ;

3. НИА-ны үйл ажиллагааг дүгнэх хэм хэмжээ;

4. Газрын үйлчилгээний хэрэгсэлд тавигдах шаардлага, тэдгээрийн аэродромын хяналтын багтаамж;

5. Хийгээр цэнэглэсэн баллоныг хэрэглэхэд анхаарах зүйл;

6. Онгоц/нисдэг тэрэг/-ны хөдөлгөөнийг газар дээр удирдах, хөдөлгүүр асаах болон ачаа ачих, буулгах үед өгөх дохио;

7. НИА-ны орон тооны тусгай зориулалтын автомашин, чиргүүлд хийх хяналтын үзлэгийн хэм хэмжээ;

8. Түлхүүр, багаж хэрэгслийг тэмдэглэх;

9. Цувааны бүрэлдэхүүн дэх автомашины хөдөлгөөний зохион байгуулалт;

10. Онгоцны зогсоол, далдлавч болон аэродромын техникийн барилга, байгууламжийн галын хэрэгслийн хэм хэмжээ.

## **УЛСЫН НИСЭХИЙН ИНЖЕНЕРИЙН АЛБАНЫ ДҮРЭМ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **Нийтлэг үндэслэл**

#### **1.1.Нисэхийн инженерийн албаны зорилго, үүрэг**

1. Нисэхийн инженерийн алба /НИА/ нь нисэхийн техникийн бэлэн байдал, сааталгүй ажиллагаа, нислэг, нислэгийн аюулгүй байдлыг хангах, нислэгт үйлчлэх бие бүрэлдэхүүний мэргэжлийн сургалт, дадлага, нисэхийн техник, хэрэгсэл дээр өдөр, шөнийн цагт, цаг агаарын ердийн болон хүндэрсэн нөхцөлд ажиллах ур чадварын түвшинг дээшлүүлэх, нислэг, техникийн бэлтгэлийн чанар байдлыг тодорхойлох, үр ашгийг дээшлүүлэх зорилготой.

2. Нисэхийн инженерийн алба нь нисэхийн техникийн ашиглалт, засвар, үйлчилгээг хариуцаж, бие бүрэлдэхүүний инженер, техникийн бэлтгэлийг хангана.

“Нисэхийн техник” гэдэг ойлголтод нисгэгчтэй /нисгэгчгүй/ нисэх хэрэгслүүд, тэдгээрийн хүчний төхөөрөмж, тоноглол, зэвсэглэл, нисэхийн хөнөөх хэрэгсэл, дадлага, сургалтын суурин төхөөрөмж, техникийн ашиглалтын болон засвар үйлчилгээ, навигацийн техник хэрэгсэл багтана.

3. Нисэхийн техникийн ашиглалт нь нислэгт бэлтгэх, нисэхийн техникийг чадамгай хэрэглэх, тэдгээрийн хэвшүүлэх ажлын гүйцэтгэл, засвар үйлчилгээ, хадгалалт зэргийг багтаана.

4. Нисэхийн техникийн ажиллах чадвар, техникийн нөөцийг сэргээх зорилгоор засвар, үйлчилгээг зохион байгуулж явуулна.

5. Инженер, техникийн бэлтгэлийг бие бүрэлдэхүүний нисэхийн техникийг ашиглах, засварлах талаарх мэдлэг, дадлага, ур чадварыг дээшлүүлэх, нисэх бүрэлдэхүүнийг нисэхийн техникийг агаарт болон газарт ашиглахад сургах зорилгоор явуулна.

6. НИА нь нисэхийн техникийн найдвартай ажиллагааг өндөр түвшинд байлгах ажлыг тогтмол зохион байгуулж, байлдааны боломжийг өргөжүүлж, ашиглалтын хүчин чадлыг сайжруулах зорилгоор нисэхийн техникийн шинэчлэлт явуулахад оролцоно.

7. Нисэхийн инженерийн алба нь:

- бие бүрэлдэхүүний ёс суртахуун, сэтгэл зүйн бэлтгэл өндөр байж, сахилга батыг чанд сахиснаар;
- нисэх баг болон инженер техникийн бүрэлдэхүүн нь нисэхийн техникийн ашиглалт, засвар, үйлчилгээг гүйцэтгэх талаарх мэдлэгээ байнга дээшлүүлж, дадлага эзэмшсэнээр;
- нисэхийн техникийн ашиглалт, засвар үйлчилгээний тогтоогдсон заавар, дүрмийн заалтыг нарийвчлан хэрэгжүүлсэнээр;
- нислэг, нислэгийн аюулгүй байдлыг хангаж, нисэхийн техникийн үр ашигтай ашиглалт, найдвартай ажиллагааг өндөр түвшинд хүргэх талаар тогтмол ажил зохиосноор;
- ажлын туршлагыг байнга судлан нэвтрүүлж, бие бүрэлдэхүүний бүтээлч идэвх санаачлагыг өрнүүлсэнээр;
- нисэхийн техникийн засвар, үйлчилгээний болон техникийн ашиглалтын түвшинг байнга дээшлүүлж, хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулснаар;
- нисэхийн инженерийн албаны бие бүрэлдэхүүний үйл ажиллагааг тасралтгүй удирдлагаар хангаж, ажлыг оновчтой төлөвлөснөөр;
- ар талын хангалтыг тасралтгүй зохион байгуулснаар өмнөө тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлнэ.

8. Байгууллагын дарга /захирагч/ ерөнхий инженерээр дамжуулан НИА-ны удирдлагыг хэрэгжүүлнэ.

9. Ерөнхий инженер нисэхийн инженерийн албаны хариуцлагыг хүлээнэ.

10. Нисэхийн анги, байгууллагын материал, хэрэгсэл, аэродром-техникийн хангалтыг аэродром-техникийн хангалтын салбар (нисэхийн хангалт үйлчилгээний анги, байгууллага) хариуцна.

11. Аэродром-техникийн хангалтын салбарын (нисэхийн хангалт үйлчилгээний анги, байгууллагын) дарга нь нисэхийн анги, байгууллагын нисэхийн зэвсэглэл, аэродром-техник, материал хэрэгслийн хангалтыг цаг тухайд нь хийх, тэдгээрийг стандартад

тохирч буй эсэх болон газрын үйлчилгээний хэрэгслийн техникийн байдал, харьяа аэродромууд, барилга байгууламж, хамгаалах далдлавч, тусгай тоног төхөөрөмж, түүний ашиглалтын бэлэн байдлыг хариуцна.

12. НИА нь нисэхийн техникийн ашиглалт, засвар, үйлчилгээнд мөрдөгдөж байгаа заавар, албаны бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх шаардлагатай бол Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалд санал тавьж шийдвэрлүүлнэ.

## **1.2. Нисэхийн техникийн эвдрэл гэмтэлгүй, байлдааны бэлэн байдал**

13. Нисэхийн техникийн байлдааны бэлэн байдал нь техникийг байлдааны үүрэг биелүүлэхэд бэлтгэх шаардлагатай хугацаа, техникийн нөөц, эвдрэл гэмтэлгүй байдлаар тодорхойлогдоно.

14. Техникийн ашиглалтын зааварт урьдчилан заагдсан ажлууд хийгдэж, нислэгийн болон үзлэгийн үед илэрсэн гэмтлүүд засагдсан, техникийг ашиглах цагийн нөөцтэй онгоц /нисдэг тэрэг, нисэх хэрэгсэл/-ыг гэмтэлгүйд тооцно.

Тавигдсан үүргийн дагуу нисэхийн зэвсэглэл, хөнөөх хэрэгслээр цэнэглэгдэж, бэлтгэгдсэн, гэмтэлгүй онгоц /нисдэг тэрэг/-ыг байлдааны үүрэг гүйцэтгэхэд бэлэн гэж тооцно.

15. Тухайн байгууллагын харьяа, дугаарласан улсын бүртгэлтэй бүх онгоц /нисдэг тэрэг/-ыг дансалсан тоонд оруулна.

16. Байлдааны жижүүрлэлтэд зөвхөн байлдааны бэлэн байдал хангасан онгоц /нисдэг тэрэг/-ыг томилно.

17. Жижүүрийн онгоц /нисдэг тэрэг/-ны нисэхийн зэвсэглэл, хөнөөх хэрэгслийг зүүн, тэсрүүлэгчийг нь угсарч, хэрэглэхэд бэлэн болгосон, артиллерийн зэвсгийг сумласан байна.

Жижүүрлэлтийн явцад гэмтэл гарвал тухайн онгоц (нисдэг тэрэг)-ыг жижүүрлэлтээс хасч, гэмтэлгүй онгоц /нисдэг тэрэг/-оор солино.

18. Нисэхийн техникийн нөөцийн төрлийг үйлдвэрээс тогтоосон /техник/, засвар хоорондын, хэвшүүлэх ажлын хоорондох, баталгаат нөөц зэргээр тогтооно.

Үйлдвэрээс тогтоосон нөөц нь техникийн байдлаас хамаарахгүйгээр ашиглалтыг зогсоох ёстой нисэхийн техникийн ажиллах цаг /ашиглалтын хуанлийн хугацаа/-ийг хэлнэ.

Засвар хоорондын техникийн нөөц гэдэг нь дараалсан хоёр засварын хоорондох нисэхийн техникийн ажиллах цаг /ашиглалтын хуанлийн хугацаа/-ийг хэлнэ.

Хэвшүүлэх ажлын хоорондох нөөц гэдэг нь хэвшүүлэх ажлын хоорондох нисэхийн техникийн ажиллах цаг /ашиглалтын хуанлийн хугацаа/-ийг хэлнэ.

Баталгаат нөөц нь нисэхийн техникийн тогтоогдсон шаардлагыг хангаж, ашиглалт, хадгалалт болон тээвэрлэлтийн заавар, дүрмийг мөрдсөн нөхцөлд хүчин төгөлдөр байхаар “Нийлүүлэгч” буюу нисэхийн үйлдвэр, эсвэл нисэхийн засварын газраас тогтоосон нисэхийн техникийн ажиллах цаг /ашиглалтын хуанлийн хугацаа/-ийг хэлнэ.

19. “Нийлүүлэгч” буюу нисэхийн үйлдвэрээс нэмэлт мэдээллийн хуудас /бюллетень/-аар зөвшөөрсөн техникийн нөөц болон ажиллах хугацааг Улсын нисэхийн хэлтсийн нисэхийн ерөнхий инженерийн заавраар тогтооно.

20. Онгоц /нисдэг тэрэг/-н дээр суурилагдсан тоноглол, агрегат болон механизмын нөөц нь тогтоогдоогүй бол тэдгээрийг тухайн загварын онгоц /нисдэг тэрэг/-ны нөөцийн хэмжээгээр ашиглана.

21. Онгоц, нисгэгчгүй нисэх хэрэгсэл /ННХ/-ийн нөөцийн зарцуулалтыг тооцохдоо агаарт болон газарт ажилласан цагийг 100 хувь, харин нисдэг тэрэгний агаарт ажилласан цагийг 100, хөдөлгүүр, даах сэнсний газарт ажилласан цагийг 20 хувиар тооцно. Нөөц нь цагаар тогтоогдсон тоноглол, агрегатуудын ажилласан цагийг онгоц /нисдэг тэрэг/-ны ниссэн цагаар, эсхүл агаар болон газарт ажилласан бодит байдлаар /цагаар/ нь тооцно.

22. “Нийлүүлэгч” эсвэл засварын газраас бүтээгдэхүүнийхээ чанар, гэмтэлгүй ажиллагааг баталгаажуулж байгаа баталгаат хугацаа, түүнчлэн захиалагчаас гомдол саналаа тавих журам, тэдгээрийг авч үзэх тухай Нийлүүлэгч, захиалагч хоёрын хоорондын гэрээнд заана.

Баталгаат хугацаа нь “Нийлүүлэгч” эсвэл засварын газартай хийсэн гэрээнд заагдсан техникийн нөхцлөөр тодорхойлогдож, формуляр /паспорт/-т бичигдсэн байна.

### **1.3. Нисэхийн инженерийн албыг удирдах**

23. НИА-ны удирдлага нь:

1. Инженер, техникийн удирдах бүрэлдэхүүн үүрэг авч судлах;
2. НИА-ны талаар мэдээлэл авах, боловсруулах;
3. Шийдвэрийг цаг тухайд нь гаргах;
4. НИА-ны бие бүрэлдэхүүнд үүрэг тавих, үүргийн биелэлтэд хяналт тавих;
5. Нисэхийн анги, байгууллагын инженерийн алба, техник ашиглалтын анги /ТАА/, онгоц /нисдэг тэрэг/-ны засварын газар, пуужин урьдчилан бэлтгэх байр /ПУББ/, бусад хангалтын салбарын харилцан ажиллагааг зөв зохион байгуулах шаардлагатай.

НИА-ны удирдлага нь анги, байгууллагын удирдлагын ерөнхий системд багтаж, байнгын /суурин/ болон хөдөлгөөнт удирдлагын байр, диспетчерийн байрнаас үүргээ гүйцэтгэнэ.

Нисэхийн анги, байгууллагын штаб нь НИА-ны удирдлагын байрыг бусад удирдах байр, ПУББ, инженерийн албаны болон хангалтын бусад салбаруудтай холбоогоор хангах ажлыг зохион байгуулна

23. НИА-ны удирдлагын байр нь НИА-ны бие бүрэлдэхүүнийг удирдах, нисэхийн техникийн бүх төрлийн бэлтгэлийг хянах, техникийн бэлтгэлийн явц, байдлын талаар захирагч /штаб/-д цаг тухайд нь мэдээлэх, нислэгийн онцгой тохиолдлын үед нисэх бүрэлдэхүүний ажиллагааг удирдахад нь нислэгийн удирдагчид туслалцаа үзүүлэх, түүнчлэн хангалт үйлчилгээний салбартай нягт харилцан ажиллахад зориулагдсан анги, байгууллагын удирдах байрын бүрэлдэхүүн хэсэг мөн.

24. НИА-ны удирдлагын байранд нислэгтэй үед нислэгийн ахлах инженер, диспетчер, харин нисэхийн техник дээр ажиллаж байгаа үед жижүүрийн инженер, диспетчер байна.

25. НИА-ны удирдлагын байрыг:

- агаар дахь цагийн байдлыг сонсох радио холбооны хэрэгслээр;
- нислэгийн удирдагч, эскадрилийн НИА-ны удирдлагын байр, техникийн байрлалууд, ТАА, аэродром, техникийн хангалтын салбарын жижүүртэй шууд харилцах радио болон утсан холбоо /харилцах утас, хоёр талын чанга яригч/-ны хэрэгслээр;
- онгоцны зогсоол, техникийн байрлалуудад команд дамжуулах зориулалттай дохиоллын хэрэгслээр;
- мэдээллийн дүрслэн үзүүлэх хэрэгслээр тус тус тоноглоно.

НИА-ны удирдлагын байрын радио холбооны хэрэгслүүд нь анги, байгууллагын холбооны ерөнхий бүдүүвчид тусгагдсан үелзэл дээр ажиллана.

28. НИА-ны удирдах байранд дараах баримт бичгүүд байна.

Үүнд:

- улсын нисэхийн инженерийн албаны дүрэм, нислэг үйлдэх дүрэм, техникийн ашиглалтын заавар;
- нислэгийн төлөвлөлтийн хүснэгтийн хуулбар, нисэхийн техникийг нислэгт бэлтгэх технологийн хуваарь;
- холбооны хэлхээний бүдүүвч, ажиллах заавар;
- нислэгийн ахлах инженерийн бүртгэлийн дэвтэр;
- нислэгийн ахлах инженер, жижүүрийн инженер, аэродром-техник хангалтын салбарын жижүүр, онгоцны зогсоолын жижүүр, техникийн цэг болон техникийн тусламжийн багийн ажиллах заавар.

29. ТАА-ийн диспетчерийн байр нь техникийн үйлчилгээ, хэвшүүлэх ажил /засвар/-ын технологийн үйл явцыг тасралтгүй удирдлагаар хангах зориулалттай.

30. Диспетчерийн байр нь НИА-ны удирдлагын байртай телефон утсаар, хэвшүүлэх ажлын бүлгүүдтэй хоёр талын чанга яригчийн холбоогоор харилцахаар тоноглогдсон байна.

31. Нисэхийн анги, байгууллагын дарга /захирагч/-ын тушаалыг үндэслэн ерөнхий инженер нь байлдааны ажиллагааг гүйцэтгэх чиглэлээр НИА-ны бие бүрэлдэхүүний ажлыг төлөвлөж зохион байгуулна.

32. Тавигдсан үүргийн дагуу ерөнхий инженер нь нисэхийн техник, хүч хэрэгслийн байдалд дүгнэлт гарган, тэдгээрийн ашиглалт, засвар үйлчилгээний тооцоог хийж, НИА-ны ажлын жилийн төлөвлөгөө болон нисэхийн дадлага, сургууль, байлдааны ажиллагааны үеийн НИА-ны бие бүрэлдэхүүний ажлын төлөвлөгөөг боловсруулна.

33. НИА-ны ажлын жилийн төлөвлөгөө, түүнд хийсэн дүн шинжилгээг үндэслэн ангийн НИА, ТАА-ийн ажлын сарын төлөвлөгөөг зохионо.

34. НИА-ны ажлын жилийн төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- нисэхийн техникийг тогтоогдсон хэм хэмжээний дагуу байлдааны бэлэн байдалд байлгах;
- нисэхийн техникийн найдвартай ажиллагаа, нислэгийн аюулгүй байдлыг хангах;
- засвар, үйлчилгээг зохион байгуулж, техникийн нөөцийг сэргээх;
- ангийн шилжин байрлалтыг тооцоолох;
- өгөгдсөн үүргийг биелүүлэхэд хүч хэрэгслийг бэлтгэх;
- бие бүрэлдэхүүний инженер, техникийн бэлтгэлийг хангах;
- нисэхийн техникийн газрын үйлчилгээ, хяналт, засварын хэрэгслийг тогтоогдсон шаардлагын дагуу бэлэн байлгах.

35. НИА-ны ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа:

- дарга /захирагч/-ын өгсөн үүрэг;
- нисэхийн техникийн бэлэн байгаа тоо, ашиглалт, засвар, үйлчилгээний хэрэгслүүдийн байдал;
- шинээр авах нисэхийн техник, материал хэрэгслийн төлөвлөлт;
- инженер, техникийн бүрэлдэхүүн, тэдгээрийн бэлтгэлжилтийн түвшин, түүнчлэн нөхөн хангалтын журам, хугацаа;
- ажиллагааны үед өдөр бүр /сургалтын үед сар/-ийн онгоц-нислэгийн тоо, төлөвлөгөөт нислэг, онгоц /нисдэг тэрэг/-ны байлдааны хэрэгсэл;
- нисэхийн техникийн байрлал болон ашиглалтын нөхцөл;

- шилжин байрлахад зориулж гаргах тээврийн хэрэгслийн тоо, төрөл;
- засвар хийгдэх /хэвшүүлэх ажил, сайжруулалт, гүйцээж хийх ажил/ нисэхийн техникийн тооцоо, тэдгээрийг өөрийн хүч, хэрэгслээр сэргээн босгох боломж зэргийг анхны өгөгдөхүүн болгон ашиглана.

36. Нисэхийн техникийн ашиглалт, засвар үйлчилгээг явуулахад шаардлагатай хүч, хэрэгслийн үндэслэлийг гаргаж, тэдгээрийн бодит боломж, ашиглах оновчтой аргыг тодруулах зорилгоор НИА-ны инженер, техникийн удирдах бүрэлдэхүүн дараах тооцоог хийнэ.

Үүнд:

- НИА-ны шилжин байрлалтын;
- аэродром, техникийн хангалтын шаардагдах хэрэгслийн;
- нисэхийн зэвсэглэлийн хангалтын;
- байлдааны цэнэглэлтийн төрөл бүрийн хувилбараар онгоц
- /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэхэд шаардагдах хугацаа;
- нисэхийн техникт хийгдэх засвар, үйлчилгээ, хэвшүүлэх ажил.

37. НИА-ны удирдах бүрэлдэхүүн инженер-штурманы тооцоо хийхэд оролцоно.

38. НИА-ыг удирдах явцад төрөл мэргэжлийн инженерүүд дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах, хянах, техникийн мэдээллийн бичилтийг баримт бичгийн тогтоогдсон маягтын дагуу үйлдэх;

- хуримтлагдсан мэдээлэлд сард нэгээс доошгүй удаа дүн шинжилгээ хийж, техникийн өгөгдсөн найдвартай чанар, эвдрэл, гэмтэлгүй хэв хэмжээг барих, нисэхийн техникийг нислэгт бэлтгэх хугацааг богиносгох, ашиглалт, засвар, үйлчилгээний үед илэрсэн дутагдлыг арилгах талаар арга хэмжээг боловсруулах;

- өвөл, зуны ашиглалтын үед нэгээс доошгүй удаа нэгж онгоц /нисдэг тэрэг/-нд хийгдэх нислэгийн бэлтгэлийн аль нэг ажиллабарт цаг хэмжилтийн бичлэг хийж, бүлэг онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх хугацааг богиносгох талаар арга хэмжээ боловсруулах.

Мэдээлэлд хийсэн шинжилгээний үр дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар НИА-ны бие бүрэлдэхүүнд танилцуулж, НИА-ны удирдлагад мэдэгдэнэ.

39. НИА-нд хэрэглэгдэх баримт бичгийг ашиглалтын, засварын, тоо бүртгэлийн ба тайлангийн гэж ангилна.

40. Ашиглалтын баримт бичигт:

- техникийн ашиглалтын заавар;
- хүндийн төв болон ачаалалтын заавар;
- нислэгийн алслалт ба үргэлжлэлтийн тооцооны зааварчилгаа;
- формулярууд /бүдүүвчүүдийн хамт/;
- техникийн паспорт;
- цахилгааны бүдүүвчийн альбомууд;
- ЗИП-ийнцэс/сэлбэг түлхүүр, багаж хэрэгсэл, тоноглолуудын/;
- ашиглалтын баримт бичгийн бүртгэл хамаарна.

41. Формуляр, техникийн паспортыг дэс дугаарлагдсан баримт бичигт тооцох бөгөөд нисэхийн техникийн эд анги бүрт хавсрагдаж, тэдгээрийн заавал дагалдах баримт бичиг болно.

42. Нисэхийн формуляр /паспорт/-ыг хөтлөх, хадгалах, сэргээх журмыг 1 дүгээр хавсралтаар үзүүлэв.

43. Засварын баримт бичигт:

- их засвар хийх гарын авлага;
- байлдааны гэмтэлтэй нисэхийн техникт засвар хийх гарын авлага;
- засварлалтад олгогдох зөвшөөрлүүд, үндсэн хэрэглэлийн альбом;
- дунд /урьдчилан сэргийлэх/ засвар хийх гарын авлага;
- засварын шугам зургууд;
- ЗИП-ийн жагсаалт /засварын/;
- их, дунд засварын сэлбэг хэрэгсэл, материалын зарцуулалтын хэмжээ;
- стандартын бус тоног төхөөрөмж, хэрэгсэл, түлхүүр багажны баримт бичгүүд;
- засварын баримт бичгийн бүртгэл зэрэг хамаарна.

44. Ашиглалтын болон засварын баримт бичигт орсон өөрчлөлт, нэмэлтийг "Нийлүүлэгч"-ийн мэдээллийн хэлбэрээр, эсвэл Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн заалтаар хүргэнэ.

45. Анги, байгууллага бүрт дугаарласнаас гадна баримт бичгийн жишлүүр эх загварын хувийг хөтлөж, түүнд нисэхийн техникийн ашиглалт, засварын талаар гарсан бүх өөрчлөлт, нэмэлтийг оруулна.

46. Жишлүүр эх загварын хувийг бүрэн чанартай бүрдүүлэх, баримт бичигт орсон бүх өөрчлөлт, нэмэлтийг бие бүрэлдэхүүнээр цаг тухайд нь судлуулахыг ерөнхий инженер болон төрөл мэргэжлийн инженерүүд хариуцна. Дээрх албан тушаалтнууд нь улиралд нэгээс доошгүй удаа баримт бичгийн жишлүүр эх загварын хувийн тоо ширхэг, бүрэн бүтэн байдлыг шалгана.

47. Баримт бичгийн ажлын хувиудад хийх өөрчлөлт, нэмэлтийг жишлүүр эх загварын хувиас авч оруулна.

#### **1.4. Хээрийн сургалт, дадлагад бэлтгэх, явуулах үеийн НИА-ны бие бүрэлдэхүүний ажиллагаа**

48. Ерөнхий инженер нь тухайн сургалт, дадлагын явцад тавигдсан үүрэгтэй уялдуулан тодотгол хийж, үүрэг гүйцэтгэх боломжтой НИА-ыг хээрийн сургалт, дадлагад бэлтгэх үлгэрчилсэн төлөвлөгөө, шилжин байрлалт /штабтай хамтарсан/-ын тооцоотой байна.

49. Хээрийн сургалт, дадлага явуулах бэлтгэлийн үед:

- хээрийн сургалт, дадлагад бэлтгэх, явуулах, зохион байгуулалтын талаар удирдлагын баримт бичгийн болон тухайн дүрмийн шаардлагыг бие бүрэлдэхүүнээр нарийвчлан судлуулж, сургалт, дадлагын явцад НИА-ны шийдвэрлэх үүргийг танилцуулна;

- тухайн хээрийн сургалт, дадлагын онцлогтой уялдуулан, бие бүрэлдэхүүнтэй болон нисэхийн техник дээр явуулвал зохих ажиллагаа, арга хэмжээний жагсаалт боловсруулна;

- сургалт, дадлагын явцад эвдрэл, гэмтэлгүй онгоц /нисдэг тэрэг/-оор хангах арга хэмжээг төлөвлөж явуулна.

50. Төлөвлөлтөд дараах арга хэмжээнүүд урьдчилан тусгагдана. Үүнд:

- тараан байрлуулсан, өнгөлөн далдалсан болон дайсан үй олноор хөнөөх зэвсэг хэрэглэсэн нөхцөлд нисэхийн техникт хийгдэх ажлын зохион байгуулалтын арга хэмжээнүүд;

- хээрийн сургалт, дадлагад оролцох онгоц /нисдэг тэрэг/-нд үзлэг хийх;

- техникийн нөөцийг нь сунгах боломжгүй агрегатуудыг хээрийн сургалт, дадлагын явцад солих нөөцтэй болох;

- тухайн хээрийн сургалт, дадлагад зохицуулж хэрэглэх үлгэрчилсэн тооцоонд тодотгол хийх;

- НИА-ны бие бүрэлдэхүүн, техникийн материал хэрэгсэл шилжүүлэн байрлуулах бэлтгэлийг шалгах;

- төлөвлөсөн хээрийн сургууль, дадлагын нөхцөлд тохируулан нисэхийн техникийг бэлтгэх, ашиглах онцлогоор нисэх ба инженер техникийн бүрэлдэхүүнд хичээл зааж, дадлага явуулах;

- шилжин байрлах аэродромуудыг урьдчилан судлах;

- хээрийн сургууль, дадлагын дараа онгоц /нисдэг тэрэг/-ны техникийн нөөцийг сэргээх арга хэмжээг зохион байгуулна.

51. Онгоц /нисдэг тэрэг/-ыг хээрийн сургалт, дадлагад бэлтгэсэн, түүнд хийгдсэн ажлын тухай онгоц /нисдэг тэрэг/-ны нислэгийн бэлтгэлийн дэвтэр /эвдрэл, гэмтлийг бүртгэх дэвтэр/-т бичилт хийнэ.

52. Хээрийн сургалт, дадлагын явцад:

- НИА-ны ажлын үр дүнгийн тухай мэдээлэл болон дарга /захирагч/-д илтгэл бэлтгэх;

- цэргийг нууцаар удирдах нөхцөлд НИА-ны удирдлагын арга хэлбэрийг эзэмшиж, боловсронгуй болгох;

- шилжилт хөдөлгөөн /маневр/ хийх үед нисэхийн техникийг сэргээн босгох, өгөгдсөн нислэгийн үүргийн дагуу онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэхэд шаардлагатай НИА-ын болон ТАА-ийн хүч хэрэгслийг тодотгох;

- төлөвлөгөө, мэдээлэл, үүрэг, заалт боловсруулж бичих дадлагатай болох;

- ар тал, бусад албатай харилцан ажиллах асуудлыг боловсронгуй болох;

- дээд зэргээр байлдаанд ойртуулсан нөхцөлд нисэхийн техникийг нислэгт бэлтгэх асуудлыг боловсруулах /онгоцыг тараан байрлуулж, нислэгийн бэлтгэлийг онгоцны нуувчинд гүйцэтгэх, түүнчлэн үй олноор хөнөөх хэрэгсэл хэрэглэсэн нөхцөлд онгоц /нисдэг тэрэг/-ыг бэлтгэх, нисэхийн техникийг хээрийн нөхцөлд засварлах дадлага явуулах.

53. Хээрийн сургалт, дадлагын явцад нисэхийн техник дээрх ажиллагаа, бие бүрэлдэхүүний ажлын туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор мэдээлэл цуглуулж, ангилан журамлана. Үүнд:

- үндсэн болон шилжин байрлах аэродромд нисэхийн техникийн нислэгийн бэлтгэлийг зохион байгуулах;

- нисэхийн техникийн сэргээн босголтыг зохион байгуулах;

- зэвсэглэлийн төрөл бүрийн хувилбараар хийгдэх нисэхийн техникийн нислэгийн бэлтгэлийн үргэлжлэл, татан оролцуулж байгаа хүч, хэрэгслийн тоо, шилжин байрлалтын цуваанд гарах бие бүрэлдэхүүн, техникийн хэрэгсэл, зэвсэглэлийн авагддаг агрегатуудыг шилжүүлэн байрлуулах, галт хэрэглэлийн жин, эзлэхүүн, шаардлагатай тээврийн хэрэгслийн тоо хэмжээнд тааруулж бодит хуваарилалт хийх;

- шилжин байрлалтыг явуулах, зохион байгуулах, нисэхийн техникийг бэлтгэх, хянан шалгах хэрэгслүүд, НИА-ны техникийн иж бүрдлийг бүрдүүлэх, аэродром, техник, материалын хангалтанд гарсан дутагдлуудад дүгнэлт хийх.

54. Хээрийн сургалт, дадлагыг явуулсан тайланд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- хээрийн сургалт, дадлагад НИА-ны хийж гүйцэтгэсэн үүрэг;

- бие бүрэлдэхүүн, нисэхийн техник, техникийн хэрэгсэл, хээрийн сургалт, дадлагад бэлтгэхэд НИА-аас авсан арга хэмжээ;

- хээрийн сургалт, дадлагын явц дахь нисэхийн техникийг эвдрэл, гэмтэлгүй, бэлэн байдлын өндөр түвшинд байлгах талаар авсан арга хэмжээ;

- хээрийн сургалт, дадлагын үед гарсан шинэлэг зүйлс;

- нисэхийн техникийн бэлтгэлийн үргэлжлэл, зэвсэглэлийн хувилбарууд, татан оролцуулсан хүч хэрэгслийн тоо, нисэхийн техникийн нислэгийн бэлтгэл, хэвшүүлэх ажил, засвар үйлчилгээний хөдөлмөр зарцуулалт;

- шилжин байрлалт;

- нисэхийн техникийг сэргээн босгох үеийн зохион байгуулалтын ажил;

- үндсэн, шилжин байрлах аэродром дээрх нисэхийн техникийн бэлтгэлийн зохион байгуулалт.

55. Гүйцэтгэсэн ажлын талаарх дүгнэлтийг тайланд тусгах ба гарсан алдаа, дутагдлыг арилгах талаар саналаа боловсруулна.

56. Хээрийн сургалт, дадлагын явцад НИА-ны бие бүрэлдэхүүний ажиллагааны талаар сургалт, дадлага дууссанаас хойш 5 хоногийн дотор Агаарын цэргийн командлалд илтгэнэ.

57. Байлдааны цагийн нөхцөлд ажиллах НИА-ны бэлэн байдлыг хангуулах зорилгоор НИА-ны бие бүрэлдэхүүнтэй дадлага явуулж, дараах зүйлсийг боловсруулна. Үүнд:

- зэвсэглэлийн олон хувилбартайгаар онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх;

- үй олноор хөнөөх зэвсэг хэрэглэсэн нөхцөлд онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх;

- шөнө гэрлийн өнгөлөн далдлалтыг ашиглан онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх;

- өдөр, шөнийн цагт ажиллах үед хэвшүүлэх, засварын ажлыг зохион байгуулж явуулах;

- НИА-ны бүлгийг хээрийн нөхцөлд үүрэг гүйцэтгүүлэхээр шилжүүлэн байрлуулах;

- өөр загварын онгоц /нисдэг тэрэг/-ыг давтан нислэгт бэлтгэх;

- НИА-ны бүлгийг маршийн үед удирдах;

- цугларах дохиогоор нисэхийн техникийг нислэгт бэлтгэх.

58. Онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх хугацааг богиносгож, бэлэн байдлыг өндөржүүлэхэд чиглэгдсэн нөөц бололцоог илрүүлэх зорилгоор штабаас шалгалт, дадлагыг байлдааны бэлтгэлийн нэг хэлбэр болгон төлөвлөж явуулна.

Шалгалт, дадлагын төлөвлөгөө, сэдвийг ерөнхий инженер штабтай хамтран боловсруулж дарга /захирагч/ батална.

Шалгалт, дадлагын дүнг нислэг-техникийн хээрийн сургалт, дадлага дээр ашиглаж шалгана.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ.

### Нисэхийн техникийн ашиглалт

#### 2.1. Бие бүрэлдэхүүнд нисэхийн техник дээр ажиллах эрх олгох

59. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс болон анги байгууллагаас томилогдсон комисс онолын мэдлэг эзэмшиж, дадлага хийсэн, нисэхийн техникийн бүтэц, зохион байгуулалт, түүнийг ашиглах заавар, аюулгүйн арга хэмжээг өөрсдийн гүйцэтгэх албан үүргийн хэмжээнд судлаж, шалгалт өгсөн нисэх баг, инженер техникийн бүрэлдэхүүнд нисэхийн техник дээр ажиллах эрх олгоно.

60. Нисэхийн техникийн бүтэц, түүний эд анги, төхөөрөмжүүдийн ажиллагааны зарчим, нисэхийн тактик, нисэхийн инженерийн албаны болон техникийн ашиглалтын заавраар инженер техникийн бүрэлдэхүүнээс дараах тохиолдолд шалгалт авна. Үүнд:

- (а) нисэхийн мэргэжлийн үнэмлэх шинээр авах;
- (б) нисэхийн техник дээр бие даан ажиллах эрх олгох;
- (в) өөр байгууллагаас шилжин ирэх;
- (г) нисэхийн техник дээр ажиллахаар шинээр томилогдохын өмнө;
- (д) шинэ эд, анги дээр явагдсан шилжүүлэн сургалт, дадлага дууссаны дараа;
- (е) нисэхийн техник дээр гурван сараас илүү хугацаагаар ажиллаагүй завсардсан;
- (ж) нисэхийн техникийн ашиглалтын заавар, дүрмийг зөрчсөн;
- (з) нисэхийн мэргэжлийн зэрэг олгох, хамгаалуулах болон ахиулах үед.

Эдгээрээс өөр тохиолдолд нисэхийн техникийн талаарх мэдлэгийг тусгай заалт, удирдамж, зааврын дагуу шалгаж болно.

Нисэх бүрэлдэхүүний мэдлэгийг нислэг үйлдэх зааврын дагуу шалгана.

61. Нисэхийн анги, байгууллагын инженерийн алба нь нисгэгч, инженер техникийн бүрэлдэхүүнээс нисэхийн техникийн талаар мэргэжлийн шалгалтыг авч ангийн захирагчийн тушаалаар баталгаажуулж, нисэхийн техник дээр ажиллах эрх олгосон,

сунгасан болон эрх хассан тухай АЦК-ын Улсын нисэхийн хэлтэст албан бичгээр мэдэгдэнэ.

62. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч шалгалтын комиссын дүгнэлтийг үндэслэн нисэхийн техник дээр ажиллах үед ноцтой алдаа гарган техникийн бэлэн байдлыг алдагдуулж, эвдрэл гэмтэл учруулсан инженер, техникийн бүрэлдэхүүний ажиллах эрхийг 6 сар хүртэлх хугацаагаар хасна.

63. Онол, дадлагын шалгалтанд хангалтгүй үнэлэгдсэн инженер, техникийн ажилтан заагдсан хугацаанд зохих сургалтанд хамрагдсаны дараа дахин шалгалт өгөх өргөдлийг шалгалтын комисст гаргаж болно. Шалгалтын комисс өргөдлийг үндэслэн дахин шалгалт авах ба хангалттай үнэлэгдсэн тохиолдолд нисэх техник дээр ажиллах эрх олгоно.

## **2.2. Нисэхийн техникийг хуваарилж, хариуцуулах**

64. Нисэхийн техник, түүний ашиглалтын хэрэгсэл, тэдгээрийн хадгалалт, бүрэн бүтэн ажиллагаа, бэлэн байдлыг нисэх баг болон инженер техникийн бүрэлдэхүүнд хуваарилан хариуцуулна.

65. Онгоц/нисдэг тэрэг/нэг бүрийг агаарын хөлгийн эзэмшигч байгууллагын дарга /захирагч/-ын тушаалаар нисэх багийн дарга /нисгэгч/, техникийн /газрын/ багт хариуцуулна.

66. Нэг техникчид зөвхөн нэг онгоц /нисдэг тэрэг/ хариуцуулна.

67. Хариуцсан техникчийг эзгүйд /амралттай, чөлөөтэй, өвчтэй/ уг онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гаргахыг хориглоно. Энэ тохиолдолд онгоц /нисдэг тэрэг/-нд техникийн үйлчилгээ хийх, бүрэн бүтэн байлгахыг эрх бүхий техникчид дарга /захирагч/-ын тушаалаар хариуцуулна.

68. Түгшүүр, цугларах дохиогоор ажиллах үед техник ашиглалтын хэсгийн дарга буюу хэсгийн техникч уг онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гаргаж болно.

69. Шилжин байрлах үед тэргүүний бүлгийн ахлагч, эсвэл ерөнхий инженерийн заавраар бэлтгэл болон шилжин байрлах

аэродром дээр онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэж гаргахыг техникчид зөвшөөрнө.

70. Хоёр ээлжийн нислэгтэй үед нэг техникчид хоёр онгоц /нисдэг тэрэг/-н дээр нислэгийн бэлтгэл хийхийг зөвшөөрнө.

71. Хоёр онгоц /нисдэг тэрэг/-н дээр ажиллах техникчдийг дарга /захирагч/-ын тушаалаар томилно. Техникчдийг нислэгийн урьдчилсан бэлтгэл хийгдсэний дараа болон нислэгтэй өдөр солихыг хориглоно.

72. Нислэгийн хэт ачаалалтай үед нэг онгоц /нисдэг тэрэг/-нд хоёр техникч ажиллуулж болно.

73. Байгууллагын дарга /захирагч/-ын тушаалаар орон тооноос илүү буюу нөөцөнд байгаа онгоц /нисдэг тэрэг/-ыг хадгалах, хамгаалах зорилгоор тусгай багт, эсвэл бүлгүүдэд хариуцуулна.

### **2.3. Нисэхийн техникийг нислэгт гаргах**

74. Нислэгт эвдрэл, гэмтэлгүй өгөгдсөн үүргийн дагуу нислэгийн бэлтгэл хийгдсэн, баримт бичиг нь зааврын дагуу хөтлөгдсөн онгоц /нисдэг тэрэг/-ыг гаргана.

75. Ерөнхий инженер, эсвэл хэсгийн техникч нь онгоц /нисдэг тэрэг/-ны нислэгийн бэлтгэлийн дэвтэр болон хяналтын хуудсанд гарын үсэг зурж, онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гаргах зөвшөөрлийг олгоно.

76. Жижүүрлэлтийн үед тэргүүний бүлгийн ахлах албан тушаалтан, эсхүл байнгын аэродромоос өөр аэродром дээр бие дааж нислэг үйлдэж байгаа нисэх багийн дарга онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гаргах эрхийг эдэлнэ.

77. Онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх заавар зөрчигдсөн тохиолдолд ерөнхий инженер /нислэгийн ахлах инженер болон түүнээс дээш албан тушаалтан/ нислэгээс хасах эрхийг эдэлнэ. Дутагдлыг арилгасны дараа уг онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гаргах зөвшөөрлийг нислэгээс хассан албан тушаалтан олгоно.

## 2.4. Онгоц /нисдэг тэрэг/-ыг агаарт шалгах нислэг

78. Онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гаргахын өмнө дараах тохиолдлуудад агаарт шалгах нислэг үйлдэнэ. Үүнд:

- үйлдвэрлэгч, засварын газар, бусад байгууллагаас авсан;
- угсралт хийгдсэн;
- 100, 200 /300, 500/ цагийн, улирлын техник үйлчилгээний /хэвшүүлэх/ ажил хийгдсэн;
- шинээр хөдөлгүүр болон удирдлагын агрегатууд тавьсан;
- онгоц /нисдэг тэрэг/-нд гарсан ноцтой дутагдлыг арилгасан;
- онцгой үүргийн нислэгийн өмнө /тээврийн онгоц, нисдэг тэрэг/.

79. Үйлдвэрлэгч болон бусад байгууллагаас хүлээн авч байгаа онгоц /нисдэг тэрэг/-ыг агаарт нисгэж шалгах нислэгийг уг байгууллагын хөтөлбөрөөр тухайн газар дээр нь үйлдэнэ.

80. Жилд нэг удаа онгоц /нисдэг тэрэг/ бүрт удирдлага болон тогтворт /балансировка/ байдлыг шалгах нислэг хийгдсэн байна. Нисгэж шалгах нислэг үйлдэхийн өмнө НИА-ны удирдах бүрэлдэхүүн хяналтын үзлэгийн багтаамжаас багагүй хэмжээнд уг онгоц /нисдэг тэрэг/-ыг үзэж, шалгасан байна.

81. Анги, байгууллагын нөхцөлд хийгдсэн засвар буюу дутагдлыг арилгасны дараа онгоц /нисдэг тэрэг/-ыг нисгэж шалгах, нислэг үйлдүүлэх тухай шийдвэрийг байгууллагын ерөнхий инженер гаргана.

Шалгах нислэгийн хөтөлбөрийг ерөнхий инженер боловсруулж, анги, байгууллагын даргаар батлуулж нислэгийг үйлдэнэ.

Уг онгоц /нисдэг тэрэг/-ыг шалгах нислэгт гаргахаас өмнө төрөл мэргэжлийн инженерүүдийн үзлэг хийгдсэн байна.

82. Хадгалалтаас гаргаж байгаа онгоц /нисдэг тэрэг/-ыг агаарт нисгэж шалгах нислэгийг улсын нисэхийн инженерийн албаны дүрэм /УНИАД/ болон Улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх дүрэм /УАХНҮД/, нислэгийн болон техникийн ашиглалтын зааврын дагуу үйлдэнэ.

83. Агаарт шалгах нислэгийг “Улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх дүрэм”-ийн дагуу үйлдэх ба нислэгийн үр дүн, дүгнэлтийг онгоц /нисдэг тэрэг/-ыг агаарт шалгасан тухай хуудас, /онгоц, нисдэг тэрэг/-ны формулярт тус тус бичнэ. Онгоц /нисдэг тэрэг/-ыг агаарт шалгасан тухай материал /агаарт шалгасан тухай хуудас, бодит хяналтын хэрэгслийн бичлэгийг уншсан баримт/-уудыг дараагийн ижил төрлийн шалгах нислэг үйлдэх хүртэл хадгална.

Шалгах нислэгийг нислэгийн өөр үүрэгтэй хавсруулан гүйцэтгүүлэхийг хориглоно.

Агаарт шалгах нислэгийн инженер-штурманы бүх төрлийн тооцоог хийж, дарга /захирагч/-аар батлуулсан байна.

84. Төрөл мэргэжлийн инженерүүд нисгэгчийн илтгэл, бодит хяналтын хэрэгслийн бичлэгийг үндэслэн, онгоц /нисдэг тэрэг/-ыг агаарт шалгасан нислэгт дүн шинжилгээ хийнэ.

Ерөнхий инженер онгоц /нисдэг тэрэг/-ыг цаашид ашиглах зөвшөөрлийг өгнө.

## **2.5. НИА-ны бие бүрэлдэхүүний нисэхийн техник дээр хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулах**

85. НИА-ны бие бүрэлдэхүүний ажлын зохион байгуулалт, нисэхийн техник ашиглалт нь “Улсын нисэхийн инженерийн албаны дүрэм”, “Техникийн ашиглалтын заавар” /ТАЗ/, техникийн үйлчилгээний хэвшүүлэх ажлын заавраар тогтоогдоно.

86. Нисэхийн техникт дараах бэлтгэлийн төрөл, ажил, техникийн хяналт байна. Үүнд:

- үечилсэн үзлэг;
- хэвшүүлэх ажлууд;
- засвар үйлчилгээ;
- тусгай зорилтот үзлэг, шалгалт;
- зун /өвөл/-ын ашиглалтад шилжүүлэх бэлтгэл;
- хадгалалтын үед хийгдэх ажлууд.

87. Үечилсэн үзлэг нь онгоц /нисдэг тэрэг/-ны техникийн байдлыг тодорхойлох хяналтын гүнзгийрүүлсэн хэлбэр болно. Үзлэгийг техникийн ашиглалтын заавраар тогтоогдсон хугацаа, багтаамжийг

баримтлан инженер, техникийн албаны удирдах бүрэлдэхүүн явуулна.

88. Ерөнхий инженер нислэг, нислэгийн аюулгүй байдлыг хангахын тулд дараах бэлтгэлийг зохион байгуулна. Үүнд:

- нислэгийн урьдчилсан бэлтгэл;
- нислэгийн өмнөх бэлтгэл;
- давтан нислэгийн бэлтгэл;
- нислэгийн дараах бэлтгэл.

Бэлтгэл хийх төлөвлөгөөг байгууллагын дарга /захирагч/ батална. Нисэхийн техник дээр хийгдэх ажлыг НИА-ны бие бүрэлдэхүүн нислэг, урьдчилсан бэлтгэл, онгоц паркийн өдөрт гүйцэтгэнэ.

89. Инженерийн албаны бие бүрэлдэхүүнийг шуурхай удирдлагаар хангах, тэдгээрээс нисэхийн техник дээр хийж байгаа бэлтгэл, үйл ажиллагаанд хяналт тавих, харилцан ажиллагааг зохион байгуулах зорилгоор нисэхийн техник дээр ажиллах өдрүүдэд жижүүрийн инженерийг томилно.

90. Ерөнхий инженер ажил эхлэхээс өмнө нисэхийн техникийг бэлтгэх онцлог, газрын үйлчилгээний хэрэгслийг ашиглах дараалал, нисэхийн техник дээр ажиллах журмыг тодотгоно.

91. Анги, байгууллагын дарга /захирагч/-ын шийдвэрээр хоёр ээлжийн нислэгийн хангалтыг зохион байгуулж болно.

Нислэгийн урьдчилсан бэлтгэл эхлэхээс өмнө техникийн бүрэлдэхүүний ээлжүүдийг тушаалаар томилсон байна. Урьдчилсан бэлтгэлтэй өдөр хоёр ээлж өөр өөрсдийн онгоц /нисдэг тэрэг/-ыг бэлтгэж бэлтгэлийн чанарт харилцан хяналт тавьж, нисэхийн техникийн онцлогийг судалж мэдсэн байна.

Нислэгийн өмнөх бэлтгэлийг нэгдүгээр ээлжийн техникийн бүрэлдэхүүн хийнэ. Ээлж солигдох үед техникийн бүрэлдэхүүн онгоц /нисдэг тэрэг/-ыг хүлээлцэхдээ давтан нислэгийн бэлтгэлийн хэмжээнд хийж гүйцэтгэнэ. Онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэсэн тухай хяналтын хуудсыг хоёрдугаар ээлжийн бүрэлдэхүүн бүрдүүлнэ.

Нэгдүгээр ээлжийн бүрэлдэхүүний ажлаас буух зөвшөөрлийг хоёрдугаар ээлжийн ахлах инженер өгнө. Нислэгийн ахлах инженерийн бүртгэлийн дэвтэрт ээлж солилцсон тухай тэмдэглэл хөтөлнө. Нисэхийн техник дээр хийгдэх нислэгийн дараах бэлтгэлийг хоёрдугаар ээлжийн бүрэлдэхүүн гүйцэтгэнэ.

92. Нисэхийн техник дээр хийгдэх техник үйлчилгээний хэвшүүлэх ажлууд, үечилсэн үзлэг, бүх төрлийн бэлтгэлийн үечлэл, ажлын багтаамжийг техник үйлчилгээний хэвшүүлэх ажлын заавар, удирдамж, НИАД-ээр тодорхойлно.

Техникийн ашиглалтын зааварт зөвшөөрөгдсөн хязгаарлалтын дотор, тодорхой тохиолдол бүхэнд бие бүрэлдэхүүний нисэхийн техникийг эзэмшсэн, судалж мэдсэн байдлыг харгалзан, цаг уурын болон байгууллагын байрлаж буй орчны нөхцлөөс хамаарч, ээлжит урьдчилсан бэлтгэл хийхгүйгээр хэдэн ээлжээр нисэх тоог байгууллагын дарга /захирагч/, эсвэл ерөнхий инженер тогтооно.

93. “Улсын нисэхийн инженерийн албаны дүрэм”-д тусгайлан заагаагүй бол тогтоосон ажлын багтаамжийг багасгахыг хориглоно.

94. Бүх төрлийн бэлтгэл, хэвшүүлэх ажлын хийж гүйцэтгэх хугацааг материал хэрэгслийн хангалт, бие бүрэлдэхүүний мэргэжил, байрлаж буй нөхцөл зэргийг харгалзан, хугацааны үлгэрчилсэн хэв хэмжээ, эсвэл удирдамжийг үндэслэн жилийн эхэнд онгоцны төрөл бүр дээр тогтоож өгнө. Тогтоогдсон хугацаа нь мэргэжлийн бүрэлдэхүүний ажлын ачаалалаас хамааралгүйгээр техникийн ашиглалтын заавар, удирдамжид тусгагдсан шаардлагын дагуу ажлын чанарыг бүрэн хэмжээнд хангахуйц байна.

95. Бие бүрэлдэхүүнийг нисэхийн техник дээр ажиллахад шаардагдах хугацааг нислэг, урьдчилсан бэлтгэл, онгоц паркийн өдрийн төлөвлөгөөний дагуу тус тусад нь тодорхойлно.

Бусад тохиолдолд, зөвхөн байгууллагын дарга /захирагч/ болон ерөнхий инженерийн зөвшөөрлөөр техник ашиглалтын хэсгийн дарга, эсвэл бүлгийн даргын удирдлаган дор онгоц-техник /нисдэг тэрэг/ дээр ажиллана.

96. Нисэхийн техник дээр хийгдэх ажлын багтаамжийг мэргэжилтэн бүрийн ажлын өдөр /ээлж/-т тохирсон технологи ажилбартай, эхэлсэн ажлыг дуусгасан байхаар тодорхойлно.

97. Зөвхөн онцгой тохиолдолд л дуусгаагүй ажлыг гүйцэтгүүлэхээр бусдад шилжүүлэхийг техник ашиглалтын хэсгийн дарга, бүлгийн дарга нарт зөвшөөрөх ба урьдчилан ажлын байдлыг биечлэн шалгаж, хэрхэн дуусгах дэс дарааллын талаар шинэ гүйцэтгэгчид зааварчилгаа өгсөн байна. Онцгой тохиолдолд нислэгийн бэлтгэлийг өөр хүн гүйцэтгэх болвол уг ажлыг эхнээс нь давтан хийнэ.

Нислэгийн бүх төрлийн бэлтгэлийн үед тухайн хүний дуусгаагүй ажлыг өөр хүнээр гүйцэтгүүлэхийг хориглоно.

98. УНИАД-ээр тогтоосны дагуу НИА-ны албан тушаалтнуудаас нисэхийн техникийн байдалд тавих хяналтыг явуулна. Үзлэг хийсэн дүнг формуляр, онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх бүртгэлийн дэвтэрт бичнэ.

99. Ерөнхий инженер болон төрөл мэргэжлийн инженерүүд нь өөрийн ажил үүргийг хуваарийн дагуу техникийн бүрэлдэхүүний сургалт бэлтгэл, бэлэн байдал, онгоц /нисдэг тэрэг/-ны нислэгийн бэлтгэлийг хариуцна. Дараах зүйлсийг судалж, тодотгосон байна. Үүнд:

- техникийн байр, зогсоол дээр байгаа онгоц /нисдэг тэрэг/-ны бэлтгэлийн хуваарь;
- инженерийн албаны мэргэжилтнүүдэд шаардагдах онгоц нисдэг тэрэгний нарийн төвөгтэй бэлтгэлийн элементийг боловсруулах;
- онгоц /нисдэг тэрэг/-ны техникийн байдлыг хянах дэс дараалал;
- НИА-ны бие бүрэлдэхүүн, бусад бүлгийн харилцан ажиллагааны зохион байгуулалт;

- нисэхийн техник дээр ажиллах үеийн аюулгүйн арга хэмжээ, онцгой тохиолдлын үед бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үйл ажиллагаа.

100. Нисэхийн техник дээр хийгдэж байгаа ажлын чанар, цагийн биелэлтийг уг ажлыг гүйцэтгэсэн албан тушаалтнууд хариуцна. Хийгдсэн бүх ажлын талаар холбогдох баримт бичигт тэмдэглэн, гүйцэтгэгч болон ажлын чанарыг шалгасан албан тушаалтан гарын үсэг зурна.

Нисэхийн техник дээр хийгдэх ажлын чанарыг онгоц /нисдэг тэрэг/-ны техникч, бүлгийн техникч, ашиглалтын хэсгийн дарга, бүлгийн дарга нар байнга хянах бөгөөд ерөнхий инженер, ТАА-ийн дарга, төрөл мэргэжлийн инженерүүд хувийн төлөвлөгөөний дагуу шалгана /2 дугаар хавсралт/. Онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх үед заавал шалгах ажлуудыг технологийн хуудсанд заасан байна.

101. Нисэхийн техник дээр ажиллаж байх үедээ нисэхийн техникийн бүрэн бус байдлыг илрүүлэх, эсхүл түүнийг гэмтээвэл энэ тухайгаа онгоц /нисдэг тэрэг/-ны техникч болон шууд захирах даргад нэн даруй илтгэнэ. Нисэх бүрэлдэхүүн нь нислэгийн үед илэрсэн бүх дутагдлыг онгоц /нисдэг тэрэг/-ны техникчид мэдэгдэж, онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх бүртгэлийн дэвтрийн хяналтын хуудсанд уг дутагдлын онцлог шинжийг тэмдэглэнэ. Онгоц /нисдэг тэрэг/-ны болон бүлгийн техникчид нь нислэг, үзлэгийн үед илэрсэн бүх дутагдлыг шууд захирах дарга нарт илтгэнэ.

Бүлгийн дарга, техник ашиглалтын хэсгийн дарга нь дутагдал илэрсэн агрегатыг биечлэн үзэж шалгаад дутагдлыг арилгах дэс дараалал, аргыг зааж өгнө. Энэ тухай ерөнхий инженер болон төрөл мэргэжлийн инженерүүдэд илтгэж, шаардлагатай сэлбэг хэрэгсэл, онгоц /нисдэг тэрэг/-ыг бэлэн болгох хугацааны талаар тодорхой мэдэгдэнэ.

Төрөл мэргэжлийн инженерүүд илэрсэн дутагдалд дүн шинжилгээ хийх үүрэгтэй бөгөөд дутагдлыг бүрэн арилгуулж, бусад онгоц /нисдэг тэрэг/ дээр ижил төрлийн дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

102. Ерөнхий инженер нь аэродром, техникийн хангалтын дутагдалтай холбоотой нисэхийн техникийн эвдрэл гэмтэл, татгалзлын шалтгааныг аэродром, техникийн хангалтын захирагчтай хамтран тогтооно.

103. Нисэхийн техник дээр илэрсэн дутагдал, гэмтлийг дутагдал бүртгэх дэвтэрт бичих ба түүний хөтлөх дараалал, дүн шинжилгээг ерөнхий инженерийн зааврын дагуу гүйцэтгэнэ.

104. Нисэхийн техникт илэрсэн дутагдалд хийсэн дүн шинжилгээг бие бүрэлдэхүүнээр судлуулах, ашиглалтын явцад гаргасан алдаа, түүнийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар өгөх зааварчилгаа, ажлын үр дүнг техникийн яриан дээр танилцуулна.

105. Хэсгийн техникч, бүлгийн дарга нар өдөр бүр ажил дууссаны дараа, ТАА-ийн дарга долоо хоногт нэгээс доошгүй, төрөл мэргэжлийн инженерүүд өөрсдийн мэргэжлийн дагуу сард нэгээс доошгүй удаа техникийн яриа хийнэ. Ерөнхий инженер улиралд нэгээс доошгүй удаа нийт инженер, техникийн бүрэлдэхүүнтэй техникийн яриа хийнэ.

106. НИА-ны үйл ажиллагааг тогтоогдсон заавар, журмын дагуу шалгана. НИА-ны үйл ажиллагааг дүгнэх хэм хэмжээ, нисэхийн техникийн үзлэгийн багтаамж, тэдгээрийн байдалд өгөх үнэлгээг 3 дугаар хавсралтад үзүүлэв.

## **2.6. Нисэхийн техник дээр ажиллах ерөнхий журам**

107. Ажил эхлэхийн өмнө онгоц /нисдэг тэрэг/-ны техникч /механикч/ лацны бүрэн бүтэн байдлыг шалгаж, онгоц /нисдэг тэрэг/-ны гадна талд үзлэг хийгээд онгоц /нисдэг тэрэг/ хүлээлцэх дэвтэрт гарын үсэг зурна.

108. Онгоц /нисдэг тэрэг/-ны гадна талд гэмтэл учирсан, лац хөдөлсөн тохиолдолд техникч шууд захирах даргад яаралтай илтгэнэ. Зөвхөн ерөнхий инженерийн зөвшөөрлөөр онгоц /нисдэг тэрэг/-ыг онгойлгох, нислэгт бэлтгэх ажлыг гүйцэтгэнэ. Ерөнхий инженер нь болсон асуудлын тухай дарга /захирагч/-д илтгэнэ.

109. Онгоц /нисдэг тэрэг/-нд зүүлтэй байгаа түлшний сав, зэвсэглэлийн авагддаг агрегатууд болон нислэгийн үед онгоцны зогсоол дээр байрлуулсан агрегатуудын хадгалалт, хамгаалалтыг онгоц /нисдэг тэрэг/-ны техникч хариуцна.

110. Онгоц /нисдэг тэрэг/-н дээр хийгдэх бүх ажил зөвхөн техникчийн зөвшөөрлөөр, түүнийг байх үед хийгдэнэ. Онгоц /нисдэг тэрэг/-н дээр ажил эхэлсэн, дууссан болон илэрсэн дутагдлууд, тэдгээрийг арилгасан тухайгаа төрөл бүрийн мэргэжилтэнгүүд онгоц /нисдэг тэрэг/-ны техникчид мэдэгдэнэ.

Бүхээгийн дэвтэр болон хяналтын хуудсанд онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэсэн тухай тэмдэглэл хийж, гарын үсэг зурна.

111. Онгоц /нисдэг тэрэг/ дээр хийгдсэн нэмэгдэл ажил, үзлэгээр илэрсэн дутагдлуудыг онгоц /нисдэг тэрэг/-ны эвдрэл, гэмтлийг бүртгэх дэвтэрт бичнэ. Үзлэг хийж дууссаны дараа эвдрэл, гэмтлүүдийг арилгана.

Ажил хийж гүйцэтгэсэн, эвдрэл, гэмтлийг арилгасан мэргэжилтэн болон уг ажлыг шалгасан албан тушаалтан эвдрэл, гэмтлийг бүртгэх дэвтэрт гарын үсэг зурна.

112. Онгоц /нисдэг тэрэг/ цэнэглэхэд зориулагдсан түлш, тос, тусгай шингэн, хий нь улсын стандартад тохирсон чанарын үзүүлэлттэй байх ёстой. Газрын үйлчилгээний хэрэгслүүд болон түлш, тос, тусгай шингэн, хий, тэдгээрийн бэлтгэл, бэлэн байдлын тухай техник хангалтын албан тушаалтнууд замын хуудас, төхөөрөмжийн ажиллагааг тооцох хүснэгт, техникийн үнэмлэх, эсхүл хяналтын тасалбар дээр бичиж, гарын үсэг зурна.

Хяналтын тасалбар нь тусгай зориулалтын автомашины жолооч, мөн төвлөрсөн системээр тоноглогдсон шатахуун түгээх цэг тус бүрт байна. Хийн болон шингэн хүчилтөрөгчийн техникийн үнэмлэхний хэмжигдэхүүн, чанар, хэрэглэж болох эсэхийг мэргэжлийн албаны дарга нар шалгана.

Онгоц /нисдэг тэрэг/-ны хүчилтөрөгчийн системийг үүрэг зориулалтаас нь хамаарахгүйгээр зөвхөн эмнэлгийн хүчилтөрөгчөөр цэнэглэнэ.

113. Түлш, тос, тусгай шингэн, хийн болон газрын үйлчилгээний хэрэгслийн онгоц /нисдэг тэрэг/-нд үйлчлэх эрхийг ерөнхий инженер /нислэгийн ахлах инженер, жижүүрийн инженер, засварын газрын дарга, бүлгийн дарга нар/ 4 дүгээр хавсралтын дагуу аэродромын хяналт хийсний дараа олгоно. Газрын цахилгаан тэжээлийн эх үүсгүүр, онгоц /нисдэг тэрэг/-ыг хүчилтөрөгчөөр цэнэглэгчийн үйлчлэх эрхийг 4 дүгээр хавсралтын дагуу аэродромын хяналт хийсний дараа олгоно.

Аэродромын хяналтаар газрын үйлчилгээний хэрэгслүүд, түлш, тос, тусгай шингэн, хий нь сайн үр дүнтэй шалгагдвал ерөнхий инженер /нислэгийн ахлах инженер, жижүүрийн инженер, засварын газрын дарга, бүлгийн дарга нар/ нь төхөөрөмжийн ажиллагааг тооцох хүснэгт, формуляр, техникийн үнэмлэх, хяналтын хуудсанд “Цэнэглэхийг зөвшөөрөв” гэж бичээд, өдөр, цагийг тэмдэглэж, гарын үсэг зурна.

Газрын үйлчилгээний хэрэгслүүд бүрэн бус, гэмтэлтэй, техникийн баримт бичиг нь хөтлөгдөөгүй, түлш, тос, тусгай шингэн, хий зэрэг нь стандартын шаардлага /техникийн нөхцөл/ хангаагүй тохиолдолд тэдгээрийг үйлчилгээнээс хасна. Энэ тухай техникийн үнэмлэх, хяналтын тасалбар, төхөөрөмжийн ажиллагааг тооцох хүснэгтэд тэмдэглэл хийнэ.

114. Шаардлага хангаагүй газрын үйлчилгээний автотехник, газрын техник хэрэгсэл болон материал хэрэгслээр онгоц /нисдэг тэрэг/-ыг цэнэглэх, сумлах, шалгах, чирэхийг хатуу хориглоно.

115. Онгоц /нисдэг тэрэг/-ыг түлш, тос, тусгай шингэн, хийгээр цэнэглэж байгаа техникч /механикч/ нь уг түлш, тос, тусгай шингэн, хийн чанар байдал, тоо хэмжээ болон цэнэглэх төхөөрөмжийн битүүжлэл найдвартай эсэхийг шалгана.

Техникч /механикч/ нь онгоц /нисдэг тэрэг/ -ыг цэнэглэхээс өмнө түлш, тос, тусгай шингэн, хий нь стандартын шаардлага хангасан, техникийн үнэмлэх, хяналтын тасалбарт шалгасан НИА-ны албан тушаалтнууд баталгаажуулсан зэргийг магадлах үүрэгтэй. Тухайн онгоц /нисдэг тэрэг/-ны ашиглалтын зааврын дагуу онгоц /нисдэг тэрэг/-нд залгагддаг төхөөрөмж нь бүрэн бүтэн, газардуулгатай, шахсан хийн тэмдэглэгээ нь битүү саван дээрхтэйгээ тохирч буй / 5 дугаар хавсралт/ эсэхийг шалгах үүрэгтэй.

116. Хий, шингэнээр системүүдийг цэнэглэхдээ цэнэглэх төхөөрөмжийн битүүжлэл найдвартай эсэх, тоо хэмжээ зэрэгт хяналт тавихыг онгоц /нисдэг тэрэг/-ны техникч, техник ашиглалтын хэсгийн дарга нар хариуцна.

117. Онгоц/нисдэг тэрэг/-ны систем, агрегатуудын ажиллагааг газарт шалгахдаа зөвхөн тухайн маягийн нисэхийн техникийн зориулалтад тохирсон даралт, вакуум, цахилгаан тэжээлийн эх үүсгүүр, хэрэгсэл, төхөөрөмжийг ашиглана.

118. Зөвхөн онцгой тохиолдолд ерөнхий инженерийн зөвшөөрлөөр нэг онгоц /нисдэг тэрэг/-ноос нөгөө онгоц /нисдэг тэрэг/-нд агрегат, блокыг шилжүүлэх бөгөөд энэ тухай онгоцны формулярт бичнэ.

119. Агуулахаас авсан агрегат /блок, жижиг хэсэг/-уудыг онгоц /нисдэг тэрэг/-нд тавихын өмнө эвдрэл, гэмтэлгүйг нь тодорхойлох зорилгоор үзлэг хийх, эсхүл ТАА-д шалгана. Хэрэв шалгаснаас хойш нэг сарын хугацаа өнгөрсөн байвал агрегатуудыг онгоц/нисдэг тэрэг/-нд тавихын өмнө дахин шалгана. Тусгай агрегат, эсхүл иж бүрдэлтэй тоноглолыг сольсон бүхий л тохиолдолд уг агрегат, тоноглол оролцсон онгоц /нисдэг тэрэг/-ны бүх системийн ажиллах чадварыг бүхэлд нь шалгана.

120. Онгоц /нисдэг тэрэг/-ыг явгалж, жолоодохыг зөвхөн нисгэгчид зөвшөөрнө. Хөдөлгүүр асааж шалгахыг тухайн хийцийн онгоц /нисдэг тэрэг/-ны нисгэгч, техникч, эсвэл хөдөлгүүр асааж шалгах эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэнэ.

121. Онгоц /нисдэг тэрэг/-ны техникч хөдөлгүүр асааж шалгахдаа техник ашиглалтын хэсгийн даргын хяналтан дор гүйцэтгэнэ. Нисдэг тэрэгний хөдөлгүүр асаахыг зөвхөн нисгэгчид зөвшөөрнө. Хөдөлгүүр асааж шалгахыг онгоцны зогсоол дээр, эсвэл тусгай тоногдосон талбай дээр гүйцэтгэнэ.

122. Техникийн бүрэлдэхүүнд тухайн маягийн онгоцны техникийн ашиглалтын зааврын дагуу бэхэлгээгээр тоногдосон талбайд хөдөлгүүрийн ажиллагааг хамгийн дээд болон хурдатгах /форсаж/ горим дээр шалгахыг зөвшөөрнө.

123. Хөдөлгүүр асаахын өмнө гал унтраах багаж хэрэгсэл, ивүүргийн байдал, ивүүрэг дугуйн дор тавигдсан эсэх, тухайн онгоцны ашиглалтын зааварт тусгагдсан бусад шаардлагыг хангасан байдлыг шалгана.

Нисдэг тэрэгний хөдөлгүүрийг асаахын өмнө дугуйны ивүүргийг авсан байна.

Хөдөлгүүр асааж шалгах үед бие бүрэлдэхүүнийг бэртээх, нисэхийн техникийг эвдэлж гэмтээхээс урьдчилан сэргийлсэн арга хэмжээ авна.

124. Хөдөлгүүрийг асааж шалгах хугацаанд нисгэгч/техникч/, газрын техникч /механикч/ нарын хооронд найдвартай дохио эсхүл радио холбоотой байна.

125. Газрын техникч /механикч/ нь хөдөлгүүрийг асааж шалгаж буй нисгэгч /техникч/-д харагдахуйц аюулгүй зайд дохионы хэрэгсэл /улаан дарцаг, дохиур, гар чийдэн/-тэй байрлана.

Хөдөлгүүр ажиллаж байгаа үед онгоц /нисдэг тэрэгний/-ны бүхээг, хөдөлгүүрийн удирдлагыг эзэнгүй орхихыг хориглоно.

126. Онгоц /нисдэг тэрэг/-ноос агрегат, хэмжих хэрэгсэл, зангилааг салгаж авах, угсрах, тэдгээрт засварын болон хэвшүүлэх ажил хийхдээ тэдгээрийн доторх жижиг хэсгүүд /винты, болты, гайки/, цахилгааны залгууруудад шингэн, тоос, шороо, цас, борооны ус орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан нөхцөлд гүйцэтгэнэ. Үүний тулд тор, бүтээлэг, занга, таглаа зэрэг хамгаалах хэрэгслийг ашиглана.

Хамгаалах хэрэгслийг улаан өнгөөр будах бөгөөд хэрвээ нэг онгоц /нисдэг тэрэг/-н дээр хэд хэдэн хамгаалах хэрэгсэл байвал хооронд нь утсаар холбоно. Хамгаалах хэрэгслийг нарийн тооцож, багаж хэрэгслийн өрөөнд буюу тусгай чингэлэгт хадгална.

127. Онгоц /нисдэг тэрэг/-ноос салгаж авсан агрегатууд, хэрэглэлүүдийг өрөөнд тавиур дээр байрлуулж, аль онгоц, агрегат /блок/-аас салгаж авсан тухай хаяг зүүнэ. Техникийн баримт бичгийг онгоц /нисдэг тэрэг/ нэг бүрд зориулагдсан шүүгээнд хадгална.

Хэвийн /засварлагдсан/ ба хэвийн бус ажиллагаатай агрегатууд, хэрэглэлүүдийг нэг дор хадгалахыг хориглоно.

Нисэхийн техникээс салгаж авсан жижиг хэсгүүдийг тусгай зориулалтын саванд хийж, аль онгоц /нисдэг тэрэг/-ны, ямар агрегатаас салгаж авсан тухай хаяг зүүнэ.

128. Нисэхийн техникийн ажил гүйцэтгэхэд ашиглаж байгаа цахилгаан агрегат, цахилгаан станц, шингэний өргөгч, халаагчуудыг мэргэжилтнүүдийн байнгын хяналтан дор ажиллуулна. Эдгээр агрегатыг техникийн бүрэлдэхүүний механикч /техникч/-д хариуцуулан өгнө.

129. Онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүр дээр ажиллаж байх үед салгаж авсан агрегат, багаж хэрэгсэл болон гадны ямар нэг зүйлийг онгоц /нисдэг тэрэг/-ны гадаргуу дээр тавихыг хориглоно.

Ажил дууссаны дараа онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийн агрегатууд, зангилаанд гадны ямар нэг эд зүйл үлдсэн эсэхийг шалгаж, багажуудаа жагсаалтын дагуу бүртгэнэ.

130. Онгоц /нисдэг тэрэг/-ыг цаг тухайд нь нислэгт бэлэн байлгахыг онгоц /нисдэг тэрэг/-ны техникч хариуцна. Техникч онгоц /нисдэг тэрэг/-н дээр өөрийн үүрэгт заагдсан болон техник ашиглалтын зааврын дагуу бүх ажлыг хийхээс гадна нисэхийн техникчид, механикчдын ажлын чанар, хийгдэх ёстой ажлууд бүрэн хэмжээгээрээ хийгдсэн, онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх болон эвдрэл гэмтлийг бүртгэх дэвтэрт тэмдэглэл хийснийг шалгана.

131. Зогсоолд байрлаж байгаа нисэхийн техник, түүний ашиглалтын хэрэглэлүүдийг гамтай ашиглахын тулд:

- онгоц /нисдэг тэрэг/, агрегатууд, тоног төхөөрөмж ба зэвсэглэлийг бүрэн бүтэн бүтээлгээр бүтээсэн байх;

- онгоц /нисдэг тэрэг/-ны янз бүрийн орох, гарах төхөөрөмж болон ашиглалтын нүх, нисгэгчийн бүхээгийг битүүмжилж сайн хаах,

- онгоц /нисдэг тэрэг/-ыг тогтмол агааржуулах, хамгаалах хаалтуудыг агаараар үлээлгэх,

- онгоц /нисдэг тэрэг/ болон газрын тоног төхөөрөмжүүдээс цас, мөс ба бохирдлыг цаг тухайд нь цэвэрлэх;

- онгоц /нисдэг тэрэг/-н дээр ажиллахдаа будаг ба гадаргууг гэмтээхгүй байх.

132. Газар дээр онгоц /нисдэг тэрэг/, нисэх хэрэгслүүдэд мөсдөлт үүссэн тохиолдолд мөсийг бүрэн арилгахгүйгээр нислэгт гаргахыг хориглоно.

133. Нислэг дууссаны дараа чагт, таглаа, хамгаалах тор, бүтээлгийг онгоц /нисдэг тэрэг/-нд техник ашиглалтын зааврын дагуу тавина. Хөдөлгүүрийг асаах /зогсоол дээрээс явгалах/-д авч, унтраасан хойно тавих шаардлагатай дээрх хамгаалах хэрэгсэл нь улаан өнгөөр будагдсан, эсхүл жижигхэн улаан дарцгаар тоноглогдож хоорондоо холбогдсон байна. Эдгээрийг нислэгийн өмнө авч, нислэгийн дараа буцааж тавих ажлыг онгоц /нисдэг тэрэг/-ны техникч хариуцна.

134. Онгоц /нисдэг тэрэг/-ыг онгоцны нуувчаас гаргах, оруулах, чирэх үед уг ажиллагааг удирдах ахлах албан тушаалтныг томилно. Чирч буй онгоц /нисдэг тэрэг/-ны бүхээгт нисгэгч, техникчийн аль нэг заавал байна. Тухайн онгоц /нисдэг тэрэг/-ны техник ашиглалтын зааварт заагдсан хурдаар чирэх ба ямар нэгэн огцом хөдөлгөөн, эргэлт хийхгүйгээр гүйцэтгэнэ. Чирч буй машины жолооч, уг ажиллагааг удирдаж байгаа ахлагчийн хооронд хоёр талын холбоо байхгүй тохиолдолд чирэгчийн тэвшин дээр ахлагчийн дохиог дамжуулах үүрэгтэй холбоочин байх бөгөөд тэр нь хөдөлгөөний үед аюулгүй байдлыг хянана.

Онгоц /нисдэг тэрэг/-ыг чирэх үед хөдөлгөөнийг удирдах дохионуудыг 6 дугаар хавсралтад заагдсаны дагуу өгнө.

Онгоц /нисдэг тэрэг/-ыг онгоцны нуувчаас гаргах, оруулах үед уг ажиллагааг удирдаж байгаа ахлагчаас өөр хүн ямар нэгэн дохио өгөхийг хориглоно. Харин ямар нэгэн осол, гэмтэл гарч болзошгүй байдлыг урьдчилан харсан хүн “ЗОГС” дохиог өгөх үүрэгтэй.

## **2.7. Ашиглалтын хяналтын хэрэгслийг хэрэглэх, бэлэн байлгах**

135. Ашиглалтын хяналтын техник хэрэгсэлд нисэхийн техникийг ашиглах болон засварлах үед тэдгээрийн байдалд хяналт тавих зорилгоор хэрэглэдэг хэмжих болон хяналт шалгалтын аппаратур, хяналтын автоматчлагдсан системүүд /онгоцны, газрын/, багаж хэрэгсэл-хяналтын лаборатори, хяналт шалгалтын станц, тоноглол, дууриалгуур болон тохируулга хийх зориулалттай хэрэгслүүд багтана.

136. Цэргийн засварын болон ашиглалтын хяналтын хэрэгслийг хэрэглэх журам нь нисэхийн техникийн ашиглалтын заавар, технологийн картууд ба засварын заавар, түүнчлэн тэдгээр хэрэгслийн техникийн баримт бичгээр тодорхойлогдоно.

Ашиглалтын хяналтын хэрэгсэл, тусгай зориулалтын автомашинууд нь НИА-ны бие бүрэлдэхүүний нэр дээр бүртгэгдэнэ.

137. Инженер, техникийн бүрэлдэхүүний цэргийн засварын ба ашиглалтын хяналтын хэрэгслийг бэлтгэх, хэрэглэх талаарх мэдлэгийг нисэхийн техникийн мэдлэгийг шалгахтай хамтруулан явуулна.

138. Хэмжих хэрэгслүүдийн хэмжил зүйн хангалтыг тухайн шаардлагын дагуу зохион байгуулж явуулна.

139. Тухайн загварын нисэхийн техникийн ашиглалтын зааварт тусгагдсан, бүрэн бүтэн, гэмтэлгүй, техникийн баримт бичиг нь хөтлөгдсөн, засварын болон ашиглалтын хяналтын хэрэгсэл хэрэглэхийг зөвшөөрнө. Зөвхөн тогтоогдсон хугацаанд нь хэвшүүлэх ажил хийж, шалгасны дараа хэмжих хэрэгсэл ашиглахыг зөвшөөрнө.

140. Дараах нөхцөлд хэмжих хэрэгслийг шалгагдсанд тооцно.  
Үүнд:

- хэмжих хэрэгсэл, эсхүл техникийн паспорт, формулярт шалгасан тэмдэг /клеймо/ тавигдсан байх;
- гэрчилгээтэй байх;
- хэмжих хэрэгсэл, эсхүл техникийн паспорт формулярт багаж хэрэгслийн үйлдвэрийн газрын техникийн хяналтын хэлтэс /ОТК/-ийн тэмдэг дарагдсан байх зэрэг болно.

Шалгагдсан багаж, хэмжих хэрэгсэл бүр хэмжил зүйн лабораторийн, эсхүл багаж хэрэгслийн үйлдвэрийн газрын баталгаа, шалгасан тэмдэгтэй байна.

Шалгалтад ордоггүй хэмжих хэрэгсэлд хэвшүүлэх ажил хийсэн нөхцөлд ашиглахыг зөвшөөрнө. Хийгдсэн ажлын тухай техникийн паспорт, формулярт бичилт хийнэ.

141. Тухайн хэрэгслийг ашиглаж байгаа НИА-ны бие бүрэлдэхүүн баримт бичигт нь заагдсан багтаамж, дарааллаар хэмжих хэрэгслийн хэвшүүлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.

142. НИА-ны салбарууд нь тогтоогдсон маягтын дагуу хэмжих хэрэгслийн техникийн байдал, шалгалт, засварын талаар тооцооны дэвтэр хөтөлнө.

143. НИА-ны бие бүрэлдэхүүн лабораторийн шалгалтад хэмжих хэрэгслийг хуваарийн дагуу оруулна. Хуваарийг холбогдох байгууллага, НИА-тай тохиролцсоны үндсэн дээр боловсруулж батлуулна.

Шалгах ажлыг цаг тухайд нь зохион байгуулахыг байгууллагын хэмжил зүйн албаны дарга хариуцна. Хэмжих хэрэгслийг цаг тухайд нь шалгалтад оруулахыг төрөл мэргэжлийн инженерүүд хариуцна.

Ерөнхий инженер нь хэмжил зүйн лабораторийн явуулын бүлгийг ажиллаж байх үед хэмжих хэрэгслийг шалгуулахтай холбогдсон ажлыг хариуцан зохион байгуулах албан тушаалтныг томилно.

144. Шалгалтын хугацаа дууссан, шалгасан тэмдэг нь зөрчилтэй, түүнчлэн цагт нь хэвшүүлэх ажил хийгдээгүй хэмжих хэрэгслийг ашиглах, хэрэглэхийг хориглоно.

145. Байгууллага болон нисэхийн засварын газарт бүтээсэн бүртгэлгүй хэрэгслүүд/суурин шалгах хэрэгсэл ба тоног төрөөрөмж/-эд хэмжил зүйн шинжлэн магадлалтыг хийсний дараа ашиглахыг зөвшөөрнө.

Байгууллагын дарга /захирагч/-ын шийдвэрийн үндсэн дээр хэмжил зүйн мэргэжилтэн, эсхүл байгууллагын хэмжих хэрэгслийн байдлыг хариуцагч даргалсан гурваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс шинжлэн магадлалтыг явуулна.

Шинжлэн магадлалтын үр дүнгийн талаарх нотломжийг хэмжил зүйн байгууллагатай тохиролцож, байгууллагын дарга /захирагч/ батлана. Хэмжил зүйн шинжлэн магадлалтын нотломжийг батлуулсны дараа түүний дүгнэлтийн дагуу бүртгэлгүй хэмжих хэрэгслийг байгууллагын дарга /захирагч/-ын тушаалаар ашиглалтад оруулна.

Шинжлэн магадлалтын комиссийн дүгнэлтийг паспорт, формулярт бичнэ.

146. Эвдрэл, гэмтэлтэй ашиглалтын хянах хэрэгслүүдийг засварт явуулах ажлыг ТАА-ийн дарга, /ерөнхий инженер/ зохион байгуулна. Эвдрэл, гэмтэлтэй хэмжих хэрэгслүүдийг цаг тухайд нь засварт өгч буй эсэхэд төрөл мэргэжлийн инженерүүд хяналт тавина.

147. Эдгээр хэмжих хэрэгслийг агуулахаас цаг тухайд нь засварт явуулахыг ерөнхий инженер хариуцна.

148. Нисэхийн засварын байгууллага нь ашиглалтын хянах хэрэгсэлд засвар, шалгалт хийсний дараа ирүүлсэн байгууллага руу нь буцааж өгөх үүрэгтэй.

149. Ашиглалтын хянах хэрэгслийг хэрэглэж байгаа НИА-ны бие бүрэлдэхүүн нь тэдгээрийн бүтэц, зохион байгуулалтыг мэдэж, хэмжилтийг шаардлагатай нарийвчлалтайгаар гүйцэтгэж чаддаг байх ёстой бөгөөд эвдрэл, гэмтэлгүй байдал, цаг тухайд нь шалгуулах асуудлыг хариуцна.

2.8. Тусгай зориулалтын автомашиныг хэрэглэх, хадгалах

150. НИА-ы салбарт байгаа тусгай зориулалтын автомашин бүр байгууллагын дарга /захирагч/-ын тушаалаар бүлгийн дарга, жолооч нарын нэр дээр данслагдаж, тэд машины техникийн бэлэн байдлыг хариуцна.

151. НИА-ны тусгай тоноглолын машин /чиргүүл/, нэгдүгээр ба хоёрдугаар техникийн үйлчилгээ, улирлын болон хэвшүүлэх ажил, хөдөлгүүр, тэвш, дугуйны урсгал засвар, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, шатах- тослох материалаар хангахыг нисэхийн техникийн хэсгийн автотракторын алба эдгээр машины жолооч нарын оролцоотой гүйцэтгэнэ.

Тусгай тоноглолын автомашин дээр байрласан, онгоц /нисдэг тэрэг/-ыг шалгах, засварлахад зориулагдсан багаж хэрэгсэлд

техникийн үйлчилгээ, хэвшүүлэх ажил ба төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг арилгах ажлыг НИА-ны мэргэжилтнүүд хийнэ.

152. Тусгай тоноглолын автомашин /чиргүүл/-д нэгдүгээр ба хоёрдугаар техникийн үйлчилгээ, техникийн үзлэг, улирлын болон хэвшүүлэх ажлыг НИА хуваарийн дагуу төлөвлөж, нисэхийн тусгай тоноглолтой автотехник хариуцсан албан тушаалтантай тохиролцож гүйцэтгэнэ.

Тусгай тоноглолын автомашин /чиргүүл/-д үзлэг хийх хэм хэмжээг 7 дугаар хавсралтад үзүүлэв.

153. НИА нь нисэхийн тусгай тоноглолтой аэродром-техникийн хангалтын хэрэгсэл, автотехникүүдэд хэвшүүлэх ажил хийж гүйцэтгэхэд туслалцаа үзүүлнэ.

Дээрх тоног төхөөрөмжид үйлчилгээний хэвшүүлэх ажил хийх хуваарийг нисэхийн тусгай тоноглолтой автотехник хариуцсан албан тушаалтан гаргаж НИА-ны удирдлагатай зөвшилцөнө.

154. Хяналтын үзлэгээр тусгай тоноглолын автомашин /чиргүүл/-ны хөдөлгүүр, дугуй, тоноглолд гадна үзлэг хийж дараах зүйлсийг шалгана. Үүнд:

- шалгаж хэмжих төхөөрөмж, багаж, галын төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, баримт бичгийн иж бүрдэл,
- тусгай тоноглолын автомашин /чиргүүл/ нь цэргийн анги, жолоочийн нэр дээр данслагдсан эсэх;
- тусгай тоноглолын автомашин болон түүний тоноглолын ажилласан цагийн тооцоо хийгдсэн эсэх;
- тусгай тоноглолын автомашинд улирлын техникийн үйлчилгээ, түүний тоноглолд хэвшүүлэх ажил, ээлжийн шалгалтууд цаг хугацаандаа хийгдэж буй эсэх;
- хяналт, шалгалтын явцад заагдсан дутагдлыг арилгасан эсэх;
- тусгай тоноглолын автомашин/чиргүүл/-ны тоноглолуудыг ажиллуулдаг мэргэжилтнүүдийн мэдлэг, дадлагыг шалгах.

## 2.9. Багаж түлхүүрийг хэрэглэх, хадгалах

155. Нисэхийн техник, тусгай тоноглолын автомашин дээр хэрэглэгддэг бүх багаж бүрэн, бүтэн байх ёстой бөгөөд хадгалалтыг хянах зорилгоор таних тэмдэг тавигдсан байна. Таних тэмдэггүй багаж хэрэглэхийг хориглоно.

Онгоц нэг бүрт зориулагдсан багаж түлхүүр, газрын тоноглолыг уг онгоц /нисдэг тэрэг/-ны техникч хариуцна. Нийтийн хэрэгцээний багаж түлхүүр, газрын тоноглолын бүрэн бүтэн байдлыг уг зүйлийг хадгалах болон тараах эрх бүхий албан тушаалтан хариуцна. Нэг бүрийн хэрэглээний багаж түлхүүр, газрын тоноглолыг үйлчилгээний ба хэвшүүлэх ажлын бүлгийн мэргэжлийн хүмүүс хариуцна. Хариуцагч /түүний шууд захирах дарга/-ийн зөвшөөрөлгүй уг багаж түлхүүр, газрын тоноглол ашиглахыг хориглоно.

Багажны таних тэмдэгт тавигдах шаардлагыг 8 дугаар хавсралтад үзүүлэв. Ерөнхий инженер багаж хадгалах, хурааж авах, олгох болон тооцох журмыг тогтооно.

156. Хариуцагч нь багаж, түлхүүр бүрэн эсэхийг ажил /нислэгийн бэлтгэлүүд/ эхлэхийн өмнө болон дууссаны дараа жагсаалтын дагуу тогтмол шалгана.

Багаж, түлхүүр алга болсон тохиолдолд илтгэж, уг багажийг олох бүхий л арга хэмжээг авна.

Техник ашиглалтын хэсгийн болон үйлчилгээний хэвшүүлэх ажлын бүлгийн дарга нар хэсэг бүлгийнхээ багаж, түлхүүрийн бүрэн, бүтэн байдлыг долоо хоногт нэгээс доошгүй удаа шалгана. Багаж, түлхүүр алга болсон тохиолдолд түүнийг хайж олох ба шалтгааныг тогтооно.

157. Ерөнхий инженерийн төлөвлөгөөний дагуу нисэхийн техник дээр үзлэг хийх үед хяналт шалгалтын техник хэрэгсэл, багажны бүрэн бүтэн байдлыг ерөнхий инженер, төрөл мэргэжлийн инженерүүд, ТАА-ийн дарга шалгана. Байгууллагын бүх хяналт шалгалтын техник хэрэгсэл, багаж, түлхүүрүүд 6 сарын дотор шалгагдсан байхаар тооцоолж төлөвлөгөөг сараар зохионо.

## 2.10. Нисэхийн техник дээр ажиллах үеийн аюулгүйн арга хэмжээ

158. Онгоц /нисдэг тэрэг/-нд үзлэг, хэвшүүлэх ажил хийх, ажил эхлэхийн өмнө тохиолдлын буудлага, шидэгддэг суудлын дарьт механизм ажиллах, түлшний сав, бөмбөг хаягдах, дугуй хураагдах, цахилгаан төхөөрөмжүүд өөрөө ажиллах нь бие бүрэлдэхүүний эрүүл мэнд ба нисэхийн техникийг гэмтгээх тул аюулгүй ажиллагааны арга хэмжээ авна. Үүний тулд:

- онгоц/нисдэг тэрэг/-нд найдвартай газардуулга хийгдсэн эсэх,
- буудлагын чиглүүлэгч хэлхээний гал хамгаалагч, бөмбөг / түлшний сав/ ба зэвсгийг ослын үед хаях товчлуурууд хамгаалах бүрхүүлээр хаагдсан эсэх;
- дугуй хураах, буулгах сэлгэн залгагч бариул цоожлогдсон эсэх;
- хэрэглэлийн гал хамгаалагчууд “Унтраах” байрлалд тавигдсан эсэх.

159. Хөдөлгүүр сольсоны дараа, хэвшүүлэх ажил хийх, зорилгот үзлэг, эсвэл дутагдлыг арилгах үед тусгайлан бэлдсэн ба тоноглогдсон талбайд хөдөлгүүрийн таглааг нээлттэй асааж, шалгана.

160. Гал гарахаас сэргийлж бүх системийн битүүмжлэлийг хөдөлгүүрийн бага ажиллагаанд шалгах ба үүний дараа хөдөлгүүрийг дээд ажиллагаанд шалгана.

161. Хөдөлгүүр ажиллаж байх үед онгоц /нисдэг тэрэг/-ны бүхээг болон хөдөлгүүрийн удирдлагын самбарыг эзэнгүй орхих, түүнчлэн цэнэглэх хоолойгоор дамжуулан түлш, масло, тусгай шингэн байгаа эсэхийг шалгахыг хориглоно.

162. Хөдөлгүүр ажиллаж буй үед онгоцны урд болон ар талд аюултай зонд болон нисдэг тэрэгний сэнсний эргэлтийн хавтгайд байхыг хориглоно.

163. Хөдөлгүүр асааж шалгахын өмнө дугуй, хурд сааруулагч хаалтыг хураах, буулгах, далавчны байрлал өөрчлөхөд ойр хавьд хүмүүс болон саад буй эсэхийг шалгана. Онгоцны дотор ба гадна ажиллаж байгаа бүх бүрэлдэхүүнд урьдчилан анхааруулах дохио өгнө.

164. Зогсоол дээр онгоцны дугуйн ивүүргийг хийнэ. Дугуйн ивүүрэггүйгээр онгоц асаахыг хориглоно. Хөдөлгүүр асаах бүх тохиолдолд дугуй заавал тоормослогдсон байна.

165. Аэродром дээр онгоцны зэвсэглэлтэй ажиллах ажиллагааг аэродромын район дахь аюулгүйн бүсэд явуулна.

166. Нисэхийн зэвсэг-хөнөөх хэрэгсэлтэй ажиллахдаа дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- нисэхийн хөнөөх хэрэгсэлд засвар хийх;
- хайрцагтай, хайрцаггүй хөнөөх хэрэгслийг хаяж унагаах, цохиж доргиох, тусгай зориулалтын хайрцаггүй чирэх;
- сум, тэсрүүлэгчийг тусгай зориулалтын хайрцаг савгүй зөөх;
- хөнөөх хэрэгслийг дэмжих, тулахгүйгээр налуу шатаар буулгах;
- нисэхийн хөнөөх хэрэгсэл ачсан машины тэвшинд хүн тээвэрлэх;
- сум, нисэхийн бөмбөг, удирдлагатай болон удирдлагагүй пуужингийн байлдааны анги, тэсрүүлэгчийг задлах, цэнэгийг нь авах;
- нисэхийн хөнөөх хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах;
- байгууллагын нутаг дэвсгэрт хөнөөх хэрэгслийн устгал хийх.

167. Дүрэмд заагдсан бусад бүх тохиолдолд зөвхөн фото хяналтын болон хараалах хэрэгсэл, зэвсэглэлийн удирдлагын цахилгаан хэлхээний хэвийн ажиллагааг шалгаж, улмаар онгоц /нисдэг тэрэг/-нд төрөл мэргэжлийн бүлгүүд нислэгийн өмнөх болон нислэг хоорондын бэлтгэлийг хийж дууссаны дараа онгоц /нисдэг тэрэг/-ны зэвсэг, хөнөөх хэрэгслийг зүүнэ.

Зэвсэглэлийн системийн аюулгүй байдлыг шалгаж буй зэвсгийн техникч нь юуны өмнө пуужин харвах төхөөрөмж блок, их буу цэнэггүй эсэхийг биечлэн үзэж шалгасан байх ёстой. Зэвсэглэлийн удирдлагын систем ба төхөөрөмжийг шалгасны дараа хаях, харвах, буудах цахилгаан хэлхээ салгагдсан эсэхийг заавал шалгана. Онгоц /нисдэг тэрэг/-ны хөнөөх хэрэгсэл зүүх үед түлш, хийгээр нэг зэрэг цэнэглэхийг зөвшөөрнө.

168. Онгоцны хурдасгагч, хөнөөх хэрэгсэл зүүх, авахын өмнө онгоц /нисдэг тэрэг/-ыг аюулгүй бүс рүү чиглүүлэн байрлуулсан байна. Бөмбөг баригч /харвах төхөөрөмж/-д урьдчилан хамгаалах чагт тавигдсан, тусгаарлалтын товчлуур салгагдсан байна.

Байлдааны бөмбөг, удирдлагагүй болон удирдлагатай пуужингийн хамгаалах чагтыг онгоц /нисдэг тэрэг/-ыг явгалахын өмнө авна.

169. Зэвсэгтэй ажиллах /цэнэглэх, цэнэггүй болгох, гацааг арилгах/ үед зэвсгийн гол төмрийн урд байх, эсхүл урдуур нь өнгөрөх, цэнэглэх, цэнэггүй болгох үед гаргах төхөөрөмжийн /блок-32/ ард байхыг хориглоно. Эдгээр ажлыг гүйцэтгэх, түүнчлэн гаргах төхөөрөмжид пуужинг зүүх, авах үед нисэхийн зэвсгийн гол төмрийн чиглэлд онгоцноос 3-5 м зайд энэ зүгт явах, өнгөрөхийг хориглосныг анхааруулсан улаан дарцаг /1,5 м урт модон иштэй, 0,25x0,40 м хэмжээтэй/, шөнө улаан дэнлүү байрлуулна. Түүнээс гадна гаргах төхөөрөмжийг цэнэглэх, цэнэггүй болгох үед улаан дарцаг /дэнлүү/-ыг онгоцны ард тавина.

170. Техникийн ашиглалтын дүрэм, бусад зааварчилгаанд өөрөөр заагаагүй бол онгоц /нисдэг тэрэг/-ны бүхээгт хүн байхад хөнөөх хэрэгсэл болон хурдасгагч зүүх, авахыг хориглоно.

171. Зэвсэглэлийн удирдлагын системд тэсэлгүүр холбох үед онгоц /нисдэг тэрэг/-нд зүүлттэй байгаа пуужин, удирдлагагүй пуужин бүхий блок, хурдасгагч, бөмбөг болон их бууны гол төмрийн өмнө хойно хүн явах, байрлахыг хориглоно.

172. Онгоц /нисдэг тэрэг/-ны их бууг цэнэглэсэн, хөнөөх хэрэгсэл зүүсний дараа тэдгээр дээр ажиллах, мөн бүхээгт удирдлагын системийг залгах, салгах, шалгахтай холбогдсон засварын ажил гүйцэтгэхийг хориглоно.

173. Онгоц /нисдэг тэрэг/-нд хөнөөх хэрэгсэл зүүсэн үед цахилгаан монтажийн аливаа ажил хийх, хэлхээнд гарсан гэмтлийг засварлахыг хориглоно.

174. Байлдааны бөмбөг хаягдаагүй, түүнчлэн буудлага хийсний дараа сум /пуужин/ үлдсэн, агаарт буудлага хийх үед сум гацсан онгоц /нисдэг тэрэг/-ыг зогсоол руу явгалуулахыг хориглоно.

Эдгээр тохиолдолд үлдсэн галт хэрэглэлийг онгоц /нисдэг тэрэг/-ноос салгах, зэвсгийг цэнэггүй болгоход онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоол, аэродромын барилга байгууламж, орон сууцны барилгаас хол тусгайлан бэлтгэсэн талбайд онгоц /нисдэг тэрэг/-ыг байрлуулна.

Буудлага, бөмбөгдөлттэй нислэгийн дараа байлдааны бөмбөгийн тэсэлгүүр салгасан, зэвсгийг нь цэнэггүй болгосон онгоц /нисдэг тэрэг/-ыг чирэхийг зөвшөөрнө.

Зогсоол руу, эсхүл аюулгүйн бүс рүү явгалуулж аваачсан /хэрэв зэвсэг хэрэглэсэн бол/ болон хөдөлгүүр унтраасны дараа онгоц /нисдэг тэрэг/ заавал газардуулагдсан байна.

Нислэгээс буцаж ирсэн онгоц /нисдэг тэрэг/-ыг газардуулагүй байхад ажиллахыг хориглоно.

175. Онгоц /нисдэг тэрэг/-ны зэвсэглэл гацсан /бөмбөг хаягдаагүй, эсхүл зоргоор хаягдсан, их буу гацсан/ тохиолдолд уг онгоц /нисдэг тэрэг/-ыг буусны дараа зэвсэглэлийн гацаа арилгах, цэнэг авах зориулалт бүхий тусгай талбай руу явгалуулж, аюулгүйн бүс рүү чиглүүлж байрлуулна.

176. Тусгайлан бэлдсэн талбай дээр хөдөлгүүр унтраасны дараа зэвсэглэлийн бүлгийн даргын удирдлаган дор зэвсэглэлийн мэргэжилтнүүд бууны цэнэг, бөмбөг, пуужин болон ажиллаагүй бусад хөнөөх хэрэгслийг авах ажлыг гүйцэтгэнэ. Энэ үед:

- зэвсэглэлийн удирдлагын бүх цахилгаан хэлхээ буюу хурдасгагчийг асаах, хаях хэлхээ, байлдааны товчлуурууд салгагдаж, урьдчилан сэргийлэгдсэн эсэхийг шалгах;

- нисэхийн бөмбөг, пуужин, хурдасгагч болон их бууны сум, хөдөлгөөнт хэсгүүд ямар байрлалд байгааг тогтоож, бөмбөг унагах, сум алдах аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсны дараа цэнэг авах, хөнөөх хэрэгсэл авах ажлыг эхэлнэ.

177. Зэвсэглэлийн гацааг арилгалгүйгээр авч эс чадвал шаардлагатай аюулгүйн арга хэмжээ авч, зэвсэглэлийг уг онгоцноос салгана. Хөнөөх хэрэгслийг онгоц /нисдэг тэрэг/-ноос газарт хаяхыг хориглоно.

178. Онгоцны бүхээгт байрлах пиропатроныг авсаны дараа нисгэгчийн суудлын буудах механизмд засвар ба хэвшүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

179. Гарааны хурдасгагчийг онгоцонд ашиглах үед дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- цахилгаан тэжээл өгөгдсөн үед онгоцонд дарин хурдасгуур тавих, авах;
- хаях хэлхээний тусламжтай хурдасгагчийг онгоцноос авах;
- онгоц асаах, цахилгаан тэжээл холбох үед хурдасгагчийн ойр байрлах, явах.

180. Цахилгаан хэлхээтэй ажиллах үед дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- онгоц /нисдэг тэрэг/-ны зэвсэглэл болон буудлагын оньснуудыг аюулгүй байдалд оруулахгүйгээр хэлхээний гэмтлийг арилгах;
- цахилгаан хэрэглэлийг задлах, угсрах, дамжуулагч утас, кабелийг залгах, салгах, блокын бүрээсийг авах тавих, хуваарилах төхөөрөмж болон залгалтын самбарыг онгорхой, хяналтгүй орхих, онгоц /нисдэг тэрэг/-ны цахилгаан хэлхээнд хүчдэлтэй байгаа үед түүнд гарсан гэмтлийг арилгах;
- гар хийцийн болон тухайн цахилгаан гүйдэл, хүчдэлд тохироогүй өөр төрлийн гал хамгаалагч тавих;
- төрөл, хүчдэл нь тухайн тоног, төхөөрөмжид тохирохгүй дохионы болон гэрэлтүүлэгч хэрэгсэл /чийдэн/ ашиглах;
- хүчдэлтэй үед гал хамгаалагч, дохионы болон электрон чийдэнг солих;
- бүхээгийн залгуурт зөөврийн гэрэл, гагнуурын алх болон бусад төрлийн хэрэглэгчдийг сэлгэхгүйгээр залгах, түүнчлэн хүчин чадал нь тухайн залгуур бүхий гүйдлийн хамгаалагчаас илүү хэрэглэгч залгах;
- дамжуулагчийг хошуувчгүй шууд холбох;

- дамжуулагч болон хоолойнуудын марк солих, дараалал алдагдуулах, бэхэлгээгүй орхих;
- дамжуулагчийг хоолойтой хавируулах;
- дамжуулагчийн төгсгөлийг тусгаарлагчгүйгээр орхих;
- ашиглалтын зааварт заагдаагүй тусгаарлагч хэрэглэх;
- хүчдэлтэй эсэхийг шалгахдаа 2 утсыг хооронд нь хавируулах, хуруугаа хүргэх, онгоц /нисдэг тэрэг/-нд их биелүүлэх.

181. Тоног төхөөрөмжүүд хүчдэлтэй үед доорх ажлыг гүйцэтгэхийг хориглоно. Үүнд:

- монтажийг үзэж шалгах;
- гэмтлийг арилгах /палат, модуль, чийдэн, эсэргүүцэл, конденсатор, реле, хагас дамжуулагч багаж болон гал хамгаалагч солих, монтажид гагнуур хийх г.м./;
- тохируулгын ажил хийхдээ цахилгааны хамгаалалтгүй багажаар ажиллах;
- блокуудыг угсрах, салгах, бүрээсийг нь авах, тавих, кабель фидерүүдийг салгах, залгах.

182. Хэт өндөр давтамжийн генератортай холбоотой бүх ажлыг цацрагаас хамгаалах арга хэмжээг авч, радио өнгөлөн далдлалтын дүрмийг хатуу мөрдсөн нөхцөлд гүйцэтгэнэ. ТАА болон засварын газарт ажиллаж байгаа хэмжилтийнхээс бусад хэт өндөр давтамжийн генераторыг тоосгон, эсхүл бетонон ханатай тусгай өрөөнд байрлуулна.

183. Ажлын байранд ямар нэгэн шалтгаанаар хэт өндөр давтамжийн энерги нэвчилтийг арилгаж чадахгүй бол бие бүрэлдэхүүнийг хортой цацрагийн үйлчлэлээс хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ /энергийн чадлыг шингээгч, халхавч байгууламж, хамгаалалтын хувцас, нүдний шил г.м./.

Хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хамгаалах чадварыг тогтоогдсон хэмжээнд байлгахыг хэт өндөр давтамжийн хэрэгсэл ажиллуулдаг инженер хариуцна.

184. Өндөр давтамжийн цахилгаан гүйдэлд цохиулахаас зайлсхийхийн тулд радиостанцын ажиллагааг газарт шалгахын өмнө дамжуулагч антенны ойролцоо хүн байхгүй эсэхийг шалгана.

Дамжуулагч залгагдсан тухай онгоц /нисдэг тэрэг/ дээр ажиллагсад сэрэмжлүүнэ. Дамжуулах төхөөрөмж ажиллаж байх үед тэдгээрийн антенны оруулга болон клемм, түүнчлэн антенны сэлгэн залгагчид хүрч болохгүй.

185. Шингэн хүчилтөрөгчөөр цэнэглэх үед аюулгүй байдлыг нарийн чанд сахиж, биеийн ил хэсэг дээр шингэн хүчилтөрөгч дусахаас сэргийлнэ. Энэ үед бээлийгүй, тусгай зориулалтын багажгүй ажиллахыг хориглоно.

Онгоц /нисдэг тэрэг/-н дээр ажиллах үед хүчилтөрөгчийн тоноглолын агрегат, тоног, төхөөрөмж болон дамжуулах хоолой дээр масло дуссан эсэхийг сайтар шалгана.

Тостой хувцастай ажиллах, даралтыг урьдчилан гадагш гаргалгүйгээр хоолой салгахыг хориглоно.

186. Онгоц /нисдэг тэрэг/-ны системийг хортой болон идэмхий шингэнээр цэнэглэх үед тусгай зориулалтын хамгаалалтын хувцастай ажиллах ба бие бүрэлдэхүүн, нисэхийн техникийг уул шингэнээс хамгаалах аюулгүйн арга хэмжээ авагдсан байх шаардлагатай.

## **2.11. Нисэхийн техникийг нислэгт бэлтгэх**

187. Нислэг үйлдэх тухай дарга /захирагч/-ын шийдвэр болон нислэгийн төлөвлөлтийн дагуу ерөнхий инженер нь нисэхийн техникийг нислэгт бэлтгэхэд шаардагдах хүч, хэрэгслийн тооцоог хийх бөгөөд инженер, техникийн бүрэлдэхүүнд зааварчилгаа өгч, үүрэг тавихдаа дараах зүйлсийг тодотгоно. Үүнд:

- нисэхийн техникийг нислэгт бэлтгэх онцлогууд;
- нислэгт үйлчлэх НИА-ны удирдлага, гүйцэтгэгчид, бие бүрэлдэхүүний томилгоо;
- техникийн тусламжийн баг, техникийн хяналтын цэгт гарах мэргэжилтнүүдийн томилгоо;
- нисэхийн техникийг нислэгт бэлтгэх үеийн НИА-ны бие бүрэлдэхүүний ажлын дэс дараалал, зохион байгуулалт;
- газрын үйлчилгээний хэрэгслийн тоо хэмжээ, түүнийг оновчтой хуваарилж, ашиглах дэс дараалал.

188. Шаардлагатай бол аэродром, техник хангалтын салбараас гаргасан жижүүрийг /нислэгийн ахлах инженер ба нислэгийн удирдагчийн заавраар/ хүч хэрэгсэл, нислэгийн хангалтыг шууд

удирдах үүрэгтэйгээр зааварчилгаа өгөх үед оролцуулна.

189. Нислэгийн үед НИА-ны бие бүрэлдэхүүний ажиллагааг удирдуулахаар урьд өдөр нь нислэгийн ахлах инженерийг томилно. Нислэгийн ахлах инженерээр ерөнхий инженер, эсхүл төрөл мэргэжлийн инженерүүдээс томилно.

190. Нислэгийн ахлах инженер нь нисэхийн техникийн бэлтгэлийн явцыг шалгах ба төлөвлөлтийн дагуу онгоц /нисдэг тэрэг/ нислэгт цагтаа гарч байгаа эсэхийг хянаж, нисэхийн техникийн байдлын талаар ерөнхий инженер болон нислэгийн удирдагчид илтгэх ба гарсан саатал, дутагдлыг арилгах арга хэмжээ авна.

191. Ерөнхий инженер /нислэгийн ахлах инженер, жижүүрийн инженер/ нь газрын үйлчилгээний хэрэгслийн захиалга, түүний тоо хэмжээг шалгана.

192. Нислэгийн ахлах инженер нь техникийн байр, онгоц / нисдэг тэрэг/ үйлчилгээнд бэлэн эсэхийг шалгах ажлыг зохион байгуулна /түлш, шахсан агаараар цэнэглэх, цахилгаан энерги, гал унтраах хэрэгсэл болон техникийн байр ашиглах талаар зааварт тусгасан бусад төхөөрөмжөөр хангах/.

193. Нислэгийн үеийн техникийн тусламжийн багийг НИА-ны болон хангалтын салбарын бүрэлдэхүүнээс томилно. Багийн бүрэлдэхүүний мэргэжилтнүүд, гаргах хэрэгслийн тоог байгууллагын дарга /захирагч/-ын тушаалаар тодруулна. Техникийн тусламжийн баг нь гэмтсэн онгоц /нисдэг тэрэг/-ыг хөөрөх, буух зурвас, явгалах замаас гаргах, ослоор газар дээр онгоц /нисдэг тэрэг/-ыг орхисон тохиолдолд нисэх баг /зорчигчдод/ тусламж үзүүлэх үүрэгтэй. Тухайн аэродром дээр уг багийн байрлах газрыг нислэг үйлдэх заавраар тодруулна. Техникийн тусламжийн баг нь нислэгийн ахлах инженерт захирагдана.

194. Нислэгийн үеэр техникийн хяналтын цэгт гарах жижүүрийг техникийн бүрэлдэхүүнээс томилно. Техникийн хяналтын цэгийг аэродром дээр дараах байдлаар байрлуулна. Үүнд:

- онгоц хөөрөх, буух зурвас дээр ирэхийн өмнөх байран дээр, эсхүл онгоцыг тараан байрлуулсан бүсээс явгалалт хийх үед гадаад байдалд нь хяналт хийх байранд;
- байлдааны хэрэгсэлтэй нислэгийн дараа тусгай зориулагдсан

талбайд зэвсэглэлийг үзэж, тоормосны шүхрийг шүхэр десантын албаны мэргэжилтнүүд хураана.

195. Нисэхийн техникийн нислэгийн бэлтгэлийг онгоцны нуувч, онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоол болон техникийн байрлалд зохион байгуулна. Онгоц /нисдэг тэрэг/-ыг газрын техникийн баг, үйлчилгээний бүлгийн мэргэжлийн тоотууд нислэгт бэлтгэнэ. Онгоц /нисдэг тэрэг/-н дээрх ажлууд нь зэрэгцээ, дараалсан хэлбэрээр технологийн хуваарь, технологийн картын дагуу явагдана. Техникийн багууд нь бүх онгоц /нисдэг тэрэг/-ыг зэрэг, харин үйлчилгээний бүлгийнхэн дараалсан хэлбэрээр бэлтгэнэ.

196. Тоотын бүрэлдэхүүн нь ажлыг бүрэн хэмжээгээр, тогтоосон хугацаанд нь дээд зэргийн чанартай хийж гүйцэтгэнэ. Тоотын бүрэлдэхүүний мэргэжлийн хүмүүсийн тоог үйлчилгээний бүлгийн дарга тогтооно. Ажлын өдөр бүрийн төгсгөлд тоотын бүрэлдэхүүнийг тодотгоно. Гүйцэд биш бүрдэлтэй техникийн тоотуудаар нисэхийн техникийг нислэгт бэлтгэхийг хориглоно.

197. Нислэгт үйлчлэх үйлчилгээний бүлгийн тоотууд, техникийн багийн бүрэлдэхүүнийг нислэгийн өмнөх өдрөөс хэтрүүлэлгүй томилоно. Тоотууд, үйлчилгээний бүлэгт байгаа мэргэжилтнүүдийн тоо нь нисэхийн техникийн бэлтгэлийн төрөл, зэвсэглэлийн хувилбарууд, түүнчлэн газрын үйлчилгээний болон техник хяналтын байгаа хүч хэрэгслээр тодорхойлогдоно.

198. Түгшүүр, цугларах дохиогоор онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх тохиолдолд мэргэжлийн тоотуудыг тухайн заасан ажлыг гүйцэтгэх эрх бүхий НИА-ны бусад салбарын мэргэжилтнүүдээс нэмж бүрдүүлнэ. Тоотын бүрэлдэхүүнд орсон хүмүүс нь түгшүүр, цугларах дохиогоор онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх дадлагыг сард нэгээс доошгүй удаа хийнэ.

199. Зэвсэглэлийг бэлтгэх орон тооны бус тоотуудын бүрэлдэхүүнд зэвсэглэлийн хувилбарыг өөрчлөх, бэлтгэх, сумлах ажлын зохих дадлага хийж, зэвсэгтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагааг судлаж зааварчилгаа авсан нисэх баг, техникийн төрөл мэргэжлийн мэргэжилтнүүд багтана. Орон тооны бус тоотуудын ажиллах эрхийг байгууллагын дарга /захирагч/-ын тушаалаар олгоно.

## **Нислэгийн урьдчилсан бэлтгэл**

200. Нислэгийн урьдчилсан бэлтгэл нь нисэхийн техникийг нислэгт бэлтгэх үндсэн төрөл мөн.

201. Урьдчилсан бэлтгэлд :

- онгоц/нисдэг тэрэг/-ны хяналтын үзлэг;
- илэрсэн дутагдлыг арилгах;
- нисэхийн хөнөөх хэрэгсэл, зэвсэглэлийн салах эд ангиудыг бэлтгэх;
- онгоц/нисдэг тэрэг/-ны газрын үйлчилгээний хэрэгсэл, хянан шалгах аппаратууд, багаж түлхүүрийг бэлтгэх ажлууд,
- нисэх болон инженер, техникийн бүрэлдэхүүнтэй дадлага явуулах;
- баримт бичгийн хөтлөлт;
- инженер, техникийн бүрэлдэхүүний ажлын бэлтгэл, бэлэн байдлын хяналт зэрэг багтана.

202. Нислэгийн урьдчилсан бэлтгэлийг ажлын нэг өдөрт явуулна. Түүнийг гүйцэтгэсний дараа инженер, техникийн бүрэлдэхүүн 8-аас доошгүй цаг амарсан байна.

203. Онгоц /нисдэг тэрэг/, нисэх бүрэлдэхүүний дадлага явуулахад зориулсан дадлагын хэрэгслийг инженер, техникийн бүрэлдэхүүн бэлтгэнэ. Нисэх багийн сургалт, дадлагыг нисэх бүрэлдэхүүний удирдлага зохион байгуулж явуулна.

Ерөнхий инженер нь төрөл мэргэжлийн инженерүүдтэй хамтарч нисэх бүрэлдэхүүнээс нисэхийн техникийн ашиглалтын дүрмээр хагас жилд нэг удаа шүүлэг, шалгалт авна.

## **Нислэгийн өмнөх бэлтгэл**

204. Нислэгийн өмнөх бэлтгэл нь нислэгийн үүргийн дагуу өдөр, шөнийн аль ч цагт нислэгийн өмнө шууд хийгдэнэ. Үүнд:

- онгоц /нисдэг тэрэг/-ны нислэгийн өмнөх үзлэг;
- онгоц /нисдэг тэрэг/-ны системийн цэнэглэлт нь нислэгийн үүрэгт тохирч буй эсэхийн шалгалт;
- нислэгийн үүргийн дагуу онгоц /нисдэг тэрэг/-ны системийн гүйцээн цэнэглэлт;
- навигацийн, хараалалтын систем болон бусад системүүдийн

өгөгдөхүүний оруулалт;

- онгоц /нисдэг тэрэг/-ны нисэхийн хөнөөх хэрэгслийн сумлалт;

- салгах төхөөрөмжүүдийн онгоц дээрх тавилт;

- нислэгийн үүргийн дагуу онгоц /нисдэг тэрэг/-ны бэлэн байдлын шалгалт.

205. Бүх мэргэжилтнүүд, онгоц /нисдэг тэрэг/-ны техникч нислэгийн өмнөх бэлтгэл хийсний дараа онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх хяналтын хуудас /нислэгт бэлтгэх бүртгэлийн дэвтэр/-ыг бөглөөд онгоц /нисдэг тэрэг/ нислэгт бэлэн болсон тухай илтгэнэ. Онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гарах зөвшөөрлийг түүний бэлэн байдлын хяналтын дараа олгоно.

206. Радиоэлектрон тоноглол тэслэх хэлхээг нислэгийн өмнөх бэлтгэлийн дараа залгаж, нислэг дуусахаар салгана. Тэслэх хэлхээг РЭТ-ын техникч залгаж, салгах бөгөөд үндсэн аэродромоос алслагдсан нөхцөлд онгоц /нисдэг тэрэг/-ны борттехникч, нисэх багийн дарга гүйцэтгэнэ. Тэслэх хэлхээг залгаагүй буюу бүрэн бус тоноглолтой онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гаргахыг хориглоно.

207. Нисэх бүрэлдэхүүнийг ирмэгц техникч нисэх багийн даргад онгоц /нисдэг тэрэг/, түүний эд анги нислэгийн үүргийн дагуу цэнэглэгдэж, бэлтгэгдсэн тухай илтгэнэ. Нисэх бүрэлдэхүүн зааварчилгааны шаардлагын хэмжээнд онгоц /нисдэг тэрэг/-ны бэлэн байдлыг шалгаж, хүлээж авна. Онгоц /нисдэг тэрэг/-ыг хүлээж авсан тухай нисэх багийн дарга хяналтын хуудсанд гарын үсэг зурна.

208. Жижүүрлэлттэй үед өдөр бүр тогтоосон цагт нисэхийн зэвсэг- хөнөөх хэрэгслийг авалгүйгээр нислэгийн өмнөх бэлтгэл хийж, хяналтын хуудсыг бөглөнө. Энэ үед ачаа хаях болон галын системийг удирдах цахилгаан хэлхээг залгахыг хориглоно.

### **Давтан нислэгийн бэлтгэл**

209. Давтан нислэгийн бэлтгэлийг шинэ нислэг эхлэх бүрийн өмнө хийнэ. Үүнд:

- онгоц /нисдэг тэрэг/-ны гарааны үзлэг;

- үзлэгийн үед болон өмнөх нислэгт илэрсэн дутагдлыг арилгах;

- онгоц /нисдэг тэрэг/-ыг түлш, тос, тусгай шингэн, хийгээр

цэнэглэх;

- навигац, хараалах болон бусад системд өгөгдөхүүн оруулах;
- онгоц /нисдэг тэрэг/-ыг нисэхийн хөнөөх хэрэгслээр сумлах;
- онгоцонд авагддаг төхөөрөмж тавих;
- нислэгийн үүргийн дагуу онгоц /нисдэг тэрэг/-ны бэлэн

байдлыг шалгах.

210. Нисэх бүрэлдэхүүнийг ирмэгц техникч нисэх багийн даргад онгоц /нисдэг тэрэг/, түүний эд анги нислэгийн үүргийн дагуу цэнэглэгдэж, бэлтгэгдсэн тухай илтгэнэ.

211. Нисэх бүрэлдэхүүн зааварчилгааны шаардлагын хэмжээнд онгоц /нисдэг тэрэг/-ны бэлэн байдлыг шалгаж, хүлээж авна. Онгоц /нисдэг тэрэг/-ыг хүлээж авсан тухай нисэх багийн дарга хяналтын хуудсанд гарын үсэг зурна.

### **Нислэгийн дараах бэлтгэл**

212. Нисэхийн техникийн нислэгийн дараах бэлтгэлийг нислэгтэй өдөр /шөнө/ бүрийн төгсгөлд, эсхүл жижүүрлэлт дууссаны дараа /жижүүрлэлтийн үед нислэгтэй байсан эсэхээс үл хамааран/ хийнэ. Үүнд:

- онгоц /нисдэг тэрэг/-нд нислэгийн дараах үзлэг хийх;
- үзлэгийн үед болон нислэгийн явцад илэрсэн дутагдлыг

арилгах;

- байгууллагын дарга /захирагч/-ын шийдвэрийн дагуу онгоц /нисдэг тэрэг/-ыг цэнэглэж сумлах.

213. Онгоц /нисдэг тэрэг/-ны техникч, үйлчилгээний бүлгийн мэргэжилтнүүд нислэгийн дараах бэлтгэл дуусмагц нислэгт бэлтгэх бүртгэлийн дэвтрийн хяналтын хуудсанд уг онгоц /нисдэг тэрэг/-нд гүйцэтгэсэн ажлын тухай тэмдэглэл хийж илтгэнэ.

#### **2.12. Хэвшүүлэх ажлууд**

214. Нисэхийн техникийн байдлыг шалгах, түүний техникийн хүчин чадлыг мөрдөж буй ашиглалтын баримт бичгийн шаардлагын түвшинд хүргэхийн тулд хэвшүүлэх ажлыг хийнэ.

215. Хэвшүүлэх болон засварын ажлыг техник ашиглалтын анги /ТАА/-ийн бие бүрэлдэхүүн тусгай байранд буюу талбайд хийнэ. Хэвшүүлэх ажлыг үндсэн аэродромоос алслагдсан нөхцөлд онгоц /нисдэг тэрэг/-ны нисэх багийг оролцуулан тусгай бүлэг гүйцэтгэж

болно.

216. Онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүр болон бүх төрлийн тоног төхөөрөмжид хийгдэх хэвшүүлэх ажлыг онгоц /нисдэг тэрэг/-ны ниссэн цаг, технологийн картаар, ажлын агуулга, дэс дараалал, өгөгдөхүүнүүд, техникийн нөхцөл, багаж түлхүүр ба хяналт шалгалтын хэрэгслүүд, ноогдох цаг, түүнчлэн хяналтад байдаг ажлыг нэгдсэн хугацаанд хийж гүйцэтгэнэ. Ажлын өдрийн эхэнд техникч бүрт өдөртөө /ээлжиндээ/ гүйцэтгэх үүрэг, дэс дарааллыг нь тодорхойлж өгнө.

217. Ерөнхий инженер хэвшүүлэх ажил, засварт оруулах онгоц /нисдэг тэрэг/-ны жилийн төлөвлөлтийг хийж, дарга /захирагч/ батална.

218. ТАА-ийн ажлын төлөвлөлтийг бүтэн жил, сараар, эсхүл тодорхой үе шатаар хөдөлмөр зарцуулалтыг нь тодорхойлж хийнэ. Үүнд:

- хэвшүүлэх ажил (онгоц/нисдэг тэрэг/-ны маяг, хэвшүүлэх ажлын төрлөөр);
- хөдөлгүүр солих;
- нисэхийн техникийн цэргийн засвар;
- нисэхийн техникт хийх нэмэлт ажлууд;
- технологийн тоног төхөөрөмж, багажинд хийх засвар;
- инженер, техникийн бэлтгэл;
- бусад ажил.

ТАА-ийн жил, сарын үйлдвэрлэлийн төлөвлөгөөг ТАА-ийн дарга хийж, ерөнхий инженер батална.

219. Хэвшүүлэх, засварын ажлын хөдөлмөр зарцуулалт нь бие бүрэлдэхүүний жилийн ажлын цагийн 70 хувиас багагүй байна.

220. Ерөнхий инженер төлөвлөгөөний дагуу, тогтоосон хугацаанд нь онгоц /нисдэг тэрэг/-ыг хэвшүүлэх ажил хийлгэхээр ТАА-д өгөх асуудлыг зохион байгуулна.

221. Хэвшүүлэх ажлыг хийлгэх зорилгоор онгоц /нисдэг тэрэг/-ыг үзлэгт оруулж, гэмтэл, дутагдлыг илрүүлэн, засварын ажлын шинж байдал, хөдөлмөрийн /ажлын/ багтаамжийг тодорхойлно. Онгоц /нисдэг тэрэг/-ны онцлогийг харгалзан хүлээж авах үеийн үзлэгийн багтаамжийг ТАА-ийн дарга тогтооно.

Бүлгийн даргын удирдлаган дор хэвшүүлэх ажлыг бүлгийн бие бүрэлдэхүүн шаардлагатай хянан шалгах багаж хэрэгслийг ашиглан үзлэгийг хийнэ. Илэрсэн гэмтэл, дутагдлыг хэвшүүлэх ажлын бүлгийн даргын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ.

ТАА-ийн дарга нь хэвшүүлэх ажлын хооронд нисэхийн техникийн ашиглалттай холбоотой дутагдлыг арилгах арга, онгоц /нисдэг тэрэг/-нд илэрсэн дутагдлын талаар ерөнхий инженерт илтгэнэ.

222. ТАА-д хэвшүүлэх ажил хийлгэх онгоц /нисдэг тэрэг/-ны хамт түүний баримт бичиг, хугацаа нь дуусч солих болсон эд анги, блок, агрегатуудын жагсаалтыг өгнө. Мөн уг онгоц /нисдэг тэрэг/-нд данслагдсан зэвсэглэл, авагддаг төхөөрөмжийн агрегатуудыг шилжүүлнэ.

Төрөл мэргэжлийн инженерүүдийн төлөвлөж, ерөнхий инженерийн баталсан хуваарийн дагуу бүлгийн зориулалттай агрегатуудыг ТАА-д өгнө.

223. Засвар буюу хэвшүүлэх ажил хийх үед онгоц /нисдэг тэрэг/-ны техникч нь ТАА-д байрлах бөгөөд ажлын дэглэм, дотоод цагийн хуваарийн хувьд ТАА-ийн даргад захирагдана.

Онгоц /нисдэг тэрэг/-ны техникч нь хэвшүүлэх ажил бүрэн хийгдэж, дутагдал засагдсан эсэх, мөн онгоц /нисдэг тэрэг/ дээр гадны зүйл орхигдож, тоног төхөөрөмж гэмтсэн эсэхийг шалгана.

224. Онгоц /нисдэг тэрэг/ дээр хийгдэж байгаа ажлын тооцоог ТАА-ийн бүлгийн дарга нар хийнэ. Онгоц /нисдэг тэрэг/-ыг ТАА-д хүлээн авах, хэвшүүлэх ажлын явц болон шилжүүлэн өгөх үед илэрсэн бүх дутагдлыг хэвшүүлэх ажлын бүлгийн бие бүрэлдэхүүн арилгаж, бүлгийн дарга нарын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ.

Агрегат, систем, тоног төхөөрөмжийн өгөгдөхүүнийг шалгаж буй мэргэжилтнүүд уг өгөгдөхүүний хэмжилтийн дүнг тохируулгын ажил хийхийн өмнөх болон дараах байдлаар нь бүртгэлийн дэвтэрт бичнэ.

225. Хэвшүүлэх ажлыг хийсэн тухай ТАА-ийн төрөл мэргэжлийн бүлгийн дарга нар формулярын зохих хэсэгт бичнэ. ТАА-ийн дарга нь бүлгийн дарга нарын илтгэл, биечлэн хийсэн үзлэгийг үндэслэн онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийн байдалд дүгнэлт хийж

бүртгэлийн дэвтэрт бичнэ.

226. ТАА-иас онгоц /нисдэг тэрэг/-ыг хүлээж авахдаа техник ашиглалтын хэсгийн дарга /хэсгийн техникч/-ын удирдлага дор бие бүрэлдэхүүн хяналтын үзлэг хийнэ.

227. ТАА-ийн дарга нь хэвшүүлэх ажил /засвар/ хийгдсэн онгоц /нисдэг тэрэг/-ны техникийн байдал, энэ үед илэрсэн дутагдлын талаар сар бүр дүн шинжилгээ хийнэ. Дүн шинжилгээний үр дүн, дутагдлыг арилгах талаарх өөрийн саналыг ерөнхий инженерт бичгээр илтгэнэ.

### **Нисэхийн техникийн засвар**

228. Нисэхийн техникийн засвар гэдэг нь нисэхийн техникийн бүрэн, бүтэн байдал, ажиллах чадварыг сэргээхээр хийгдэж буй иж бүрэн ажил юм. Засварын ажлыг нисэхийн засварын үйлдвэр /НЗҮ/-ийн явуулын хэсэг болон байгууллагын засварын газар /ТАА/-ын бие бүрэлдэхүүний хүчээр гүйцэтгэнэ. Байгууллагад дунд /урьдчилан сэргийлэх/, урсгал, жижиг засварыг хийж гүйцэтгэнэ.

229. Нисэхийн засварын газрууд дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- нисэхийн техникийн гэмтэл, доголдлыг шуурхай засварлах;
- мэдээ /бюллетень/-ний дагуу гүйцэтгэхээр заагдсан нисэхийн техникийн сайжруулалт;
- нисэхийн техникт хээрийн нөхцөлд засвар хийх хөдөлгөөнт хяналт засварын хэрэгсэл, багаж төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгах;
- газрын тоног төхөөрөмж, багаж түлхүүрийг засах, сайжруулах.

230. Нисэхийн техникийг засварлах үндсэн үйлдвэрлэл, техникийн бааз нь тусгай төхөөрөмж, хяналт-засварын хэрэгсэл, хяналт-шалгалтын аппаратур болон багажаар тоноглогдсон хөдөлгөөнт хяналт-засварын хэрэгсэл юм.

Хөдөлгөөнт хяналт-засварын хэрэгслийг техник ашиглалтын анги /ТАА/-ийн бүлгийн дарга нарт, эсхүл нисэхийн техникийн засварын үед түүнийг шууд хэрэглэгч мэргэжилтнүүдэд хариуцуулна. Хөдөлгөөнт хяналт-засварын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зориулалтын бус зүйлд ашиглахыг хориглоно.

231. Хөдөлгөөнт хяналт-засварын хэрэгсэл нь ашиглагдаж

байгаа нисэхийн техникийг засварлахад байнга бэлэн, бүрэн бүтэн тоног төхөөрөмж, багажны иж бүрдэлтэй, агаар, төмөр замаар тээвэрлэхэд байнгын бэлэн байна.

232. Хөдөлгөөнт хяналт-засварын хэрэгсэл, түүний тоног төхөөрөмжийг засварлуулах ажлыг засварын баримт бичгийн шаардлагын дагуу ерөнхий инженер зохион байгуулна. Хөдөлгөөнт хяналт-засварын хэрэгслийг хариуцагч нь тусгай зориулалтын машины гүйлт, тоног төхөөрөмжийн ажилласан цагийн тооцоог хөтөлнө.

233. Засварын газрын инженерийн албаны бие бүрэлдэхүүн нисэхийн техникийн засварыг хийж гүйцэтгэхэд бэлтгэгдсэн байна. Засварын сургалтыг төлөвлөн явуулна.

234. Засварын газар нисэхийн техникийн засварын төлөвлөлтийг жил, сараар хийж, дараах үндсэн дээр явуулна. Үүнд:

- нисэхийн техникийг засварт өгөх тооцоо;
- засварын ажлын гүйцэтгэлийн цаг хугацааны хэм хэмжээ;
- хөдөлмөр зарцуулалтын гүйцэтгэл.

235. Нисэхийн засварын газрын бие бүрэлдэхүүн нь засварын ажлыг бүлгийн даргын үүргээр гүйцэтгэнэ. Үүрэгт ажлын хэлбэр, гүйцэтгэх арга, хугацаа, техникийн аюулгүйн шаардлага, хяналт шалгалтын аргыг заана. Хэрэв ажлын нэг хэсэгт хэд хэдэн мэргэжилтнүүд ажиллаж байвал дотроос нь ахлагчийг томилно. Даалгагдсан ажлын чанар, бүрэн гүйцэтгэлийг гүйцэтгэгч өөрөө, мөн түүний ажилд хяналт тавигч хариуцна.

236. Бүлгийн дарга, техникч, ахлах механикчийн нисэхийн техникийн задаргаа, засвар, угсралт болон агрегат, зангилааны туршилтын шатанд явуулж буй үечилсэн хяналт, шалгалт нь засварын чанарт тавих хяналтын үндсэн хэлбэр болно.

237. Засварын газар, үйлдвэрийн явуулын хэсэг нь ерөнхий инженерийн мэдэлд ажиллана.

Хэсгийн засварын ажлын гүйцэтгэлийн зохион байгуулалтыг ерөнхий инженер, харин ажлын гүйцэтгэлийн чанарыг хэсгийн дарга хариуцна.

### **Зорилгот үзлэг, шалгалт**

238. Зорилгот үзлэг, шалгалтыг нисэхийн техникийн агрегат,

систем, механизм ба бүтцийн элемент тус бүрийг нарийвчлан шалгах зорилгоор хийнэ.

239. Зорилгот үзлэг, шалгалтын багтаамж, дэс дараалал, явагдах хугацааг ерөнхий инженер, эсхүл ахлах дарга нар тодорхойлно. Зорилгот үзлэг явуулах удирдамж гаргагч нь түүний зорилго, гүйцэтгэлийн технологийг зааж өгнө.

240. Ерөнхий инженер нь зорилгот үзлэгийг явуулахад оролцох бие бүрэлдэхүүнд гүйцэтгэлийн технологийг шууд нисэхийн техник дээр үзүүлж, зааварчилгаа зохион байгуулна.

241. Гүйцэтгэгч нь зорилгот үзлэг, түүний үр дүнгийн тухай дутагдлын тооцооны дэвтэр (онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх)-т тэмдэглэнэ.

### **Онгоц паркийн өдөр**

242. Онгоц паркийн өдрөөр техникийн зорилгот үзлэг, онгоц /нисдэг тэрэг/-ны байлдааны ижийн ерөнхий байдал, арчлалтыг шалгах, нисэх бүрэлдэхүүний техникийн үзлэг, бие бүрэлдэхүүнийг цугларах дохиогоор ажиллуулах дадлага, сургалт хийх, нисэх болон техникийн бүрэлдэхүүний дадлага, газрын тоног төхөөрөмж болон хянан шалгах аппаратуруудын арчлалтыг шалгах зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

Онгоц паркийн өдрийг нислэгийн урьдчилсан бэлтгэлийн өмнөх өдөр явуулна. Онгоц паркийн өдөр нислэг, нисэхийн техникийн урьдчилсан бэлтгэл, аж ахуйн ажил зохион байгуулахыг хориглоно.

Онгоц паркийн өдрийг сард хоёроос доошгүй удаа явуулна.

243. Ерөнхий инженер нь онгоц паркийн өдрийн ажлын төлөвлөгөөг урьдчилан хийж, байгууллагын дарга /захирагч/-аар батлуулна.

Онгоц паркийн өдөр нисэх, инженер техникийн бүрэлдэхүүн бүгд хамрагдана.

244. Хэвшүүлэх ажил хийлгэхээр ТАА-д орсон онгоц /нисдэг тэрэг/-нд паркийн өдрийг ТАА-ийн бие бүрэлдэхүүн гүйцэтгэнэ.

245. Онгоц паркийн өдрийн үеэр НИА-ны бие бүрэлдэхүүний ажиллагааг удирдуулахаар жижүүрийн инженерийг томилно.

Онгоц паркийн өдрийн төгсгөлд техникийг бэлэн байдалд оруулж, паркийн өдрийн төлөвлөгөөний биелэлтийн үр дүнгийн

талаар техникийн яриа хийнэ.

### **Нисэхийн техникийг өвөл /зун/-ийн улирлын ашиглалтад бэлтгэх**

246. Нисэхийн техникийг өвөл /зун/-ийн улирлын ашиглалтад шилжүүлэх үед бие бүрэлдэхүүний болон нисэхийн техникийн зохих бэлтгэлийг хангуулна.

247. Бие бүрэлдэхүүн болон нисэхийн техникийн өвөл /зун/-ийн улирлын ашиглалтын бэлтгэлд дараах зүйлүүд орно. Үүнд:

- нисэхийн техникийг өвөл /зун/-ийн үед ашиглах онцлогоор бие бүрэлдэхүүнтэй хичээл /бага хурал/ явуулах;
- ерөнхий инженерийн заавраар нисэхийн техник дээр хийгдэх ажлууд;
- сургалт, үйлдвэрлэлийн баазын бэлтгэлийг хангах;
- бие бүрэлдэхүүний өвөл /зун/-ийн тусгай хувцасны хангалтад үзлэг явуулах.

248. НИА-ны ажлын үүрэг, төлөвлөлтийг ерөнхий инженер боловсруулна.

249. Байгууллагын дарга /захирагч/ нисэхийн техникийн тухайн улирлын үйлчилгээний төгсгөлд бие бүрэлдэхүүн болон нисэхийн техникийн бэлэн байдлыг шалгаж, дүн гаргана.

### **Гэмтэл /дефектоскоп/-ийн хяналт**

250. Гэмтлийн хяналтыг онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийн инженер хариуцна.

Гэмтлийн хяналтын хэрэгслийн бүрэн, бүтэн байдал, түүнийг хэрэглэх мэргэжилтнүүдийн бэлтгэл, ажлын байрны тоног төхөөрөмж, технологийн баримт бичгийн иж бүрдэл болон нарийн эд ангийн гэмтлийн хяналтыг онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийн хэвшүүлэх ажлын бүлэг /засварын газарт үйлдвэрлэлийн/-ийн дарга шууд хариуцна.

251. Байгууллагын засварын газар /ТАА/ бүрт гэмтлийн шинжилгээ хийх газар /лаборатори/ байгуулах бөгөөд тэнд бүх хэрэгсэл буюу гэмтлийн хяналтад байдаг нисэхийн техникийн нарийн эд ангийн жагсаалт, хяналт явуулах эд ангийн технологийн карт, арга зүйн гарын авлага, нисэхийн техникийн эд ангиудад хяналтыг чанартай явуулахад шаардагдах тоног төхөөрөмжүүд

байна.

252. Гэмтлийн засвар, тохируулга хийх, эд ангийг шалгах болон туршилт явуулах ажлын байр төхөөрөмжилнө.

253. Хэвшүүлэх ажил болон зорилгот үзлэг явуулах үед гэмтлийн хяналтын хэрэгслийг ашиглан нарийн эд ангид хяналт тавих зорилгоор 2-4 хүн бэлтгэгдсэн байна. Тухайн мэргэжилтнүүдэд байгууллагын дарга /захирагч/-ын тушаалаар эд анги шалгах эрхийг олгож, жил бүр сунгана.

254. Гэмтлийн хяналтыг хариуцагч нарын цугларалтыг жил бүр зохион байгуулна. Цугларалтаар хяналтын аргын физикийн үндэс, нисэхийн техникийн нарийн эд ангийн хяналтын технологийг судалж, гэмтлийн хэрэгслийн хэрэглээний үр дүн болон хяналт, зохион байгуулалтын асуудлаар туршлага солилцоно.

255. Гэмтлийн хяналтын хэрэгслийн байдал, түүний хяналтын технологи, тоноглолын талаарх бие бүрэлдэхүүний мэдлэгийг онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийн инженер жилд нэгээс доошгүй удаа шалгана.

### **Нисэхийн техникийн хадгалалт**

256. Хадгалалтад ажиллагаатай, иж бүрэн нисэхийн техникийг тавина.

257. Хадгалалтын хугацааг дараах байдлаар тогтооно. Үүнд:

- богино хугацааны /нэг сараас нэг жил хүртэлх/;
- урт хугацааны /нэг жилээс дээш хугацаагаар/.

258. Нисэхийн техникийн хадгалалт нь хамгаалалтад бэлтгэх, битүүмжлэн хадгалах, хадгалалтын явцад хийх ажил, хадгалалтаас гаргах, нисэхийн техникийг зориулалтаар нь ашиглахад бэлтгэх зэрэг дэс дараалалтай байна.

259. Хадгалалтад шилжүүлж байгаа онгоц /нисдэг тэрэг/ нь орон тооны, иж бүрэн тоног төхөөрөмжтэй, газрын үйлчилгээний хэрэгсэл болон багажтай, бүрэн бүтэн, ажиллагаатай байна.

260. Удирдах байгууллагын даргын зааврыг үндэслэж, байгууллагын дарга /захирагч/-ын тушаалаар урт хугацааны хадгалалтад тавьж буй нисэхийн техникийн тоог тогтооно. Байгууллагын дарга /захирагч/-ын тушаалд нисэхийн техникийн нэр, тоо, дугаар, хадгалах байдал, бэлтгэлийн хугацаа, материалын

хангалт, нисэхийн техникийг хадгалалтын хугацаанд хариуцах хүний овог, нэр болон хадгалах журмыг заасан байна.

261. Нисэхийн техникийг хадгалалтад тавих үед үечилсэн үзлэг болон хадгалалт /консервац/ хийнэ.

Хадгалалт /консервац/ гэдэг ойлголтод тогтоосон хадгалалтын хугацаанд нарийн эд анги, зангилаа, механизм, тоноглолуудын зэврэлт, элэгдэлт, хуучралтаас хамгаалах иж бүрэн ажил багтана.

Хадгалалтын үеийн ажлын багтаамж, технологийг нисэхийн техникийн ашиглалтын зааврыг мөрдлөг болгон тогтооно.

262. Урт хугацааны хадгалалтыг тусгай төвд /бааз/ зохион байгуулах ба хадгалалтын ажлыг тусгай төвийн бие бүрэлдэхүүн гүйцэтгэнэ.

Байгууллагын дарга /захирагч/-ын тушаалаар томилогдсон техникийн бүрэлдэхүүн хадгалалтад байгаа онгоц /нисдэг тэрэг/-ны арчлалт, хамгаалалтыг хариуцна.

263. Байгууллагын инженер, техникийн бүрэлдэхүүн эдгээр хадгалалтанд байгаа онгоц /нисдэг тэрэг/-ыг агаарт нисгэж, шалгах бэлтгэлийг хангана.

Хадгалах тасгийн дарга нь онгоц /нисдэг тэрэг/-ыг хадгалах үеийн үечилсэн ажил болон шалгах ажлын хуваарийг боловсруулна.

264. Хадгалалтад байгаа онгоц /нисдэг тэрэг/-ыг тусгай бүсэд тараан, нуувч болон өнгөлөн далдалсан газарт байрлуулна. Онгоц /нисдэг тэрэг/ тус бүрийн өмнө хадгалалтын ээлжит ажил болон хадгалалтыг /консервац/ хийсэн хугацааг заасан тэмдэглэгээг тавина. Хэрэв онгоц /нисдэг тэрэг/ түр хугацаагаар бүрэн бус ажиллагаатай байсан бол тэмдэглэгээн дээр шалтгааныг заана.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ.**

### **Нисэхийн инженерийн албанд тавигдах нэмэлт шаардлага**

#### **3.1. Цэргийн тээврийн нисэх хүчин**

265. Цэргийн тээврийн НИА-ны ажлын үндсэн онцлог нь нислэгийн бэлтгэлийг байнгын байрлалаасаа алслагдсан аэродром дээр зохион байгуулдаг явдал юм.

Онгоц /нисдэг тэрэг/-ны нисэх багийн гишүүд нь байнгын байрлалаасаа алслагдсан аэродром дээр удаан хугацаагаар ажиллахад бэлтгэгдсэн байна. Үүнд:

- нислэгийн бүх төрлийн бэлтгэлийг хийх;
- эвдрэл, гэмтлийг засаж чаддаг байх;
- хөөрөлт, буулт, десант хаях үе дэх онгоц /нисдэг тэрэг/-ны жин болон төвлөрөлтийн тооцоог хийж чаддаг байх;
- нислэгийн инженер-штурманы тооцоо хийж чаддаг байх.

266. Онгоц /нисдэг тэрэг/-ны зөв ачаалалт, нислэгийн хүнд болон төвлөрөлтийн тооцоог нисэх багийн дарга хариуцна.

267. Цэргийн тээврийн НИА-ны шилжин байрлах журамд тэргүүн бүлэг болон нэг, хоёрдугаар цуврааны шуурхай бүлгийг урьдчилан зааж гаргасан байна.

Тэргүүн бүлэг нь манёврлаж буй аэродром дээр онгоц /нисдэг тэрэг/ хүлээн авч байрлуулах, тэдгээрийн техникийн байдлыг тодруулах, эвдрэл гэмтлийг арилгахад нисэх багийнханд туслах, онгоц /нисдэг тэрэг/ сумлах зэрэг ажлыг зохион байгуулна.

НИА-ны нэгдүгээр цуврааны бие бүрэлдэхүүн нь нисэх багийнхантай хамтран манёврлаж буй аэродромоос нисэх бэлтгэл явуулж, мөн гэмтэлтэй онгоц /нисдэг тэрэг/-нд урсгал засвар хийнэ. Тэргүүн бүлэг болон нэгдүгээр цувраанд ороогүй НИА-ны бие бүрэлдэхүүн хоёрдугаар цуврааг бүрдүүлэх ба ажил ихтэй засвар, техникийн хэвшүүлэх ажлыг хийж, нэгдүгээр цувраанд хүч нэмэгдүүлнэ.

268. Цэрэг болон байлдааны техник, ачаа зөөж, нэг аэродром дээр олон дахин буулт хийж байгаа нөхцөлд нислэгийн бэлтгэлийг НИА-ны шуурхай бүлгээр гүйцэтгүүлнэ.

269. Онгоц /нисдэг тэрэг/-нд хэрэглэдэг тээвэр-десантын тоноглолын иж бүрдэл, тусгай төхөөрөмжийг байгууллагын дарга /захирагч/-ын тушаалаар онгоц /нисдэг тэрэг/ нэг бүрт нь данслана. Онгоц /нисдэг тэрэг/-нд байрлуулахад зориулагдсан тоноглолын ижийг зогсоолын дотор, эсвэл түүний зогсоолын орчим чингэлэгт хадгална. Бусад тоног төхөөрөмжийг эвдрэл гэмтэлгүйгээр нисэхийн техникийн ангид хадгална.

Тээвэр-десантын тоноглолын иж, бүрэн бүтэн байдал, ажиллагааг болон ижийг онгоц /нисдэг тэрэг/-ны борттехникч хариуцна.

270. НИА-ны албан тушаалтан нь хариуцаж буй хүмүүсийг оролцуулан тээвэр-десантын тоноглолын иж бүрдэл, ажиллагааг

жилд хоёр удаа, мөн онгоц /нисдэг тэрэг/-ны эд ангийг хүлээлцэх үеэр шалгана.

271. Нисэх багийн бүрэлдэхүүн болон мэргэжилтнүүд тээвэр-десантын тоног төхөөрөмжийг ашиглалтад бэлтгэнэ. Онгоц /нисдэг тэрэг/-ны нисэх багийн дарга нь тээвэр-десантын тоног төхөөрөмжийн иж бүрдэл, зөв угсралт, ажиллах чадварыг заавал шалгаж үзнэ.

Тээвэр-десантын тоног төхөөрөмжийг цаг тухайд нь бэлтгэх ажлыг нисэх багийн дарга хариуцаж, бэлтгэлийн бүрэн хангалтыг онгоц /нисдэг тэрэг/-ны борттехникч хариуцна.

272. Онгоц /нисдэг тэрэг/-ны шаардлагатай захиалгыг тодруулахын тулд НИА нь тээвэрлэх ачааны тоо, овор хэмжээ, жингийн талаар штабаас тодотгоно.

273. Тээвэрлэлтийн үүргийг гүйцэтгэхийн тулд их бие, хөдөлгүүр, тэдгээрийн эд анги нь засвар хоорондын болон дараагийн хэвшүүлэх ажил хүртэлх нөөц сэлбэгтэй, төлөвлөсөн нислэгийг хангаж чадахуйц онгоц /нисдэг тэрэг/-ыг гаргана.

274. Ерөнхий инженерийн баталсан жагсаалт, хувилбарын дагуу техникийн аптек, газрын үйлчилгээний хэрэгслийг онгоц /нисдэг тэрэг/ тус бүрийн хийцэд тохируулан бүрдүүлж онгоц /нисдэг тэрэг/-нд ачна. Тэдгээр нь төлөвлөсөн хувилбарын дагуу бусад байлдааны ачаалалт хийхэд саад болохгүй байх ёстой.

275. Онгоц /нисдэг тэрэг/-нд ачаалалт хийх үед дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- ачих болон ачаанд татлага хийхэд зөвхөн онгоц /нисдэг тэрэг/-ны орон тоонд байгаа зориулалтын хэрэгслийг ашиглах;

- ачааны бүхээгт байрлуулахад тохиромжгүй /нийлэмжгүй/ аюултай ачаа ачихад;

- шингэн зүйлтэй савнууд нь эзлэхүүнийхээ 0,9 хувиас ихгүй дүүргэгдсэн, хоосон савнуудыг онгойлгосон /битүүмжийг алдагдуулсан/ эсэхийг мэдэх;

- онгорхой буюу битүүмж нь алдагдсан шингэний савыг ачихгүй байх.

276. Ачих, буулгах үед түүнийг удирдах мэргэжилтэнгээс өөр хэн нэгэн дохио өгөхгүй, харин хүн болон техник гэмтэж болох

аюулыг ажиглаж мэдсэн хүн “Зогс” дохиог өгч болно.

277. Бие бүрэлдэхүүн /өөрөө явагч техник/, хөлдөж царцдаг шингэн болон бусад хөргөх ёсгүй зүйлсийг тээвэрлэхэд шаардлагатай бол ачааны бүхээгийг халаана.

Нислэгийн явцад борттехникч /механикч/ нь хүмүүсийн биеийн байдал, тогтоогдсон хэв журам, ачааны татлага зэрэгт хяналт тавьж, нисэх багийн даргад байнга илтгэнэ.

278. Ачааг явуулж байгаа, эсвэл хүлээн авч байгаа байгууллагын хүмүүс нисэх багийнхны оролцоотой ачих, буулгах, татлага хийх, авах ажлыг гүйцэтгэнэ.

Нисэх багийн дарга нь ачих, буулгах болон ачаа /хүмүүс/-г онгоц /нисдэг тэрэг/-нд байрлуулах, аюулгүйн арга хэмжээнд хяналт тавина.

Онгоц /нисдэг тэрэг/-ны борттехникч нь ачаанд татлага хийх, авах, түүнийг зөв найдвартай татах ажлыг хариуцна.

Зорчигчид /десантчид/-ыг суулгах үед онгоц /нисдэг тэрэг/-ны борттехникч хамгийн сүүлд орж хаалгаа хаах бөгөөд буулгахад нь түрүүлж гаран, хөдөлгөөн үйлдэх аюулгүй чиглэлийг зааж өгнө.

279. Нислэгийн хүндийн төвлөрөлт, штурманы тооцоо хийгдээгүй, ачаа нь гүйцэд бус татлагатай онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гаргахыг хориглоно. Ачааны татлагыг онгоц /нисдэг тэрэг/ зогссоны дараа нисэх багийн даргын зөвшөөрлөөр авна.

280. НИА-ны шуурхай бүлэг, тэргүүн бүлэг байхгүй тохиолдолд онгоц /нисдэг тэрэг/ ганцаарчилсан тээвэрлэлт хийвэл ачаалалт, сумлалт, бэлтгэлийг нисэх баг гүйцэтгэнэ. Нислэгийн бэлтгэлийн багтаамж, түүний чанарт тавих хяналтыг нисэх багийн дарга хэрэгжүүлнэ.

Нисэх багийн гишүүдийн ажлын хуваарилалтыг ерөнхий инженер жагсаалтаар гаргаж, байгууллагын дарга /захирагч/ батална.

Нисэх багийнхан жагсаалтын дагуу хийх дадлагыг улиралд нэгээс доошгүй удаа гүйцэтгэнэ.

### **3.2. Галын дэмжлэгийн нисэх**

281. Нисэх экипаж нь ангиасаа алслагдсан нөхцөлд үүрэг гүйцэтгэх үедээ нислэгийн бүх төрлийн бэлтгэлийг бие даан хийж

чаддаг байх ёстой.

Нисдэг тэрэгний нислэгийн бэлтгэлийг техникийн ашиглалтын хэвшүүлэх ажлын зааварт заасан хэмжээгээр гүйцэтгэнэ. Нисэх экипажийн ажлын хуваарилалтыг ерөнхий инженер жагсаалтаар гаргаж, байгууллагын дарга /захирагч/ батална.

Нисэх экипаж хийх ажлын дадлагыг жагсаалтын дагуу улиралд нэгээс доошгүй удаа гүйцэтгэнэ.

282. Нисдэг тэрэгний зөв ачаалалт, цэнэглэлт, нислэгийн хүнд болон төвлөрөлтийн тооцоог нисэх багийн дарга хариуцна.

Нисдэг тэрэгний нислэгийн бэлтгэлийн хяналтын хуудас /нислэгт бэлтгэх дэвтэр/-ыг борттехникч хөтөлнө.

283. Тээвэр-десантын тоног төхөөрөмжийг хэрэглэхэд бэлтгэх, байрлуулах журам түүнчлэн бие бүрэлдэхүүн болон ачааг тээвэрлэх үед нисдэг тэрэгний багийн гишүүдийн гүйцэтгэх үйлдлийг энэ дүрмийн 269, 270, 275-282-г зааснаар гүйцэтгэнэ.

284. Нисдэг тэрэгний зэвсэглэл, харвах суурь, блокууд байнгын бэлэн байдалд байна. Анги шилжин байрлах үед харвах суурь, блокууд, зэвсгийг нисдэг тэргэнд байрлуулна. Байлдааны ажиллагааны явцад гүйцэтгэж буй байлдааны үүрэгт тохирсон зэвсэглэлээр цэнэглэнэ.

285. Үндсэн аэродромоос алслагдсан нөхцөлд бие даасан ажиллагааг өндөржүүлэх зорилгоор нисдэг тэрэг бүрт багаж түлхүүр, хяналт шалгалтын хэрэгсэл, нислэгийн бэлтгэл хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж бүхий техникийн аптек байхаас гадна, системийг нэмэлт цэнэглэлтээр хангахуйц тос, тусгай шингэний нөөцтэй явна.

Ерөнхий инженерийн баталсан жагсаалт, хувилбарын дагуу техникийн аптек, газрын үйлчилгээний хэрэгслийг бүрдүүлж, нисдэг тэргэнд ачна.

286. Түр буулт /хүлээлт/-ын талбайд нисдэг тэрэгний бэлтгэлийг үйлчилгээний бүлгийн бие бүрэлдэхүүн болон нисэх багийн гишүүдээс бүрдсэн тоотоор гүйцэтгэнэ.

287. Үйлчилгээний бүлэг тус бүр гэмтэл, дутагдал арилгах, урьдчилсан бэлтгэлийн багтаамжтай ажлыг хангахуйц иж бүрэн багаж, сэлбэг хэрэгсэл, зарцуулалтын материалтай байна.

288. Байлдааны ажиллагаа явагдаж буй бүсэд нисдэг тэрэгний давтан нислэгийн бэлтгэлийг нисэх экипаж гүйцэтгэнэ.

289. ТАА-ийн хөдөлгөөнт засварын бүлэг /агаарын хөдөлгөөнт/ нь нисэх багийнхны оролцоотойгоор алслагдсан нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа нисдэг тэргэнд хэвшүүлэх болон засварын ажлыг гүйцэтгэж болно.

290. Галын дэмжлэгийн нисэх хүчний анги, салбаруудын нисдэг тэргэнд хийх үзлэгийн хэм хэмжээг энэ зааврын 2 дугаар хавсралтаар үзүүлэв.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **Нисэхийн зэвсэглэл, цахилгаан, тусгай болон радиоэлектрон тоноглолын ашиглалтын онцлог**

#### **4.1. Ерөнхий шаардлага**

291. Хуваарилах төхөөрөмж /гал хамгаалагчийг оруулаад/-өөс эхлээд нисэхийн зэвсэглэл, радиоэлектрон тоноглол болон нисэх багийг аврах хэрэгслийн объектуудын цахилгаан хэлхээний эвдрэл, гэмтэлгүй байлгахыг инженер техникийн бүрэлдэхүүн хариуцна.

292. Онгоц /нисдэг тэрэг/-ны цахилгаан сүлжээний засвартай холбоотой бүх ажил болон чангалуурын /жгут/ жийргэвчийг өөрчлөх, дамжуулагчийг солихдоо цахилгаан, тусгай тоноглолын мэргэжилтнүүдийн хяналтан дор гүйцэтгэнэ.

293. Сүлжээний гэмтсэн дамжуулагчийг залгахдаа зөвхөн халуун гагнуурын тусламжтайгаар /хүчил хэрэглэлгүй/, эсвэл даралттай хүйтэн гагнуураар болон холбогч холхивчийн тусламжтай хийхийг зөвшөөрнө. Чангалуурын /жгут/ нэг огтлолцол дээр хэд хэдэн дамжуулагч залгаж гагнахыг хориглоно.

Хэлхээний шинэ хэсгийг зөвхөн бүтэн дамжуулагчаар тавина. Дамжуулагчийг солихдоо шинэ дамжуулагч утасны хөндлөн огтлолцол нь хуучныхтай адилхан байхаар авна.

294. Онгоц /нисдэг тэрэг/ болон хүчлэх байгууламж, тоног төхөөрөмж, зэвсэглэлийн агрегат, жижиг хэсгүүдийн саатуулгаас хамгаалах элементийн байдлыг тухайн агрегат, жижиг хэсгүүдийг ашиглаж байгаа мэргэжлийн техникч нар хариуцна.

295. Агаарын даралт хүлээн авагч /ПВД/-ийн дамжуулах хоолойн битүүмжлэл, тэдгээрт тавих хяналтыг цахилгаан тусгай тоноглолын мэргэжилтэн хариуцна.

Агаарын даралт хүлээн авагчийн бүрэн болон тогтонги даралт

авдаг төхөөрөмжийн байдал, битүүмжлэлийг тухайн системийг ашиглаж байгаа мэргэжлийн техникч хариуцна.

296. Агаарын даралт хүлээн авагч /ПВД/-д залгагддаг нисэхийн тоног төхөөрөмжид хамаарагддаггүй агрегатуудыг угсрах, салгахдаа тухайн мэргэжлийн техникч нисэхийн цахилгаан, тусгай тоноглолын бүлгийн даргад илтгэнэ.

Ажил дууссаны дараа дамжуулах хоолойн агрегатад залгасан чанар байдлыг нисэхийн цахилгаан, тусгай тоноглолын техникч хянана. Нисэхийн цахилгаан, тусгай тоноглолын техникч хянах самбарын ард хийгдсэн бүх ажил дууссаны дараа тэдгээрийг хааж, улмаар аэрометрийн багаж хэрэгслийн ажиллах чадвар, ПВД-гийн битүүмжлэлийг шалгана.

297. Онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүр, нисэхийн зэвсэглэл, радиоэлектрон тоноглолын системийн датчикиг угсрах, салгахыг тухайн системийг ашиглаж байгаа мэргэжилтэн хариуцна. Датчик болон түүний хэлхээний техникийн эвдрэл, гэмтэлгүй байдал, залгалтыг тухайн датчикиг эзэмшдэг мэргэжилтэн хариуцна.

298. Зөвхөн бага хүчин чадлын хэрэглэгчийг богино хугацаанд шалгах, түүнчлэн онгоц /нисдэг тэрэг/-ны ашиглалтын зааврын дагуу хөдөлгүүр асаах зорилгоор онгоц /нисдэг тэрэг/-ны зайн хураагуурыг ашиглахыг зөвшөөрнө.

299. Хэрэглэлийн болон хүчилтөрөгчийн тоног төхөөрөмжийн мэргэжилтэн нь оньст харвуулын төхөөрөмжид тавигддаг хүчилтөрөгчийн багаж хэрэгсэл, автоматуудын хэвшүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

Мөн хүчилтөрөгчийн системийн харилцааны нэгдсэн салгах хэсгүүдийн байдал, оньст харвуулын төхөөрөмжийг онгоц /нисдэг тэрэг/-ны агаарын даралт хүлээн авах системд залгахыг хариуцна.

300. Түлш, тос, шингэн, агаарын болон хүчилтөрөгчөөр тэжээх системийн харилцааны шугамыг холбох, түүнчлэн хүчний байгууламжийн удирдлагын элементийг салгах, залгахтай холбоотой хүчний байгууламжийн удирдлагын цахилгаан системийн агрегатуудыг угсрах, задлахыг онгоц, хөдөлгүүрийн мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

301. Цахилгаан тоног төхөөрөмжийн мэргэжилтнүүд залгавчийн

залгуурыг салгах, залгах, тэдгээрийг лацдах, түүнчлэн хүчний байгууламжийн удирдлагын систем, агрегатуудын цахилгаан хэмжигдэхүүнийг шалгана.

302. Онгоц хөдөлгүүрийн мэргэжилтнүүд хүчилтөрөгчийн редуктороос хойшхи хүчилтөрөгчийн тэжээлийн харилцах шугам, цахилгааны бус байгууламжийн байдлыг хариуцна.

303. Онгоц /нисдэг тэрэг/ хөдөлгүүрийн мэргэжилтнүүд онгоц /нисдэг тэрэг/-ны удирдлага, хүчлэх болон тасралт, суултын төхөөрөмж, түлш, тос, агаарын системийн удирдлагад байдаг цахилгааны, цахилгаан шингэний, цахилгаан агаарын агрегат, заагуур, хүлээн авагч, дохиологчийг угсрах, задлах ажлыг гүйцэтгэнэ. Дээр дурьдсан агрегатын цахилгааны чангалуур, тусгай дамжуулагчийг задлах, салгахыг нисэхийн цахилгаан, тусгай тоноглолын техникч гүйцэтгэнэ.

304. Онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийн мэргэжилтнүүд онгоц /нисдэг тэрэг/ болон хүчлэх байгууламжийн удирдлагын эд ангийн төгсгөлийн салгагчуудад үйлчилдэг шахагч байгууламж, хүчний тохируулгыг гүйцэтгэнэ. Тохируулга хийсний дараа онгоц, хөдөлгүүрийн мэргэжилтнүүд цахилгаан тоноглолын техникчтэй хамтран төгсгөлийн салгагчуудын ажиллах чадварыг шалгана.

305. Нисэхийн цахилгаан, тусгай тоноглолын хэвшүүлэх ажлын бүлгийн мэргэжилтнүүд радиоэлектрон тоноглолын бүтэц /бүрэлдэхүүн/-д хамаарах тусгай агрегат, блокын маягаар ордог фоторегистратор, цахилгаан хувьсгагч, өндөр, хурдны заагуур болон чиглэл, солбицол заагчийн хэвшүүлэх ажил, засварыг гүйцэтгэнэ. Радиоэлектрон тоноглолын системд ордог шингэний болон шингэний хөргөлтийн систем, хий шахагч /наддув/-ийн агрегатуудын хэвшүүлэх болон засварын ажлууд болон онгоц /нисдэг тэрэг/-ны ерөнхий системд залгагддаг агрегатууд, дамжуулах хоолойн угсрах, задлах ажлыг онгоц, хөдөлгүүрийн хэвшүүлэх ажлын бүлгийн мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

Дээрх ажлыг гүйцэтгэсний дараа радиоэлектрон тоноглолын системийн ажиллах чадвар, битүүмжлэлийг шалгах, гүйцэтгэлийг тооцож бүртгэхийг радиоэлектрон тоноглолын мэргэжилтнүүд хариуцна.

306. Радиоэлектрон тоноглол, нисэхийн зэвсэглэл хэрэгслийн фоторегистраторын соронзон хальс, мэдээллийн бичлэг бүхий туузтай дамруудыг газрын боловсруулах байранд авчрах, эргүүлж хүргэхийг захирагчийн тушаалаар томилогдсон мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

307. Онгоц /нисдэг тэрэг/-нд зүүлтэй байгаа болон нуувчинд байрлуулсан чингэлэг, нисэхийн хөнөөх хэрэгслийн хадгалалт, хамгаалалтыг онгоцны техникч хариуцна.

308. Оньст харвуулт суудлыг авах, тавих үед тэсрүүлэгчийн хэлхээний цоожлогчийг цаг тухайд тавих, авах ажиллагааг онгоцыг ослын үед орхих системийн бүлэг /САПС/-ийн мэргэжилтнүүд хариуцна.

309. Нислэгийн жолоодлого болон сургалтын суурин төхөөрөмж ашиглалтыг суурин төхөөрөмжийг бэлтгэх үйлчилгээний тусгай бүлгүүд хариуцна.

Тусгай бүлгийн бүрэлдэхүүнд нисэхийн цахилгаан, тусгай тоноглолын, тооцоолон бодох техникийн, радиолокацийн мэргэжилтнүүд багтана.

Эдгээр сургалтын суурин төхөөрөмжийн ашиглалт, байнгын бэлэн байдлыг электрон автоматикийн болон тооцоолон бодох байгууламжийн инженерүүд хариуцна. Нисэх болон инженер, техникийн бүрэлдэхүүнийг сургах тусгай зориулалтын сургалтын суурин төхөөрөмжийг мэргэжилтнүүд хариуцаж ашиглана.

310. Онгоц /нисдэг тэрэг/-ны зэвсэглэл, цахилгаан, тусгай тоноглол болон радиоэлектрон тоноглолын төхөөрөмж дээрх бүх төрлийн хэвшүүлэх ажил, засвар, тохируулгыг хийхдээ бие бүрэлдэхүүнийг өндөр хүчдэлд цохиулах, тусгай генераторуудын цацрагаас хамгаалах аюулгүйн арга хэмжээг авсан байна.

Байрны хана, туургыг гэгээтэй тосон будгаар, шалыг линолеум юмуу будгаар будаж бүрсэн байна. Ажлын байрны 10-15 м2 тутамд нэг чийдэн байхаар тооцоолно. Ажлын ширээний гадна талыг ялтаслаг материалаар бүрсэн байна. Ажлын хувцас солих байрыг ажлын байрнаас тусдаа байрлуулна. Ажлын байранд өвөл 15-20 хэм дулаан байх ёстой. Ууршсан хүчил, шүлт зэрэг хортой хольц агаарын найрлагад байлгахыг хориглоно.

## 4.2. Нисэхийн зэвсэглэлийн ашиглалт

311. Нисэхийн зэвсэглэлд дараах зүйлс орно. Үүнд:

- нисэхийн хөнөөх хэрэгсэл;
- гарааны хурдасгуур болон пиропатрон;
- нисэхийн хараалах систем;
- нисэхийн зэвсэглэлийн суурин хэрэгсэл;
- нисэхийн зэвсэглэлийг удирдах систем;
- нисэхийн зэвсэглэлийн техникийн ашиглалтын газрын хэрэгсэл.

312. Нисэхийн зэвсэглэлийн хөнөөх хэрэгсэлд: Байлдааны төрөл бүрийн бөмбөг, удирдлагатай хөнөөх хэрэгслүүд /удирдлагатай пуужин, нисэхийн торпед, түүний элементүүд/, удирдлагагүй хөнөөх хэрэгслүүд /удирдлагагүй пуужин, их буу, буудлагын зэвсэглэл, нисэхийн төрөл бүрийн бөмбөгнүүд, гранатомёт, шатаагч хэрэгслүүд/, удирдлагагүй пуужин, нисэхийн шатаагч бак, мин, агаарын их бууны сум, пулемёт, гранат, тэдгээрт хамаарах хэрэгслүүд/ хамаарна.

313. Гарааны хурдасгуур болон пиропатроны төрөлд: дохионы пуужин, цахилгаан тэсрүүлэгч, дохионы утаа гаргагч, бусад бялтат техник хэрэгслүүд хамаарна.

314. Нисэхийн хараалах системд төрөл бүрийн цахилгаан тооцоолон программчлагч төхөөрөмж, ердийн болон электрон, телевизийн, хэт ягаан туяаны дуран хараа, дулааны пеленгатор, байг илрүүлэн алслалтыг тодорхойлогч тусгай станц, блокууд хамаарна.

315. Агаарын их буу, пулемётыг байрлуулах зориулалт бүхий төхөөрөмж, пуужингийн харвагч сууриуд, удирдлагагүй тийрэлтэт сумны блокууд болон байлдааны бөмбөг баригч, идэвхгүй саатуулгын төхөөрөмж, десант-тээврийн болон чирэгч хэрэгсэл, хөнөөх хэрэгслийг ачих, тэдгээрийг байлдааны нөхцөл байдалд шилжүүлэгч механизм, агрегатууд нь нисэхийн зэвсэглэлийн суурин хэрэгсэлд орно.

316. Удирдлагатай хөнөөх хэрэгслийн байг заагч ба чиглүүлэгч биеэ даасан системүүд, тэсрүүлэгчийг удирдах системүүд, удирдлагын хэрэгсэл, хөнөөх хэрэгслүүдийг тэжээгч бие даасан системүүд, хөнөөх хэрэгслийн хаялт, буудалт, харвалтын удирдлагын

тооцоог хийгч, тооцоолон программчлах төхөөрөмжүүд, фото хяналтын хэрэгсэл, нисэхийн зэвсэглэлийн систем, агрегатуудын ажиллагаанд хамаарах блокууд нь нисэхийн зэвсэглэлийг удирдах системд хамаарна.

317. Удирдлагатай хөнөөх хэрэгслийг хянах, бэлтгэх төхөөрөмж, хөнөөх хэрэгслийн зүүгч, өргөгч механизмууд, зэвсэглэлийн агрегатуудыг тээвэрлэх, хадгалахад зориулсан тусгай чингэлэгүүд, нисэхийн зэвсэглэлийг хэрэглэхэд бие бүрэлдэхүүнийг дадлагажуулахад зориулагдсан хэрэгсэл, дадлагажуур нь нисэхийн зэвсэглэлийн техникийн ашиглалтын газрын хэрэгсэлд багтана.

318. Нисэх экипаж онгоц /нисдэг тэрэг/-ны зэвсэглэлийн бэлэн байдал, хөнөөх хэрэгслийн зөв цэнэглэлт, тэдгээрийн тэсрүүлэгчийг нислэгийн үүрэгт тохирсон эсэхийг нислэгийн өмнө шалгана.

319. Нисэх багийн дарга нислэгийн үүргийн дагуу онгоц /нисдэг тэрэг/-ны бөмбөгдөгч зэвсэглэлийн бэлэн байдал, тоо, тэсрүүлэгчийн иж бүрдэл, удирдлагын механизмын холболт зөв эсэхийг шалгана.

320. Нисэхийн хөнөөх хэрэгслийн байлдааны ижийн нөөц, тэдгээрийн бүрдэл, бэлэн байдлын зэрэг, хадгалах журмыг дарга /захирагч/-ын холбогдох тушаалаар тогтооно.

Байлдааны иж гэж орон тоонд байгаа онгоц /нисдэг тэрэг/-ны тактик-техникийн өгөгдөхүүнд тохируулан нэг удаа хамгийн их хэмжээгээр цэнэглэх нисэхийн хөнөөх хэрэгсэл /пуужин, бөмбөг, сум г.м./-ийн тоо хэмжээг хэлнэ.

321. Нисэхийн хөнөөх хэрэгслийн нэгдүгээр иж ангийн бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу онгоц /нисдэг тэрэг/-ны нэг удаагийн байлдааны нислэгт зориулагдана. Нэгдүгээр ижийн хадгалалт, хамгаалалтын зохион байгуулалт, онгоц /нисдэг тэрэг/-ыг цэнэглэх хувилбарыг ангийн захирагч тогтооно. Нисэхийн бусад хөнөөх хэрэгслийн байлдааны иж /нөөц/-ийн хадгалалт, хамгаалалт, бэлэн байдлын тогтоосон зэрэгт байлгах асуудлыг зэвсэглэлийн инженер хариуцна.

322. Зэвсэглэлийн инженер нэгдүгээр ижийн техникийн бүрэн бүтэн байдал, ажиллагаа, бэлэн байдлын тогтоогдсон зэрэгт байлгах асуудлыг хариуцна. Нисэхийн зэвсэглэлийн агуулахад хадгалагдаж байгаа байлдааны ижийн техникийн бүрэн бүтэн байдалд хяналт

тавина.

323. Пуужин урьдчилан бэлтгэх байранд тухайн бүлгийн дарга нисэхийн хөнөөх хэрэгслийн нэгдүгээр ижийн паспортын өгөгдөхүүн, бүрэлдэхүүний тооцоог хөтөлж явуулна.

Нэгдүгээр ижид байгаа сумнуудыг онгоцны формулярт бичнэ.

324. Байлдааны нэгдүгээр ижийг:

- удирдлагатай пуужин, бөмбөгийг онгоц /нисдэг тэрэг/ тараан байрлуулсан бүсэд, хамгаалалт бүхий тусгай хадгалах байранд тэргэнцэр дээр, ийм байргүй нөхцөлд онгоц /нисдэг тэрэг/-нд түргэн хүргэх тооцоотойгоор пуужин урьдчилан бэлтгэх байранд хадгална.

- удирдлагагүй пуужинг онгоц /нисдэг тэрэг/-ны ойролцоо эсвэл нуувчинд тэргэнцэр, тавиур дээр; пуужингийн тэсрүүлэгчийг хийж, блоконд нь цэнэглэх буюу зориулалтын хайрцагт хийж хадгалж болно.

- бөмбөг, шатаагч бакуудыг хамгаалалтын хайрцагт эсвэл тусгай тавиур, зөөврийн өргөгч тэргэнцэр дээр онгоц /нисдэг тэрэг/-ны ойролцоо хадгална.

- онгоц /нисдэг тэрэг/-нд байрлуулаагүй сумнуудыг дайзалж, онгоц /нисдэг тэрэг/ тус бүрт зориулсан хайрцагт хийн, тусгай тоноглон байр /чиргүүл/, эсвэл агуулахад хадгална. Хайрцаг тус бүр дээр сумны тоо, марк, онгоц /нисдэг тэрэг/-ны дугаарыг бичнэ. Зэвсэглэлийн бүлгийн дарга бөмбөг, пуужингийн тэсрүүлэгч, сум болон удирдлагагүй пуужинтай хайрцгийг лацдана.

325. Нэгдүгээр ижийн техникийн байдал, иж бүрдлийн шалгалтыг сард нэгээс доошгүй удаа бүлгийн даргын удирдлагаар хийнэ. Нисэхийн галт хэрэглэлийн зориулалтыг тооцох дэвтэрт үзлэгийн дүнгийн талаар бичнэ. Нисэхийн зэвсэглэлийн инженер байлдааны нэгдүгээр ижийн техникийн бүрэн бүтэн байдлыг улиралд нэгээс доошгүй удаа биечлэн шалгана.

326. Нисэхийн хөнөөх хэрэгслийг онгоц /нисдэг тэрэг/-нд зүүх, зөөж авчрахад ашигладаг механик хэрэгслийг нуувчинд буюу тусгай байранд хадгална. Өргөгч төхөөрөмжийг тогтоосон бүрдэлтэйгээр онгоц /нисдэг тэрэг/ тус бүрт байлгана.

327. Байлдааны бэлтгэлийн зориулалттай нисэхийн хөнөөх хэрэгслийн нөөц нь нэг өдрийн нислэгийн үүрэг гүйцэтгэх

хэрэгцээнээс давах ёсгүй бөгөөд байлдааны ижээс тусдаа байна.

Нислэгийн өдөр /шөнө/ дууссаны дараа зарцуулаагүй нисэхийн хөнөөх хэрэгслийг хүлээлцэх дэвтэрт гарын үсэг зуран, агуулахад буцааж өгнө.

328. Байлдааны бэлтгэлд зориулсан ижийг байнга сэргээн шинэчлэж, үндсэн үзүүлэлтээрээ хамгийн бага нөөц, үлдэгдэлтэй нисэхийн хөнөөх хэрэгслийг эхний ээлжинд зарцуулна.

329. Нисэхийн ангид дараах зүйлсийг хадгалахыг хориглоно:

- ашиглалтад байдаггүй, сургалтын зориулалтаас бусад хөнөөх хэрэгсэл;

- үйлдвэрт болон агуулахад угсрахдаа цэнэглэсэн блокноос харвах зориулалттай пуужингаас бусад тэсрүүлэгчийг нь тавьсан удирдлагагүй пуужин ба бөмбөг.

330. Нисэхийн хөнөөх хэрэгслийг албан байр, орон сууц, хичээлийн танхимд хадгалахыг хориглоно. Хичээлийн байранд зөвхөн сургуулийн зориулалттай, загвар зүсмэл хадгалахыг зөвшөөрнө.

331. Сургуулийн хөнөөх хэрэгслүүд нь тогтоогдсон тэмдэглэгээтэй байна. Үүнд:

- удирдлагатай пуужин хар зурвас бүхий бүслүүр дээр цагаан будгаар "сургуулийн" гэж бичсэн;

- удирдлагагүй пуужин их биеийг нь хараар будаж, дээр нь цагаанаар "сургуулийн" гэж бичсэн;

- бөмбөг гадна гадаргуу нь хар өнгөтэй, дээр нь цагаанаар "сургуулийн" гэж бичсэн;

- тэслүүрийн гадна тал нь цагаанаар будагдсан, толгойн хэсэгт нь "сургуулийн" гэж бичсэн;

- сумнууд үзүүр нь цагаанаар будагдсан, хонгио нь нүхтэй, бялт нь цохигдсон байна.

Дээрх тэмдэглэгдсэн зүйлс хийгдээгүй сургуулийн хөнөөх хэрэгсэл ашиглахыг хориглоно.

### **Удирдлагатай хөнөөх хэрэгсэл**

332. Удирдлагатай пуужин нь бэлэн байдлын зэргүүдэд холбогдох зааврын дагуу байлдааны ижийн бүрдэлд хадгалагдана.

333. Пуужин урьдчилан бэлтгэх байр /ПУББ/-ны бүх тоног

төхөөрөмж нь шалгагдсан, хэрэглэхэд байнгын бэлэн байх шаардлагатай. ПУББ-ын техник, хэрэгслийн байрлал нь найдвартай ажиллагаа, ажлын өндөр бүтээмжийг хангахаас гадна, богино хугацаанд хураах боломжтой байх ёстой.

334. ПУББ нь штаб, командын болон инженерийн албаны удирдлагын байр, галт хэрэгслийн агуулахтай байнгын утсан холбоотой байна.

335. Нисэхийн техникийн хангалтын салбар нь пуужинг дарга / захирагч/-ын тогтоосон хугацаанд зохих тоогоор нь олгоно.

336. Нисэхийн техникийн хангалтын салбар дараах зүйлсийг хариуцна. Үүнд:

- пуужин, түүний бүрдүүлэгч хэсгийг зохих зааврын дагуу агуулахад хадгалах;

- пуужингуудад техникийн хяналтын үечилсэн үзлэгийг зааварт заасан багтаамжийн дагуу хийж гүйцэтгэх;

- тогтоогдсон иж бүрдэлтэй, бүтэн хайрцагтай, техникийн баримт бичигт заагдсан, хадгалах болон хэрэглэх хугацаа нь дуусаагүй пуужинг олгох.

337. Агуулахад хадгалагдаж байгаа пуужингуудад хэвшүүлэх болон засварын зарим нэмэгдэл ажлыг ПУББ-ын бие бүрэлдэхүүний хүчээр гүйцэтгэх ба пуужинг цаг хугацаанд нь олгох асуудлыг аэродром, техникийн хангалтын салбарын дарга хариуцна.

338. ПУББ-ын дарга нь олгогдсон пуужинг бэлэн байдалд оруулж, баримт бичгийг бүрдүүлнэ. Хүлээн авах үед пуужин нь захиалгын дагуу, техникийн хяналтын үечилсэн үзлэг хийгдсэн эсэх, иж бүрдэл, хэрэглэх хугацааг шалгана.

Үзлэгийн үед дутагдал илэрсэн пуужинг хүлээн авахгүй.

339. Удирдлагатай пуужинд хийх хэвшүүлэх ажлыг урьдчилан төлөвлөнө.

340. Хэвшүүлэх ажлын үеийн шалгалтын дүнг пуужингийн формуляр, хэмжигдэхүүнүүдийн хэмжилтийн үр дүнг тэмдэглэх дэвтэр, ПУББ-нд байгаа пуужингийн эд ангиудыг тооцооны болон хэвшүүлэх ажлын дэвтэрт тус тус хөтөлнө.

341. ПУББ-нд пуужин техник дээр ажиллах, түүнийг хадгалах, тооцоолох, түүнчлэн шилжүүлэх, буцааж авахдаа зохих зааврын шаардлагын дагуу тогтоосон баримт бичгийг хөтөлнө.

342. ПУББ-нд пуужинг бэлтгэх ажиллагааг тусгайлан бэлтгэгдсэн орон тооны, эсвэл сургаж дадлагажуулсан орон тооны бус бүрэлдэхүүн гүйцэтгэнэ. Орон тооны бус бүрэлдэхүүнийг захирагчийн тушаалаар томилж, дадлагыг сард нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

343. Пуужин бэлтгэх ажлыг ПУББ-нд технологийн хуваарийн дагуу ажлын өндөр бүтээмжийг хангасан байхаар зохион байгуулна. Хуваарийг дадлагын явцад тогтмол тодотгоно.

344. Ашиглалтын явцад илэрсэн пуужингийн гэмтлийг ПУББ-ны бүрэлдэхүүн эсвэл үйлдвэрийн бие төлөөлөгчид засварлах ба гэмтлийг засаж чадахгүй бол пуужинг байлдааны ижээс хасаж, хангалтын салбарт шилжүүлэн, засварт явуулна. Оронд нь шалгагдсан, ажиллагаатай пуужинг авч, байлдааны ижид оруулна.

345. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын зөвшөөрлөөр пуужингийн бэлэн байдлын зэргийг нь бууруулах буюу удаан хугацааны хадгалалтад шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд хийгдэх ажлын багтаамж, хадгалалтад шилжүүлэх дэс дараалал, хадгалах хугацаа, хэрэглэх боломжийг пуужингийн ашиглалтын болон хадгалах заавраар тодорхойлно.

346. Бэлэн болсон пуужинг зааврын дагуу нислэгийн үүрэг гүйцэтгэх онгоц /нисдэг тэрэг/-нд хүргэнэ.

347. Пуужинг онгоцны зогсоолын талбай руу зориулалтын тэргэнцэр, чирэгч машинаар тээвэрлэх үед өдөр улаан дарцгаар, шөнө улаан гэрлээр дохио өгч, дэлбэрэх аюултай ачаа авч яваагаа мэдэгдэнэ. Тэргэнцэртэй пуужин, сургуулийн пуужинг чирэгчээр тээвэрлэнэ. Чирэгчийн тэвшин дээр хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, пуужинг хүргэх дагалдагч байрлана.

348. Онгоц /нисдэг тэрэг/-нд авчирсан пуужинг нисэхийн зэвсэглэлийн үйлчилгээний бүлгийн дарга /техникч/, эсвэл пуужин зүүх тоотын ахлагч хүлээн авна.

Хүлээж авснаас хойшхи пуужин болон тэргэнцэрийн техникийн байдал, хадгалалт, хамгаалалтыг нисэхийн зэвсэглэлийн үйлчилгээний бүлгийн дарга, тоотын ахлагч хариуцна. Онгоц /нисдэг тэрэг/-нд зүүсний дараа техникч хариуцна. Онгоц пуужинтайгаар манёврлах, аэродром дээр буусан тохиолдолд түүний хамгаалалтыг

техникийн бүрэлдэхүүний ахлагч /онгоцны техникч/ хариуцна.

349. Пуужинг бэлэн байдалд байлгах, нислэгийн өмнө болон дараа хийх бүх төрлийн үзлэгийг нисэхийн зэвсэглэлийн үйлчилгээний бүлгийн бие бүрэлдэхүүн гүйцэтгэнэ.

350. Пуужингийн хэвшүүлэх ажлын хоорондох тогтоогдсон хугацаа гүйцсэн, чийгшилт ихтэй нөхцөлд хадгалсан, онгоц ширүүн газардсаны дараа пуужинг ПУББ-нд техникийн хэвшүүлэх ажил хийлгэхээр шилжүүлнэ. Нисэхийн зэвсэглэлийн үйлчилгээний бүлгийн дарга/техникч/ зохих баримт бичгийг бүрдүүлж шилжүүлнэ.

Хэвшүүлэх ажлын хугацаанд пуужинг ээлжийн бус журмаар шалгах шийдвэрийг зэвсэглэлийн инженер гаргана.

351. Онгоц /нисдэг тэрэг/-нд байгаа пуужингийн байдалд тавих хяналт, ажлын гүйцэтгэлийг онгоц /нисдэг тэрэг/-ны зэвсэглэлийн үйлчилгээний бүлгийн дарга хариуцна.

352. Шингэн түлштэй хөдөлгүүр бүхий пуужингийн ашиглалтын онцлог нь түүний түлшний хольцтой харьцах аюулгүйн тусгай арга хэмжээгээр тодорхойлогдоно. Шингэн түлштэй хөдөлгүүрийн түлшний хольцыг хангалтын салбар хариуцах ба пуужин цэнэглэх ажиллагааг ПУББ-ны бие бүрэлдэхүүн гүйцэтгэнэ.

353. Ашиглалтын явцад пуужин, түүний бүрэлдэхүүн хэсгийн нөөцийн зарцуулалтыг тооцох, хадгалах хугацаа, хөөрөлт, буултын тоо, ажилласан цагийг тогтмол хөтөлнө.

Бэлэн байдлын янз бүрийн зэрэгт байгаа пуужингуудын ашиглалтын хугацаа, хадгалах нөхцлийг пуужингийн ашиглалтын болон хадгалалтын заавраар тодорхойлно.

### **Удирдлагагүй хөнөөх хэрэгсэл**

354. Удирдлагагүй пуужин, бөмбөгийг онгоц /нисдэг тэрэг/-нд зүүсний дараа тэсрүүлэгчээр цэнэглэнэ. Онцгой тохиолдолд нислэгт бэлтгэх хугацааг багасгах зорилгоор зааварт зөвшөөрөгдсөн тохиолдолд бөмбөгийг тэсрүүлэгчээр, блокийг тийрэлтэт сумаар газарт цэнэглэж, онгоц /нисдэг тэрэг/-нд зүүхийг зөвшөөрнө. Тэсрүүлэгчид үзлэг хийх, бэлтгэх ажлыг тусгайлан бэлтгэсэн байранд явуулна. Үүнд:

- онгоцны нуувч, онгоцноос хол тусгайлан бэлтгэсэн талбай,

шороон далан, бөмбөг /тийрэлтэт сум/ бэлтгэх байранд;

- бие бүрэлдэхүүний байрлалаас 50 м-ээс багагүй зайд.

Тэсрүүлэгч бэлтгэх байрыг улаан дарцаг /улаан гэрэл/-аар тэмдэглэнэ.

355. Нисэхийн бөмбөг, удирдлагагүй тийрэлтэт пуужинг бэлтгэхэд эскадриль бүрт шаардлагатай механик хэрэгсэл, тусгай тавиур, хөнөөх хэрэгслийг бэлтгэх аргачлал, аюулгүйн арга хэмжээний зааварчилгаа бүхий тусгай талбайг төхөөрөмжилнө.

356. Нисэхийн бөмбөг, пуужинг цэнэглэхийн өмнө тэсрүүлэгч, бусад галт хэрэгслийн битүүмжилсэн хайрцгийг задална. Ингэхдээ өмнө нь задалж, хугацаа дуусах дөхсөн тэсрүүлэгч, бусад галт хэрэглэлийн элементүүдийг түрүүлж ашиглана.

357. Артиллерийн төхөөрөмжийн байлдааны ижид нэг үйлдвэрт, нэг онд, нэг ангилан үйлдвэрлэсэн, нэг хийцийн толгойтой сум байна. Жич: нэг хийцийн, хоёр ангилалын сум байхыг зөвшөөрнө. Блокуудыг нэг төрлийн тийрэлтэт сумаар цэнэглэнэ.

358. Доорх эвдрэл, гэмтэл бүхий сумтай дайз хэрэглэхийг хориглоно. Үүнд:

- сумны толгой нь хонгиондоо чөлөөтэй эргэлдэж байвал;
- хонгио нь хонхойсон байвал;
- хонгионы амны хэсэгт нүдэнд харагдахуйц цууралт гарсан байвал;
- тэсрүүлэгчийн мембран эргэсэн, эсвэл гэмтсэн байвал;
- тэсрүүлэгчийн мембран бэхлэгдсэн орчноор зэврэлт үүссэн байвал;
- баллистик хошуу ганхаж /холхиж/ байвал;
- дайзны үеүд нь сунасан, эсвэл цууралт гарсан байвал.

Сум ба дайзанд дээрх дутагдал илэрвэл байлдааны ижээс авч, устгах арга хэмжээ авна.

359. Зэвсэглэлийн инженер нь удирдлагагүй хөнөөх хэрэгслийн үйлдвэрлэгдсэн он, үйлдвэр, тодорхой ангилалыг харгалзан, тогтоосон маягтын дагуу ашиглах болон хязгаарлах тооцоог хөтөлнө.

360. Хэрэглэхийг хориглосон, эсвэл хэвийн бус ажиллагаатай удирдлагагүй хөнөөх хэрэгслийг ангийн байрлалд хадгалахыг хориглоно. Ийм хөнөөх хэрэгслийг нисэхийн техникийн хангалтын салбарт шилжүүлнэ. Удирдлагагүй хөнөөх хэрэгслийг /ашиглалтын

зааварт заагдсанаас бусад тохиолдолд/ нисэхийн ангид засварлахыг хориглоно.

### **Бялгат техникийн хэрэгсэл /пиропатрон/ ба гарааны хурдасгуур**

361. Нисэхийн техникийн хангалтын салбараас бялгат техникийн хэрэгсэл, тэсрүүлэгч хүлээж авах, ус, чийгийг шалгах ажлыг дараах албан тушаалтан гүйцэтгэнэ. Үүнд:

- онгоцны бүхээгийг хаях болон аврах системийг /САПС/ цэнэглэхэд аврах системийн бүлгийн дарга нар;
- радиоэлектрон тоноглол, гал унтраах систем, түлшний дүүжин бак болон бөмбөг хаях, их буу /пулемёт/, бусад системийг дахин цэнэглэхийг зэвсэглэлийн бүлгийн дарга нар;
- онгоцны төхөөрөмжийг бялгат техникийн хэрэгсэл, тэсрүүлэгчээр цэнэглэх /цэнэг авах/, тэдгээрийг ашиглах, солих, байнга бэлэн байлгахыг тухайн системийн мэргэжилтнүүд.

362. Бялгат техникийн хэрэгслийг цоожтой төмөр хайрцаг, эсвэл шүүгээнд лацдаж, хадгална. Эдгээр хэрэгслийг зөөвөрлөхдөө бие биенээ мөргөх, цохих, бялт авалцах зэргээс хамгаалж, тусгайлан зассан үүр бүхий төмөр хайрцаг хэрэглэнэ.

363. Гарааны хурдасгуурын ашиглалтын зааврыг үндэслэн, гарааны хурдасгуурыг хэрэглэхэд бэлтгэх, онгоцны системийг шалгах, онгоцонд зүүх ажиллагааг нисэхийн зэвсэглэлийн мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ.

364. Ашиглалтын үед онгоцны иж бүрдэлд ороогүй, түүнчлэн цэнэгийн агаарын дулаан нь хурдасгуурын ашиглалтын зааварт заасан хязгаарлалтаас хэтэрсэн гарааны хурдасгуур ашиглахыг хориглоно.

365. Хурдасгуур зүүхийн өмнө онгоцны газардуулгыг шалгаж, хурдасгуурын асаах хэлхээг салгасан байна.

### **Нисэхийн зэвсэглэлийг хэрэглэхэд бэлтгэх**

366. Цаг хугацаанд нь бэлдсэн нисэхийн галт хэрэглэлийг захиалгын дагуу онгоц руу хүргэх ажиллагааг нисэхийн хангалтын салбар хариуцна. Энэ үед сумнуудыг дайзалсан байна.

367. Хөнөөх хэрэгслийг зөвхөн үйлчилгээний зэвсгийн бүлгийн дарга нар үзлэг хийж, хүлээж авсны дараа онгоцонд цэнэглэнэ.

368. Зохих бэлтгэл, техникийн шаардлага хангаагүй нисэхийн хөнөөх хэрэгсэл хэрэглэхийг нисэхийн зэвсэглэлийн инженер хориглох ёстой.

369. Хэрэглэхэд зориулагдсан удирдлагатай пуужингуудын урьдчилсан бэлтгэлийг ПУББ-ны дарга, харин онгоцны бие даасан удирдах, чиглүүлэх системийн бэлтгэлийг нисэхийн зэвсэглэл, үйлчилгээний бүлгийн дарга нар хариуцна.

370. Нислэг үйлдэх гэж байгаа онгоц /нисдэг тэрэг/-ыг цэнэглэсэн нисэхийн хөнөөх хэрэгслийн тоо хэмжээ, паспортын өгөгдөхүүнийг онгоц бэлтгэх дэвтэрт бичиж тэмдэглэнэ.

371. Нислэгийн үүргийн дагуу зэвсэглэлийн хувилбарыг өөрчлөхдөө зэвсэглэлийг удирдах систем болон сууриудын ажиллагааг үндсэн ба нисэхийн хэлхээгээр шалгана.

372. Бэлэн байдлыг хангахын тулд нислэг дууссаны дараа онгоцны зэвсэглэл, бусад тоноглолыг захирагчийн тогтоосон хувилбарын дагуу бэлэн байдалд оруулна.

### **Артиллерийн зэвсэглэл болон төхөөрөмж**

373. Цэргийн тээврийн онгоц, нисдэг тэрэгний хөдөлгөөнтэй, хөдөлгөөнгүй артиллерийн төхөөрөмжийн зэвсэглэлийг цэнэглэх, байлдааны ижийг сэлбэх ажлыг нисэх багийн гишүүд гүйцэтгэнэ. Тухайн ажлын гүйцэтгэлийг нисэхийн зэвсэглэлийн үйлчилгээний бүлгийн дарга нар хянана.

374. Блок, харвах суурь, артиллерийн зэвсэглэлийн тосолгоо, цэвэрлэгээ, үзлэгийг:

- буудлагатай нислэгийн дараа;
- буудлагагүй нислэгийн үед техникийн байдлаас хамаарч, гэхдээ сард нэгээс доошгүй удаа;
- хадгалалтаас авах /гаргах/ үед;
- онгоц /нисдэг тэрэг/-нд хэвшүүлэх ажил хийх үед;
- зэвсэглэлд агаарын тунадас, бохир зүйл орсон тохиолдолд зэвсэглэлийн инженерийн заалтаар хийнэ.

375. Артиллерийн зэвсэглэлд дараах төрлийн цэвэрлэгээ хийнэ. Үүнд:

- задаргаагүй цэвэрлэгээ /зэвсэг сууринаас авагдахгүй/;

- хагас задаргаатай цэвэрлэгээ /зэвсэг сууринаас авагдаж, агрегат задаргаа хийгдэнэ/;

- бүрэн задаргаатай цэвэрлэгээ /зэвсэг сууринаас авагдаж, бүрэн хэмжээний задаргаа хийгдэнэ/.

376. Хагас задаргаатай цэвэрлэгээ нь буудлагатай, буудлагагүй нислэгийн дараах ээлжит цэвэрлэгээний үед хийгдэнэ.

Бүрэн задаргаатай цэвэрлэгээг:

- хадгалалтаас авах, гаргах үеэр;

- онгоцны техникийн ашиглалтын зааврын дагуу хийгдэх хэвшүүлэх ажлын үеэр;

- тодорхой тоо хэмжээтэй буудлагын дараагаар;

- нисэхийн зэвсэглэлийн инженерийн шийдвэрээр хийнэ.

Агаарын тунадас, бохир зүйл зэвсэгт орсон үед болон буудлагагүй нислэгийн дараа нисэхийн зэвсэглэлийн бүлгийн дарга нар цэвэрлэгээний төрлүүдийг тодорхойлно.

377. Буудлагын дараа тэр өдөртөө зэвсгийг цэвэрлэж тослох ба онцгой нөхцөлд дараах өдрөөс нь хэтрүүлэлгүйгээр уг ажиллагааг гүйцэтгэнэ.

378. Артиллерийн зэвсэглэлийг цэвэрлэх, үзлэг хийхэд нисэх бүрэлдэхүүнийг татан оролцуулна. Онгоц /нисдэг тэрэг/-ны хөдөлгөөнт төхөөрөмжийн зэвсгийн цэвэрлэгээ, тосолгоог зэвсэглэлийн мэргэжлийн хүмүүсийн оролцоо, хяналттайгаар нисэх багийн гишүүд гүйцэтгэнэ.

379. Зэвсгийг хэрэглээнд байнга бэлэн байлгахын тулд гол төмрийн сувгийг нимгэн тосолно. Хэрэв онгоц /нисдэг тэрэг/ нисээгүй бол нисэхийн зэвсэглэлийн үйлчилгээний бүлгийн даргын шийдвэрээр тосолгоог шинэчилнэ. Гэхдээ 7 хоногт нэгээс доошгүй удаа хийнэ.

380. Түгшүүр, цугларалтаар ажиллах үед нимгэн тосолгоотой гол төмрийн сувгийг арчихгүй байж болно. Сургуулийн буудлагатай нислэгийн үед заавал арчина. Гол төмрийн тосыг арилгахын тулд хоолойд нь сум байгаа эсэхийг заавал үзэж, шалгана.

381. Артиллерийн зэвсэглэлийг зэврэлтээс хамгаалах зорилгоор түүний сум, сумны туузыг тохирсон тосоор нь нимгэн тослохыг зөвшөөрнө.

382. Артиллерийн зэвсэглэлийг хэрэглэхээр нислэгт бэлтгэгдэж байгаа онгоцны зэвсэг нь агаарт гараад нэг удаагийн дахин цэнэглэлтийн дараа бэлэн болох ёстой. Агаарт дахин цэнэглэлт хийгддэггүй бууг буудахад бэлтгэж газарт цэнэглэнэ.

### **Нисэхийн авагддаг зэвсэглэл**

383. Нисэхийн авагддаг зэвсэглэлд далавчны баригчууд, харвах сууриуд, удирдлагагүй пуужингийн блокууд, их бууны контейнер, хөнөөх хэрэгслийн өгөгдсөн хувилбарын дагуу нэмэгдэж тавигдах бусад агрегат, төхөөрөмж, удирдлагатай пуужинг чиглүүлэгч сууриуд хамаарна.

384. Нэгдүгээр ижид хэрэглэхэд зориулагдсан нисэхийн авагддаг хэрэгслийг онгоц /нисдэг тэрэг/ тус бүрт нь данслан, формулярт бичиж хадгална. Тавигдсан үүрэг, иж бүрдлийг хадгалах нөхцлийг харгалзан нисэхийн авагддаг зэвсэглэлийг хэрхэн хуваарилж, хадгалуулах асуудлыг захирагч шийдвэрлэнэ. Нэгдүгээр ижид ороогүй нисэхийн авагддаг хэрэгслийг онгоц /нисдэг тэрэг/-нд тавихдаа түүний хяналтын хуудсанд тэмдэглэнэ.

385. Онгоц /нисдэг тэрэг/-нд тавигдаагүй авагддаг зэвсэглэлийг зориулалтын хайрцаг, чиргүүл, чингэлэгт хадгална. Хадгалалт нь шилжин байрлах үед тэдгээрийг тээврийн хэрэгсэлд ачих, онгоцонд түргэн хүргэх болон бүрэн бүтэн байлгах нөхцөл хангасан байх ёстой.

386. Нэгдүгээр ижид хийх хэвшүүлэх ажлыг зэвсэглэлийн техник үйчилгээний бүлэг тогтоогдсон хугацаанд нь гүйцэтгэнэ. Хэвшүүлэх ажилд авагддаг зэвсэглэл, түүний бүх төхөөрөмж, блок, агрегатыг хамруулж, тоо ширхэг, эдэлгээний байдлыг шалгана.

387. Хэвшүүлэх ажлын бүлэг нь хадгалалтад байгаа зэвсэглэлд хийгдэх хэвшүүлэх болон урьдчилан сэргийлэх ажлыг зэвсэглэлийн үйлчилгээний бүлгийн оролцоотойгоор баримт бичгийн дагуу тогтоосон хугацаанд нь гүйцэтгэнэ. Энэ зорилгоор уг ажлыг гүйцэтгэх төлөвлөлт, хуваарийг жилээр гарган, захирагчаар батлуулна. Төлөвлөлт, хуваарийн дагуу эд материалаар хангах, ажлын чанар, гүйцэтгэлийг зэвсэглэлийн инженер хариуцна.

388. Зэвсэглэлийн хувилбарыг өөрчлөх үед нисэхийн авагддаг

зэвсэглэлийн агрегат, төхөөрөмж, блокыг тавихын өмнө мөрдөж байгаа ашиглалтын зааврын дагуу үзэж шалган бэлтгэх ёстой. Энэ үед тэдгээрт зохих хэвшүүлэх ажлууд хийгдсэн эсэхийг шалгана. Онгоц /нисдэг тэрэг/-нд зүүсний дараа хянан шалгах хэрэгслийн тусламжтайгаар тэдгээрийн ажиллах чадвар, хаях хэлхээг цахилгаан гүйдэл өгч шалгана.

389. Онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх хугацааг богиносгох, бие бүрэлдэхүүний дадлагыг өндөржүүлэх зорилгоор сард нэгээс доошгүй удаа орон тооны бус тоотой нисэхийн зэвсэглэлийн хувилбараар дадлагыг явуулна.

### **Нисэхийн зэвсэглэлийн тогтоол буудлага, тохируулга**

390. Онгоцны зэвсэглэлийн тогтоол буудлага гэдэг нь бүх пуужингийн суурь, целийн солбицол хэмжилтийн төхөөрөмж /дулааны удирдлагатай чиглэлийг олох багажны дурант шагайврын төхөөрөмж, радиолокацийн станцын антенн г.м./-ийн тэнхлэгийн чиглэлүүд нь онгоцны зохих эд ангиудын тэнхлэгтэй шаардлагатай нарийвчлалтайгаар зохицуулагдахыг хэлнэ.

391. Тогтоол буудлагыг ашиглалтын зааврын дагуу нисэхийн зэвсэглэлийн үйлчилгээний бүлэг гүйцэтгэнэ. Нисэхийн зэвсэглэлийн тогтоол буудлагыг зэвсэглэлийн систем, онгоцны зохих эд ангиудын системийн тохируулгатай хамт нэгэн зэрэг хийнэ.

392. Зэвсэглэлийн системийн тогтоол буудлагыг техникийн ашиглалтын зааврын дагуу тогтоосон хугацаанд, түүнчлэн дараах тохиолдолд хийнэ. Үүнд:

- онгоцыг ангид шинээр ирэхэд /хүлээн авахад/;
- шагайврын болон илрүүлэгч төхөөрөмж, бүхээгний хуягт шил, их буу /пулемёт/-г сольсны дараа;
- зэвсэглэл байрлуулсан онгоц /нисдэг тэрэг/-нд агрегат сольсны дараа;
- зэвсэглэлийн байрлалд нөлөөлөх жижиг хэсэг, зангилаа, суурийг сольсон /зассан/-ы дараа;
- хэрэв ашиглалтын баримт бичигт заагдсан бол буу, зэвсэглэлийн харвах суурь, блок, бусад төхөөрөмж сольсны дараа;
- тогтоол буудлагын нарийвчлалд алдаа гарсан үед.

393. Зэвсэглэлийн тогтоол буудлагыг цаг хугацаанд нь

хийлгэхийг захирагч хариуцна. Тогтоол буудлагын зохион байгуулалт, гүйцэтгэлийн чанарт тавих хяналтыг зэвсэглэлийн инженер, нисэх багийн дарга хариуцна. Тогтоол буудлагыг нисэх багийн бүрэлдэхүүний оролцоотойгоор хийнэ. Тогтоол буудлага / тохируулга/ нь хугацаандаа хийгдээгүй онгоц /нисдэг тэрэг/-ыг гэмтэлтэй гэж үзнэ.

394. Онгоцыг хөдөлгөөнгүй байлгах төхөөрөмж дээр суурилуулсны дараа артиллерийн зэвсэглэлийн тогтоол буудлагыг халуун, хүйтэн аргаар хийнэ. Хүйтэн аргыг өнцөг хэмжигч багажийн тусламжтайгаар, халуун аргыг тусгай тоноглогдсон буудлагын талбайд буудаж хийнэ. Хөдөлгөөнтэй артиллерийн болон пуужингийн төхөөрөмж, фото хяналтын багажийн тогтоол буудлагыг дуран харааллын өнцөг хэмжигчийн тусламжтайгаар гүйцэтгэнэ.

Зэвсгийн шагайлтын солбицлын цэгийг онгоц /нисдэг тэрэг/-ны тогтоол буудлагын бүртгэлд бичиж, формулярт хадгална.

395. Хараалах системийн тохируулга, зэвсэглэлийн тогтоол буудлага бүрийн тухай формулярт бичиж уг ажлыг гүйцэтгэсэн мэргэжилтэн, нисэх багийн дарга гарын үсэг зурна.

396. Хараалах системийг ашиглах явцад тогтоогдсон аргачлалын дагуу тооцоолж, дүн шинжилгээ хийнэ.

### **4.3. Нисэхийн цахилгаан, тусгай тоноглолын ашиглалт**

397. Нисэхийн цахилгаан, тусгай тоноглолд дараах тоног төхөөрөмж хамаарна. Үүнд:

- цахилгаан тоног төхөөрөмж;
- хүчний байгууламжийн удирдлагын төхөөрөмж, цахилгаан систем;
- хэрэглэлийн тоног төхөөрөмж;
- өндрийн тусгай төхөөрөмж;
- гэрэл зургийн болон тагнуул, эрэл хайгуулын, дулааны төхөөрөмж;
- тусгай төхөөрөмж /радиотехникийн бус/;
- нисэхийн техникийн байдал, нислэгийн хэмжигдэхүүнийг бүртгэх хяналтын автомат систем /бүртгэн тэмдэглэгч хэрэгсэл/;
- жолоодлого, дадлага сургалтын суурин төхөөрөмжийн

цогцолбор /тренажер/.

398. Цахилгаан тоног төхөөрөмжид онгоц /нисдэг тэрэг/-ыг тогтмол ба хувьсах гүйдлээр хангах төвлөрсөн систем, түлшний болон шингэний системийн шахуургын төвлөрсөн систем, онгоцны хөөрөлт, буултын механикжсан байгууламжуудын цахилгаан дамжуулга, цахилгаан халаагуурын систем, битүүмжлэгдсэн хэсэг ба бүхээгийн агааржуулалтын цахилгаан төхөөрөмж, мөстөлт эсэргүүцэх төхөөрөмж, галын дохиоллын автомат систем, гал унтраах, галын аюулыг урьдчилан мэдээлэх систем, цахилгаан гэрэлтүүлгийн техникийн болон гэрлэн дохиоллын систем хамаарна.

399. Хүчлэх эд ангийн цахилгаан систем болон удирдлагын төхөөрөмжид: хүчлэх эд ангийн ажлын горимын удирдлага, асаах төхөөрөмж, агаарын сэнсийг флюгерт оруулах цахилгаан систем, турбины болон тосны халуун, хүйтний тохируулга, хязгаарлалт, турбины эргэлтийн үелзлийн тохируулга, оруулах байгууламжийн удирдах систем хамаарна.

400. Электрон автоматикийн төхөөрөмжид:

- автомат жолоодлого, онгоцыг автоматаар удирдах систем, автомат тогтворжуулагч, хэлбэлзэл арилгагч демпферүүд, хэлбэлзлийг арилгагч автомат систем, дайрах өнцгүүд, хэт ачааллыг хязгаарлагч, тохируулагч, нислэгийн горим, аюултай байдлыг мэдээлэх дохиоллын автомат, онгоцны удирдлагын ачааллыг хөнгөвчлөх /тохируулах/ автомат,

- удирдлагын жолоодлогын систем, гироскоп, инерциал болон байрлал тогтоох систем, жолоодлогын үед ажиллагааг тооцоолон бодох машины тусламжаар гүйцэтгэх тоноглол, бүхээгийн шилний духны хэсгээс ойсон цахилгаан долгионы тусламжтайгаар онгоц /нисдэг тэрэг/-ны жолоодлогыг дүрслэх систем, тооцоолон бодох машин, тусгай хэрэглэлийн тоноглол, цахилгаан эзлэхүүний шатахуун хэмжигч, шатахуун зарцуулалтыг хэмжигч, түүний шатахууны зарцуулалтын ажиллагааг удирдах цахилгаан автомат систем хамаарна.

401. Хэрэглэлийн тоног төхөөрөмжид аэрометрийн хэрэглэлүүд, тэдгээрийн агаарын тэжээлийн систем, онгоцны хөдөлгөөнийг агаарын орчинтой харьцуулсан хэмжигдэхүүнийг хэмжигч төвлөрсөн систем, уран жолоодлогын гироскоп болон онгоц жолоодлогын

хэрэглэл, цаг, акселерометр, удирдлагагүй пуужин, хэт ачаалал заагч, агаарын болон шингэний, тосны систем, хүчний байгууламжийн ажиллагааг хянах хэрэгсэл, чичиргээ хэмжигч, битүүмжлэгдсэн бүхээгийн хэсэг дэх агаарын хэмжигдэхүүнийг хянах хэрэгсэл, хөдөлгүүр болон нисэх хэрэгслийн элементийн ажиллагааг хянах хэрэгсэл, ослын үед онгоцыг орхих хэрэгсэл хамаарна.

402. Хүчилтөрөгчийн төхөөрөмжид бүхээгийн болон шүхрийн хэрэгсэл, хүчилтөрөгчөөр тэжээх систем, хүчлэх эд ангийг хүчилтөрөгчөөр тэжээх систем, бүхээгийн хэвийн байдлыг хангах цахилгаанжсан хэрэглэл багтана.

403. Өндрийн тусгай хэрэгсэлд хүчилтөрөгчийн бак, битүүмжлэгдсэн ба хамгаалах дуулга, өндрийн нислэгийн хувцас, скафандарууд, даралт тохируулагч, өндрийн хувцаснуудад агаар солилцуулах цахилгаан систем хамаарна.

404. Гэрэл зургийн болон тагнуул, эрэл хайгуулын системд агаарын гэрэл зургийн төхөөрөмж, тагнуул, эрэл хайгуулын дулааны станц, агаарын гэрэл зургийн гадаад байгууламжийн элементийн фото бүртгэгч, авсан зургийг боловсруулах систем, автоматаар барагцаалах цэг тодорхойлох, онгоцны радиолокацийн дэлгэцнээс зураг буулгах систем, фотолюкын удирдлагын систем, онгоцноос тагнуулын мэдээ хүлээн авах систем, шөнийн цагаар зураг авах цахилгаан гэрлийн тоноглол зэрэг багтана.

405. Нисэхийн техникийн байдал, нислэгийн хэмжигдэхүүнийг бүртгэх хяналтын автомат системд /бүртгэн тэмдэглэгч хэрэгсэл/ тооцоолон бодох машины тусламжтайгаар онгоцны төрөл бүрийн тоног төхөөрөмжийн ажиллагааг автоматаар хянаж, боловсруулах цогцолбор орно.

406. Жолоодлого, дадлагын сургалтын суурин төхөөрөмжийн цогцолборт агаарт осол гарсан тохиолдолд эсвэл нислэгийн бүх үед нисгэгчийн гаргах шийдвэр, хийх үйлдлийн газрын сургалтыг хангах зориулалттай дадлагын хэрэгслүүд багтана.

### **Цахилгаан тоноглол**

407. Нислэгт ашиглаж байгаа хүчлийн зайн хураагуурын батарейны багтаамж нь 75 хувиас багагүй байна. Шүлтийн зайн хураагуурын батарейн хамгийн бага багтаамжийг зааврын

дагуу тогтооно. Онгоцонд тавьсан хүчлийн болон шүлтийн зайн хураагуурын батарейг тухайн батарейны ашиглалтын зааврын дагуу ашиглана.

408. Онгоц /нисдэг тэрэг/-ны зайн хураагуур түүний авагддаг контейнерыг тухайн онгоц /нисдэг тэрэг/-нд данслана. Батарей, контейнер дээр онгоц /нисдэг тэрэг/-ны дугаар болон харьяа салбарын дугаар бичигдсэн байна. Батарей эвдрэл, гэмтэлтэй үед нөөц батарей тавихыг зөвшөөрнө. Өөр онгоцны батарейг хооронд нь түр хугацаагаар сольж ашиглахыг цахилгаан, тусгай тоноглолын инженер шийдвэрлэнэ.

409. Зайн хураагуурыг онгоцны ойролцоо тогтмол халаалттай байранд хадгална. Хүчил болон шүлтийн зайн хураагуурын батарейг нэг дор хадгалах, цэнэглэхийг хатуу хориглоно.

410. Дараах тохиолдолд онгоц /нисдэг тэрэг/-нд зайн хураагууртай орхихыг хориглоно. Үүнд:

- эвдрэл гэмтэлтэй;
- онгоц /нисдэг тэрэг/-ыг түр хадгалтад тавих үед;
- онгоцыг хасах хэмд удаан хугацаагаар зогсоох үед /хэрэв зааварт заагдаагүй бол/.

### **Электрон автоматик**

411. Гироскоп төхөөрөмж орсон системийг ашиглахдаа дараах зүйлсээс урьдчилан сэргийлнэ. Үүнд:

- гадны цохилт доргилтоос хамгаалах арга хэмжээ авахгүйгээр тээвэрлэх;
- гироскоп төхөөрөмжийг шалгахгүйгээр хөөрөлт, буулт хийх.

412. Чиглэлийн систем, соронзон луужингийн девиацийг тодорхойлж, арилгах ажлыг ангийн штурман, нисэхийн цахилгаан тусгай тоноглолын мэргэжилтнүүд хамтран жилд нэгээс доошгүй удаа дараах тохиолдолд гүйцэтгэнэ. Үүнд:

- соронзон датчик, луужингийн коррекцийн механизм, чиглэлийн системийг солих үед;
- соронзон талбайд гажилт оруулдаг нэмэгдэл төхөөрөмжийг онгоцонд тавих үед;
- дарга /захирагч/-ын шийдвэрээр онцгой хариуцлагатай үүрэг гүйцэтгэх үед.

Девиацийн ажлыг тухайн онгоц /нисдэг тэрэг/-ны бүх луужинд нэгэн зэрэг хийж, ангийн штурман формулярт тэмдэглэл хөтөлнө.

413. Гиромоторын цахилгаан тэжээлийн хэлхээнд угсралт, нэмэлт ажил хийсний дараа гироскоп агрегатуудын ажиллагааг шалгана.

### **Хэрэглэлийн тоног төхөөрөмж**

414. Агаарын даралтаар ажилладаг хэрэгслийг хуурай шахсан агаараар үлээлгэхдээ агаарын даралтаар ажилладаг бүх хэрэглэл төхөөрөмжүүдийг салгасан байх ёстой. Үлээлгэх агаарын даралт нь 2-4 кгс/см<sup>2</sup> байна. Дараа нь гуурсыг холбож, хэрэгслийн битүүмжлэлийн хэвийн заалтыг шалгана.

415. Өндөр хэмжигчийн заалтыг “тэг дээр” тавиад тэр өдрийн агаарын даралттай тохируулан, алдааг тодорхойлно. Хэрэв байх ёстой хэмжигдэхүүнээс хэтэрч заавал ТАА-д өгч, бүрэн хэмжээг шалгуулна.

416. Өгөгдсөн цувраанд нислэгийг хангахын тулд нисгэгч /штурман/-ийн бүхээгт нийлбэр заслыг тооцсон өндөр хэмжигчийн үзүүлэлттэй хүснэгт байрлуулна. Өндөр хэмжигчийн тохируулга, заслыг ТАА-ийн цахилгаан, тусгай тоноглолын бүлгийн мэргэжилтэн тодорхойлно. Өндөр хэмжигчийн үзүүлэлтийн тооцоо, хүснэгтийг ангийн штурман хийнэ. Хүснэгтийг онгоцонд байрлуулахыг цахилгаан тусгай тоноглолын үйлчилгээний бүлгийн дарга хариуцна.

417. Тогтонги ба динамик даралтын төмөр хоолой, резинэн гуурсыг зөв залгахын тулд тэдгээрт өнгөөр ялгасан тэмдэг тавина.

418. Гиродатчик, авиагоризонтыг сольсон үед онгоцыг агаарт шалгах нислэг үйлдэж, тэдгээрийн ажиллагааг шалгана.

419. Онгоц /нисдэг тэрэг/-ны цагны хэвийн ажиллагааг цахилгаан, тусгай тоноглолын бүлгийн мэргэжилтнүүд хариуцна. Харин нисэх багийн бүрэлдэхүүн цагийн зүүг нарийвчлалтайгаар тавина.

### **Хүчилтөрөгчийн тоног төхөөрөмж**

420. Тусгай автомашин дээр байрлуулсан хүчилтөрөгчөөр цэнэглэх хөдөлгөөнт станцаас болон эмнэлгийн зориулалттай зөөврийн баллоноос онгоц /нисдэг тэрэг/-ыг хийн хүчилтөрөгчөөр

цэнэглэнэ. Цэнэглэх хоолойд тэсрэлт үүсэхээс сэргийлэхийн тулд хадгалалтын тосыг сайтар цэвэрлэх ба бүрэн шалгаагүй хоолой /шланг/-г хэрэглэхийг хориглоно.

Тосыг нь салгаж арилгасан хоолойг өргөнөөрөө 5 см, хоорондоо мөн 5 см зайтай, хөх цэнхэр өнгөөр тэмдэг тавьж ялгана. Машины их биед хөх дэвсгэр дээр цагаанаар "Эмнэлгийн хүчилтөрөгч" гэж бичнэ.

421. Шингэн хүчилтөрөгчөөр онгоцыг цэнэглэхдээ системийг заавал дүүртэл цэнэглэнэ. Шингэн хүчилтөрөгчөөр цэнэглэх олон төрлийн хувилбартай онгоцонд, тухайн нислэгийн байдалд тохируулан цэнэглэлт үйлдэхийг байгууллагын дарга /захирагч/ тодорхойлно.

422. Шингэн хүчилтөрөгчийг онгоцоор тээвэрлэх үед нисэх багийн гишүүд түүнийг тээвэрлэх, цэнэглэх дүрмийг судалсан байх ёстой. Онгоцонд шингэн хүчилтөрөгчийг тээвэрлэх тухай заавар байна. Хоосон савыг тээхдээ цоргыг нь хаасан байна.

423. Даралтгүй хүчилтөрөгчийн баллоныг ашиглахдаа 2-3 удаа хүчилтөрөгчөөр угааж, дараа нь зохих даралтыг нь хүртэл цэнэглэнэ. Хүчилтөрөгчийн сав ус, хаг, зэврэлт, бусад гадны хольцтой байвал ашиглахыг хориглох ба тусгай цэвэрлэгээг зааврын дагуу хийнэ.

424. Хүчилтөрөгчийн төхөөрөмжийг ашиглах үед хориглох зүйлс:

- хүчилтөрөгчийн төхөөрөмж дээр тослог бодис байх буюу тостой багаж, хувцастай ажиллах;
- хүчилтөрөгчийн төхөөрөмжийн системийн битүүмж алдагдсан;
- хүчилтөрөгчийн төхөөрөмжийн эд ангийг үлээлгэх, угаахдаа зааварт заагдаагүй хийн шингэн хэрэглэх;
- хүчилтөрөгчийн хоолойнуудыг зориулалтын бус материал ашиглаж гагнах;
- даралтыг нь урьдчилан гаргаж буулгалгүйгээр хоолойнуудыг салгах;
- хүчилтөрөгчийн шланг болон дамжуулах хоолойнуудыг мушгиралдуулах.

## Нисэх багийн өндрийн тусгай төхөөрөмж

425. Нисэх бүрэлдэхүүний хувийн тоног төхөөрөмжид өндрийн хувцас хэрэглэл, хамгаалалтын дуулга, гарнитур, микрофоны өсгөгч зэрэг орно. Түүний бүрэн бүтэн байдал, ашиглалтыг нисгэгч хариуцна.

426. Өндрийн хувцас хэрэглэлийн хадгалалт, ариун цэврийн байдал, нисгэгчийн биеийн хэмжээ авалт, хувцас тохируулгыг эмнэлгийн албаны дарга /эмч/ хариуцна.

427. Өндрийн бүлгийн мэргэжилтнүүд өндрийн төхөөрөмжийг техникийн ашиглалтын зааврын дагуу нислэгт бэлтгэнэ.

428. Нисэх багийн өндрийн төхөөрөмжид хийгдэх хэвшүүлэх ажлыг өндрийн тоноглолын үйлчилгээний бүлэг, радиоэлектрон тоноглолын хэвшүүлэх ажлын бүлгийн мэргэжилтэн гүйцэтгэнэ.

429. Өндрийн хувцас /битүүмжлэлтэй дуулга, хүчилтөрөгчийн баг/-ны тохируулга, дахин тааруулах /угааж цэвэрлэсний дараа/-ыг өндрийн бүлгийн мэргэжилтэнтэй хамтран эмнэлгийн албаны дарга /эмч/ гүйцэтгэнэ.

430. Хүчилтөрөгчийн баг, битүүмжлэлтэй дуулгыг нислэгийн дараа цэвэрлэж, ариутгахыг өндрийн бүлгийн мэргэжилтнүүд нисгэгчийн хамт гүйцэтгэнэ.

431. Хүчилтөрөгчийн баг, цүнх болон бусад өндрийн төхөөрөмжид нисгэгчийн овог, нэр бичигдсэн байна. Тэдгээрийг тусгай байранд бэлэн байдалтайгаар хадгалах ба бусдад шилжүүлэхийг хориглоно.

432. Шүхрийн хүчилтөрөгчийн болон автомат хэрэглэлүүдийг ашиглахад бэлэн байдалтайгаар шүхэртэй хамт хадгална.

433. Шүхэр, шүхрийн систем, хүчилтөрөгчийн хэрэгсэл, автомат хэрэглэлүүдэд хэвшүүлэх ажлыг цахилгаан тусгай тоноглолын хэвшүүлэх ажлын бүлэг гүйцэтгэнэ.

434. Шүхрийн хэрэгслийг агуулахаас авах /өгөх/, хадгалах, бүрэн бүтэн байдал, хэвшүүлэх ажлыг цаг тухайд нь гүйцэтгэхийг шүхэр-десантын албаны мэргэжилтэн хариуцна.

435. Микрофон, өсгөгч, харилцуур, ларингофоны хэвшүүлэх болон засварын ажлыг радиоэлектрон тоноглолын бүлгийн мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

## **Гэрэл зургийн болон тагнуул, эрэл, хайгуулын дулааны төхөөрөмж**

436. Онгоцны тагнуулын болон фото хяналтын хэрэгслийг 5 хэмээс доошгүй дулаантай, хуурай байранд, вандан дээр хадгална. Энэ үед агаарын дулааны огцом хэлбэлзэл байж болохгүй.

437. Агаарын гэрэл зураг авалт болон фото хяналтын системийг нислэгт бэлтгэхдээ тухайн системийн цагнуудын түлхэлтийг шалгаж, нарийвчлан тохируулж, нөөц хальсыг тогтооно.

438. Соронзон хальсыг нислэг бүрийн дараа авч, цэнэглэж тавина. Сургуулийн нислэгийн үед соронзон хальсыг нислэг дууссаны дараа дахин цэнэглэхийг зөвшөөрнө.

439. Соронзон хальсыг цэнэглэх /цэнэг авах/-дээ тусгай төхөөрөмжлөгдсөн лаборатори буюу машинд гэрэл зургийн мэргэжилтнүүд гүйцэтгэнэ. Хальс бэлтгэх, халуун, хүйтний тогтворжилтыг хангах ажлыг гэрэл зургийн бүлгийн мэргэжилтэн хариуцна.

440. Нислэгт хугацаа дууссан зургийн хальс хэрэглэхийг хориглоно.

441. Фотоконтейнеруудын цахилгаан чангалуурыг онгоцонд залгах, салгахыг гэрэл зургийн тоноглолын бүлгийн мэргэжилтнүүд хариуцна.

442. Цахилгаан импульс, гэрэлтүүлгийн төхөөрөмжтэй ажиллаж байх үед аюулгүйн арга хэмжээг мөрдөнө. Үүнд:

- өндөр хүчдэлийн төхөөрөмжтэй ажиллаж байх үед хамгаалалтын гутал, резинэн бээлий бүхий мэргэжилтэн хоёроос доошгүй байх;

- төхөөрөмжийн ажиллах чадварыг шалгагч пультайн газардуулгыг найдвартай хангах;

- төхөөрөмжийг унтраасны дараа түүн дээр ажиллахдаа өндөр хүчдэлийн хураагуурын цэнэгийг алдуулсан байх, цэнэг алдуулагчийн тусгаарлагч, резинэн бээлий, гутлыг зохих зааврын дагуу үечлэн шалгана.

## **Нисэхийн техникийн байдал, нислэгийн хэмжигдэхүүнийг бүртгэх хяналтын автомат систем /бүртгэн тэмдэглэгч хэрэгсэл/**

443. Нислэгийн хэмжигдэхүүнийг бүртгэн тэмдэглэгч хэрэгсэлд

нисэхийн техникийн ажиллах чадвар, нисэх бүрэлдэхүүний үйлдэлд бодит хяналт тавьдаг техникийн төхөөрөмжүүд хамаарна. Бүртгэн тэмдэглэгч хэрэгслийг ерөнхий болон тусгай зориулалтын гэж хоёр ангилна.

Ерөнхий зориулалтын бүртгэн тэмдэглэгч хэрэгслийг нислэгийн хэмжигдэхүүн, нисэх багийн үйлдэл, хүчний байгууламж, онгоцны систем, тоног төхөөрөмжийн ажиллагааны мэдээллийг бичиж авах, хадгалахад ашиглана.

Тусгай зориулалтын бүртгэн тэмдэглэгч хэрэгслийг онгоцны цогцолборын хэмжигдэхүүн, түүний систем, тэдгээрийг ашиглаж байгаа нисэх багийн үйлдлийг бүртгэн тэмдэглэхэд ашиглана.

444. Ерөнхий зориулалт /нислэгийн хэмжигдэхүүнийг бүртгэн тэмдэглэгч/-ын хэрэгслүүд, тэдгээрийн мэдээллийг боловсруулагч төхөөрөмжийн ашиглалтыг цахилгаан тусгай тоноглолын бүлгийн мэргэжилтнүүд хариуцна.

Тусгай зориулалтын бүртгэн тэмдэглэгч хэрэгсэл, түүний мэдээллийг боловсруулагч төхөөрөмжийн ашиглалтыг тухайн цогцолбор, системийн мэргэжилтнүүд хариуцна.

445. Онгоц, хөдөлгүүр, радиоэлектрон болон цахилгаан тусгай тоноглол, зэвсэглэлийн систем дэх датчикуудыг тавих /авах/ ажлыг эдгээр системийг ашиглаж байгаа тухайн бүлгийн мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

446. Ерөнхий зориулалтын бүртгэн тэмдэглэгч хэрэгслийг нислэг үйлдэх бүрт бэлтгэж, онгоц /нисдэг тэрэг/-нд тавьж, залгана.

447. Нислэгийн сүйдэл гарсан тохиолдолд мэдээлэлтэй хайрцгийг шалгаж байгаа комиссын даргын зөвшөөрөлгүйгээр, нислэгийн сүйдэл гарах дөхсөн үед байгууллагын дарга /захирагч/-ын зөвшөөрөлгүйгээр онгойлгохыг хориглоно.

448. Тарировк бичсэн хальсыг дараагийн тарировк, хэвшүүлэх ажил хийгдтэл ТАА-д онгоц /нисдэг тэрэг/ тус бүрээр нь хадгална. Онгоц /нисдэг тэрэг/-ыг агаарт шалгаж ниссэн тухай материал /гэрэл зургийн хальс, шалгах нислэгийн зураг г.м./-ыг онгоц тус бүрээр нь нисэхийн засварын газарт уг ажиллагаа дахин хийгдэх хүртэл хадгална.

449. Онгоц /нисдэг тэрэг/ үндсэн аэродромоос алс нислэг үйлдэх үед нисэхийн техникийн ажиллагааны талаар нисэх баг

гэмтэл дутагдал заасан тохиолдолд нислэгийн хэмжигдэхүүнийг бүртгэн тэмдэглэгчийн мэдээллийг боловсруулалт хийж, шинжилнэ. Бүртгэн тэмдэглэгчийн мэдээллийг дараагийн нислэг эхлэхийн өмнө буусан аэродром дээр нь үзэж, дүн шинжилгээ хийнэ. Нислэг бүрийн хэмжигдэхүүнийг бичсэн бодит хяналтын хэрэгслийн материалыг томилогдсон аэродромд очмогц, шилжүүлэн өгнө.

### **Хүчлэх эд ангийн удирдлагын төхөөрөмж, цахилгааны тоноглол**

450. Цахилгаан, тусгай тоноглолын бүлгийн мэргэжилтнүүд дараах цахилгаан агрегатуудын хэмжигдэхүүнийг шалгаж тохируулна.

Үүнд:

- оруулах байгууламжийн тохируулгын систем;
- тийрэлтэт соплоны хавтаснуудын байрлал;
- маслын болон газын температур;
- турбин компрессорын эргэлт зэрэг болно.

451. Хөдөлгүүр ажиллаж байх үед хүчлэх эд ангийн ажлын горимын удирдлага, асаалтын системийн цахилгаан төхөөрөмжийн ажиллах чадварыг онгоц /нисдэг тэрэг/-ны их бие, хөдөлгүүрийн бүлгийн мэргэжилтнүүд шалгана.

452. Хүчлэх эд ангийн удирдлагын системийн цахилгаан төхөөрөмжийн гэмтэлгүй, бүтэн байдлыг цахилгаан, тусгай тоноглолын бүлгийн мэргэжилтнүүд хариуцна.

### **Жолоодлого, суурин дадлагажуурын цогцолбор /тренажёр/**

453. Жолоодлого, суурин дадлагажуурын цогцолбор /тренажёр/-ыг 5-аас 25 хэмийн дулаантай, 98 хувиас ихгүй чийгшилтэй, агааржуулагдсан байхаар төхөөрөмжлөгдсөн тусгай өрөөнд байрлуулна.

454. Жолоодлого, суурин дадлагажуурын цогцолборыг техникийн ашиглалт, үйлчилгээ, засвар, ажиллагаанд бэлтгэх, гэмтэлгүй, бүрэн бүтэн байлгахыг үйлчилгээний тусгай бүлгийн мэргэжилтнүүд хариуцна. Тэдний эзгүйд цогцолбор дээр сургалт явуулах, ажиллахыг хориглоно.

Уг бүлэгт радиоэлектрон болон цахилгаан, тусгай тоноглолын, тооцоолон бодох төхөөрөмжийн мэргэжилтнүүд орно. Дадлагын төхөөрөмжийн ашиглалт, бэлэн байдлыг электрон-автоматик болон тооцоолон бодох төхөөрөмжийн инженер хариуцна.

455. Зөвхөн нисэх анги, байгууллагын даргын тушаалаар томилогдсон шалгагч /багш/-ийн удирдлага дор нисэх бүрэлдэхүүн дадлагыг хийнэ. Дадлагад бэлтгэх, явуулах ажиллагааг үйлчилгээний бүлгийн мэргэжилтнүүдийг байлцуулан эвдрэл, гэмтэлгүй бүрэн бүтэн дадлагажуурын цогцолборт явуулна. Инженер, техникийн бүрэлдэхүүнээс дадлагажуур дээр өөрөө бие даан сурах болон ажиллахыг хориглоно.

456. Жолоодлого, суурин дадлагажуурын цогцолборт хэвшүүлэх болон засварын ажил хийсний дараа түүнийг электрон-автоматикийн /нисэхийн тоног төхөөрөмжийн/ инженерийн заавар, болон ашиглалтын заавраар тодорхойлогдсон хөтөлбөрийн дагуу ажлын горимоор шалгасан байх ёстой. Энэ үед хяналтын дасгалыг нисэх багийн гишүүд гүйцэтгэнэ.

457. Үйлчилгээний бүлгийнхэн “нийлүүлэгч”-ээс хүлээж авсан мөчөөс эхлэн дадлагын цогцолбор, түүний системийн нөөцийн зарцуулалтыг тоолуураар гаргана. Хэрвээ тоолуур байхгүй бол цахилгаан тэжээл залгах бүрт ажилласан хугацааны нийлбэрээр нөөцийн зарцуулалтыг тооцно.

458. Жолоодлого, суурин дадлагажуурын цогцолбор дээр ажиллах үед дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- цогцолборыг хүчдэлд залгасан тохиолдолд хяналтгүй орхих;
- цогцолборын бүхээг, пультайн шүүгээний нээлхий, хаалгыг онгорхой орхих;
- түүний бүх элемент, хэмжигдэхүүнийг анхны байдалд нь оруулахын өмнө цогцолборыг салгах;
- цогцолбор, түүнийг хангадаг системийг залгах, салгах тогтоогдсон дэс дарааллыг зөрчих;
- гэмтэлтэй цогцолбор дээр дадлага хийх;
- техникийн нөхцөлд заасан хязгаарлалтаас гадуур хэмжигдэхүүний тохируулгыг хийх;
- хэмжигдэхүүнүүд нь техникийн нөхцөлд тохироогүй

цахилгаан тэжээлд цогцолборыг залгах.

459. Үйлчилгээний бүлгийн мэргэжилтнүүд цогцолборын ажилласан цаг, бүх гэмтэл, засвар, хийгдсэн ажлын тооцоо, бүртгэлтэй байх ёстой бөгөөд цогцолборын формулярыг хөтөлнө.

#### **4.4. Радиоэлектрон тоноглолын ашиглалт**

460. Радиоэлектрон тоноглолд:

- холбооны радио хэрэгсэл;
- онгоц жолоодлогын ба суултын радио хэрэгсэл;
- бөмбөгдөлт ба десантын радио хэрэгсэл;
- хайх, илрүүлэх, амдан сөнөөх, хараалах радио хэрэгсэл;
- идэвхтэй хариулалт, зарлан мэдээлэх, танин мэдэх радио хэрэгсэл;
- удирдлагын, хөтлөх, агаарын байг чиглүүлэгч радио хэрэгсэл;
- электрон тагнуулын радио хэрэгсэл;
- радио электрон тэмцлийн хэрэгсэл;
- радиоэлектрон тоноглолын эрэн хайх- аврах систем;
- радиоэлектрон тоноглолын электрон тооцоолон бодох хэрэгслүүд;
- радиоэлектрон тоноглолыг хянах, урьдчилан мэдээлэх автомат систем;
- радиоэлектрон тоноглолыг хянах газрын автомат систем багтана.

461. Холбооны радио хэрэгсэлд удирдлагын болон холбооны радиостанц, тусгай холбооны радиостанц, бүх төрлийн долгионы хүлээн авагч, харилцах утас, цахилгаан мэдээний болон телекодын далд холбооны хэрэгсэл, онгоцноос тагнуулын ба тусгай мэдээлэл дамжуулах автомат радио шугам, автомат дамжуулан нэвтрүүлэгч, зарлан болон яриан мэдээллийн радио хэрэгсэл, нисэх багийн хооронд ярилцах холбооны төхөөрөмж, дуу, дүрс бичлэг болон хуулбарлах радио хэрэгсэл, нисэх бүрэлдэхүүний нисэхийн гарнитурын өсгөгч, хувиргагч хэрэгсэл багтана.

462. Онгоцны жолоодлого, суултын хэрэгсэлд радио луужин, тусгай болон алсын, ойрын навигацийн систем, суултын систем, доплерын навигацийн систем, олон улсын агаарын замын нислэгийг

хангах систем, саад тойрон өнгөрөх, аянга цахилгаантай фронт тодорхойлох болон мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх хэрэгсэл, байлдааны журамд автомат жолоодлогыг хангах, онгоц /нисдэг тэрэг/-ны байрлалыг хянах систем, их бага өндрийн радио өндөр хэмжигч, маркерын хүлээн авагч, хиймэл дагуул болон бусад системүүд багтана.

463. Бөмбөгдөлтийн болон десантын радио хэрэгсэлд:

- хараалах цэгийн солбицол тодорхойлогч, газрын радиоэлектрон хэрэгсэлтэй хамтрах буюу бие дааж ажилладаг хараалах десантын болон бөмбөгдөлтийн цэгт хүрэх нислэгийн өгөгдөхүүнийг тооцоологч систем, тактикийн бөмбөгдөлтийн хэрэгсэл, онгоцны радиолокацийн дохиологч-хариулагч төхөөрөмж, дохиологч-хариулагч радио хэрэгсэл багтана.

464. Хайх, илрүүлэх, амдан сөнөөх, хараалах хэрэгсэлд:

- хараалах радиолокацийн станц;  
- пуужин чиглүүлэх ба удирдах радио хэрэгсэл;  
- радиолокацийн алсыг хэмжигч;  
- дуулгаар чиглүүлэх радио хэрэгсэл;  
- байг илрүүлэн солбицлыг нь автоматаар тодорхойлж улмаар тухайн зэвсэглэлийг чиглүүлэн харвах ажиллагааг хангах хараалах радиолокацийн станцууд багтана.

465. Идэвхтэй хариулалт, зарлан мэдээлэх, ялган таних радио хэрэгсэлд:

- улсын харьяаллыг тодорхойлох систем,  
- онгоцны байрлал, нислэгийн хэмжигдэхүүний мэдээг газрын радиолокацийн станцад дамжуулах систем багтана.

466. Удирдлага, агаарын байг заагч, чиглүүлэгч радио хэрэгсэлд:

- целийн районд онгоцыг чиглүүлэх хэрэгсэл;  
- газрын байг илрүүлэх, автоматаар дагах, пуужинг чиглүүлэх хэрэгсэл;  
- байг илрүүлэх улмаар хөнөөх хэрэгслийг тээвэрлэгч хэрэгсэлд мэдээлэл дамжуулах хэрэгсэл;  
- хөвөгч аврах хэрэгслийн радио удирдлагын хэрэгслүүд багтана.

467. Тагнуулын радиоэлектрон хэрэгсэлд:

- газар орны дүрс, зураглалыг хүлээн авах;
- дайсны радиоэлектрон хэрэгслийн үндсэн хэмжигдэхүүнийг тодорхойлох;

- мэдээллийн боловсруулалт, хүлээн авалт, дамжуулалтыг хангах;

- радиолокацийн, телевизийн, электрон, дуран авайн систем;
- радиоэлектрон тагнах хэрэгслийн хэмжигдэхүүнийг бүртгэх, тодорхойлох радиотехникийн систем;

- радио долгион барих хэрэгслүүд багтана.

468. Радиоэлектрон тэмцлийн хэрэгсэлд:

- радиоэлектрон тэмцлийн хэрэгслийн удирдлага;
- цацрагийн тухай экипажид мэдэгдэх болон радиоэлектрон шууд тагнах хэрэгсэл;

- нэг буюу бүлэг нисэх хэрэгслийг хамгаалах зорилго бүхий идэвхтэй саатуулгын станц болон систем;

- радио удирдлагатай “Агаар-радиолокацийн станц” пуужинд зориулсан бай илрүүлэгч заагч хэрэгсэл;

- нэг удаа хэрэглэх саатуулгын радио хэрэгсэл;

- радио навигацийн ба радио холбооны хэрэгслээр саатуулга бий болгох хэрэгсэл багтана.

469. Радиоэлектрон тоноглолын эрэн хайх, аврах системд:

- радио хүлээн авагч төхөөрөмж буюу ойрын эрэл хийх автомат систем;

- ослын үед ганцаар ба бүлгээр хэрэглэдэг аврах радиостанц;

- дохиологч-хариулагч радио хэрэгсэл;

- эрэл хайгуул /бүхээг/-ийн телевизийн төхөөрөмжүүд багтана.

470. Радиоэлектрон тоноглолын электрон тооцоолон бодох хэрэгсэлд радиоэлектрон системд хэрэглэгдэх оруулах, гаргах төхөөрөмжтэй тооцоолон бодох электрон машин багтана.

471. Радиоэлектрон тоноглолын урьдчилан мэдээлэх байдал, бүхээгийн болон газрын шалгалтын хянах төхөөрөмжид:

- олон талт хяналтын системүүд;

- радиоэлектрон тоноглолын цогцолбор, автомат байгууламжийн байдлыг бүртгэх онгоцны систем;

- радиоэлектрон тоноглолын байдлыг урьдчилан мэдээлэх,

хянах автомат системүүд багтана.

472. Онгоцны радиоэлектрон тоноглол, пуужин, залуурт сум, сольдог чингэлэг, дадлагын төхөөрөмж болон радиоэлектрон тоноглолын хяналтын техник хэрэгслийн ашиглалтыг мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

473. Радиоэлектрон тоноглолд багтдаг хөргөлт, шингэний систем болон блокыг хийлэх, дамжуулах хоолойг ерөнхий шугамд залгах хүртэлх гэмтэлгүй, бүрэн бүтэн байдлыг радиоэлектрон тоноглолын техникч, мэргэжилтнүүд хариуцна.

474. Радиоэлектрон тоноглолын блоконд тавигдсан фото бүртгэлийн соронзон хальсыг онгоцонд тавих /авах/, тэдгээрийн цагийг тааруулах түлхэх, нарийвчлан тохируулах, ажиллах чадварыг нь шалгах ажлыг радиоэлектрон тоноглолын мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

475. Ээлжийн радиоэлектрон тоноглолтой төхөөрөмж, чингэлэг, радиоэлектрон иж бүрдлийг нууцлагдсан байдлыг нь хангаж тусгай байранд онгоцонд ойр хадгалж хамгаална. Онгоцонд дээрх зүйлсийг тавьсан тухай радиоэлектрон тоноглолын мэргэжлийн хүмүүс хяналтын хуудас, бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хөтөлнө.

Чингэлэг, радиоэлектрон аппаратурын ээлжийн иж бүрдлийн хадгалалтыг тогтоогдсон хугацаанд бэлэн байлгах, бүрэн бүтэн ажиллагааг радиоэлектрон тоноглолын мэргэжилтнүүд хариуцна.

476. Радиоэлектрон тоноглолыг хэрэглэх нөөц хувилбарын тоо хэмжээ, бэлэн байдлын зэрэг, хадгалалтыг тогтоогдсон журмаар гүйцэтгэнэ. Тэдгээрийг гэмтэлгүй, бүрэн бүтэн байлгах, заагдсан бэлэн байдлын зэрэгт байлгахыг радиоэлектрон тоноглолын инженер хариуцна. Радиоэлектрон тоноглолыг хэрэглэх хувилбар, ажлын хөтөлбөрийг дарга /захирагч/ тодорхойлж, тогтоогдсон хугацаанд ээлжийн хувилбараар ажиллах боломжийг тооцоолон, бичгээр үйлдэж радиоэлектрон тоноглолын нөөц хувилбар /литер/, хөтөлбөр болон залгах горимыг цаг тухайд нь зөв залгаж /салгаж/ байхыг нисэх бүрэлдэхүүн хариуцна.

477. Радио холбооны систем болон радио луужинг тохируулах, алсынболонцэргийн тээврийн онгоцонд нислэгийн нөгөгдэхүүнүүдийг нислэгийн хөтөлбөрт оруулах түүнчлэн радиоэлектрон тоноглолын

хэрэгслийг ажлын үелзлийн горимд шилжүүлж тавихыг нисэх багийн бүрэлдэхүүн гүйцэтгэж үнэн зөв эсэхэд хариуцлага хүлээнэ.

478. Нислэгийн үүргийн дагуу онгоцны гадна тавигдсан радио холбооны систем, радио луужин, түүнчлэн радиоэлектрон тоноглолын ажлын горимыг удирдах төхөөрөмжийн өөрчлөлт, код тавилт, нислэгийн хөтөлбөр оруулалт, хувилбар /литер/, ээлж солилтын зөв гүйцэтгэлийг радиоэлектрон тоноглолын мэргэжилтнүүд, нисэх багийн гишүүд хариуцна.

Радиоэлектрон тоноглолын хэрэгслүүдэд нислэгийн хөтөлбөр оруулах, радио холбооны систем, радио луужинг өөрчлөн тохируулах болон код солих /өөрчлөх/ өгөгдэхүүнийг холбооны албаны дарга /штурман/ радиоэлектрон тоноглолын инженерт /нисэх багийн даргад/ тогтоогдсон хугацаанд шаардлагатай ажлыг гүйцэтгэх боломжтой цагийг тооцоолон бичгээр өгнө.

479. Онгоцны радиоэлектрон тоноглолд байгаа авагддаг хэрэгсэл, электровакуумын багаж, түүний нөөцөд байгаа иж бүрдлийг тогтоогдсон хугацаанд лабораторид оруулах, техникийн өгөгдэхүүнүүдийг шалгахыг хэвшүүлэх ажлын явцад хийж, ерөнхий инженерийн зааврын дагуу гүйцэтгэнэ.

Электровакуумын болон хагас дамжуулагч хэрэгслийг агуулахаас хүлээж аваад лабораторид техникийн өгөгдэхүүнийг нь шалгана. Электровакуумын болон хагас дамжуулагч хэрэгсэл, радио жижиг хэсэг, гал хамгаалагч, микросхемийг тоноглолуудад тавихын өмнө хянах хэрэгсэл, багажаар шалгана. Лабораторийн ажлын техникийн удирдлагыг радиоэлектрон тоноглолын инженерт хариуцуулна.

480. Онгоцны радио удирдлагын цогцолбор болон радиолокацийн хараалалтын системийн антенны чиглэлийн диаграммын баримжааллыг радиоэлектрон тоноглолын мэргэжилтнүүд зэвсгийн хүйтэн тогтоол буудлагатай нэгэн зэрэг нисэхийн зэвсэглэлийн мэргэжилтнүүдтэй хамтарч хийнэ.

481. Антенны чиглүүлэх диаграммын баримжаалал, байг заагчийн сувгийг шалгах болон үүнтэй холбогдох радиоэлектрон тоноглолын тохируулгыг тухай бүрт техникийн ашиглалт, хэвшүүлэх ажлын зааварт заагдсаны дагуу дараах тохиолдлуудад

хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- чиглэлийн диаграммд нөлөөлдөг антенн, блокыг солих;
- онгоц /нисдэг тэрэг/-нд нэмэгдэл антенн болон тоноглол тавих үед чиглэлийн диаграммд өөрчлөлт орохоор бол;
- нисэх бүрэлдэхүүнээс дутагдал заасан тохиолдолд радиоэлектрон тоноглолын бүлгийн мэргэжилтнүүд түүнийг арилгана.

482. Радиодевиаацийн ажлыг тогтоосон хугацаанд зааврын дагуу дараах тохиолдолд хийнэ. Үүнд:

- раман антенны чиглэлийн диаграммыг өөрчилж болзошгүй нэмэгдэл антенн болон төхөөрөмж тавих үед;
- чиглэлийн өнцөг заагч, радио луужингийн раман антенн буюу гониометр солих үед;
- нисэх бүрэлдэхүүнээс дутагдал заагдсан үед;
- радиодевиаацийн ажлыг салбарын штурман, радиоэлектрон тоноглолын бүлгийн инженер, техникчийн бүрэлдэхүүний оролцоотойгоор гүйцэтгэнэ. Уг ажлыг цаг тухайд нь хийлгэх, протокол хөтлөх, радиодевиац арилгасан тухай онгоц /нисдэг тэрэг/-ны формулярт тэмдэглэл хөтлөхийг штурман /экипаж/ хариуцна.

483. Нуувчинд байгаа онгоцны радионавигацийн болон радио холбооны системийн ажиллах чадварыг шалгахдаа онгоцны тогтоогдсон төхөөрөмж болон газрын тоноглолын үлгэрчилсэн бүдүүвчээр шалгана.

Радиоэлектрон тоноглолыг нислэгт бэлтгэж, радио луужинг шалгахад ашигладаг чиглүүлэх болон өргөн нэвтрүүлгийн радио станцын чигийн өнцгийг тодорхойлж, зөөврийн антенн төхөөрөмжөөр нуувчуудыг тоноглоно.

484. Газрын холбооны хэрэгсэл хариуцагч нарын оролцоотойгоор газрын радиотехникийн хэрэгсэлтэй хамтран ажилладаг онгоц /нисдэг тэрэг/-ны радиоэлектрон тоноглолын ажиллагаа муудсан шалтгааныг тодруулна. Дутагдлыг радиоэлектрон тоноглолын инженер, техникч арилгана. Саатлыг бий болгогч төхөөрөмжийг хариуцагч нь радиоэлектрон тоноглолын ажиллагаанд гарсан саатлыг арилгана.

485. Ослын халдашгүй нөөц, ослын үед хэрэглэхээр үүргэвч

шүхэрт байдаг хүн нэг бүрийн радиостанцыг аврах хэрэгслийн хамт хадгална. Нисэх бүрэлдэхүүний хувцсанд байдаг радиостанцыг шүхэр десантын албаны байранд хадгалж, зөвхөн нислэгтэй үед нисэх бүрэлдэхүүнд тавьж олгоно.

486. Ослын үед хэрэглэх радиостанцын тэжээлийн хэвшүүлэх болон засварын ажлыг радиоэлектрон тоноглолын бүлгийн техникч хийнэ. Нүүрсхүчилтэй баллонд хийгдэх ажлыг онгоцыг ослын үед орхих системийн мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

487. Ослын үед хэрэглэх хүн нэг бүрийн радиостанцын тэжээл, зай хураагуурын байдал, хадгалалт, хэвшүүлэх ажлыг цаг тухайд нь хийх, шалгах, агуулахаас авах /өгөх/-ыг шүхэр десантын алба хариуцаж гүйцэтгэнэ.

488. Газрын радиолокацийн дохиологч-хариулагчийг хэрэглэх бэлтгэлийг шүхэр десантын албаны бие бүрэлдэхүүн гүйцэтгэнэ. Чингэлгийн радио дохиологч-хариулагчийг онгоцонд зэвсэглэлийн техникч нисэх багийнхны оролцоотой зүүнэ.

489. Газрын радиолокацийн дохиологч болон автоматчлагдсан чингэлгийн радио дохиологч-хариулагчийн радиоэлектрон тоноглолын хэвшүүлэх, засварлах ажлыг радиоэлектрон тоноглолын хэвшүүлэх ажлын мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

490. Цэргийн алсын болон тээврийн онгоцонд радиоэлектрон тоноглолын нислэгийн өмнөх бэлтгэлийг хийх үед хянан шалгах хэрэгсэл шаардагдахгүй бол уг ажлыг нисэх баг гүйцэтгэнэ.

491. Ээлжийн кварц, үелзлийн датчик, радиоэлектрон тоноглолын ажлын хөтөлбөрийн датчикуудыг онгоц /нисдэг тэрэг/-нд, эсвэл радиоэлектрон тоноглолын үйлчилгээний бүлгийн байранд онгоц /нисдэг тэрэг/ тус бүрийн бүрдлээр хадгална. Үйлчилгээний бүлэгт хадгалагдаж байгаа үед радиоэлектрон тоноглолын мэргэжилтнүүд онгоцонд байгаа үед түүний техникч /борттехникч/ хариуцна.

492. Радиоэлектрон тоноглолын нөөцийн нэг бүрийн бүрдүүлэгчийг агуулахад, тусгай гаргасан байранд тооцоотойгоор хадгална. Хадгалалт, тооцоололт, ашиглалт, түүнийг шууд зориулалтаар ашиглах, цаг тухайд нь нөхөн хангалт хийлгэхийг радиоэлектрон тоноглолын инженер хариуцна. Нэг бүрийн бүрдүүлэгчийг техникч /борттехникч/ хариуцна.

## **ТАВДУГААР БҮЛЭГ.**

### **Шилжин байрлах үеийн нисэхийн инженерийн албаны зохион байгуулалт**

495. Шилжин байрлах явцад байлдааны ажиллагаа явуулах, бэлэн байдлын өндөр түвшинг хангахын тулд НИА нь шилжин байрлах ажиллагаанд өөрийн хүч хэрэгслийг байнга бэлэн байлгах ёстой.

496. НИА-ны хүч хэрэгслийг шилжүүлэн байрлуулах ажиллагааг явуулах бэлтгэл ажлыг урьдчилсан болон шууд гэж ангилна. Урьдчилсан бэлтгэлийн явцад янз бүрийн тээврийн хэрэгслээр шилжин байрлах тоотуудыг томилж, бие бүрэлдэхүүн, нисэхийн техник, техник хэрэгслийг шилжин байрлах ажиллагаанд бэлтгэнэ. Энэ үед шилжин байрлах ажиллагааны төлөвлөгөөг нисэх ангийн захирагчийн шийдвэрийн дагуу ерөнхий инженер төлөвлөж, доорх арга хэмжээг авна. Үүнд:

- онгоц, хөдөлгүүр, багаж хэрэгслийн сэлбэгийн нөөцийг сэргээх;

- шаардлагатай сэлбэг хэрэгсэл, зарцуулалтын материалыг бэлтгэх;

- нисэхийн техникийг нислэгт бэлтгэх бүх төрлийн бэлтгэлийг явуулахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хайрцаглах /савлах/, чингэлэгт хийж бэлтгэх;

- нисэх бүрэлдэхүүнийг бие даан онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх ажиллагаанд дадлагажуулах;

- шинээр шилжин байрлах аэродром дээр, түүнчлэн шилжин байрлалтын завсрын байрлалтуудад онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх ажлын онцлогоор сургалт явуулах;

- инженер, техникийн бүрэлдэхүүнийг НИА-ны эд аж ахуйг ачиж, буулгах ажиллагаанд дадлагажуулах;

- инженер, техникийн бүрэлдэхүүний удирдах ажилтнуудыг инженер-штурманы тооцоололтын ажилд оролцуулах;

- шилжин байрлах үед буулт хийх аэродромтой урьдчилан танилцах, бэлтгэх ажилд инженер, техникийн удирдах бүрэлдэхүүнийг оролцуулах.

Шууд бэлтгэл нь НИА-ны бие бүрэлдэхүүн, нисэхийн техник,

техник хэрэгслийг тухайн шилжин байрлах ажиллагаанд бэлтгүүлэх зорилготой.

НИА-ны хүч хэрэгслийг шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө нь ангийг шилжүүлэн байрлуулах төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг мөн.

497. НИА-ны шилжин байрлах төлөвлөгөөг боловсруулах, түүнд бэлтгэх ажлыг ерөнхий инженер хариуцна.

498. Шилжин байрлах ажиллагаанд НИА-ны хүч хэрэгслийн байнгын бэлэн байдлыг техник ашиглалтын ангийн дарга, пуужин урьдчилан бэлтгэх байрын дарга, холбогдох бусад мэргэжилтнүүд хариуцна.

499. Инженер, техникийн албаны техник хэрэгслийг баглаж, хайрцаглан чингэлэгт хийх ажлыг бие бүрэлдэхүүний хүчээр гүйцэтгэнэ.

500. НИА-ны хүч хэрэгслийг шинээр байрлах аэродром /завсрын аэродром/ дээр хүргэх ажиллагааг штабын дарга зохион байгуулна.

501. Шилжин байрлах үед НИА-ны албан хариуцлагатны үүрэг /гүйцэтгэх ажил/-ийг ерөнхий инженер хуваарилна. Хэсэг, бүлэг /баг/-ийн ахлагч нарт зааварчилгаа өгнө.

502. Инженер, техникийн бүрэлдэхүүний бүлгийн ахлагч /цуваа бүрийн/ нар дараах баримт бичгийг заавал авч явна. Үүнд:

- бүлгийн бүрэлдэхүүний нэрсийн жагсаалт;
- шаардлагатай баримт бичиг /хэвшүүлэх ажлын заавар, техникийн ашиглалтын нууц биш заавар гэх мэт/;
- онгоц /нисдэг тэрэг/-ны дамжин өнгөрөх төлөвлөлтийн хүснэгтийн хуулбар;
- Дамжин өнгөрөх аэродром дээр онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх тоотын нэр;
- ангийн штурман, холбооны дарга нарын баталсан холбооны хэрэгсэл /радио навигацийн систем, онгоцны навигацийн иж, ижийн системд хөтөлбөр оруулах аяны замын өгөгдөхүүн/-д тохируулга хийх;
- техник хэрэгслийн нэр, жин, талбай, эзлэхүүний жагсаалт;
- техникийн гэрчилгээ, ШТМ-ын тасалбар, галт хэрэглэлийн гэрчилгээ.

503. НИА-ны бие бүрэлдэхүүн нь шилжин байрлах үед өөрийн ажлын үүргээ сайн мэддэг, түргэн чадварлаг гүйцэтгэдэг байх ёстой.

Шилжин байрлах үед НИА-ны бүрэлдэхүүнд ажлын үүргийг танилцуулах, бэлэн байдлыг шууд захирах дарга нь хариуцна.

Шилжин байрлах үед НИА-ны бие бүрэлдэхүүний хийх ёстой ажил үүргийг хүргэх, ажиллагаанд бэлэн байлгахыг шууд захирах дарга нар нь хариуцна.

504. Шилжин байрлахаар нисэн очиж буй аэродроомоос тухайн онгоцны бэлтгэлд үзүүлж чадах тусламжаас хамаарч /буулт хийх аэродромын талаар авсан мэдээг үндэслэж/ нисэн очиж буй ангийн захирагч тэргүүн бүлгийн бүрэлдэхүүнийг томилно.

Шилжин байрлаж буй аэродром дээр байгаа ангийн ахлах дарга нь нисэн ирж буй онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх, гаргах баг /дагалдах бүлгийнхэн/-т туслах зорилгоор шаардагдах инженер, техникийн бүрэлдэхүүнийг томилно. Эдгээр томилогдсон бүрэлдэхүүн шилжин байрлахаар ирж буй онгоцыг дагалдан яваа НИА-ны бүрэлдэхүүний ахлагчийн шууд удирдлага, хяналтан дор ажил үүргээ гүйцэтгэнэ.

505. Шилжин байрлахаар нисэн ирж буй онгоцыг аэродром, техник, материал хэрэгслээр хангах ажлыг уг аэродромын ангийн ахлах дарга шууд хариуцна.

506. Шилжин байрлахаар болсон хэд хэдэн ангийн олон тооны онгоц хэд хэдэн дамжин өнгөрөх аэродромыг дамжин нисэж ирэх тохиолдолд уг ангийн инженер, техникийн бүрэлдэхүүнээс инженер, техникийн албаны шуурхай хэсгийг зохион байгуулж болно.

Шуурхай хэсгийг зөвхөн ангиудын шилжин байрлалтын үед л зохион байгуулах ба эдгээр ангийн онгоцыг дамжин өнгөрөх аэродром дээр бэлтгэх, дараагийн аэродром руу нисгэх ажлыг шуурхай хэсэг хариуцна.

507. Шилжин байрлахаар нисэн ирж буй онгоцыг нислэгт бэлтгэх, хэд хэдэн анги зэрэг шилжин байрлаж байгаа тохиолдолд бэлтгэлийн дараалал, тэргүүн бүлэгт туслах ажил, түүнд хяналт тавьж ажиллахыг уг аэродром /завсрын/ дээр байрлаж байгаа ангийн ахлах дарга шууд хариуцна.

508. Суулт үйлдэж байгаа аэродром дээр уг онгоцыг дараагийн

нислэгт бэлтгэх чадвар бүхий техникийн бүрэлдэхүүн байхгүй тохиолдолд нисэх багийнхан нислэгийн бэлтгэлийг хийжгүйцэтгэхэд сургагдсан байх ёстой.

509. Дамжин өнгөрөх аэродромууд дээр онгоцыг дараагийн нислэгт бэлтгэх ажлыг онгоцонд байрлах технологийн картын дагуу нисэх багийнхан гүйцэтгэнэ.

Технологийн картанд бүх төрөл мэргэжлээр онгоцыг дараагийн нислэгт бэлтгэх ажлын жагсаалт, түлш, хий, тусгай шингэнээр цэнэглэх тоо хэмжээг заасан заавар, дээрх ажлыг хийх үед дагаж мөрдөх техникийн аюулгүйн дүрэм, бусад шаардлагатай материал тусгагдсан байна.

510. Дамжин өнгөрөх аэродром дээр онгоцыг дараагийн нислэгт бэлтгэх үед бэлтгэлийн хуудсыг 2 хувь үйлдэж, 1 хувийг нисэх багийн дарга өөртөө авна.

511. Дамжин өнгөрөх аэродром дээр нисч ирсэн онгоцны гэмтлийг арилгахын тулд уг аэродром дээр байрлаж буй ангийн инженер, техникийн бүрэлдэхүүнээс авч ажиллуулж болно. Эдгээр хүмүүсийн мэргэжлийн түвшин нь уг ажлын чанарыг хангахуйц байвал зохино.

512. Дамжин өнгөрөх аэродром дээр нисэхийн сүйдэл гарч болзошгүй болсон, эсхүл нисэхийн техникт татгалзал гарсан зэрэг шалтгааныг тодорхойлох шаардлагатай тохиолдолд бодит хяналтын хэрэгслийн өгөгдөхүүнийг тайлж уншина.

### **5.1. НИА-ны хүч хэрэгслийг агаарын тээврээр шилжүүлэн байрлуулах**

513. НИА-ны хүч хэрэгслийг агаараар шилжүүлэн байрлуулах тохиолдолд ерөнхий инженер нь албаны бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг онгоц /нисдэг тэрэг/ бүрт хуваарилсан байна. Инженер, техникийн албаны бие бүрэлдэхүүний нэр, техник хэрэгслийн жагсаалтыг гаргана. Ачаа хэрэгслийн жагсаалтад тэдгээрийн нэр, жин, эзлэхүүнийг заана.

514. Онгоц /нисдэг тэрэг/-нд ачаа ачих /суух/, буулгах /буух/ үед НИА-ны бие бүрэлдэхүүн нь тээвэрлэлтийн журам, дэглэм, тээврийн онгоцны нисэх багийн даргаас өгсөн зааврыг биелүүлнэ. Техник,

хэрэгслийг ачиж, буулгах ажлыг нисэх багийн гишүүд хянана.

515. НИА-ны ачаа, эд хэрэгслийг ачихад урьдчилан бэлтгэсэн байна. Хүнд, овор ихтэй ачаа, баглаа боодол, чингэлэг дээр тэдгээрийн жинг тонноор илэрхийлж бичихээс гадна 200 кг-аас дээш бол хүндийн төвийн байрлалыг зааж тэмдэг тавина.

516. Ачааны болон тусгай зориулалтын машин, чиргүүл дээрх ачааг найдвартай бэхлэх ба тэвшинд байгаа ачааг тооцоолсны үндсэн дээр автомашины жин, түүний хүндийн төвийг заана.

517. Ачааг явуулагч нь түүний тээвэрлэлтийн онцлогтой холбогдсон бэлтгэлийг хариуцах бөгөөд үзлэгийн үед нисэх багийн заасан зөрчлийг арилгана. Хэрэв онгоцны тоног төхөөрөмж нь ачааг ачиж буулгах, бэлтгэх, зөөх болон аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахгүй тохиолдолд нэмэлт тоног төхөөрөмжийг ачаа явуулагч тал нийлүүлнэ.

518. НИА-ны тусгай тоноглолын машинуудыг агаараар шилжүүлэн байрлуулахдаа тэдгээрийн тоноглол, чиргүүлийг ашиглалтын зааврын дагуу анхны байдалд нь оруулахаас гадна дараах зүйлсийг шалгана. Үүнд:

- тэвшин дээр болон бүхээгт байгаа тоноглолын бэхэлгээний найдвартай байдал;
- хөдөлгүүрийн шингэний систем, түүний агрегатуудын хэвийн ажиллагаа, шингэн алдаагүй байдал;
- хөдөлгүүр, тоормос, удирдлагын механизм болон арал ангийн техникийн байдал;
- дугуйн даралт зэрэг болно.

Түлшний бакуудыг эзлэхүүнийх нь 75 хувиас ихгүй түлшээр цэнэглэсэн байх ёстой.

### **Онгоцыг агаараар тээвэрлэх**

519. Онгоц /нисдэг тэрэг/-ыг тээвэрлэлтэд бэлтгэх, задлах болон тэдгээрийг тээврийн онгоцны ачааны бүхээгт байрлуулахдаа тухайн онгоц /нисдэг тэрэг/-ны ашиглалтын заавар, тээвэрлэлтийг зохион байгуулах аргачлалыг хатуу мөрдөнө.

520. Тээврийн онгоцонд онгоц /нисдэг тэрэг/-ыг ачих, татах, байрлуулах зориулалттай тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай, бүрэн иж бүрдэлтэйгээр агуулахад хадгална.

521. Онгоц /нисдэг тэрэг/-ыг тээвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг тухай бүрт нь гаргаж өгөх болон иж бүрдэл, хадгалалт, хамгаалалтыг аэродром, техник, үйлчилгээний салбар хариуцна.

522. Ачигдан ирж байгаа онгоц /нисдэг тэрэг/ болон тээвэрлэлтийн тоног төхөөрөмжийг нисэх багаас ерөнхий инженер хүлээж авна.

Тээвэрлэлтийн тоног төхөөрөмжийг хүлээн авах, хүлээлгэн өгөх ажлыг дагалдах хуудас /акт/-аар гүйцэтгэнэ.

Бүрэн хэмжээний иж бүрдэлтэй тээвэрлэлтийн тоног төхөөрөмжийн хамгаалалт, агуулахад шилжүүлэх /өгөх/ ажлыг ерөнхий инженер зохион байгуулна.

НИА-ны хэрэгцээнд зориулж уг төхөөрөмжөөс авч үлдэхийг хориглоно.

523. Онгоц /нисдэг тэрэг/-ыг гадна дүүжлүүрт нисдэг тэргээр зөөж тээвэрлэх бэлтгэлийг зөөж тээвэрлэх зааврын дагуу гүйцэтгэнэ. Тээвэрлэгдэж байгаа онгоц /нисдэг тэрэг/-ны бүхээгт хүн байхыг хориглоно.

## **5.2. НИА-ны хүч хэрэгслийг авто тээврээр шилжүүлэн байрлуулах**

524. Авто тээврээр шилжүүлэн байрлуулах ажиллагааг бие даасан цуваагаар, эсвэл ангийн цувааны бүрэлдэхүүнд оруулан гүйцэтгэнэ. Бие даасан цуваагаар шилжүүлэн байрлуулах тохиолдолд цувааны даргыг инженер, техникийн албаны удирдлагаас томилно.

525. Техник ашиглалтын анги, пуужин урьдчилан бэлтгэх байрны дарга нар авто цувааны урьдчилан хийсэн тооцоотой байх ба бие бүрэлдэхүүн, ачаа, холбоо, зэвсэг хэрэгслийг машин бүрт хуваарилж, цуваан дахь автомашины дарааллыг тогтоох үүрэгтэй.

Автомашин бүрт ахлагч томилох бөгөөд тэдгээр нь цувааны даргад захирагдана.

526. Дарга /захирагч/-ын тушаалаар томилогдож, шилжүүлэн байрлуулах ажиллагааг удирдан явуулж буй цувааны дарга нь машины ахлагч нарт зааварчилгааг өгч, түүний баталгаажсан томилолтыг гардуулна.

Цувааны дарга газрын зураг дээр явах маршрут, хөдөлгөөний график бусад өгөгдөхүүнийг тэмдэглэнэ. Явах маршрутаа

нарийвчлан тодотгохын тулд газар орны байдалд урьдчилан туршуул явуулна. Цувааны бүрэлдэхүүн дэх автомашины хөдөлгөөний зохион байгуулалтыг 9 дүгээр хавсралтаар үзүүлэв.

### **5.3. НИА-ны хүч, хэрэгслийг төмөр замын тээврээр шилжүүлэн байрлуулах**

527. НИА-ны хүч, хэрэгслийг төмөр замаар шилжүүлэн байрлуулах ажлыг нисэхийн техникийн ашиглалтын зааврын дагуу гүйцэтгэнэ. НИА-ны техник, хэрэгслийг шилжүүлэн байрлуулах тооцоог гаргахдаа төмөр замаар тээвэрлэдэг ачааны овор хэмжээг бодолцон хийнэ.

528. Аэродром, техникийн хангалтын салбар нь төмөр замын тээврээр шилжүүлэн байрлуулах НИА-ны хүч, хэрэгслийг ачаалах, буулгах хэрэгсэл, боодлын хайрцаг сав болон нисэхийн техникийг бэхлэх материал хэрэгслээр хангана.

529. Нисэхийн техниктэй төмөр замын цувааг шилжин байрлахаар гарахын өмнө цувааг дагалдан яваа хүмүүст галын аюулгүйн арга хэмжээ, ачааг бэхлэх журам, тэдгээрт тавих ажиглалтын талаар ерөнхий инженер зааварчилгааг өгнө.

Онгоц /нисдэг тэрэг/-ыг төмөр замаар тээвэрлэх үеийн харуул, хамгаалалтыг ангийн штабаас зохион байгуулна.

530. Онгоц /нисдэг тэрэг/-ыг техникийн ашиглалтын зааврын дагуу хадгалалтад оруулж төмөр замаар тээвэрлэнэ.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ.**

### **Нисэхийн техникийн засвар**

#### **6.1. Ерөнхий ойлголт**

531. Нисэхийн техникийн засвар нь түүний ажлын чадвар, ресурсийг сэргээхээр хийгдэнэ.

Засварыг ажлын багтаамжаар нь их, дунд /урьдчилан сэргийлэх/, урсгал, жижиг гэж ангилна. Засварыг гүйцэтгэх газраар нь үйлдвэрийн ба цэргийн засвар гэж ангилна.

Засварыг нисэхийн засварын үйлдвэр ба цэргийн засварын газар, явуулын бригад буюу байгууллагын бие бүрэлдэхүүний хүчээр гүйцэтгэнэ.

532. Нисэхийн техникийн засвар хоорондын болон тогтоосон /техникийн/ ресурс дууссаны дараа ресурсийг дахин сэргээх,

эсвэл түүний бүтцийн үндсэн элементүүд эвдэрсэн тохиолдолд их засварыг хийнэ.

533. Тусгай систем, агрегат, зангилаа, механизмын ажлын чадварыг сэргээх зорилгоор тогтоосон хугацаанд ажилласан /нислэг үйлдсэн/ цаг, эсвэл ашиглалтын тогтоосон хугацаа дууссан, түүнчлэн эвдэрсэн тохиолдолд дунд /урьдчилан сэргийлэх/ засварыг хийнэ.

534. Нисэхийн техникийн жижиг хэсгүүд, зангилаа, механизм, блок, хэрэгсэл болон агрегатуудад гарсан эвдрэл, гэмтлийг арилгах зорилгоор урсгал засварыг явуулна.

Жижиг засвар нь жижиг хэсгүүд, зангилаа, механизм, хэрэглэл болон агрегатуудад гарсан эвдрэл, гэмтлийг арилгах зорилготой.

535. Нисэхийн техникт хийх засварын төрлийг НИА-ны комисс тогтооно. Нисэх ангийн захирагч, ерөнхий инженер техникийн актыг үндэслэн гэмтэлтэй нисэхийн техникийг үйлдвэрийн нөхцөлд засварлуулах шийдвэрийг АЦК-ын Улсын нисэхийн хэлтэс гаргана.

536. Ерөнхий инженер нисэхийн техникт гарсан эвдрэл, гэмтлийг инженер, техникийн бүрэлдэхүүний хүчээр арилгах арга хэмжээг авна.

Хэрэв хөдөлгүүр, зангилаа, агрегат, хэрэглэлийг солих замаар эвдрэл, гэмтлийг арилгасан бол эвдрэл, гэмтэл гарсан шалтгааныг судалж, тухайн гэмтэлтэй жижиг хэсгүүдийг засвар хийсэн газар руу буцааж явуулна.

## **6.2. Нисэхийн техникийн найдвартай ажиллагааг хангах**

537. Нисэхийн техникийн найдвартай ажиллагаа нь нислэгийн бэлэн байдал, үр дүнтэй, аюулгүй ажиллагааны нэг үндсэн нөхцөл болно.

538. Нисэхийн техникийн найдвартай ажиллагаа гэж тогтоогдсон хугацаа /нислэг/-ны туршид үйл ажиллагаагаа явуулж, улмаар өгөгдсөн хязгаарлалтын дотор өөрийн нислэг-техникийн хүчин чадлыг хадгалах чадварыг хэлнэ.

539. Нисэхийн техникийн найдвартай ажиллагаа нь:

- ашиглалтын болон засварын заавар, дүрмийг хатуу чанд биелүүлснээр;

- тэргүүн туршлага нэвтрүүлэх үндсэн дээр ашиглалт болон засварын чанарыг байнга дээшлүүлснээр;

- ашиглалт болон үйлчилгээ, засварын ажлын туршлагыг тогтмол хуримтлуулан баяжуулах үндсэн дээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж нэвтрүүлэх, түүнчлэн нисэхийн техникийн ажиллагааны гэмтэл, татгалзал, ашиглалтын явцад нисэх ба инженер, техникийн бүрэлдэхүүнээс гаргасан алдаанд дүн шинжилгээ хийх замаар;

- хийж гүйцээх ажлыг цаг тухайд нь гүйцэтгэснээр тус тус хангагдана.

540. Нисэхийн техникийн найдвартай ажиллагааг дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

- агаарт гарсан гэмтэл татгалзалд дүгнэлт хийж ажилласан;

- гэмтэл, дутагдлыг газарт болон агаарт илрүүлэн завсарлаж ажилласан зэрэг болно.

541. Нисэхийн техникийн татгалзал гэж агаарт болон газарт илэрсэн аливаа /бүрэн, хэсэгчилсэн, түр зуур/ ажиллах чадварын алдагдлыг хэлнэ.

Хөөрөлтийн үед нисэх хэрэгсэл хөдөлгөөнөө эхэлсэн мөчөөс эхлэн суултанд орж хөөрөх, буух зурвасыг чөлөөлж дуусах хүртэлх хугацаанд тохиолдсон татгалзлууд нь агаарт гарсан татгалзалд хамаарна.

542. Эвдрэл, гэмтэл гэж систем /агрегат/, түүний элемент /зангилаа, жижиг хэсэг/-үүд нь ашиглалтын шаардлагыг хангахгүй байгаа, эсвэл ажиллах чадварыг алдагдуулсан эсэхээс үл хамааран ашиглалт болон үйлчилгээ, засварын баримт бичгийн аливаа шаардлагад тохирохгүй байгааг хэлнэ.

543. НИА нь нисэхийн техникийн найдвартай ажиллагааг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг боловсруулахад шаардлагатай үндэслэл бүхий өгөгдөхүүнийг авах зорилгоор дараах ажлыг тогтмол явуулна. Үүнд:

- ашиглалтын болон засварын явцад илэрсэн бүх эвдрэл, гэмтлийн бүртгэл, тооцоог хөтлөх;

- нисэхийн техникийн найдвартай ажиллагаанд тогтмол дүн шинжилгээ хийх;

- онгоц/нисдэг тэрэг/-ыг туршин нисэх журмаар;

- ажилласан цаг нь янз бүр байх үед нисэхийн техникийн байдалд судалгаа хийх;

- нисэхийн техникийн гүйцээж хийгдсэн ажилд дүн шинжилгээ хийх.

544. Нисэхийн анги /байгууллага/-д техникийн эвдрэл, гэмтлийн бүртгэл, тооцоог хөтөлнө.

Эвдрэл, гэмтлийн бүртгэл тооцоо, дүн шинжилгээний үндсэн баримт бичигт эвдрэл, гэмтлийг бүртгэх дэвтэр, онгоц /нисдэг тэрэг/-ны нислэгийн бэлтгэлийн дэвтэр, хэвшүүлэх ажлын бүлгийн даргын дэвтэр орно.

545. НИА-ны албан тушаалтнууд нисэхийн техникийн эвдрэл, гэмтлийн тухай бүрэн мэдээллийг байгууллагын удирдлагад цаг тухайд нь хүргэх хариуцлагыг хүлээнэ.

546. Нисэхийн техникийн найдвартай ажиллагаанд тогтмол дүн шинжилгээ хийх нь НИА-ны албан тушаалтны үүрэг мөн. Найдвартай ажиллагаанд хийх дүн шинжилгээг урсгал ба үечилсэн гэж ангилна.

Урсгал дүн шинжилгээг нисэх хэрэгслийн систем, агрегатад илэрсэн эвдрэл, гэмтэл бүрийн шалтгааныг тогтоох, улмаар ижил төстэй тохиолдлоос урьдчилан сэргийлэх шуурхай арга хэмжээг авах зорилгоор явуулна.

Үечилсэн дүн шинжилгээг:

- нисэхийн техникийн найдвартай ажиллагааны чанарын үзүүлэлтүүд, тэдгээрийн өөрчлөгдөх хандлага, нөхцөл шалтгааныг тодруулах;

- ашиглалтын явц дахь нисэхийн техникийн өгөгдөхүүнүүдийн өөрчлөлт, ажлын болон ачааллын нөхцөлд үнэлгээ өгөх;

- инженер, техникийн бүрэлдэхүүний ажлын үр дүнд үнэлгээ өгөх;

- нисэхийн техникийн нислэгийн бэлтгэл болон хэвшүүлэх ажлын гүйцэтгэл, эвдрэл, гэмтлийг арилгах хүн/цагийн (хөдөлмөр зарцуулалт) дүн шинжилгээ хийх;

- ашиглалтын баримт бичгийн үнэлгээ хийх;

- бэлтгэлийн төрлүүдээр нисэхийн техникийн байдалд хийж байгаа хяналтын үр нөлөөний үнэлгээ өгөх;

- эвдрэл, гэмтлийн дүн шинжилгээ, бүртгэл тооцооны байдлын үнэлгээг тогтоох зорилгоор явуулна.

547. Нисэхийн техникийн эвдрэл, гэмтлийн шалтгааны дүн

шинжилгээнд:

- онгоц /нисдэг тэрэг/-ны болон газрын хяналтын хэрэгслийн тогтвортой үзүүлэлтүүд, нислэгийн өгөгдөхүүнүүдийг бүртгэгч газрын болон онгоц /нисдэг тэрэг/-ны хэрэгслийн бичлэгийг ашиглан нисэхийн техникийн эвдрэл, гэмтэл үүссэн байдал, түүний ажлын нөхцлийг судлах;

- засвар болон ашиглалт нь зааврын дагуу зөв явагдаж буй эсэхийг шалгах;

- ижил төстэй эвдрэл, гэмтлийг ангилах, тэдгээрийн бүртгэлийн материалыг судлах;

- эвдрэл, гэмтлийн байдлыг түүний гаднах шинж тэмдгээр нь тодорхойлох болон хяналт шалгалтын хэрэгслийн тусламжтай илрүүлэх боломжид үнэлгээ өгөх;

- зангилаа, жижиг хэсгүүдийн байдлыг тодорхойлохын тулд эвдрэл, гэмтлийн шинжийг тодруулах шалгалт явуулах, шаардлагатай бол задаргаа хийх;

- эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоох, түүнийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах зэрэг багтана.

548. Нислэгийн үүрэг гүйцэтгэж чадахгүйд хүргэсэн урьдчилсан нөхцөл болон татгалзал /саатал/-д, нисэхийн сүйдлийн урьдчилсан нөхцөл гарахад хүргэсэн татгалзал /саатал/-ыг арилгах зэрэгт ерөнхий инженер дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.

Тухайн төрөл мэргэжлийн инженер, нисэх багийн гишүүдийг оролцуулан нислэг, нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй, түүнчлэн нислэгийн үүрэг гүйцэтгэж чадахгүйд хүргэсэн эвдрэл, гэмтэлд дүн шинжилгээ хийнэ.

Ерөнхий инженер эдгээр эвдрэл, гэмтлийн талаар хийсэн шинжилгээний үр дүн, авсан арга хэмжээнийхээ талаар анги /байгууллага/-ийн дарга болон Зэвсэгт хүчний АЦК-д илтгэнэ.

549. Газрын радиотехникийн хэрэгсэлтэй харилцан ажиллагаатай онгоц /нисдэг тэрэг/-ны радиоэлектрон тоноглолын эвдрэл, гэмтлийн шалтгааныг тодруулахад газрын хэрэгслийн ажиллагааг хариуцагч нарыг оролцуулна.

550. Ерөнхий инженер нь аэродром, техникийн хангалтын

доголдолтой холбогдож гарсан нисэхийн техникийн эвдрэл, гэмтэл, татгалзлын шалтгааныг тодруулахад холбогдох албан тушаалтнуудыг оролцуулна.

551. Эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоохын тулд нисдэг лаборатори, түүнчлэн нисэхийн техник нь баталгаат хугацаатай бол үйлдвэрлэгч-нийлүүлэгчийн газрын төлөөлөгч, хэрэв засвар хийлгэсэн бол нисэхийн засварын үйлдвэрийн төлөөлөгчдийг дуудаж оролцуулна.

552. НИА-ны албан тушаалтнууд нисэхийн техникийн эвдрэл, гэмтлийг илрүүлсэн шинжилгээний үр дүнгээр дараах ажлыг заавал хийнэ. Үүнд:

- бие бүрэлдэхүүний хамт эвдрэл, гэмтлийн шинж байдал, шалтгаан болон тэдгээрийг илрүүлэх, арилгах, урьдчилан сэргийлэх арга замыг судлах;

- нисэхийн техникийн онцлог, түүний ашиглалт, хадгалалт болон засварын нөхцлийг харгалзан тооцоолж, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар нэмэлт ажил явуулах.

553. Анги /байгууллага/-д эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоож чадаагүй буюу урьд нь гарч байгаагүй эвдрэл, гэмтэл илэрвэл уг нисэхийн техникийн асуудлыг Зэвсэгт хүчний АЦК-ын Улсын нисэхийн хэлтэст илтгэнэ.

554. Үечилсэн дүн шинжилгээг сар тутам хийнэ. Шинжилгээний үр дүнг НИА-ны бие бүрэлдэхүүнд танилцуулж, Зэвсэгт хүчний АЦК-д илтгэнэ.

555. НИА-ны хийсэн дүн шинжилгээний үндсэн дээр нисэхийн техникийн найдвартай ажиллагааг хангах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- бие бүрэлдэхүүний бэлтгэлийн болон ажлын дутагдал доголдлыг арилгах;

- нисэхийн техникийн ашиглалт, засвар, хадгалалт, зохион байгуулалтын хэлбэр болон хэрэгсэл, арга барилыг боловсронгуй болгох;

- засварын болон хэвшүүлэх ажлууд, онгоц/нисдэг тэрэг/-ны нислэгийн бэлтгэлийн үечлэл, багтаамжийг нарийвчлан тодотгох, гүйцэтгэх аргачлалыг боловсронгуй болгох;

- нисэхийн техникийн засвар, ашиглалтын зориулалттай материал, сэлбэг хэрэгслийн бүрдүүлэлт болон зарцуулалтын хэмжээний талаар саналаа боловсруулах зэрэг багтана.

### **6.3. Нисэхийн техникийн нэмэлт ажлыг явуулах**

556. Нисэхийн техникийг сайжруулж, шинэчлэх, боловсронгуй болгох, түүнд байгаа бүтэц, үйлдвэрийн дутуу хийгдсэн зүйлсийг засахад “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч”/завод/-ийн мэдээ /бюллетень/-ний дагуу нэмэлт ажлыг явуулж хэрэгжүүлнэ.

557. Нэмэлт ажлыг дарга /захирагч/-ын баталсан засварын төлөвлөгөөний дагуу “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч” /завод/, эсхүл байгууллагын засварын газар /ТАА/-т гүйцэтгэнэ. Засварын төлөвлөгөөнд онгоц /нисдэг тэрэг/-нд нэмэлтээр хийх ажлыг оруулж ээлж, гүйцэтгэх хугацааг тодруулна.

558. Нэмэлт ажлыг ерөнхий инженер зохион байгуулна.

Төрөл мэргэжлийн инженерүүд мэдээний /бюллетень/ тооцоог хөтөлж, шаардагдах агрегатуудын хэрэгцээг тодруулж илтгэх ба тэдгээрийг иж бүрдлээр хүлээж авахад нь хяналт тавьж, нэмэлт ажлын гүйцэтгэлийг онгоц /нисдэг тэрэг/ тус бүрээр нь тооцож, тайлан гаргана.

559. ТАА-ийн дарга бүх төрөл мэргэжлийн дагуу ирсэн мэдээ /бюллетень/-ний бүрэн хэмжээний жагсаалт гарган хөтлөх бөгөөд онгоц /нисдэг тэрэг/-ыг хэвшүүлэх ажилд орох үед нэмэлт ажлын гүйцэтгэлийг бодит байдал дээр нь шалгана.

560. “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч” /завод/-ийн гүйцэтгэж байгаа сайжруулах ажлын чанар, гүйцэтгэлийг нийлүүлэгчийн төлөөлөгчид хариуцна.

561. Үйлдвэрээс хийж гүйцэтгэсэн ажлыг техник ашиглалтын хэсгийн дарга, үйлчилгээ /хэвшүүлэх ажил/-ний бүлгийн даргаас доошгүй албан тушаалтай төрөл мэргэжлийн мэргэжилтнүүд хүлээж авна.

562. Мэдээ /бюллетень/-ний дагуу хийгдсэн ажлын дараа үйлдвэрээс ирсэн төлөөлөгч болон байгууллагын төрөл мэргэжлийн инженерүүд гүйцээж хийсэн ажлынхаа тухай онгоц /нисдэг тэрэг/-ны формуляр /паспорт/-т бичилт хийнэ.

563. Мэдээ /бюллетень/-ний дагуу хийгдсэн бүх ажлын талаар

үйлдвэрээс ирсэн төлөөлөгч болон байгууллагын төрөл мэргэжлийн инженерүүд техникт нотломж бичнэ.

564. Нийлүүлэгчээс мэдээ /бюллетень /-нд заагдсан хугацаандаа хийгээгүй, эсхүл чанар муутай, технологи зөрчиж гүйцэтгэсэн нэмэлт ажлын талаар тухайн онгоц /хэрэглэл, агрегат, систем/ баталгаат хугацаатай эсэхээс үл хамааран, тогтоогдсон журмын дагуу санал, гомдлоо гаргана.

565. Анги /байгууллага/-ын хүчээр гүйцэтгэсэн нэмэлт ажлын чанарыг хийсэн бүрэлдэхүүн хариуцна. Инженер, техникийн бүрэлдэхүүний хийсэн нэмэлт ажлын бичилтийг онгоцны формуляр /хэрэглэл, агрегат, системийн паспорт/-т техник ашиглалтын хэсгийн болон үйлчилгээ/хэвшүүлэх ажил/-ний бүлгийн дарга нар хөтөлж, төрөл мэргэжлийн инженерүүд хянана.

566. Нисэхийн техникийн хийц болон ерөнхий-угсралтын бүдүүвчийг өөрчлөх, бүдүүвчинд заагаагүй агрегат, хэрэгслийг залгаж шалгах, хийцэд нь заагаагүй агрегат, төхөөрөмжийг угсрах, түүнчлэн тухайн онгоц /нисдэг тэрэг/-ны техникийн ашиглалтын зааварт заагдаагүй нисэхийн материал, ШТМ, тусгай шингэн, шахсан хий хэрэглэхийг хориглоно.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ.**

### **Аэродром дээрх нисэхийн техникийн байрлал, хамгаалалт, галын аюулгүйн арга хэмжээ**

#### **7.1. Аэродром дээрх нисэхийн техникийн байрлал**

567. Аэродром дээр онгоц /нисдэг тэрэг/-ыг хамгаалалттай нуувчинд болон тусгай тоногдсон талбайд байрлуулна.

Онгоц /нисдэг тэрэг/, байлдааны иж, газрын ба ээлжийн тоног төхөөрөмж, техникийн албаны байр байрлаж байгаа аэродромын нутаг дэвсгэрийг онгоцны зогсоол гэнэ.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл ба тусгай газрын төхөөрөмжийг хамгаалагдсан техникийн бүсэд байрлуулна.

Аэродром дээр нисэхийн техник, нисэхийн хөнөөх хэрэгсэл байрлуулах журмыг анги, байгууллагын дарга тодорхойлно.

568. Байнгын аэродром нь:

- нисэхийн техникийн нуувч, нисэхийн хөнөөх хэрэгслийн иж, газрын үйлчилгээний тусгай хэрэгслээр;

- бие бүрэлдэхүүнийг ердийн болон үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах хоргодох байр;

- ТАА-ийн болон нисэхийн салбарын тусгай зориулалтын машины далдлах байраар;

- онгоц /нисдэг тэрэг/ бэлтгэх техникийн байрлалаар;

- онгоц /нисдэг тэрэг/-н дээр тавигдаагүй тоног төхөөрөмж, нисэхийн хөнөөх хэрэгслийн ижийг хадгалах байраар;

- нууцалсан аппарат, блок, зангилаа, баримт бичиг, тэдгээрийн тусгаарлан хадгалах байраар;

-ТАА-ийн нуувч-лаборатори, хэвшүүлэх болон засварын ажил хийх онгоцны зогсоолын талбайгаар;

- НИА-ны удирдлагын байраар;

- нисэн ирж /буулт хийгээд нисч/ байгаа онгоцны зогсоолоор;

- түлшээр сумлах, шахсан хийгээр цэнэглэх, цахилгаан эрчим хүчээр хангах төвлөрсөн хэрэгслээр;

- пуужин урьдчилан бэлтгэх болон хадгалах байраар;

- нисэхийн техникийн бэлтгэл, нислэгт үйлчилж байгаа бие бүрэлдэхүүний хооллох, амрах байраар;

- өндрийн, нислэгийн болон техникийн хувцсыг хадгалах, хатаах, сольж өмсөх байраар;

- тоормосны болон аврах шүхрийг хатааж эвхэх, хадгалах байраар;

- зэвсэглэлийн тогтоол буудлага хийх газраар;

- нисэхийн техникт тусгай ариутгал хийх талбайгаар;

- хараалах станцын ажиллах чадварыг шалгах, тохируулга, нарийн хэмжилт хийх болон радио, соронзон луужингуудын девиацийг арилгах талбайгаар;

- нисэхийн хөнөөх хэрэгслийг бэлтгэх талбайгаар;

- зэвсэглэл хэрэглэсэн нислэгийн дараа түүний байдлыг шалгахад зориулсан талбайгаар;

- хөдөлгүүрийг асааж шалгах талбайгаар;

- холбооны хэрэгслээр тоноглогдсон байна.

Нисэхийн техникийн ашиглалтыг хангахад зориулагдсан барилга, байгууламжийн хэмжээ нь байрлалтын нөхцөл, гүйцэтгэж байгаа нөхцөл, зэвсэглэлд байгаа нисэхийн техникийн хэлбэр,

маягаас хамаарна.

569. Онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоол нь нисэхийн техникийн хадгалалт, хамгаалалт, тэдгээрийн нислэг болон байлдааны хэрэглээний бэлтгэл ажлыг хангахуйц, шаардлагатай байгууламжаар тоноглогдсон байна.

Нисэхийн хөдөлгүүрийн ажиллагааг “максималь” болон “форсаж” горим дээр шалгахын тулд ТАА-ийн онгоцны зогсоол дээр хиймэл хучилттай талбайг тоноглоно.

Хөдөлгүүрийг асааж, шалгах талбай нь онгоцыг бэхлэх нэмэлт төхөөрөмж, дугуйны ивээс, гарч байгаа хийг чиглүүлэх төхөөрөмж, гал унтраах багаж хэрэгсэлтэй байна.

Зогсоолд онгоц /нисдэг тэрэг/ явгалах буюу түүнийг чирэх, газрын үйлчилгээний хэрэгсэл очих /ойртох/ аюулгүй байдлыг хангасан зам тавина.

570. Онгоц/нисдэг тэрэг/-ыг бүлгээр байрлах зогсоол/техникийн бэлтгэлийн байр/ дээр байрлуулсан үед зэргэлдээ онгоцнуудын далавчны үзүүрийн хоорондын зай нь дараах байдлаар байна. Үүнд:

- нэг хөдөлгүүртэй онгоцнуудын хооронд 2 м-ээс багагүй;
- хоёр хөдөлгүүртэй онгоцнуудын хооронд 3 м-ээс багагүй;
- дөрөв, түүнээс олон хөдөлгүүртэй бол 5 м-ээс багагүй.

Далавчныхаа суман хэлбэрийг өөрчилдөг онгоцнуудын зайг уг далавчны хамгийн бага өнцөгтэй үед нь тогтооно.

Нисдэг тэрэгнүүдийн сэнсний тэнхлэгээс авсан хоорондох зай нь даах сэнснийхээ хоёр диаметрээс багагүй байна.

571. Онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоол нь инженер, техникийн бүрэлдэхүүний ажлын нөхцөл, онгоц оруулах, гаргах бүх боломжийг хангасан байна.

Онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоол /нуувч/-ыг дараах зүйлсээр тоноглоно. Үүнд:

- онгоцны газардуулга, аргамжих хэрэгслээр;
- авагддаг тоног төхөөрөмжийг байрлуулах байраар;
- инженер, техникийн бүрэлдэхүүний ажлын байраар;
- цахилгаан эрчим хүч, түлш, шахсан хийгээр хангах төвлөрсөн хэрэгслээр;
- гал унтраах тоноглол, хэрэгслээр;

- газрын үйлчилгээний тусгай хэрэглээний хэрэгслийг байрлуулах байраар.

Бэлэн байдал, аюулгүйн арга хэмжээг хангах шаардлагын үүднээс далдлавч болон онгоцны зогсоол дээр тоног, төхөөрөмжийг байрлуулах нэгдсэн журмыг ерөнхий инженер тогтооно.

Нисэхийн хөнөөх хэрэгслийн иж болон бялтат техник, идэвхгүй саатуулгын хэрэгслийг байрлуулах, хадгалах журмыг ангийн захирагч тодорхойлно.

Авагддаг тоног төхөөрөмжийг үйлчилгээний бүлгийн /бэлтгэх/ байранд, эсхүл тусгай чингэлэгт хадгална.

572. Аэродром дээр гэнэтийн аюул тохиолдсон үед бие бүрэлдэхүүн, нисэхийн техник, газрын үйлчилгээний хэрэгслийг байрлуулах аюулгүйн бүсийг тодорхойлно.

573. Байгалийн гэнэтийн аюул тохиолдсон үед нисэхийн техникийн аюулгүй байдлыг хангахуйц шаардлагатай аргамж хэрэгслээр нисдэг тэрэг, хөнгөн онгоцны задгай зогсоолыг тоноглоно. Ажил дууссаны дараа цаг агаар ямар байгаагаас хамаарахгүйгээр нисдэг тэрэг, хөнгөн онгоцыг аргамж, уяа, хавчаараар бэхэлнэ.

574. Онгоц /нисдэг тэрэг/-ыг зогсоол дээр байх үед дугуйн дор тулгуур ивээс тавих бөгөөд урьдчилан заасан бол аргамжина. Ерөнхий инженер онгоц /нисдэг тэрэг/-ыг бүтээлгээр бүтээх хувилбарыг тодорхойлно.

Авагддаг таглаа, урьдчилан сэргийлэх түгжээг улаан өнгөөр будаж, онгоцны дугаараар тэмдэглэн, ашиглалтын зааврын дагуу тавина. Эдгээрийн болон онгоцны жижиг хэсэг, зэвсэглэлийн тусгай агрегатуудын бүтээлэгт суурь нь 0.1 м, урт нь 0.3 м гурвалжин улаан дарцаг хадна.

575. Түлшээр сумлах, шахсан хийгээр цэнэглэх, цахилгаан эрчим хүчээр хангах төвлөрсөн системийн хэрэгслээр онгоцны зогсоол, далдлавчийг тоноглох үед тэдгээрийг хэрэглээнд бэлтгэх, техникийн үйлчилгээ, засварын ажлыг гүйцэтгэх, ажиллагаанд эвдрэл, гэмтэлгүй байнга бэлэн байлгахыг нисэхийн техникийн мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

576. Онгоцны нуувчийн ашиглалт, түүний тоног төхөөрөмжийн хамгаалалт, аюулгүйн арга хэмжээний мөрдөлт, тогтоогдсон хэв журам, түүний орчин тойрны нутаг дэвсгэрийн хамтаар уг нуувчийг

харьяалуулсан албан тушаалтнууд хариуцна.

577. Үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах шаардлагатай уялдуулан нисэхийн техникийн бэлэн байдлыг хангахуйц, ажиллахад хамгийн тохиромжтой бүсүүдэд ТАА, ПУББ болон бусад НИА-ны салбарыг тараан байрлуулна.

578. Онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоол, аэродром дээрх байгууламжийн бэлтгэл, бэлэн байлгах, засварыг аэродром, техникийн үйлчилгээний салбар гүйцэтгэнэ.

НИА-ны бие бүрэлдэхүүн нь байгууламжийг ашиглах заавар, галын аюулгүйн арга хэмжээг мөрдөж, бүх байрыг тогтмол цэвэр, журамтай байлгахыг хариуцна.

## **7.2. Нисэхийн техникийн хамгаалах нуувч /ангар/-ийг ашиглах, бэлэн байлгах**

579. Байгууллагын дарга/захирагч/-ын тушаалаар онгоцны нуувч бүрийг онгоцны техникчид, нисэх хэсгийн онгоцны нуувчуудын бүсийг техник ашиглалтын хэсгийн дарга нарт харьяалуулна.

Онгоцны нуувчуудыг дугаарлан, хариуцагчийн овог нэрийг заана.

580. Онгоцны нуувчууд, тэдгээрийн тоног төхөөрөмжийн техник үйлчилгээг зааврын шаардлагын дагуу аэродром, техник хангалтын салбарын бие бүрэлдэхүүн гүйцэтгэнэ.

581. Ерөнхий инженер улиралд 1-ээс доошгүй удаа хамгаалах нуувч, тэдгээрийн тоног төхөөрөмжийн байдлыг шалгана,

582. Хаалттай төрлийн хамгаалах онгоцны нуувчинд нислэгийн бүх төрлийн бэлтгэл, тоног төхөөрөмжийн техникийн байдлын шалгалт, нисэхийн техникийн урсгал засвар хийх, түүнчлэн онгоц /нисдэг тэрэг/-ыг нисэхийн төрөл бүрийн хөнөөх зэвсэглэлээр цэнэглэх, хөдөлгүүрийг асааж, тогтоосон хязгаарлалт, аюулгүйн арга хэмжээг мөрдөх замаар явгалаулж гаргахыг зөвшөөрнө.

Хамгаалах нуувчинд онгоц /нисдэг тэрэг/-н дээр ажиллаж байх үед 36 В-оос илүүгүй хүчдэлтэй зөөврийн цахилгаан хэрэгсэл хэрэглэж болно.

583. Хаалттай төрлийн хамгаалах нуувчинд дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

- Онгоц /нисдэг тэрэг/-ны ажиллах чадвар болон бусад тоног төхөөрөмжийн системийг шалгах зорилгоор хөдөлгүүр асаах;

- нисэхийн бөмбөг болон бусад хөнөөх хэрэгслийн битүүмжлэгдсэн боодлыг задлах;

- ил задгай гал /дөл/ гаргаж хэрэглэх, оч үүсгэхтэй холбоотой ажлыг нисэхийн техник дээр хийх, цахилгаан хөдөлгүүр, аливаа зуух, пийшинг бензин, спиртээр асаах.

584. Ажлын өдөр дууссаны дараа, бие бүрэлдэхүүн хооллох, сургалт болон техникийн ярианд суух гэх мэтэд хамгаалах нуувчийн хаалгыг хаана.

### **7.3. Онгоц /нисдэг тэрэг/-ны хамгаалалт**

585. Ажлын бус цагаар аэродром дээрх онгоц /нисдэг тэрэг/, байлдааны иж, ПУББ, түүний объектын хамгаалалтыг Монгол Улсын “Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм”-ийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

Жижүүрийн онгоц /нисдэг тэрэг/, ерөнхий зориулалтын газрын үйлчилгээний хэрэгслийн хамгаалалтыг НИА-ны болон аэродром, техникийн хангалтын салбарын бие бүрэлдэхүүн байлдааны жижүүрлэлтийн зааврын дагуу гүйцэтгэнэ.

586. Зогсоол дээр ажил явагдаж байгаа үед онгоц /нисдэг тэрэг/, албаны объект, тоног төхөөрөмжийн хамгаалалтыг тухайн объект, онгоц /нисдэг тэрэг/-ыг харьяалдаг инженер, техникийн бүрэлдэхүүн хариуцна.

587. Ажлын цагаар техникийн бүрэлдэхүүн байхгүй үед нисэхийн техникийг хамгаалах зорилгоор онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоолын жижүүрийг байгууллагын дарга /захирагч/-ын тушаалаар томилно.

Зогсоолын жижүүрт офицер, ахлагчийг томилно. Зогсоолын жижүүр нь анги /байгууллага/-ийн жижүүрт захирагдах бөгөөд дотоод албаны журмын хувьд ерөнхий инженерт захирагдана.

588. Зогсоолын жижүүрийн дүрэмт хувцас нь техникийн ажлын хувцас, зэвсэглэл нь орон тооных байна. Жижүүрийн зүүн гарт ОЗЖ /онгоцны зогсоолын жижүүр/ гэж улаан даавуун дээр цагаанаар бичиж зүүнэ. Тэмдгийн хэмжээний урт нь 30 см, өргөн 10 см, үсгийг 1 см-ийн өргөнтэйгээр бичнэ.

589. Зогсоолын жижүүр нь байгууллагын дарга /захирагч/ гарын үсэг зурж, тамга дарсан нэг удаагийн зөвшөөрлийн бичгээр

харуулаас хамгаалалтад нь байгаа зогсоолыг нээж, онгоц /нисдэг тэрэг/-ыг хүлээж авна.

590. Зогсоолын жижүүрээс онгоц /нисдэг тэрэг/-ны техникч, эсхүл механикч нь “Онгоц /нисдэг тэрэг/ хүлээлцэх дэвтэр”-т гарын үсэг зурж, онгоц /нисдэг тэрэг/-ыг хүлээлцэнэ.

Хүлээлцэх үед онгоц /нисдэг тэрэг/-нд гадна эвдрэл, гэмтэл учирсан, эсхүл лац нь хөдөлсөн байвал холбогдох дарга нарт нэн даруй илтгэнэ.

591. Зогсоолын жижүүр нь тогтоогдсон журмын дагуу зогсоолыг цаг тухайд нь нээх, хамгаалалтад хүлээлгэж өгөхийг хариуцна. Зогсоолын жижүүр нь зогсоолыг нээсний дараа НИА-ны удирдлагын байранд, эсхүл зогсоол дээр, зогсоолыг хаасны дараа аэродром дээр тогтоосон байранд байрлана.

592. Зогсоолын жижүүр нь зогсоолыг хүлээж авснаас харуулд хүлээлгэж өгөх хүртэлх хугацаанд хамгаалалтыг хариуцна. Тэр:

- хамгаалж байгаа онгоц /нисдэг тэрэг/-ны тоо, дугаар, харьяалсан техникч /механикч/-ийг мэдэх;

- ямар онгоц /нисдэг тэрэг/-нд ажил хийгдэх, ямар онгоц /нисдэг тэрэг/-ыг зогсоолоос нь хэдийд авч /явгалуулж/, буцааж тавихыг мэдэх;

- ажил хийхээр урьдчилан заагдаагүй онгоц /нуувч/-ыг онгойлгуулахгүй байх;

- гал команд дуудах, гал түймэр унтраах хэрэгслийг зогсоол дээр байрлуулах журмыг мэдэж, ашиглаж чаддаг байх;

- объектуудыг харуулын хамгаалалтад өгөх, тэдгээрийг хүлээж авах;

- онгоц /нисдэг тэрэг/-ны гадна байдал, лац болон албаны объектуудыг техникийн бүрэлдэхүүн, харуулаас хүлээж авахдаа шалгах;

- бие бүрэлдэхүүний өнгөлөн далдлалтын зааврын мөрдөлтийг хянах, бие бүрэлдэхүүний тогтоогдсон зарлан мэдээлэх дохиоллыг өгөх;

- галын аюулгүйн арга хэмжээ, бие бүрэлдэхүүн, авто тээврийн аэродром дээрх хөдөлгөөний дүрмийн биелэлтийг шалгах;

- хамгаалах нуувчуудын хаалга хаагдсан эсэхийг хянах

үүрэгтэй.

Зогсоолын жижүүрийн бэлтгэлийг шууд захирах дарга нар нь хариуцна.

Зогсоолын жижүүрийг түүний үүрэгтэй холбогдолгүй ажилд томилохыг хориглоно.

593. Зогсоол /нуувч/-оос явгалах төлөвлөгөөгүй онгоц /нисдэг тэрэг/ гарах тохиолдолд уг явгалалтыг зогсоох бүхий л арга хэмжээг авна.

594. Зогсоолын жижүүрийг хооллохоор явах үед үүргийг нь зааварчилгаанд заагдсан хүмүүс гүйцэтгэнэ.

595. Ажлын өдөр дууссаны дараа бүх онгоц /нисдэг тэрэг/, далдлавч болон албан байрыг лацдаж зогсоолын жижүүрт хүлээлгэж өгнө.

Объектуудыг хоёр янзын лацаар лацдана. Нэг лац нь тухайн объектыг хариуцагч онгоц /нисдэг тэрэг/-ны техникч /механикч/-ийнх, нөгөө нь зогсоолын жижүүрийнх байна.

Онгоц /нисдэг тэрэг/, далдлавч, албан байр лацдах журмыг дарга /захирагч/-ын тушаалаар тодруулж, харуулын бүртгэлийн хүснэгтэд оруулна.

596. Зогсоолын жижүүр нь зогсоолыг харуулын хамгаалалтад өгсний дараа амралтын байранд байна.

Онгоц /нисдэг тэрэг/ хүлээлцэх дэвтэр, лацны тэмдэг /хавчаар/-ийг зогсоолын жижүүрт хүлээлгэж өгнө.

597. Ерөнхий инженер болон дээд даргын зөвшөөрөлгүйгээр онгоц /нисдэг тэрэг/, объектод гадны хүн ойртуулахыг хориглоно.

#### **7.4. Галын аюулаас хамгаалах**

598. Онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоолыг галын аюулаас хамгаалах ажлыг Монгол Улсын “Цэргийн дотоод албаны дүрэм”-ийн шаардлагын дагуу зохион байгуулна.

599. Байгууллагын дарга нь галын аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, зохион байгуулалтын ажлыг хариуцна.

600. ТАА-ийн дарга, техникийн байр, засварын цех, лаборатори болон бусад объектын дарга нар өөрсдийнхөө салбарын галын аюулгүй байдлыг хариуцна.

Тэдгээр нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- гал, түймрийн үед бие бүрэлдэхүүний ажиллах зааварчилгаа, эд хогшил /техник/-ыг зөөж шилжүүлэх бүдүүвч, нисэхийн техник дээр ажиллаж байгаа үед галын аюултай холбогдсон ажлын болон аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх;

- галын аюулгүйн дүрмийг бие бүрэлдэхүүн хэрхэн мөрдөж байгаад хяналт тавих;

- халаалт, гэрэлтүүлэг, цахилгаан техник, хийн тоног төхөөрөмж, холбоо ба дохиоллын хэрэгслийн аюулгүй нөхцөл, эвдрэл, гэмтэлгүй байдлыг хангах;

- шатны тавцан, нүүлгэн шилжүүлэх гарц, байшин, усан сангийн орц, байшингуудын хоорондох галын аюулгүй байдлыг хангасан зайнуудыг сул чөлөөтэй байлгах;

- ажил дууссаны дараа байрны хаалгыг түгжихийн өмнө тэдгээрийн галын аюулгүй байдлыг биечлэн шалгах, гаднах унтраагчийн тусламжтайгаар цахилгаан хэлхээг салгах.

601. Гал, түймэр гарсан үеийн бие бүрэлдэхүүний ажиллагаа нь НИА-ны зохих албан тушаалтныг оролцуулан, галын даргын боловсруулсан аюулгүйн арга хэмжээний зааварчилгаагаар тодорхойлогдоно. Галын тоног төхөөрөмжийн хэв хэмжээг 10 дугаар хавсралтад үзүүлэв.

Онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоол, албаны объектуудын гал унтраах хэрэгслийн техникийн байдал, бүрдүүлэлтийг аэродром, техник хангалтын салбарын захирагч хариуцна.

Нисэхийн техникийн зогсоол, барилга байгууламжийг гал унтраах тоноглол, төхөөрөмжөөр хангана.

602. Гал унтраах хэрэгслийг зөв ашиглах, бэлэн байлгах асуудлыг зохих албан тушаалтнууд хариуцна.

603. Нисэхийн техник дээр ажиллахын өмнө тухайн ажлыг удирдаж байгаа мэргэжилтэн дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- тухайн байранд байнга буюу түр ажиллаж буй албан хаагчдаас галын тоотуудыг томилж, зааварчилгаа авч томилогдсон тоотуудын нэр, тэдгээрийн үүргийг тусгай самбар дээр бичиж, харагдахуйц газар тавих;

- галын аюултай холбоотой ажлын жагсаалт, аюулгүйн арга хэмжээг авах талаар бие бүрэлдэхүүнээр судлуулах;

- жижүүрийн чирэгч машиныг бэлэн байлгах;

- гал унтраах хэрэгслийг шаардлагатай үед ашиглахад бэлэн эсэхийг шалгах;

- гал унтраах ангитай ярих холбооны хэрэгслийг шалгах.

604. Онгоц /нисдэг тэрэг/ асаах талбайд гал унтраагч хорыг тавьж, ажиллаж байгаа хүмүүсээс галын тоотыг томилно.

Шаардлагатай тохиолдолд хөдөлгүүр асаах үед галын автомашинтай тоотыг гаргана.

605. Онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоол, онгоц бэлтгэх техникийн байрын хог, хуурай өвсийг цэвэрлэж, аэродромын өвсийг хадна.

606. Онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоол, аэродромын байгууламжийн орчин тойронд галын аюулгүй байдлыг хангахын тулд дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- гал унтраах хэрэгсэлгүйгээр онгоц /нисдэг тэрэг/-ны хөдөлгүүрийг асаах;

- онгоц болон цэнэглэгч хэрэгслийг газардуулгагүйгээр түлшээр цэнэглэх;

- түлш, тосолгооны материалыг асгах;

- гагнуурын аппарат, онгоц /хөдөлгүүр/ халаагч хэрэгслийг онгоц болон аэродромын барилга байгууламжаас 25 м-ээс ойр зайд асаах;

- ажиллаж байгаа халаагч хэрэгслийг эзэнгүй орхих;

- галын байгууллагын зөвшөөрөлгүйгээр барилгын зураглал, бүтцийг өөрчлөх, пийшин зуух, халаалтын төхөөрөмж, түр байгууламж босгох;

- зориулалтын бус байранд тамхи татах (тамхи татах байрыг онгоц /нисдэг тэрэг/ болон объектоос 25 м-ээс багагүй зайд байрлуулна);

- онгоц /нисдэг тэрэг/, аэродромын байгууламжаас 100 м-ээс ойр зайд түүдэг асаах, өвс, хог шатаах;

- шатах, тослох материалыг онгоц /нисдэг тэрэг/-ноос 75 м-ээс ойр зайд хадгалах (түлшний тунадас авах савыг онгоцноос 25 м-ээс багагүй зайд байрлуулахыг зөвшөөрнө);

- гал унтраах хэрэгсэлгүй тусгай зориулалтын машинуудыг аэродром дээр үйлчлүүлэхээр гаргах.

607. Онгоцны нуувчнуудад дараах ажлыг хийхийг хориглоно.

Үүнд:

- гал унтраах багаж хэрэгсэлд хүрэх замыг таглах, газрын болон бусад тоног төхөөрөмжийг заасан байрлалаас нь өөр газар байрлуулах;

- онгоц/нисдэг тэрэг/-ыг түлшээр цэнэглэх үед оч үүсгэж болзошгүй ямар нэгэн ажил хийх;

- ил гал, гагнуурын алх, халаагчийг асаах;

- тосолгооны материал, хүчилтөрөгчтэй баллон, онгоц /нисдэг тэрэг/-ноос авсан зай хураагуур, тостой даавуу хадгалах;

- гал унтраах хэрэгсэлгүйгээр ямар нэгэн ажил хийх.

608. Засварын газар, цех, лабораторид дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- шатамхай бодис, шингэн болон хийтэй баллон хадгалах;

- авто тээврийн хэрэгсэл, мотоцикль, мотороллер хадгалах;

- ажил дууссаны дараа ажлын байрыг хаахдаа онгоц /нисдэг тэрэг/-нд тусгай тоноглол, авто цахилгаан агрегатыг /тэдгээрийн хүчдэлээс хамаарахгүйгээр/ залгаастай нь үлдээх;

- цехүүдэд онгоц /нисдэг тэрэг/-ыг баканд нь түлштэй, зайн хураагууртай нь оруулах.

609. Засвар хийгдэж байгаа онгоц /нисдэг тэрэг/-ыг тээвэрлэхэд тохиромжтойгоор байлгана.

610. Зогсоолын жижүүр, галын тоотод томилогдсон хүмүүс ажлын өдрийн төгсгөлд онгоц /нисдэг тэрэг/-ны зогсоол, ажлын байрыг шалгаж тухайн зогсоолыг харуулын хамгаалалтад өгөхөөс өмнө илэрсэн зөрчлийг арилгана.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ. НИСЭХИЙН ТЕХНИКИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ**

### **8.1. Нисэхийн техникийг “үйлдвэрлэгч-нийлүүлэгч”/завод/ болон засварын газраас хүлээн авах, хүлээлгэн өгөх**

611. “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч”-ээс онгоц /нисдэг тэрэг/-ыг хүлээж авахад /хүлээлгэн өгөхөд/ тухайн загварын нисэхийн техник дээр ажиллах эрх бүхий бие бүрэлдэхүүнийг томилно.

Уг бүрэлдэхүүнийг байгууллагын дарга /захирагч/ тодорхойлох ба ахлагчаар нь ерөнхий инженерийг томилно.

Байгууллагад ашиглагдаж байгаагүй шинэ загварын онгоц /нисдэг тэрэг/-ыг хүлээж авах, нисгэж авчрах үед тусгай бүрэлдэхүүнийг томилно.

612. Онгоц /нисдэг тэрэг/-ыг хүлээж авах /хүлээлгэн өгөх/ инженер, техникийн бүрэлдэхүүнийг “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч”-ийн ахлах төлөөлөгч дуудна.

Онгоц /нисдэг тэрэг/ хүлээн авч байгаа инженер, техникийн бүрэлдэхүүний ахлагч, тухайн үйлдвэрийн ахлах төлөөлөгчтэй тохиролцсоны үндсэн дээр “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч” -рүү нисэх багийнхныг дуудна.

613. Нийлүүлэгчээс онгоц/нисдэг тэрэг/-ыг хүлээн авахаар ирсэн /хүлээлгэн өгөхөөр очсон/ бие бүрэлдэхүүн тухайн үйлдвэрийн цагийн хуваарийн дагуу ажил үүргээ гүйцэтгэж, үйлдвэрийн даргад захирагдана.

614. “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч”-ийн ахлах төлөөлөгч нь хүлээлцэж байгаа онгоц /нисдэг тэрэг/-ны ашиглалтын заавар, бүтцийн онцлогоор нисэх болон инженер, техникийн бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулна.

615. Онгоц /нисдэг тэрэг/-ыг ашиглалтад хүлээлцүүлэхээр “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч”-ийн /засварын газар болон судлан шинжлэх лабораторийн станц, техник хяналтын хэлтсийн дарга нар/ ахлах төлөөлөгч танилцуулна.

Онгоц /нисдэг тэрэг/-ыг эвдрэл гэмтэлгүй, нэгдсэн баримт бичгийн дагуу авагддаг болон газрын тоног төхөөрөмжтэй, газрын тоноглолын нэг бүрийн ба хэсэгчилсэн иж, багаж, баримт бичгийн бүрэн бүрдэлтэй, үйлдвэрийн нөхцөлд нисгэж шалгах бүрэн хөтөлбөрөөр агаарт шалгагдсан онгоц /нисдэг тэрэг/-ыг хүлээж авна.

Онгоц /нисдэг тэрэг/-ны шалгах нислэгийн бэлтгэлийн чанарыг “үйлдвэрлэгч- нийлүүлэгч”-ийн ахлах төлөөлөгч хариуцна.

Онгоц /нисдэг тэрэг/-ны нислэгийн бэлтгэлийн болон хяналтын хэрэгслийг зохих бүрдүүлэгчтэй нь уг онгоц /нисдэг тэрэг/-той хамт шилжүүлэн авна.

616. Үйлдвэрийн аэродром дээр онгоц /нисдэг тэрэг/-ыг агаарт шалгах, нисгэж аваачих нислэгийн бэлтгэлийг ахлах төлөөлөгч болон байгууллагын мэргэжлийн хүмүүсийн хяналтан дор “Үйлдвэрлэгч-

нийлүүлэгч”-ийн мэргэжилтнүүд хангана.

Ашиглалтад авч байгаа онгоц /нисдэг тэрэг/-ыг байгууллагын нисэх багийнхан агаарт нисгэж шалгах нислэгийг “Нислэг үйлдэх заавар”-ын дагуу гүйцэтгэнэ.

617. Онгоц /нисдэг тэрэг/-ыг “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч”-ээс нисгэж явуулах нислэгийн бэлтгэл, анхны буулт хийх хүртэлх нисэхийн техникийн бэлтгэлийн чанарыг тухайн байгууллагын ахлах төлөөлөгч /засварын газрын дарга/ хариуцна.

618. Онгоц /нисдэг тэрэг/-ыг байгууллагад хүргэхээр нисгэхийн өмнө радиоэлектрон тоноглолын блоконд цахилгаан тэслүүр тавьж, тэсэргээний хэлхээг залгасан байна.

619. Онгоц /нисдэг тэрэг/-ыг авах үедээ үечилсэн үзлэгийн багтаамжтай шалгалт хийх шаардлагатай. “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч”-ийн ахлах төлөөлөгч /засварын газрын дарга/ нь хүлээлцэх үед илэрсэн нисэхийн техникийн эвдрэл, гэмтлийг арилгаж, иж бүрдүүлэлтийн дутууг богино хугацаанд гүйцээх үүрэгтэй.

620. “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч”/засварын газар/-ээс бүрдүүлэлт дутуу, эсхүл мэдээний /бюллетень/ дагуу хийгдэх ёстой ажил хийгдээгүй онгоц /нисдэг тэрэг/-ыг хүлээн авах, нисгэж аваачихыг хориглоно.

Баримт бичиг хөтлөгдөж, гарын үсэг зурагдсан, тамга тэмдэг дарагдсан онгоц, хөдөлгүүр, нисэхийн радиоэлектрон болон цахилгаан, тусгай тоноглол, зэвсэглэлийн формуляр, түүнчлэн гэрээнд заагдсан ашиглалтын баримт бичгийг онгоц /нисдэг тэрэг/-той нь хамт хүлээж авсан байх ёстой.

621. Үйлдвэрээс нисгэж авч ирэх онгоц /нисдэг тэрэг/-ны дамжин өнгөрөх аэродром дахь нислэгийн бэлтгэл, бэлэн байдлын хяналтыг онгоц /нисдэг тэрэг/ хүлээж авахаар томилогдсон инженер, техникийн бүрэлдэхүүн гүйцэтгэнэ.

Буулт хийж байгаа аэродромуудад бэлтгэл хийхээр томилогдсон бүлэгт инженер, техникийн бүх төрөл мэргэжлийн хүмүүс байх ёстой бөгөөд шаардлагатай үед техникийн тусламж үзүүлэхээр үйлдвэрлэгч-нийлүүлэгчийн төлөөлөгч байна.

Бүлэг нь нислэгийн урьдчилсан болон өмнөх бэлтгэл хийхэд

шаардлагатай хяналт- хэмжилтийн хэрэгсэл, багаж, газрын тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

Онгоц /нисдэг тэрэг/ нисгэж авч ирэх, хүргэхдээ шаардлагатай бие бүрэлдэхүүн, газрын тоног төхөөрөмжийг тээвэрлэх асуудлыг нисэхийн техник хүлээн авч байгаа тал хариуцна.

622. “Үйлдвэрлэгч-нийлүүлэгч” онгоц /нисдэг тэрэг/-ыг төмөр зам болон бусад төрлийн тээврийн хэрэгслээр илгээсэн тохиолдолд онгоц /нисдэг тэрэг/ -ны бүрдүүлэлт, баглаа боодол, ачаалалтыг тухайн үйлдвэрийн ахлах төлөөлөгч хариуцна.

623. Хүргэгдэн ирж байгаа онгоц /нисдэг тэрэг/-ны ачааг хүлээн авагч нь аэродром, техникийн хангалтын салбар болно.

Аэродром, техникийн хангалтын салбарын дарга нь олон дахин хэрэглэхээр тооцоолж эргэлтэд оруулсан эд хогшил, хайрцаг, савыг буцаах, ачаа буулгах, тэдгээрийн хадгалалтыг хариуцна.

624. Төмөр зам болон бусад төрлийн тээврийн хэрэгслээр ирсэн онгоц /нисдэг тэрэг/-ыг угсрах ажлыг техникийн ашиглалтын зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

## **8.2. Сэлбэг хэрэгсэл, зарцуулалтын материалыг авах, эргүүлж өгөх, зарлагадах**

625. Нисэхийн техникийн ашиглалт, засварын сэлбэг хэрэгсэл, материалыг иж бүрдлээр болон ширхэгээр хангана.

626. Иж бүрдлийн төрлийг дараах байдлаар тогтооно. Үүнд:

- нисэхийн техникийн нэг, эсхүл бүлэг эд ангийн ашиглалт, урсгал засварыг хангах зориулалттай сэлбэг, хэрэгслийн нэг бүрийн ба бүлэг ашиглалтын иж бүрдэл;

- байлдааны ажиллагааны үед нисэхийн техникийн дунд болон их засварыг хангах зориулалттай тусгай материал сэлбэгийн бүлэг иж бүрдэл.

627. Сэлбэг хэрэгсэл, материалын хэрэгцээг тодорхойлох үндэс нь 100 цаг /их, дунд засвар/-ийн техникийн үйлчилгээний ажилд зарцуулагдах хэв хэмжээ болно.

Бүрдүүлэгчийн нэр төрөл, зарцуулалтын хэв хэмжээнд зохицуулалт хийхийн тулд инженер, техникийн бүрэлдэхүүн зохих журмын дагуу саналаа боловсруулна.

628. Сэлбэг хэрэгсэл, материалыг шаардах үндсэн баримт бичиг

нь НИА-ны аэродром техник хангалтын салбартай зохицож хийсэн жилийн тооцоот захиалга болно.

Тооцоот захиалгыг зохицуулахдаа агрегат, блок, хэрэглэлийн нэр төрөл, тоо ширхэгийг тэдгээрийн ашиглалтын нөөц /ресурс/, гэмтлээс хамааран солихтой уялдуулж тогтооно.

Нэг удаагийн нэмэлт захиалгыг дараах тохиолдолд хийнэ. Үүнд:

- үндсэн тооцоот захиалгад тусгагдаагүй нисэхийн техник шинээр ирэх үед;

- тусгай үүрэг гүйцэтгэх, хээрийн сургууль, манёвр хийх үед;

- нэмэлт зэвсэглэл, нисэхийн техникийн бат найдвартай байдлыг ашиглалтын явцад сайжруулах /засварын/ үед.

629. Нисэхийн техникээс авагдсан бүх эвдэрч, гэмтсэн агрегат /хэрэглэл, блок, эдлэл г.м./-ыг солисноос хойш хоёр хоногоос хэтрүүлэлгүйгээр агуулахад буцааж өгөх ба дараа нь техникийн байдал, хийгдэх засварыг тодруулахаар /баталгаат хугацаа дуусаагүй бол/ нисэхийн засварын газар явуулна.

Нисэхийн техникээс авагдсан жижиг хэсэг, хэрэгсэл, агрегат, блокыг хөтлөгдсөн баримт бичгийн хамтаар хайрцаг саванд хийж, битүүмжлэн агуулахад хадгалалтад тавина.

Формуляр /паспорт/-гүй хэрэгсэл, агрегат, блоконд ажилласан цаг, авсан шалтгааныг заасан техникийн нотломжийг хавсаргана.

Нотломжийг ТАА-ийн дарга, эсхүл төрөл мэргэжлийн инженерийн даргалсан комисс үйлдэж, ерөнхий инженер батална.

630. Аэродром, техникийн хангалтын салбар хайрцаг сав, хадгалалтын материалаар хангана.

Нисэхийн техникээс авагдсан эвдрэл, гэмтэлтэй жижиг хэсэг, зангилаа /узель/, агрегат, хэрэгсэл, блок мэтийг “Гэмтэлтэй сэлбэг, хэрэгсэл” гэж бичээд агуулахад тусгай шүүгээ /хайрцаг/-нд хадгална.

631. Эрх бүхий инженер техникийн албаны удирдах бүрэлдэхүүн, ерөнхий инженерийн гарын үсэгтэй баримт /захиалга/ нь агуулахаас нөөц, сэлбэг, материалыг авах үндэслэл болно.

632. Дарга /захирагч/-ын тушаалаар томилогдсон, эрх бүхий хүмүүс агуулахаас сэлбэг хэрэгсэл, материалыг авна.

633. Сэлбэг хэрэгсэл, материалыг агуулахаас орлого, зарлагын мэдүүлгээр олгоно. Хойшлуулшгүй тохиолдолд нисэхийн техникийн

сэлбэг хэрэгслийг түр олгох бүртгэлд хүлээн авагчийн гарын үсгийг зуруулж олгоод 3 хоногийн дотор орлого, зарлагын мэдүүлгийг бүрдүүлнэ.

634. “Нийлүүлэгч”-ээс нисэхийн техниктэй хамт өгсөн нэг бүрийн болон бүлэг иж бүрдлийг агуулахад хадгална.

Бүлэг иж бүрдлийг задалж, түүний бүрэлдэхүүнд байгаа сэлбэг хэрэгслийг жижиглэн олгоно.

635. Нэг бүрийн иж бүрдлийг ерөнхий инженерийн шийдвэрээр үйлчилгээний болон хэвшүүлэх ажлын бүлгүүдэд данс бүртгэлээр олгоно.

636. Нислэгийн явц, хээрийн сургууль болон бусад тусгай үүрэг биелүүлэх үед нисэхийн техникийг шуурхай сэргээх зорилгоор ерөнхий инженерийн зөвшөөрлөөр холбогдох албан тушаалтнууд сэлбэг хэрэгсэл, материал техникийн нөөц /ресурс/ бүрдүүлнэ.

Техникийн нөөцийг агуулахад хадгална. Техникийн нөөцөөс сэлбэг хэрэгсэл, материалыг ерөнхий инженерийн зөвшөөрлөөр олгоно.

637. Эвдрэл, гэмтэлтэй нисэхийн техникийг богино хугацаанд ашиглалтад оруулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, материалыг ашиглалтын бүлэгт байлгах ёстой.

638. НИА-нд авсан нисэхийн техникийн хэрэгслийг хадгалах, зориулалтаар нь ашиглах, зохион байгуулах асуудлыг ерөнхий инженер хариуцна.

Төрөл мэргэжлийн инженерүүд, ТАА-ийн дарга, ПУББ-ын болон бүлгийн дарга нар авсан сэлбэг хэрэгсэл, материалын хадгалалт, ашиглалтыг хариуцна.

Нисэхийн техникийн ашиглалтад зориулагдсан сэлбэг хэрэгсэл, материалыг зориулалтын бусаар хэрэглэхийг хориглоно.

639. Төрөл мэргэжлийн инженерүүд, ТАА-ийн үйлдвэрлэл эрхэлсэн орлогч нь агуулахад байгаа сэлбэг хэрэгсэл, материалын тоо хэмжээ, нөөцийг мэдэж байх ёстой бөгөөд тэдгээрийг тухай бүрд нь нөхөн хангуулах талаар холбогдох захиалгыг хийнэ.

640. Сэлбэг хэрэгсэл, зарцуулалтын материал, тэдгээрийн техникийн байдал, тоо хэмжээ, нөөцөд хагас жилд нэг удаа ангийн захирагчийн тушаалаар томилогдсон эд хөрөнгийн комисс тооллого явуулна.

641. Бүртгэлтэй сэлбэг хэрэгсэл, материалыг зарлагадах үндэслэл нь орлого, зарлагын мэдүүлэг болно.

НИА-ны нотломжийг үндэслэн материал, хэрэгслийн тооцооны данснаас зарцуулалтын материалыг зарлагадна.

642. Нисэхийн техникийн ашиглалт, засварын зориулалттай түлш, тос, тусгай шингэнийг олгох, онгоцноос авсан түлш, тосыг зарцуулалтын баримтаар гүйцэтгэнэ.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **Нисэхийн техникийн бүртгэл тооцоо, түүнийг данснаас хасах, задлах**

#### **9.1. Нисэхийн техникийн бүртгэл, тооцоо**

643. Нисэхийн техник, зэвсэглэл, эд хөрөнгө, материал хэрэгслийн бүртгэл тооцоог “Улсын нисэхийн багц дүрэм” болон бусад холбогдох удирдлагын бичиг баримтыг үндэслэн явуулна.

Онгоц, нисдэг тэрэг, хөдөлгүүр, бусад үндсэн тоног төхөөрөмжийг үйлдвэрийн дугаараар нь бүртгэнэ.

644. Байгууллагад шинээр хүлээн авсан онгоц /нисдэг тэрэг/-ыг аэродром дээр ирснээс хойш арав хоногоос хэтрүүлэлгүйгээр улсын бүртгэлд бүртгүүлнэ. Дараах онгоц /нисдэг тэрэг/-ыг бүртгэл тооцооноос хасна. Үүнд:

- хүлээлцэх нотломж нь бүрдсэн өөрийн аэродром дээр өөр байгууллагад шилжүүлж байгаа онгоц /нисдэг тэрэг/;
- томилгоот газраа очихоор аэродромын нутаг дэвсгэрээс нисэн явж байгаа онгоц /нисдэг тэрэг/;
- актлагдаж, данснаас хасагдсан тухай баримт бичгийн бүрдэлтэй онгоц /нисдэг тэрэг/.

Бүртгэлд оруулах, хасахдаа онгоц /нисдэг тэрэг/-ны дугаараас гадна түүнд тавигдсан хөдөлгүүрийн маяг, дугаарыг заана.

Агуулахаас авч байгаа, эсхүл агуулахад өгч байгаа онгоц /нисдэг тэрэг/-ны хөдөлгүүрийг хүлээлцэх нотломжийн үндсэн дээр тэр өдөртөө бүртгэлд авах буюу бүртгэлээс хасна.

Онгоц /нисдэг тэрэг/-ны хөдөлгүүрийг актлагдсан даруйд данснаас хасна.

Онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийг актлах тухай баримт бичиг бүрдээгүй бол бүртгэл тооцоонд хэвээр байлгана.

Эвдрэл, гэмтэлтэй онгоц /нисдэг тэрэг/-ыг үйлдвэрийн дугаараар нь бүртгэнэ. Үүнд:

- хэвшүүлэх ба нэмэлт ажлын үед гарсан эвдрэл гэмтлийг арилгах шаардлагатай;

- эвдрэлээс болж жагсаалаас гарсан, засвар хийлгэх шаардлагатай;

- эвдрэл болон элэгдлээс болж жагсаалаас гарсан, данснаас хасвал зохих.

645. Онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийг агуулах болон бусад газарт ирсэн өдөрт нь бүртгэнэ.

Онгоц /нисдэг тэрэг/, нисэхийн хөдөлгүүрийг бүртгэл тооцоонд авах, бүртгэлээс хасах үндэслэл нь тэдгээрийг хүлээлцсэн тухай баримт бичгүүд болно.

646. Сэргээн засварлах боломжгүй, эсхүл энэ нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь батлагдсан, техникийнхээ байдлаар нислэгийн шаардлага хангахгүй байгаа онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийг бүртгэл тооцооноос хасуулахаар Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалд саналаа оруулна.

## **9.2. Нисэхийн техникийг данснаас хасах**

647. Зэвсэгт хүчний АЦК-ын Улсын нисэхийн хэлтэс нь нисэхийн техникийн байдлыг баталсан байгууллагын нотломжийг үндэслэн онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийг данснаас хасуулах саналыг холбогдох газарт хүргүүлнэ.

649. Газрын тоног төхөөрөмж, хянан шалгах хэрэгсэл, нисэхийн зэвсэглэл, онгоц /нисдэг тэрэг/-ны агрегат, хэрэгсэл, бусад тоног төхөөрөмжийг харьяалах яамдын сайдын тушаалыг үндэслэн данснаас хасна.

650. Техникийн байдлын нотломжид гарын үсэг зурсан болон баталсан албан тушаалтнууд нисэхийн техник, түүний талаарх дүгнэлтийн үнэн зөвийг хариуцна.

651. Автомашин, бусад авто техникийн арал анги дээр суурилуулсан тусгай тоноглол, төхөөрөмжийг данснаас хасуулах техникийн байдлын нотломжийг тоног төхөөрөмж, арал анги тус бүр дээр нь гаргана.

652. Данснаас хасуулахаар нотломж нь бичигдээд байгууллагадаа,

эсхүл агуулахад хадгалагдаж байгаа нисэхийн техникийг акталсан тухай баримт бичиг бүрдэж, баглагдаагүй бол устгах, задалж сэлбэг хэрэгсэл болгох, сургалтын зориулалтаар ашиглахыг хориглоно.

### **9.3. Данснаас хасагдсан нисэхийн техникийг задлах, ашиглах**

653. Данснаас хасагдсан нисэхийн техникийн задаргааг инженер, техникийн бүрэлдэхүүн гүйцэтгэнэ. Задаргааны үед жижиг хэсэг, агрегатыг салгаж авахдаа эвдэж гэмтээхгүй, дэс дараалалтай, аюулгүйн арга хэмжээг мөрдөж ажиллана.

Байгууллагын ерөнхий инженер онгоц /нисдэг тэрэг/ задлах ажиллагааг явуулахын тулд хариуцагчийг томилно.

654. Онгоц /нисдэг тэрэг/-ыг задаргаанд бэлтгэхийн өмнө дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- цахилгаан эрчим хүчний тэжээлийг салгах;
- зэвсэглэлийг цэнэггүй болгох;
- оньст харвуулын суурь болон тэсэлгээний төхөөрөмжийн цэнэгийг авах;
- систем, агрегатуудын даралтыг гаргах;
- газрын урьдчилан хамгаалах чагтнуудыг тавих;
- онгоц /нисдэг тэрэг/-ноос ачааг авч, түлш, тусгай шингэнийг юүлэх.

655. Онгоц /нисдэг тэрэг/-ноос авсан эвдрэл гэмтэлгүй, засварт явуулах хөдөлгүүр, агрегат, тоноглол, жижиг зүйлд хадгалалт хийж, паспорт, формулярын хамтаар засварт, эсхүл хяналт шалгалтад явуулахаар агуулахад өгнө.

Паспорт, формулярт ажилласан цагийг бичсэн байна.

Шахсан хийтэй баллон, шингэний зайн хураагуур, зөөллөх тулгуур, цилиндр болон онгоц /нисдэг тэрэг/-ны бусад тоног төхөөрөмжийг цэнэггүй болгож агуулахад өгнө.

656. Үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмжийг тусгай заалтын дагуу задлах, устгах ажлыг гүйцэтгэнэ.

657. Данснаас хасагдсан онгоц /нисдэг тэрэг/-ноос авсан ашиглалтын нөөцтэй эвдрэл, гэмтэлгүй хөдөлгүүр, агрегат, тоноглолын техникийн нөхцөл тохирч буй эсэхийг шалгасны дараа ерөнхий инженерийн зөвшөөрлөөр онгоц/нисдэг тэрэг/-нд ашиглаж болно.

658. Данснаас хасагдсан нисэхийн техникийн ашиглах боломжтой багаж, газрын тоног төхөөрөмж, сэлбэгийг сургалтын зориулалтаар ашиглаж болно.

659. Задаргаа болон хоёрдогч түүхий эдэд зориулагдсан онгоц /нисдэг тэрэг/-ыг данснаас хасах тухай нотломж, баримт бичиг нь бүрдсэний дараа дахин сэргээж нислэгт ашиглахыг хориглоно.

## **АРАВДУГААР БҮЛЭГ.**

### **Бие бүрэлдэхүүний инженер, техникийн бэлтгэл**

660. Инженер, техникийн бэлтгэл нь эрх, үүргийн дагуу нисэхийн техникийн ашиглалт, засварын явц дахь бие бүрэлдэхүүний онолын мэдлэгийг тогтмол дээшлүүлэх, дадлагыг сайжруулах, түүнчлэн шинээр ирэгсдийг сургаж, дадлагажуулах зорилготой.

661. Бие бүрэлдэхүүний инженер, техникийн бэлтгэл нь байлдааны бэлтгэлийн курсын дагуу хийгдэж, байгууллагын үүрэг, зорилготой нийцэж байх ёстой.

### **10.1. Инженер, техникийн бэлтгэл**

662. Инженер, техникийн бэлтгэлийг дараах албан тушаалтнууд хариуцна. Үүнд:

- байгууллагын дарга /захирагч/ нь сургалтын материаллаг баазын хангалт, хөтөлбөрийн дагуу бүх бүрэлдэхүүнийг хамруулах, бэлтгэлийн ерөнхий байдлыг;

- ерөнхий инженер нь өмнө тавигдсан зорилттой уялдуулан сэдвийн сонголт хийх, бие бүрэлдэхүүний техникийн мэдлэгийн түвшинг сайжруулж, бүлгийн удирдагчдыг сонгон авч бэлтгэх;

- штабын дарга нь сургалтын зохион байгуулалт, төлөвлөлт, сургалтын байрыг бэлтгэх, сургалтын явцыг тооцох асуудлыг хариуцна.

663. Инженер, техникийн бэлтгэл нь бие даалт, бүлгийн цугларалт, үзүүлэх сургууль, нисэхийн техник дээр хийх дадлага, нислэгийн болон техникийн яриа, хурал зэргээр хэрэгжинэ.

664. Нисэхийн техник, түүний ашиглалт, засварын заавар, дүрмийг бие дааж сургах нь бие бүрэлдэхүүний мэргэжлийг дээшлүүлэх гол арга болно. Бие даалтыг удирдах, түүнд тавих хяналтыг мэргэжлийн ахлах дарга, инженерүүд хариуцна.

665. Бие бүрэлдэхүүнийг сургалтаас чөлөөлөх асуудлыг дарга / захирагч/ болон ерөнхий инженер шийдвэрлэнэ. Бие бүрэлдэхүүний мэдлэгийн түвшинг харгалзан инженер, техникийн бэлтгэлийн сургалтын бүлгийг мэргэжлийнх нь дагуу зохион байгуулна.

666. Сургалтын бааз нь бие бүрэлдэхүүний онолын мэдлэгийг дээшлүүлэх, нисэхийн техникийн ашиглалтыг сайжруулах, засварыг чанартай хийх, дадлагыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

Сургалтын танхим, суурин төхөөрөмж, нисэхийн техник нь сургалтын үндсэн бааз болно. Дараах сургалтын танхимыг байгуулна. Үүнд:

- онгоц /нисдэг тэрэг/-ны их бие;
- хөдөлгүүрийн;
- радиоэлектрон тоноглолын;
- цахилгаан, тусгай тоноглолын;
- зэвсэглэлийн.

Ашиглах болон засвар хийлгэх боломжгүй нисэхийн техник, түүний агрегат, тоноглолыг сургалтын болон үзүүлэн таниулах материалын зориулалтаар ашиглаж, танхим тоноглохыг зөвшөөрнө.

Ерөнхий инженер танхим тоноглох сургалтын болон үзүүлэн таниулах материалыг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, төхөөрөмжлөлтийг төрөл мэргэжлийн инженерүүд хариуцна.

667. Инженер, техникийн бэлтгэлийн төлөвлөгөөг сургалтын жилийн өмнө хийж, түүний үндсэн дээр сургалтын хуваарийг гаргана. Цагийг бүлгүүдэд хуваарилан өгөхдөө мэдлэгийг нь шалгах хугацааг тусгана.

Нисэхийн төрөл мэргэжлийн бие даалтын сэдвийг харьяалах дарга нар боловсруулж, судлах хугацааг зааж өгнө.

668. Дарга /захирагч/-ын тушаалаар инженер, техникийн бэлтгэлийг удирдах бүлгийн удирдагчдыг томилно.

Туршлагын болон суурин дадлагын сургалт явуулах, түүний явцад хяналт тавих асуудлыг харьяалах дарга нар хариуцна.

Бүлгийн удирдагчдын бэлтгэлийг дээшлүүлэх зорилгоор арга зүйн болон үзүүлэх сургалтыг зохион байгуулна.

669. Нисэхийн техникийн шинэ загвартай танилцахын тулд бүлгээр хичээллэх хэлбэрээр нисэх ба инженер, техникийн

бүрэлдэхүүнтэй, түүнчлэн шинээр ирэгсдийг бэлтгэх, дахин сургахын тулд цугларалтыг явуулна.

670. Нисэхийн техникийн ашиглалт, засварын талаарх туршлагыг судлах, нэвтрүүлэх зорилгоор нисэхийн техникийг өвөл / зун/-ийн ашиглалтад шилжүүлэхийн өмнө нийт бие бүрэлдэхүүнтэй техникийн онолын бага хурлыг ажлын нэгээс хоёр өдөрт явуулна.

Төрөл мэргэжлийн инженерүүд техникийн бага хурлын төлөвлөгөөг боловсруулж, арга зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэн, батлуулж, хурлын ажиллагаа эхлэхээс 15 хоногийн өмнө бие бүрэлдэхүүнд танилцуулсан байна. Бага хурлын ажиллагааг ерөнхий инженер удирдана.

671. НИА-ны бие бүрэлдэхүүнийг сургаж, дадлагажуулах хөтөлбөр нь хоёр шатаас бүрдэнэ. Үүнд:

Нэгдүгээр шат: Томилогдсон албан тушаалын үүргээ биелүүлэх эрх олж авахын тулд шаардлагатай мэдлэг болон дадлага олж авах;

Хоёрдугаар шат: Техникийнхээ мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, улмаар мэргэжлийн зэрэг авах шалгалт өгөхөд бэлтгэх.

672. Инженер, техникийн албанд шинээр ирэгсдийг сургаж, дадлагажуулах ажлыг ерөнхий инженер, мөн мэргэжлийн хувьд харьяалах дарга нар нь хариуцна.

673. Төрөл мэргэжлийн инженерүүд нь дараах зүйлсийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- шинээр ирэгсэд нэг бүрийн техникийн мэдлэг, тусгай бэлтгэлийн түвшин болон албан үүргээ биелүүлэхэд бэлтгэгдсэн байдлыг нь тодруулах;

- шинээр ирэгсэдэд албан үүргээ биелүүлэх эрх олгохын өмнө нэмэгдэл бэлтгэл шаардлагатай эсэхийг тогтоох;

- сургаж, дадлагажуулах болон бэлтгэлийн хөтөлбөрийг боловсруулж, биелэлтийг хангах;

Шинээр ирэгсдийг богино хугацаанд сургаж, дадлагажуулахаар хөтөлбөрт урьдчилан тооцоолсон байна. Ерөнхий инженер хөтөлбөрийг батлана.

674. Сургаж, дадлагажуулах төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- эрх, үүргээ судлах;

- нисэхийн техникийн бүтэц, ашиглалтын зааврыг судлах;
- нисэхийн техникийн ашиглалтын заавар, засвар, түүний зохион байгуулалт, удирдлагын баримт бичгийг судлах;
- эрх, үүргийн хэмжээнд нисэхийн техник дээр гүйцэтгэх ажлын технологийг судалж эзэмших;
- түгшүүр, цугларалтаар ажиллах ажиллагааг судлах;
- эрх, үүрэгт заагдсан үндсэн бүх ажлыг зааварлагчийн удирдлага дор нисэхийн техник дээр дадлагаар хийх;
- орлон ажиллах;
- бие дааж ажиллах эрхийн шалгалт өгөх.

675. Инженерийн удирдах бүрэлдэхүүний бэлтгэлд дараах зүйлс орсон байна. Үүнд:

- тооцоолон бодох хэрэгслийг ашиглан инженер-оперативын тооцоог хийх дадлага, ажиллагаанд суралцах;
- нисэхийн техникийн ашиглалтын болон засварын зааврыг судлах;
- харьяалах инженер, техникийн бүрэлдэхүүний удирдлагын систем, тайлан, тооцооны баримт бичгийг хөтлөх журам, мэдээлэл танилцуулах хугацаа зэргийг судлах;
- харьяалах албан тушаалтны ажил хэрэгч чанарыг судлах.

676. Шинээр ирэгсдийн томилогдсон албан тушаал дээрээ ажиллах сургалт, дадлагыг нисэхийн техник дээр явуулна.

677. Техникийн бүрэлдэхүүнээс хамгийн сайн бэлтгэл, дадлага, туршлагатайг нь сургалт, дадлагын зааварлагчаар томилно.

678. Инженер-техникийн бүрэлдэхүүнээс ерөнхий инженер, төрөл мэргэжлийн инженерүүдийн шууд оролцоотойгоор нисэхийн техникийн ашиглалтын мэдлэгийн шалгалт, шүүлгийг авна.

679. Нисэхийн их, дээд, дунд сургууль, дамжаа төгссөн, эсхүл цэргийн бэлтгэл үүрэгтнээс татагдсан техникийн бүрэлдэхүүний онолын мэдлэгийг нь бататгаж, дадлага, туршлага суулгахын тулд хамгийн сайн бэлтгэлтэй мэргэжилтэнд даалгаж ажиллуулахаар томилно.

680. Цэргийн бэлтгэл үүрэгтнээс татагдаж ирсэн инженер, техникийн бүрэлдэхүүний онолын бэлтгэлийг тухайн нөхцөл байдлаас хамаарч цугларалтын аргаар зохион байгуулан явуулж

болно.

681. Байлдааны ажиллагаа явагдаж байгаа үед НИА-ны бие бүрэлдэхүүний техникийн сургалт бэлтгэлийн үндсэн хэлбэр нь туршлагатай мэргэжилтнүүдийн удирдлага дор нисэхийн техник дээр ажиллуулах ганцаарчилсан сургалтын болон дадлагын бие даах арга болно. Сургалтыг нисэхийн техник дээр шууд явуулна.

682. Нисэхийн их, дээд, дунд сургууль, дамжааны сонсогчдын дадлагын үндсэн үүрэг, зорилт нь нисэхийн анги, байгууллагуудад мэргэжлийнхээ дагуу инженер техникийн албан тушаалд бие даасан ажиллагааны дадлага, туршлага эзэмших явдал мөн.

683. Тэдний дадлагыг удирдах, хянах асуудлыг ерөнхий инженер хариуцна. Сонсогчдын ажлын шууд гүйцэтгэлийг дадлагын хөтөлбөрийн хэмжээнд хийлгэхийг төрөл мэргэжлийн инженерүүд, ТАА-ийн болон бүлгийн дарга нар хариуцна.

684. Сонсогчид дадлагыг нисэхийн техник дээр, инженерийн болон техникчийн албан тушаалд хийж гүйцэтгэнэ.

685. Дадлагажигчдыг орлон ажиллагчийн журмаар томилох бөгөөд даалгаж өгсөн мэргэжилтнүүдийн удирдлага дор ажил, үүргийг гүйцэтгэнэ.

686. Нисэхийн анги /байгуулага/-д шинэ маягийн техник эзэмших сургалтын төлөвлөлтийг энэ тухай шийдвэр гармагц эхэлнэ.

Нисэхийн шинэ техникийг ашиглалтад бэлтгэх бэлтгэлд дараах зүйлс орно. Үүнд:

- инженер, техникийн бүрэлдэхүүнийг уг шинэ техникийг эзэмшсэн байгууллага, сургалтын төв болон үйлдвэрлэгч-нийлүүлэгч дээр сургалтад хамруулах, шинэ техникийг судлуулах, дадлага хийлгэх;

- нисэхийн шинэ техникийн сургалтын бааз байгуулах, бие бүрэлдэхүүнийг шилжүүлэн сургах, сургалт удирдах багш нарыг бэлтгэх бэлтгэлүүд орно.

687. Нисэхийн шинэ техникийг судалж, дадлага, туршлага эзэмшүүлэхийн тулд эхний ээлжинд нисэх болон инженер техникийн удирдах бүрэлдэхүүнийг сургана. Шилжин сургалтад хамрагдсаны дараа бие бүрэлдэхүүнийг сургахад хичээл удирдах багш нар зааварлагчийн журмаар ажиллана.

688. Шилжин сургалтыг баталсан хөтөлбөрийн дагуу анги /

байгууллага/-д явуулж болно. Шилжин сургалтын хөтөлбөрт шилжин суралцагчдыг албан үүргийн хэмжээнд нь дадлагажуулах асуудлыг заавал тусгасан байна.

689. Бие бүрэлдэхүүний нисэхийн эд анги дээр ажиллах зөвшөөрөл /мэргэжлийн үнэмлэх/-ийг нисэхийн шинэ техникийн талаарх мэдлэг, түүний ашиглалтын заавраар авсан шалгалтын дүнг үндэслэн анги /байгууллага/-ийн захирагчийн тушаалаар олгоно.

690. Инженер, техникийн бэлтгэлийн бас нэг гол үүрэг нь бие бүрэлдэхүүнийг хос мэргэжил эзэмшүүлэх, түүнчлэн байлдааны тоотын бүрэлдэхүүн /орон тооны бус тоот/-д орж ажиллахад сургах явдал юм.

Бүлэг онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх хугацааг багасгах, багтаамж ихтэй ажлыг гүйцэтгэхийн тулд /нисэхийн хөнөөх зэвсэглэлээр цэнэглэх, тусгай зориулалтын контейнер зүүх, ачих буулгах г.м./ байлдааны тоотыг зохион байгуулна.

691. Эвдрэл, гэмтэлтэй эд анги, агрегатуудыг сэргээн засварлах технологийг харуулсан загварыг бэлтгэж, ТАА-ийн хэвшүүлэх ажлын бүлгүүдэд байрлуулж, сургалт, дадлага явуулахад ашиглана.

692. НИА-ны бие бүрэлдэхүүний нисэхийн техникийг засварлах байнгын бэлэн байдлыг хангах зорилгоор инженер техникийн удирдах бүрэлдэхүүн нь дараах ажлыг тогтмол зохион байгуулна. Үүнд:

- инженер, техникийн бүрэлдэхүүнийг эвдэрч, гэмтсэн нисэхийн техникийг сэргээн сайжруулах болон засварлах дадлагыг боловсронгуй болгоход сургах;

- сэргээн сайжруулах ажлыг гүйцэтгэх, зохион байгуулах талаар туршлага солилцох зэрэг багтана.

693. Слесарь-механикийн бүлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэхдээ уг бүлгийн мэргэжилтэн хүн бүр нисэхийн техникийг засварлах талаар хос мэргэжлийг эзэмшсэн байхаар тооцож зохион байгуулна.

Слесарь-механикийн бүлгийн мэргэжилтэн бүр өөрийн үндсэн мэргэжлээр багшлах хэмжээнд бэлтгэгдсэн байна.

694. Хэвшүүлэх ажлын бүлгийн онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүр, радиоэлектрон болон цахилгаан, тусгай тоноглол, нисэхийн зэвсэглэлийн мэргэжилтэн нь онгоц /нисдэг тэрэг/-ны их биеийг

засварлах, гагнах, цахилгааны чангалуур, залгуур, их бие, агрегат, блокуудыг засварлах, тэдгээрийг солих, түүнчлэн засварын ажил дууссаны дараа техникт хяналт, шалгалт хийхэд сургагдсан байх ёстой.

695. Засварын ажлын төрөл бүрээр дадлага, туршлагыг нь шалган үнэлж, нисэхийн техник дээр засварын ажил гүйцэтгэх тусгай эрхийг олгож болно.

## **АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **Нисэхийн инженерийн албаны албан тушаалтны эрх, үүрэг**

696. НИА-ны албан тушаалтан нь тусгай мэргэжлийн хувьд энэ дүрэмд заагдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

697. НИА-ны бүх албан тушаалтнууд мэргэжлийн дагуу ахлах дээд албан тушаалтанд захирагдана.

698. Нисэхийн техникийн ашиглалт, засвар болон бие бүрэлдэхүүний инженер, техникийн сургалт бэлтгэлийн асуудлаар гаргасан АЦК-ын Улсын нисэхийн хэлтсээс өгөгдсөн үүрэг, даалгаварыг НИА-ны бие бүрэлдэхүүн биелүүлэх үүрэгтэй.

### **11.1. Анги /байгууллага/-ийн ерөнхий инженер /эскадрилийн инженер/**

699. Ерөнхий инженер нь анги /байгууллага, эскадриль/-ийн дарга /захирагч/-д захирагдана. Ерөнхий инженер нь байгууллагын инженер техникийн бүрэлдэхүүний шууд захирах дарга мөн.

700. Ерөнхий инженер нь :

- нисэхийн техникийн ашиглалт, засвар, байлдааны бэлэн байдал, бүрэн бүтэн байдал;
- бие бүрэлдэхүүний инженер, техникийн сургалт бэлтгэл;
- түүнд шууд харьяалагддаг салбаруудын бэлэн байдал, бие бүрэлдэхүүний сахилга, дэг журам, зохион байгуулалт зэргүүдийг хариуцна.

701. Ерөнхий инженер нь дараах үүрэгтэй. Үүнд:

- нисэхийн техникийн засвар, ашиглалтын заавар, дүрэм, НИА-ны бие бүрэлдэхүүний ажлын зохион байгуулалтыг тодорхойлдог баримт бичгүүдийг бие бүрэлдэхүүнээр судлуулах, хатуу чанга дагаж мөрдүүлэх;

- Анги /байгууллага/-ийн зэвсэглэлд байгаа нисэхийн техникийн бүтэц, түүний ашиглалтын зааврыг мэдэх;
- УНИАД-ийн дагуу НИА-ны бие бүрэлдэхүүний үйл ажиллагаа, нисэхийн техникийн ашиглалт, засварыг зохион байгуулах;
- нисэхийн техникийг эвдрэл гэмтэлгүй, байнгын бэлэн байдалд байлгах;
- нисэхийн техникийн нөөц /ресурс/, хэвшүүлэх ажил, шаардлагатай захиалга, засварын төлөвлөлтийг цаг тухайд нь хийх;
- НИА-нд хамаарах асуудлаар байлдааны болон дайчилгааны төлөвлөлтийг боловсруулахад оролцох, зохион байгуулах;
- Инженер техникийн бие бүрэлдэхүүний техникийн сургалт бэлтгэлийг удирдах;
- нисэхийн техникийн найдвартай ажиллагаа, нислэгийн аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээ зохион байгуулах;
- НИА-ны бие бүрэлдэхүүн болон нисэхийн техникийн ажиллагаанд дүн шинжилгээ тогтмол хийж, ашиглалтанд байгаа нисэхийн техникийн ашиглалтын онцлог, эвдрэл, гэмтэл үүсэх шалтгааныг техникийн бүрэлдэхүүнээр судлуулах;
- нисэхийн техникийн эвдрэл, гэмтэлд дүн шинжилгээ хийх, инженер техникийн бүрэлдэхүүнтэй биечлэн техникийн яриа хийх, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- нисэхийн техникийн байдал, тэдгээрийн бэлэн байдал, ашиглалт зөв явагдаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих;
- нисэхийн техникийн нислэг-техникийн өгөгдөхүүнийг илүү үр дүнтэй ашиглах талаар тооцоо судалгаа хийж, санал боловсруулах;
- байлдааны бэлтгэл болон хээрийн сургуулийн явцад гарсан НИА-ны бие бүрэлдэхүүний ажлын туршлагыг баяжуулах;
- нислэгийн ярианд шаардлагатай өгөгдөхүүнийг удирдлагад бэлтгэж өгөх, нислэгийн ярианд оролцох;
- нисэхийн техник, бэлтгэлийн чанарт биечлэн үзлэг хийх, НИА-ны төрөл бүрийн мэргэжлийн инженерүүдийн нисэхийн техникт хийх үзлэгийн хэм хэмжээний биелэлтэд хяналт тавих;
- УНИАД-ийн шаардлагыг хангаагүй, эвдрэлтэй онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гаргахгүй байх, шаардлага хангасан онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гаргах зөвшөөрөл олгох;

- нислэгтэй өдрүүдэд зэвсэглэлийн өгөгдсөн хувилбарын дагуу онгоц /нисдэг тэрэг/-ыг цаг тухайд нь бэлтгэх ажлыг зохион байгуулах;

- эвдрэл, гэмтэлтэй газрын үйлчилгээний болон хяналт-хэмжилтийн багаж хэрэгсэл ашиглан нисэхийн техникийг нислэгт бэлтгэхийг хориглох;

- бие бүрэлдэхүүний мэргэжлийн түвшинг харгалзан, ашиглалтын янз бүрийн нөхцөлд нисэхийн техник дээр гүйцэтгэх ажилд дүн шинжилгээ хийх, эдгээр ажлыг гүйцэтгэх хугацааг тогтоох;

- НИА-ны техник төхөөрөмжийг байрлуулах, хадгалах, хамгаалах журам тогтоох, ашиглалтад байгаа нисэхийн техникийн нийтийн болон нэг бүрийн хэрэглээний зориулалттай газрын үйлчилгээний хэрэгсэл, аэродромын барилга, байгууламжийн байдалд тогтмол хяналт тавих, түлш, тос болон тусгай шингэнүүдийн чанарыг шалгах;

- сэлбэг, материал, хэрэгслийг шууд зориулалтаар нь ашиглаж байгаа байдал, тэдгээрийн тоо ширхэг, техникийн байдалд тогтмол хяналт тавих, мэдэж байх, шаардлага хангахгүй болсон материал, хэрэгслийг солиулах, засварлуулах арга хэмжээ авах, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах;

- аэродром дээр буулт үйлдээд нисч байгаа нисэх багийнханд туслалцаа үзүүлэх, нисэхийн техникийг нислэгт бэлтгэхэд нь туслах;

- нисэхийн техникийн үйлчилгээний ажлыг цаг тухайд нь зохион байгуулж, чанартай хийлгэх;

- инженер-оперативын тооцоо хийх, инженер-штурманы тооцоо хийхэд оролцох;

- нисэхийн техникийн ашиглалт, засварт шаардлагатай сэлбэг, тоног төхөөрөмж, хяналт хэмжилтийн хэрэгсэл болон бусад материалыг цаг тухайд нь шаардах, тэдгээрийг авах, ашиглах, хуваарилж өгөх ажлыг зохион байгуулах;

- шинээр ашиглалтад орж байгаа нисэхийн техникийг эзэмших, инженер, техникийн бүрэлдэхүүнийг сургаж, дадлагажуулах ажлыг зохион байгуулах;

- нисэхийн техник, түүний ашиглалтын заавраар бие

бүрэлдэхүүнтэй сургалт явуулах;

- нисэхийн техникийг ашиглах, засварлах, хамгаалах заавар, дүрмийн мэдлэгээр бие бүрэлдэхүүнийг шалгах;
- ашиглалтад байгаа нисэхийн техникт технологийн картын дагуу хэвшүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;
- тогтоогдсон тайлан, тооцоо, баримт бичгийг цаг тухайд нь үнэн, зөв хөтлөж буй эсэхийг хянах, зохион байгуулах.

## **11.2. Төрөл мэргэжлийн ахлах инженер, инженер**

702. Төрөл мэргэжлийн ахлах инженер, инженерүүд нь ерөнхий инженерт захирагдана.

703. Төрөл мэргэжлийн ахлах инженер, инженерүүд нь харьяалдаг бие бүрэлдэхүүний шууд захирах дарга нь бөгөөд өөрсдийн мэргэжилд хамааралтай нисэхийн техникийн ашиглалтын асуудлаар нисэх ба инженер, техникийн бүрэлдэхүүнд зааварчилгаа өгөх эрхтэй.

704. Нисэхийн төрөл мэргэжлийн ахлах инженер, инженерүүд нь мэргэжлийнхээ дагуу:

- нисэхийн техникийн байлдааны болон бүрэн бүтэн байдал;
- нисэхийн техник дээрх ажлын гүйцэтгэлийн чанар болон бие бүрэлдэхүүний аюулгүйн арга хэмжээний мөрдөлт;
- бие бүрэлдэхүүний техникийн сургалт бэлтгэл;
- нисэхийн техник дээр нэмэлт ажлын зохион байгуулалт;
- бие бүрэлдэхүүний тусгай бэлтгэл, сахилга бат, дэг журмыг хариуцна.

705. Төрөл мэргэжлийн инженерүүд нь нисэхийн техникийн ашиглалтыг зохион байгуулах ажиллагаанд өөрсдийн мэргэжлийн дагуух үүргийг гүйцэтгэнэ.

Төрөл мэргэжлийн ахлах инженер, инженерүүд нь шаардлагатай тохиолдолд ерөнхий инженерийг орлон ажиллах чадвартай байна.

## **11.3. Техник ашиглалтын ангийн дарга /засварын газрын дарга/**

706. ТАА-ийн дарга нь ТАА-ийн бие бүрэлдэхүүний шууд захирах дарга мөн. Тэр ерөнхий инженерт захирагдана. ТАА-ийн дарга нь:

- ТАА-д байгаа нисэхийн техник дээр хийгдэх хэвшүүлэх ажил, засвар, нэмэлт ажлын чанар, гүйцэтгэл, зохион байгуулалт, төлөвлөлт;

- ТАА-д байгаа материал болон техник, хэрэгслийн ашиглалтын тооцоо;

- ТАА-ийн бие бүрэлдэхүүнээр холбогдох дүрэм, журам, заавруудыг мөрдүүлж ажиллуулах зэргийг хариуцна.

707. ТАА-ийн дарга нь дараах үүрэгтэй:

- нисэхийн техникийг засвар болон хэвшүүлэх ажилд оруулах жил, сарын төлөвлөлтийг боловсруулах;

- ТАА-ийн шилжин байрлалтын тооцоог хийх;

- ТАА-ийн бие бүрэлдэхүүний ажлыг төлөвлөх, зохион байгуулах;

- нисэхийн техник дээрх нэмэлт ажил, засварын болон цаг үеийн хэвшүүлэх ажлыг эхлэхийн өмнө, болон дууссаны дараа түүнд биечлэн үзлэг хийх;

- нисэхийн техник дээр илэрсэн эвдрэл, гэмтэлд дүн шинжилгээ хийх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах;

- ТАА-ийн ажлын тайланг сар бүр гаргаж, бие бүрэлдэхүүний техникийн яриаг долоо хоног бүр хийх;

- ТАА-ийн бие бүрэлдэхүүн хяналт, засварын хөдөлгөөнт хэрэгслийг бүрэн эзэмшиж, хэрэглэж сурах, тэдгээрийг ашиглалтад байнга бэлэн байлгах ажлыг зохион байгуулах;

- ТАА-ийн ажилд шаардлагатай материал, хэрэгслийн тооцоог хийж захиалах, тэдгээрийн ашиглалт, хадгалалтыг хянах;

- ТАА-ийн бие бүрэлдэхүүний ажлын туршлагыг баяжуулах, засвар, цаг үеийн хэвшүүлэх болон нэмэлт ажлын хүн/цагийн зарцуулалтыг багасгах зорилгоор дүн шинжилгээ хийх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, ажлын технологийг боловсронгуй болгох арга хэмжээг зохион байгуулах;

- тайлан тооцооны бүх хэлбэрийн ажлыг зохион байгуулах, тэдгээрийн гүйцэтгэлийг хянах;

- ТАА-ийн бие бүрэлдэхүүний тайлан тооцоо, эх загвар болон дэс дараалсан баримт бичгийн бүрдэлт, хөтлөлтөд хяналт тавих;

- техникийн аюулгүй байдал, галын аюулаас сэргийлэх арга

хэмжээг зохион байгуулах.

#### **11.4. Техник ашиглалтын хэсгийн дарга буюу хэсгийн техникч**

708. Техник ашиглалтын хэсгийн дарга нь нисэх хэсгийн даргад захирагдана. Техник ашиглалтын хэсгийн дарга нь хэсгийн техникийн бүрэлдэхүүнийг шууд захирах дарга бөгөөд хэсгийнхээ онгоц /нисдэг тэрэг/-ны бүрэн бүтэн байдал, байлдааны бэлэн байдал, нислэгийн бэлтгэлийн чанарыг хариуцна.

709. Техник ашиглалтын хэсгийн дарга нь дараах үүрэгтэй. Үүнд:

- УНИАД, техник ашиглалтын зааврын дагуу онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх ажлыг зохион байгуулах;

- хэсэгт байгаа онгоц /нисдэг тэрэг/-ны бүтэц, ашиглалтын заавар, хэрэглэгддэг шатах, тослох материалын төрөл зүйл, тэдгээрийн зарцуулалт, түүнчлэн онгоц /нисдэг тэрэг/ бүрийн түлш, тос, бодит зарцуулалтыг мэдэж байх;

- онгоц /нисдэг тэрэг/-ны нислэгийн бүх төрлийн бэлтгэлийг бие даан гүйцэтгэж чаддаг байх, эвдрэл, гэмтлийг түргэн олж арилгах, онгоц /нисдэг тэрэг/-ны нислэгийн бэлэн байдлыг тодорхойлж чаддаг байх;

- онгоц /нисдэг тэрэг/ бүрийн ерөнхий байдлыг мэддэг байх, хэсгийн техникийн бүрэлдэхүүний гүйцэтгэж буй ажлын чанарыг биечлэн хянах;

- онгоц /нисдэг тэрэг/-нд үзлэг хийж, эвдрэл, гэмтлийг засах талаар зааварчилгаа өгөх;

- нислэгийн бэлтгэлийг биечлэн шалгаж, нислэгт гаргах зөвшөөрөл өгөх, түүнчлэн техникийн ашиглалтын зааврын шаардлага зөрчигдөж бэлтгэгдсэн, эсхүл эвдрэл, гэмтэлтэй онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт гаргахгүй байх бүхий л арга хэмжээг авах;

- хэсгийн техникч, механикчдыг зааврын дагуу онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэхэд сургах, техникийн яриаг өдөр бүр хийж байх,

- хэсгийн онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бүх төрөл мэргэжлээр болон цэнэглэлт, сумлалтаар бүрэн дүүрэн бэлтгэгдсэн эсэхийг хянах;

- нисэхийн техникийн газрын үйлчилгээний хэрэгсэлд үзлэг хийх, онгоц /нисдэг тэрэг/-нд үйлчлэх аэродромын хэрэгсэлд тавигдах шаардлагын дагуу түлш, тос, тусгай шингэнүүдийн чанарыг шалгах;

- тайлан тооцоог хийх, баримт бичгийг цаг тухайд нь үнэн, зөв хөтлөж байгаа эсэхийг хянах;

- нисэхийн техник дээр ажиллах үеийн аюулгүй байдлын болон галын аюулаас сэргийлэх арга хэмжээний мөрдөлтийг хангах.

## 11.5. Бүлгийн дарга

710. Бүлгийн дарга нар нь:

- үйлчилгээний бүлгийн дарга нар ахлах инженер, инженерүүдэд;

- хэвшүүлэх ажлын бүлгийн дарга ТАА-ийн даргад;

- ПУББ-ын дарга нисэхийн зэвсэглэлийн инженерт;

- өндрийн тоног төхөөрөмж, хэрэгслийн үйлчилгээний бүлгийн дарга нисэхийн цахилгаан, тусгай тоноглолын инженерт;

- дадлагын суурин төхөөрөмжийн үйлчилгээний бүлгийн дарга электрон-автоматик болон нисэхийн цахилгаан тусгай тоноглолын инженерт тус тус захирагдана.

Бүлгийн дарга нар бүлгийн бие бүрэлдэхүүний шууд захирах дарга нь болно.

711. Бүлгийн дарга нь:

- бүлэгт хариуцуулсан нисэхийн техникийн бүрэн бүтэн байдал, байлдааны бэлэн байдлыг;

- нисэхийн техник дээр хийгдэх ажлуудын цаг хугацааны биелэлт, чанар байдал, аюулгүйн арга хэмжээг;

- тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн байдал, ашиглалт, зориулалтаар нь ашиглаж байгаа эсэх;

- бүлэг дэх тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж, хяналт шалгалтын хэрэгсэл, багаж, материал хэрэгслийн зөв ашиглалт, хадгалалт зэргийг хариуцна.

712. Бүлгийн дарга нь:

- бүлгийн ажлыг төлөвлөх, ажлын баримт бичгийг бие бүрэлдэхүүн зөв хөтөлж буй эсэхийг хянах;

- баримт бичгийг тогтоосон шаардлагын дагуу хатуу мөрдөж

хөтлөх;

- нисэхийн техникийн тохируулга, шалгалт, засварын талаарх хамгийн нарийн төвөгтэй ажлыг бие даан хийж чаддаг байх;

- нисэхийн техникийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тодруулах, арилгах дэс дарааллын талаар зааварчилгаа өгөх;

- мэргэжлийн дагуу нисэхийн техникийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийн тооцоог хөтлөх, биелэлтийг хянах;

- тогтоосон хэв хэмжээний дагуу нисэхийн техникт үзлэг хийх;

- нисэхийн техник дээрх бүлгийн ажлын туршлагыг баяжуулах, бэлэн байдлыг дээшлүүлж, хүн/цагийн зарцуулалтыг багасгах, хөдөлмөрийн бүтээмж, чанарыг дээшлүүлэхэд чиглэгдсэн ажлын туршлагыг нэвтрүүлэх, техникийн яриаг өдөр бүр хийх;

- нисэхийн техникт засвар, бэлтгэл ажил хийх болон нисэхийн техник дээрх эвдрэл, гэмтлийг илрүүлэх, арилгах, түүнчлэн хяналт шалгалтын хэрэгсэл, багаж эзэмшүүлж сургах;

- мэргэжлийн дагуу нисэхийн техникийн тоног төхөөрөмж, системийн ажиллах зарчим, бүтэц, түүний ашиглалтын заавар, техникийн байдал, нисэхийн техникийн бүх төрлийн бэлтгэлийг хийх технологи, багтаамжийг мэддэг байх;

- бүлгийн бие бүрэлдэхүүн, техникийн эд хогшлыг шилжин байрлах болон хээрийн нөхцөлд ажиллахад бэлтгэх;

- нисэхийн техник дээр сэргээн сайжруулах болон хэвшүүлэх ажил гүйцэтгэх үед мэргэжлийн дагуу бүлгийнхээ хүчээр тоног, төхөөрөмжийн задаргаа хийх;

- газрын үйлчилгээний хэрэгсэлд хяналтын үзлэг болон шингэн, хийн, цахилгаан тэжээлийн чанарт шалгалтыг чадварлаг хийдэг байх;

- ажлын байрны цэвэрлэгээ, тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж, хяналт-шалгалтын хэрэгсэл, багажны хадгалалтад хяналт тавих, тэдгээрийг цаг тухайд нь засварлуулах, нөхөн хангуулах арга хэмжээ авах, багаж түлхүүрийн тоо ширхэг, чанар байдлыг өдөр бүр шалгаж байх;

- бүлгийг цаг тухайд нь материал хэрэгслээр хангуулах арга хэмжээг авах, тэдгээрийн хангалт, шууд зориулалтын зарцуулалтад хяналт тавьж, тооцоо хөтлөх;

- нисэхийн техник дээр ажиллах үеийн техникийн аюулгүйн

дүрэм болон галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангуулах зэрэг үүрэгтэй.

### **11.6. Онгоц /нисдэг тэрэг/-ны ахлах техникч /техникч/**

713. Онгоц /нисдэг тэрэг/-ны техникч /ахлах техникч/ нь мэргэжлийн хувьд техник ашиглалтын хэсгийн дарга буюу хэсгийн техникчид захирагдана.

714. Ахлах техникч /техникч/ нь:

- онгоц /нисдэг тэрэг/-ны бүрэн бүтэн болон байлдааны бэлэн байдал, нислэгийн бүх төрлийн бэлтгэл, түүний чанар;
- харьяалдаг техникч, механикч нарын онгоц /нисдэг тэрэг/-н дээр хийх ажлыг дүрэм зааврын дагуу гүйцэтгүүлж сургах;
- өөрт хариуцуулсан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хадгалалт зэргийг хариуцна.

715. Ахлах техникч /техникч/ -ийн үүрэг:

- онгоц /нисдэг тэрэг/-ний бүтэц болон хүчлэх эд ангиудын техникийн ашиглалтын заавар, түүнчлэн нисэхийн радиоэлектрон болон десантын тоног төхөөрөмж, зэвсэглэлийн зориулалт, ажиллах зарчим, түүнтэй харьцах дүрэм болон өөрт хариуцуулсан онгоц, хөдөлгүүр, тоног төхөөрөмжийн үүрэг зориулалт техникийн төлөв байдал, нөөцийг мэдэх;

- хэрэглэгддэг түлш, тос, тусгай шингэн, хийн төрөл зүйл, тэдгээрийн зарцуулалтын хэмжээ, түүнчлэн хариуцуулсан онгоц /нисдэг тэрэг/-ны түлш, тосны бодит зарцуулалтыг мэдэх, сумлаж байгаа түлш, тос, тусгай шингэн, хийнүүдийн хэмжээг өөрийн биеэр хянах, тэдгээрийн агаар дахь зарцуулалтыг хянах;

- нислэгийн бэлтгэл болон хэвшүүлэх ажлын багтаамж, гүйцэтгэх дэс дарааллыг мэдэх, нислэгийн бүх төрлийн бэлтгэлийг хийж чадах, үйлчилгээний болон ТАА-ийн бүлгийн хүмүүсээс онгоц /нисдэг тэрэг/-н дээр хийж байгаа ажлын гүйцэтгэлийг хянах, онгоц /нисдэг тэрэг/ нислэгийн үүрэг гүйцэтгэхэд бэлэн болсон эсэхийг тодорхойлох;

- нисэх багийн даргын өгсөн бүх үүргийг ёсчлон биелүүлэх, онгоц /нисдэг тэрэг/-ны техникийн багийн ажлыг удирдах;

- нисэхийн техникийн бүх эвдрэл, гэмтлийн тухай нисэх багийн дарга болон техник ашиглалтын хэсгийн даргад илтгэх;

- тогтоогдсон тайлан тооцоог хугацаанд нь хийх, онгоц /нисдэг тэрэг/-ны баримт бичиг зөв хөтлөгдөж буй эсэхэд хяналт тавих;

- нислэгийн бэлтгэлийг бие даан хийж чаддаг байх, түүнчлэн техникийн төлөв байдлыг чадварлаг шалгадаг, эвдрэл, гэмтлийг илрүүлж, арилгаж чаддаг байх;

- нисгэгчийн бүхээг, шүхэр, суудлыг бэлтгэх болон нисгэгчийг онгоц /нисдэг тэрэг/-нд суух, хөдөлгүүр асаах үед туслалцаа үзүүлэх;

- нислэгт зөвхөн эвдрэл, гэмтэлгүй бүрэн бэлтгэгдсэн онгоц /нисдэг тэрэг/-ыг гаргах, нислэгийн өмнөх болон давтан нислэгийн бэлтгэлийн төгсгөлд нисэх багийн дарга, техник ашиглалтын хэсгийн даргад онгоц /нисдэг тэрэг/ нислэгт бэлэн болсон тухай илтгэх;

- нислэгийн дараа нисэх бүрэлдэхүүнээс нислэгийн үе дэх нисэхийн техникийн ажиллагааны талаарх тэмдэглэгдсэн дутагдал, доголдлыг арилгах арга хэмжээ авах;

- онгоц /нисдэг тэрэг/-ны дагалдах газрын тоног төхөөрөмжийг эвдрэл, гэмтэлгүй, цэвэр байдалд байлгах, цаг тухайд нь шалгаж, засварлах, онгоцны зогсоол, онгоцны нуувч, явгалах зам руу очих хэсгийг цэвэрлэх зэрэг болно.

716. Онгоцны техникчийн үүрэг, хариуцлага нь борттехникч, борт-инженерүүдэд нэгэн адил хамаарна.

### **11.7. Үйлчилгээний бүлгийн болон хэвшүүлэх ажлын бүлгийн ахлах техникч /техникч/**

717. Үйлчилгээний бүлгийн болон хэвшүүлэх ажлын бүлгийн ахлах техникч /техникч/ нь бүлгийн даргад захирагдана. Тэд мэргэжлийн хувьд бүлгийн бүх бүрэлдэхүүнд зааварчилгаа өгөх эрхтэй.

Бүлгийн ахлах техникч /техникч/ нь:

- бүлэгт нь хариуцуулсан онгоц /нисдэг тэрэг/ систем тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, байлдааны бэлэн байдал;

- бүлэгт нь хариуцуулсан газрын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хяналт шалгалтын хэрэгслийн зөв ашиглалт, бүрэн бүтэн байдал, хадгалалт;

- нисэхийн техник дээр хийгдэж байгаа ажлын гүйцэтгэл, чанарыг хариуцаж ажиллана.

718. Үйлчилгээний бүлгийн болон хэвшүүлэх ажлын бүлгийн

ахлах техникч /техникч/-ийн үүрэг :

- нисэхийн техникийн бүтэц, техникийн ашиглалтын заавар, нислэгийн бэлтгэлийн болон хэвшүүлэх ажлын багтаамж, дэс дараалал, технологийг мэдэх, нислэгийн бүх төрлийн бэлтгэлийг бие даан хийж чаддаг байх;

- нисэхийн техник дээр хийгдэх ажлыг чанартай, цаг тухайд нь гүйцэтгэх;

- нисэхийн техник дээрх эвдрэл, гэмтлийг түргэн шуурхай илрүүлэн арилгаж чаддаг байх, энэ талаар бүлгийнхээ техникийн бүрэлдэхүүнд зааварчилгаа өгөх;

- хяналт-шалгалтын хэрэгслийг ашиглалтыг мэддэг, хэрэглэж чаддаг байх, тэдгээрийг ашиглахад байнга бэлэн байлгах;

- бүлгийнхээ хүмүүсийг ажлын гүйцэтгэл дадлага, туршлагад дүрэм зааврын дагуу сургах, нисэхийн техник дээрх хийж гүйцэтгэсэн ажлын чанарыг шалгах;

- нисэхийн техник дээр ажиллах үеийн техникийн аюулгүйн дүрмийг мэдэх, нарийн чанд биелүүлэх;

- тогтоогдсон тайлан, тооцоог хийх.

719. Үйлчилгээний болон хэвшүүлэх ажлын бүлгийн техникчийн үүрэг, хариуцлага нь онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийн ажиллагааг хянан шалгах, онгоцыг ослын үед орхих хэрэгслийн болон бодит хяналтын бүлгийн техникч нарт нэгэн адил хамаарна.

### **11.8. Ахлах механикч /механикч/**

720. Ахлах механикч /механикч/ нь онгоц /нисдэг тэрэг/-ны техникч /бүлгийн техникч/-д захирагдах бөгөөд нисэхийн техник дээр хийгдэж байгаа ажлын гүйцэтгэл, чанар, онгоц /бүлэг/-ны дагалдах газрын үйлчилгээний хэрэгсэл, багаж хэрэгсэл, хянан шалгах хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

727. Ахлах механикч /механикч/-ийн үүрэг нь:

- өөрт хариуцуулсан нисэхийн техникийн бүтэц, техникийн ашиглалтын зааврыг мэдэх, ажлын дадлага, туршлагаа байнга дээшлүүлэх;

- өөрт хариуцуулсан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах,

- нисэхийн техник дээр хийгдэх бүх төрлийн ажил, бэлтгэлийг цаг тухайд нь чанартай хийж гүйцэтгэх;
- онгоц /нисдэг тэрэг/-ны системүүдэд хэрэглэгддэг түлш, тос, тусгай шингэн, хийн төрөл зүйл, зөв цэнэглэлт /сумлах/, хяналт шалгалтын хэрэгслийг хэрэглэх зааврыг мэдэх;
- илэрсэн бүх дутагдлыг тухай бүр техникч /бүлгийн техникч/-д илтгэх, нисэхийн техникийн эвдрэл, гэмтлийг илрүүлж, арилгаж чаддаг байх;
- нисэхийн техник дээр ажиллах үед аюулгүйн арга хэмжээний шаардлагыг биелүүлэх.

### **11.9. Жижүүрийн инженер**

728. Нисэхийн техник дээр ажиллаж байгаа инженерүүдээс өдөр бүр жижүүрийн инженерийг томилох бөгөөд тэр нь ерөнхий инженерт захирагдана. Жижүүрийн инженер нь инженер техникийн бүрэлдэхүүнийг нисэхийн техник дээр ажиллах үед тогтоосон журам, аюулгүйн арга хэмжээг дагаж мөрдүүлэхийг хариуцна.

729. Жижүүрийн инженерийн үүрэг нь:

- онгоц /нисдэг тэрэг/-н дээр хийж гүйцэтгэх ажлын багтаамж, хугацааг мэдэх, хуваарийн дагуух гүйцэтгэлийн ээлж дарааллыг хянах;
- газрын үйлчилгээний хэрэгслийн өгөгдсөн захиалгыг мэдэж байх, тэдгээрийн цагтаа гарч ирсэн эсэхийг хянах;
- онгоц /нисдэг тэрэг/-н дээр хийгдэх ажлууд /хөдөлгүүрийг асааж, шалгах, хөл ангийг хураах, буулгах, тогтоол буудлага г.м./-ын гүйцэтгэлийн тухай мэдээллийг цаг тухайд нь авах асуудлыг зохион байгуулах;
- заагдсан ажлуудыг тогтоогдсон байранд аюулгүйн арга хэмжээний дагуу хийж буйд хяналт тавих;
- онгоц /нисдэг тэрэг/-нд үзлэг хийх үед илэрсэн дутагдлыг арилгах зорилгоор шаардлагатай тохиолдолд ТАА-ийн холбогдох мэргэжлийн хүмүүсийг дуудах;
- жижүүрлэлтэнд томилгоожсон онгоц /нисдэг тэрэг/-ны нислэгийн бэлтгэлийг хянах, онгоц /нисдэг тэрэг/, НИА-ны бие бүрэлдэхүүний байлдааны жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг цаг тухайд нь хангуулах арга хэмжээ авах;

- Ажлын явцад гаргасан дутагдал, нисэхийн техникийн эвдрэл, гэмтэл тэдгээрийг арилгасан талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг ахлах инженерийн дэвтэрт бичиж тэмдэглэн тухай бүрт ерөнхий инженерт илтгэх;

- цаг агаарын аюултай үзэгдлийн тухай мэдээг цаг тухайд нь бие бүрэлдэхүүнд урьдчилан мэдээлэх.

### **11.10. Нислэгийн ахлах инженер**

730. Нислэгийн ахлах инженер нь нислэгийн удирдагчид захирагдах бөгөөд тухайн ээлжийн нислэгт үйлчилж буй нийт инженер, техникийн бүрэлдэхүүний дарга нь болно.

Нислэгийн ахлах инженер нь нислэгийн үед инженер, техникийн бүрэлдэхүүнээр тогтоогдсон журам, дэглэм болон аюулгүйн арга хэмжээг дагаж мөрдүүлэхийг хариуцна.

731. Нислэгийн ахлах инженерийн үүрэг нь:

- нислэгийн төлөвлөлт /хүснэгт/, нислэгийн өдөр /шөнө/-ийн гүйцэтгэх үүрэг болон нислэгийн явц дахь НИА-ны бие бүрэлдэхүүний ажлын онцлогийг судлах;

- аэродром, техникийн хангалтын салбараас ирүүлсэн нислэгт үйлчлэх техник хэрэгслийн тоо хэмжээг захиалгын дагуу өгсөн эсэхийг шалгах;

- газрын үйлчилгээний хэрэгслийн бэлэн байдал болон түлш, тос, тусгай шингэн, хийн чанар байдал, шаардлага хангаж буй эсэхийг хянах;

- газрын үйлчилгээний хэрэгслийн хуваарилалтыг эскадриль/хэсэг/, байрлал бүрээр нь хянах;

- НИА-ны удирдлагын байр, техникийн байр болон байршил, техникийн тусламжийн багууд ажиллагаанд бэлэн эсэхийг шалгах;

- онгоц /нисдэг тэрэг/ нислэгт бэлэн болсон тухай илтгэл авах, инженер, техникийн бүрэлдэхүүнд нислэгийн төлөвлөлт /хүснэгт/, гүйцэтгэх үүрэг, тухайн нислэгийн онцлогийг танилцуулж, тодотгох;

- нисэхийн техник болон аэродром, техник хангалтын хэрэгслүүд нислэгт бэлэн болсон тухай нислэгийн удирдагчид илтгэх.

Нислэгийн явцад:

- онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгийн төлөвлөлт /хүснэгт/-ийг

нарийн чанд баримтлан нислэгт гаргах;

- онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэхэд гарсан саатал, тэдгээрийг арилгах талаар авсан арга хэмжээний тухай болон бие бүрэлдэхүүн нисэхийн техникийн ашиглалтын заавар зөрчсөн тохиолдолд нислэгийн удирдагчид илтгэх;

- нислэгийн үед онгоц /нисдэг тэрэг/-ны ашиглалтын заавар зөрчигдсөн бүх тохиолдол, нислэгийн өгөгдөхүүнүүд ашиглалтын хязгаарлалтаас хэтрэх, эсхүл нисэхийн техникийн эвдрэл, гэмтэл гарсан тухай илтгэлийг бодит хяналтын хэрэгслийн бичлэгт дүн шинжилгээ хийж байгаа мэргэжилтнээс авч нислэгийн удирдагч, ерөнхий инженер нарт нэн даруй илтгэх;

- нислэгийн ахлах инженерийн дэвтэрт нисэхийн техникийн эвдрэл, гэмтэл, инженер, техникийн бүрэлдэхүүний үйл ажиллагаа болон нислэгийн хангалтад гарсан дутагдал, доголдлыг бичиж хөтлөх;

- нислэгийн онцгой тохиолдлын үед нисэх бүрэлдэхүүний үйлдлийн талаар нислэгийн удирдагчид туслах;

- нислэгээс ирсэн нисэх багт онгоц /нисдэг тэрэг/-ыг тавих байрыг зааж өгөх, тэдгээрийн сумлагааг зохион байгуулах.

Нислэгийн дараа:

- нислэгийн өдөр /ээлж/-ийн ажлын дүнг гаргаж ерөнхий инженерт илтгэх;

- НИА-ны бие бүрэлдэхүүн болон газрын үйлчилгээний хэрэгслүүдийг нислэгээс буулгах зөвшөөрөл өгөх.

732. Нислэгийн ахлах инженер нь нислэгийн явцад аэродром, техник хангалтын жижүүрт газрын үйлчилгээний хэрэгслийг ашиглах асуудлаар зааварчилгаа өгөх эрхтэй.

**Нисэхийн техникийн баримт бичгийг хөтлөх,  
хадгалах, сэргээх журам /42-р зүйл/**

1.Формуляр, паспортыг дараах албан тушаалтнууд хөтөлнө.

Үүнд:

- онгоц /нисдэг тэрэг/-ны их бие, хөдөлгүүрийн техникч /борттехникч/;
- нисэхийн радиоэлектрон болон цахилгаан тусгай тоноглол, зэвсэглэлийн үйлчилгээний бүлгийн дарга /техникч/.

2. Формулярт:

- хэвшүүлэх ажил хийсэн тухай формулярын тухайн хэсэгт хэвшүүлэх ажлын бүлгийн дарга нар;
- бие бүрэлдэхүүний үйлчилгээний ажлын тухай төрөл мэргэжлийн инженерүүд, ТАА-ийн дарга;
- үйлдвэрлэгч-нийлүүлэгчийн хийсэн нэмэлт ажлын тухай үйлдвэрлэгч-нийлүүлэгчийн хариуцлагатай төлөөлөгч;
- засвар хийсэн тухай засварын газрын дарга /ерөнхий инженер/;
- үечилсэн үзлэгийн үеийн нисэхийн техникийн байдлын талаар ерөнхий инженер бичилт хийнэ.

3. Формулярын хөтлөлт, чанар байдлыг техникч, үйлчилгээний бүлгийн дарга нар хариуцна.

Ерөнхий инженер формулярын үнэн, зөв хөтлөлтийг улиралд нэгээс доошгүй удаа шалгана.

Формуляр, паспортын бичилтийг зөвхөн хар бэхээр цэвэр, гаргацтай бичнэ.

4. Онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүр, тоноглол, зэвсэглэлийн агрегат нь паспорттай байна. Паспортад агрегатын техникийн өгөгдөхүүн, ажилласан цаг, ашиглалт болон засварын ажлын гүйцэтгэлийг бичнэ.

5. Формуляр, паспортын бичилтэд хийгдсэн засварыг ерөнхий инженер, эсхүл холбогдох төрөл мэргэжлийн инженер гарын үсэг зурж, байгууллагын тамга даран баталгаажуулна. Баталгаажуулаагүй бол хүчингүйд тооцно.

6. Онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүр, тусгай агрегатуудыг засварт

болон өөр байгууллагад шилжүүлэхдээ формуляр, паспортад нь ажилласан тухай дүнг бичиж, агрегат, блокуудын дугаарыг формуляр, паспорттай нь тулгаж шалгана. Формуляр дахь дүгнэлтийн өгөгдөхүүнүүд үнэн зөв гэдгийг ерөнхий инженер гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулна.

7. Хэрвээ формуляр, паспортын хуудас нь дууссан бол формуляр, паспорт шинээр нээнэ. Шинээр нээсэн формуляр, паспортын эхний хуудсанд энэ нь түрүүчийн формуляр, паспортын үргэлжлэл болох тухай бичилтийг хийж, он, сар, өдрийг тавина.

Шинэ формуляр, паспортын эхний хуудас дахь бичилтүүд болон ажилласан цаг, өгөгдөхүүнийг ерөнхий инженер гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулна.

Хуучин, шинэ формуляр, паспортыг хамт хадгална.

8. Нисэхийн техникийн формулярыг тусгай байранд, зориулалтын тоногдсон шүүгээнд хадгална. Тэдгээрийн хадгалалтыг ахлах инженерүүд, ТАА-ийн дарга нар хариуцна.

9. Ашиглалтад байгаа нисэхийн техникийн формуляр, паспортыг хүчингүй болсон /гээгдэж, үрэгдсэн/ тохиолдолд байгууллагын тооцоонд байгаа өгөгдөхүүнийг үндэслэн формуляр, паспортыг орлуулж хөтөлнө. Үүний тулд ерөнхий инженер нь формуляр, паспортад байсан өгөгдөхүүнийг сэргээх бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

Орлуулсан формуляр /паспорт/-т ерөнхий инженер гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулна.

Хэрвээ нисэхийн техникийн үндсэн өгөгдөхүүнийг сэргээх боломжгүй бол засварын газарт явуулна. Нисэхийн засварын газарт нисэхийн техникийн байдлыг шалгасны дараа формуляр, паспортыг орлуулан хөтөлж өгнө. Нисэхийн хөдөлгүүрт бүрэн хэмжээний ялгалт цэгцлэлт хийж, эвдрэл, гэмтлийг арилгасны дараа орлуулсан формулярыг олгоно.

10. Байгууллагын ерөнхий инженер нисэхийн техникийн формуляр хүчингүй болсон /гээгдэж, үрэгдсэн/ тохиолдолд түүний шалтгааныг тогтоож, дарга /захирагч/-д илтгэнэ.

11. Онгоц /нисдэг тэрэг/-ыг үйлдвэрлэгч-нийлүүлэгч /завод/, засварын газраас нисгэж авчрах, хээрийн сургуульд оролцох үед агаарын хөлгийн бүхээгийн хуудас /карт/ нь хамт байна.

**Нисэхийн техникийн нислэгийн нислэгийн бэлэн байдалд тавих нарийвчилсан хяналт, үзлэгийн хэм хэмжээ /100, 290 дүгээр зүйл/**

|   | Үзлэг хийдэх онгоц/нислэг тэрэг/-ны тоо |                                  |                |                                   |                            |   |
|---|---|----------------------------------|----------------|-----------------------------------|----------------------------|---|
|   | нислэгийн өмнөх үзлэг                   | гарааны өмнөх үзлэг              | хяналтын үзлэг | үечилсэн үзлэг                    |                            |   |
| НИА-ны албан тушаалтан                              | Фронт-ын нисэх                          | Цэргийн тэвэрч                   | Фронт-ын нисэх | Цэргийн тэвэрч                    | Фронт-ын нисэх             | Цэргийн тэвэрч  |
|   | Сард 2 онгоц                            | Сард 2 онгоц                     | Сард 1 онгоц   | Хувийн төлөвлөгөөний дагуу        | Сард 4 онгоц               | Сард 3 онгоц  |
| Ерөнхий инженер, гөрөл мэргэжлийн инженерүүд        | Сард 2 онгоц                            | Сард 2 онгоц                     | Сард 1 онгоц   | Хувийн төлөвлөгөөний дагуу        | Сард 4 онгоц               | Сард 3 онгоц  |
| Онгоц/нислэг тэрэг/, хөдөл-гүүрийн инженер          | 2 онгоц                                 | 2 онгоц                          | Сард 1 онгоц   | Хувийн төлөвлөгөөний дагуу        | Сард 4 онгоц               | Сард 3 онгоц  |
| ТАА-ийн дарга                                       |   |                                  |                |                                   | Сард 4 онгоц               | Сард 3 онгоц  |
| Эскадрилийн инженер, үйлчилгээний бүлгийн дарга нар | Сард 6 онгоц                            | Нислэгтэй өдөр / шөнө/-т 1 онгоц |                | Хувийн төлөвлөгөөний дагуу        | Хувийн төлөвлөгөөний дагуу | Хувийн төлөвлөгөөний дагуу                              |
| Техник ашиглалтын Хэсгийн дарга/хэсгийн техникч/    | Нислэгийн өмнөх бэлтгэлд нэг онгоц      | Нислэгтэй өдөр шөнө/-т 1 онгоц   |                | Урьдчилсан бэлтгэлийн үед 1 онгоц | Хувийн төлөвлөгөөний дагуу | Хувийн төлөвлөгөөний дагуу                              |
| Хэвшүүлэх ажлын бүлгийн дарга                       |   |                                  |                |                                   |                            | Хэвшүүлэх ажил хийхийн өмнө болон дараа нь бүх онгоцонд |

Тайлбар:

1. Энэхүү нарийвчилсан хяналт, үзлэгийг 12 нэгжээс дээш онгоц /нисдэг тэрэг/-той анги салбарууд дагаж мөрдөнө.

Онгоц /нисдэг тэрэг/-ноос авч, агуулахад хадгалж байгаа нисэхийн хөнөөх хэрэгслийн байлдааны ижүүдийг дарга /захирагч/-ын томилсон комисс жилд хоёроос доошгүй удаа үзэж шалгана.

2. Техник ашиглалтын хэсгийн дарга буюу хэсгийн техникч бүх онгоц /нисдэг тэрэг/-ны нислэгийн бэлтгэлийн гүйцэтгэлийг шалгана.

3. Нисэх бүрэлдэхүүний нисэхийн техникт хийх үзлэгийн хэм хэмжээг дарга /захирагч/ тогтооно.

4. Ерөнхий инженер нь төрөл мэргэжлийн инженерүүд, ТАА-ийн дарга, бүлгийн дарга нарын оролцоотойгоор нисэхийн техникийн үзлэгийг иж бүрнээр хийнэ.

5. Үзлэгийн явцад баримт бичгийн хөтлөлт, багаж, тоног төхөөрөмжийн байдлыг шалгана.

6. Онгоц /нисдэг тэрэг/-ны байдалд тавих үнэлгээг ерөнхий инженер, НИА-ны албан тушаалтнууд онгоц /нисдэг тэрэг/-ны формулярт, бүлгийн дарга нар онгоц /нисдэг тэрэг/-ыг нислэгт бэлтгэх дэвтэрт тус тус бичнэ.

7. Үзлэгийн үед илэрсэн эвдрэл, гэмтлийн талаар нислэгт бэлтгэх дэвтэрт бичих ба уг эвдрэл, гэмтлийг арилгасан, хянасан хүмүүс гарын үсэг зурна.

**НИА-ны үйл ажиллагааг дүгнэх хэв хэмжээ /106 дугаар зүйл/**

Шалгалтын үед НИА-ны үйл ажиллагааг дүгнэхэд дараах зүйлсийг удирдамж болгоно. Үүнд:

**1. Хэрэв:**

- эвдрэл, гэмтэлгүй онгоц /нисдэг тэрэг/-ны тоо жилийн туршид дунджаар тогтоогдсон хэм хэмжээнээс доогуур болоогүй бол;

- шалгалтын үед үзлэгээр орсон онгоц /нисдэг тэрэг/-ны 80-аас доошгүй хувь нь “онц”, эсхүл “сайн” байдалд байгаа бөгөөд тэдгээрийн дотор ”Хангалтгүй” үнэлгээтэй онгоц /нисдэг тэрэг/ байхгүй бол;

- шалгуулсан бие бүрэлдэхүүний инженер, техникийн бэлтгэлийн түвшин ”Онц” гэж дүгнэгдсэн бол;

- нисэхийн техникийн бат найдвартай чанар, бэлэн байдлыг өндөржүүлэхэд чиглэгдсэн ажил өрнүүлсэн, бэлэн байдалд оруулах хугацааг тогтмол багасгаж, түүнийг засварлах, ашиглах талаар туршлага хуримтлуулж нэвтрүүлсэн бол;

- нисэхийн техник, хөдөлгөөнт хяналт, засварын хэрэгсэл, нуувчийн ашиглалт, хамгаалалт, тэдгээрийн арчилгаа, тордлогыг зааврын дагуу зохион байгуулсан бол;

- бие бүрэлдэхүүнээр зэвсэглэлд байгаа нисэхийн техникийг аль болох бүрэн хэмжээгээр судлуулах шаардлагад сургалтын бааз нь тохирч байвал байгууллагын НИА-ны үйл ажиллагааг ”Онц” гэж дүгнэнэ.

**2. Хэрэв:**

- эвдрэл, гэмтэлгүй онгоц /нисдэг тэрэг/-ны тоо жилийн туршид дунджаар тогтоогдсон хэв хэмжээнээс доогуур болоогүй бол;

- шалгалтын үед үзлэгээр орсон онгоц /нисдэг тэрэг/-ны 60-аас доошгүй хувь нь “онц”, эсхүл “сайн” байдалд байгаа бөгөөд тэдгээрийн дотор ”Хангалтгүй” гэсэн үнэлгээтэй онгоц /нисдэг тэрэг/ байхгүй бол;

- шалгуулсан бие бүрэлдэхүүний инженер, техникийн бэлтгэлийн түвшин ”Сайн” гэж дүгнэгдсэн бол;

- бусад бүх шаардлага нь "онц" гэсэн үнэлгээтэй адил байх нөхцөлд байгууллагын НИА-ны үйл ажиллагааг "Сайн" гэж дүгнэнэ.

### 3. Хэрэв:

- эвдрэл, гэмтэлгүй онгоц /нисдэг тэрэг/-ны тоо жилийн туршид дунджаар тогтоогдсон хэм хэмжээнээс 5 хувиас ихгүйгээр буурсан байвал;

- үзлэгээр орсон онгоц /нисдэг тэрэг/-ны байдал "хангалттай" түвшинд байвал;

- шалгуулсан бие бүрэлдэхүүний техникийн бэлтгэлийн түвшин "хангалттай" үнэлгээнээс доогуургүй байвал;

- бусад бүх шаардлага нь "онц" үнэлгээтэй адил байх нөхцөлд байгууллагын НИА-ны үйл ажиллагааг "Хангалттай" гэж дүгнэнэ.

### 4. Хэрэв:

- шалгалтын үед үзүүлэлтүүд нь "хангалттай" гэсэн үнэлгээнд өгөх шаардлагаас доогуур байвал байгууллагын НИА-ны үйл ажиллагааг "Хангалтгүй" гэж дүгнэнэ.

- НИА-ны үйл ажиллагааг дүгнэх үед онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгөөнт хяналт, засварын хэрэгсэл, нуувчийн 10-15 хувиас доошгүйг үечилсэн үзлэгийн багтаамжтай үзсэн байна.

- Сүүлийн жилд НИА-ны бие бүрэлдэхүүний буруугаас нислэг, нислэгийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зөрчил, дутагдал гарсан бол үнэлгээг бууруулна.

1. Үзлэгийн үр дүнгээр онгоц /нисдэг тэрэг/-ыг дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

- хэрэв онгоц /нисдэг тэрэг/ эвдрэл, гэмтэлгүй, ашиглалтын зааврын шаардлага зөрчигдөөгүй бол "Онц";

- хэрэв онгоц /нисдэг тэрэг/ эвдрэл, гэмтэлгүй, гэхдээ ашиглалтын зааврын шаардлага зарим нэг талаар зөрчигдсөн бол "Сайн";

- хэрэв нислэгийн аюулгүй байдалд шууд нөлөөлөхөөргүй зарим нэгэн гэмтэл илэрсэн, эсхүл онгоц /нисдэг тэрэг/-ны ашиглалтын зааврын шаардлагыг бүдүүлгээр зөрчөөгүй бол "Хангалттай";

- хэрэв нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц эвдрэл, гэмтэл онгоц /нисдэг тэрэг/-нд илэрсэн, эсхүл ашиглалтын зааврын

шаардлага зөрчигдсөн бол “Хангалтгүй”.

Онгоц /нисдэг тэрэг/-ны техникийн байдлын үнэлгээг формулярт нь, харин эвдрэл, гэмтлийг нислэгт бэлтгэх дэвтэр /эвдрэл, гэмтлийг бүртгэх/-т бичнэ.

“Хангалтгүй” гэж үнэлэгдсэн онгоц /нисдэг тэрэг/-ны эвдрэл, гэмтлийг зассаны дараа үечилсэн үзлэгийн багтаамжтай төрөл мэргэжлийн инженерүүдийн үзлэгт оруулна.

2. Онгоц/нисдэгтэрэг/,эдангидээрхүннэгбүртэйшуудярилцлага хийсний үндсэн дээр бие бүрэлдэхүүний инженер, техникийн бэлтгэлийн түвшинд үнэлгээ өгөх ба нисэх бүрэлдэхүүнийг “Нислэг үйлдэх дүрэм”, техникийн бүрэлдэхүүнийг тухайн загварын онгоц /нисдэг тэрэг/-ны техникийн ашиглалтын заавраар шалгана.

Бие бүрэлдэхүүний инженер, техникийн бэлтгэлийн түвшинг дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

- дундаж үнэлгээ нь 4.6-аас багагүй бол “Онц”;
- дундаж үнэлгээ нь 3.6-аас багагүй бол “Сайн”;
- дундаж үнэлгээ нь 3.0-аас багагүй бол “Хангалттай”.

**Газрын үйлчилгээний хэрэгсэлд  
тавигдах шаардлага, тэдгээрийн аэродромын  
хяналтын багтаамж / 113-р зүйл /**

1. Газрын үйлчилгээний хэрэгсэлд аэродромын хяналт тавихдаа дараах зүйлсийг удирдамж болгоно. Үүнд:

- тогтоогдсон бүх баримт бичиг нь холбогдох албан тушаалтны гарын үсэг зурагдаж, бүрэн хэмжээгээр албан ёсны болсон байх, сумлаж байгаа ШТМ /түлш, тусгай шингэн, тос, хий г.м./-ын хяналтын тасалбарт шаардагдах өгөгдөхүүн бөглөгдсөн, улсын стандартын шаардлага хангасан, тухайн загварын онгоц /нисдэг тэрэг/-нд хэрэглэхээр зөвшөөрөгдсөн байх;

- түгээх төхөөрөмж, хяналт хэмжилтийн хэрэгсэл нь эвдрэл, гэмтэлгүй, баталгаажуулсан байх бөгөөд түгээгүүрийн шүүр нь цэвэр, тогтоогдсон загварын, гэмтэлгүй байх;

- тохируулгын болон хамгаалалтын төхөөрөмж нь тухайн загварын онгоц /нисдэг тэрэг/-ны ашиглалтын шаардлагад тохирсон хэмжээнд тавигдсан байх;

- газардуулагч төхөөрөмж нь бүрэн бүтэн, гал унтраах хэрэгсэлтэй байх;

- газрын үйлчилгээний хэрэгсэл нь нисэх хэрэгсэлд үйлчлэх үед машины арын дугуйны дор тавих хоёроос доошгүй хязгаарлагч ивээстэй байх ёстой.

2. Тусгай тоног төхөөрөмж, түлш, түлшээр цэнэглэгч, түлш цэнэглэх төвлөрсөн систем, тос цэнэглэгч болон шингэний байгууламж дахь шингэнийг хянаж шалгах үед хавсралт 1-ийн шаардлагаас гадна дараах зүйлсийг удирдамж болгоно. Үүнд:

- шүүрний таглаа, амьсгалах хавхлаг, хүлээн авах патруб нь найдвартай таглагдсан, ломбодсон, хамгаалах бүрээснүүд нь бүтэн, цэвэр байх ёстой;

- тунгалаг шилэн саванд авсан тунадас нь механик хэсгүүд, усгүй байх, өвлийн цагт мөсөн талстууд, гадны хольц болон булингартай байх ёсгүй. Түлшний тунадасыг түлшээр цэнэглэгчийн түлшний шүүрнээс, эсхүл төвлөрсөн түлш цэнэглэгч, агрегатын шүүр, нөөцлүүр савнаас, тос болон шингэний системийн тунадасыг

тос цэнэглэгчийн бак, цистерн болон шингэний төхөөрөмж, бусад цэнэглэгч хэрэгслээс тус тус авна;

- түлш цэнэглэх төвлөрсөн системийн шүүгч элемент үзлэг хийх хүртэл нислэгийн бүх хугацаанд саадгүй ажиллагааг хангах ёстой бөгөөд шүүрнүүд дээрх даралтын уналт 0,3-1,5 кг/см.кв-ын хооронд байвал зохино;

- масло цэнэглэгчийн маслын температур нь цаг агаар ба улирлын ямар ч нөхцөлд цэнэглэгч болон нисэх хэрэгслийн техникийн ашиглалтын зааврын шаардлагыг хангаж байх ёстой;

- шингэний төхөөрөмжийн гаралт дээр байгаа шүүрний цэвэрлэгээ нь нисэх хэрэгслийн шингэний системийн шүүрнийхээс доогуур байх ёсгүй.

3. Аэродромын хөдөлгөөнт цахилгаан агрегат (АПА)-ын тусгай тоноглолыг шалгах үед дараах зүйлсийг удирдамж болгоно. Үүнд:

- цахилгаан агрегатын аккумуляторын батарейны хүчдэл нь түр зуур гадны ачаалал /10 сек-ээс ихгүй хугацаанд/ залгах үед 25 В-оос багагүй байх;

- зөөврийн резисторын тусламжтай ачаалал өгөх үед хүчдэлийн өөрчлөлтийн цар нь 24,3–29,7 В-ын хооронд байх;

- кабель дамжуулагчийн үзүүрийн өнгө ялгасан будаг, тэмдэг нь цахилгаан агрегатын хуваарилах байгууламжийнхтай тохирч байх.

4. Тусгай цэнэглэгчийн түлшний бүтэц, найрлага, тоног төхөөрөмжийг шалгах үед дараах зүйлсийг удирдамж болгоно. Үүнд:

- цутгах хоолой, амьсгалах хавхлаг, нээлхийний болон хүлээн авах патрубны таглаа, сорьц авах, тунадас юүлэх цоргыг лацдаж, ломбодсон байх;

- цэнэглэх төхөөрөмжийн хамгаалах хэрэгсэл нь тогтоогдсон загварынх бөгөөд бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангасан байх;

- ШТМ-аас сорьц авч үзсэний үндсэн дээр уг сумлагч тэнцсэн тухай, мөн түүнийг ломбодсон дардасны дугаарыг зааж, сумлагчийн формулярт бичилт хийсэн байх.

5. Онгоц /нисдэг тэрэг/-ыг хүчилтөрөгч, азот, агаараар цэнэглэх

автостанц, түүний тоног төхөөрөмжид хяналтын үзлэг хийхэд дараах зүйлсийг удирдамж болгоно. Үүнд:

- хий нь хэв хэмжээндээ байгаа эсэхийг хүчилтөрөгчийн паспорт дахь бичилтийг тухайн нисэх хэрэгслийн техникийн ашиглалтын заавар болон улсын стандартын шаардлагатай харьцуулж шалгах /азотоор цэнэглэгчийн ажлын тооцооны дэвтэрт азотыг, агаараар цэнэглэгчийн ажлын дэвтэрт агаарыг/;

- хамгаалах бүрээс нь цэвэр, бүтэн бөгөөд цэнэглэх төхөөрөмжиндөө найдвартай бэхлэгдсэн байх;

- нисэх хэрэгслийн системд цэнэглэх штуцерийг залгахын тулд цэнэглэх станц нь нэг загварын бүрэн бүтэн, тэмдэгтэй, тосгүй болгосон, иж бүрэн түлхүүр, багажтай байхаас гадна шингэн хүчилтөрөгчөөр цэнэглэхийн тулд цэвэр брезентэн бээлийтэй байх;

- хүчилтөрөгчийн чанарыг холбогдох албаны дарга болон ангийн эмч шалгаж, гарын үсэг зурж баталгаажуулсан байх;

- шахсан агаарын шүүдэрлэлтийн цэг /агаараар цэнэглэгчийн ажлын тооцооны дэвтэр дэх бичилтээр/ нь нисэх хэрэгслийн техникийн ашиглалтын заавраар тогтоогдсоноос дээгүүр байж болохгүй, харин эдгээр өгөгдөхүүн байхгүй бол 150 кг/см.кв даралттай үед -40 хэмээс дээшгүй байх.

Техникч /механикч, борттехникч/ түлш, тослох материал, тусгай шингэнээр цэнэглэхийн өмнө онгоц /нисдэг тэрэг/-нд заавал газардуулга хийж, цэнэглэгчийн газардуулга, ШТМ-ын паспорт /хяналтын тасалбар/ нь цэнэглэх зөвшөөрөлтэй эсэх, ШТМ нь тухайн онгоц /нисдэг тэрэг/-ны ашиглалтын шаардлагатай тохирч буй эсэх, түүнчлэн түгээгч төхөөрөмжийн бүрэн бүтэн, цэвэр байдал, цэнэглэгч хэрэгслийн лац, ломбыг шалгана.

Газрын үйлчилгээний хэрэгслийг онгоц /нисдэг тэрэг/-нд залгахын өмнө техникч /механикч/ нь тэдгээрийн хэмжигдэхүүн /даралт, агаарын дулаан, хүчдэл г.м./ тухайн загварын онгоц /нисдэг тэрэг/-ны техникийн ашиглалтын зааврын шаардлагад тохирч буй эсэхийг шалгана.

**Хийгээр цэнэглэсэн баллоныг хэрэглэхэд  
анхаарах зүйл / 115 дугаар зүйл /**

1. Зориулалтын баллонд хийг шахаж, зохих өнгөөр будан тухайн баллонд байгаа хийний нэрийг бичнэ.

| Хийний нэр                    | Баллоны өнгө | Баллон дээрх бичээс        | Бичээсний өнгө |
|-------------------------------|--------------|----------------------------|----------------|
| Азот                          | Хар          | Азот                       | Шар            |
| Шивтэр /аммиак/               | Шар          | Аммиак                     | Хар            |
| Техникийн аргон               | Хар          | Техникийн аргон            | Хөх            |
| Цэвэр аргон                   | Саарал       | Цэвэр аргон                | Ногоон         |
| Ацетилен                      | Цагаан       | Ацетилен                   | Улаан          |
| Устөрөгч                      | Хар ногоон   | Устөрөгч                   | Улаан          |
| Агаар                         | Хар          | Шахсан агаар               | Цагаан         |
| Хүчилтөрөгч                   | Цэнхэр       | Хүчилтөрөгч                | Хар            |
| Эмнэлгийн<br>хүчилтөрөгч      | Цэнхэр       | Эмнэлгийн хүчил-<br>төрөгч | Хар            |
| Хүхэрт устөрөгч               | Цагаан       | Хүхэрт устөрөгч            | Улаан          |
| Нүүрсхүчил                    | Хар          | Нүүрсхүчил                 | Шар            |
| Бусад бүх шатамхай<br>хий     | Улаан        | Хийний нэр                 | Цагаан         |
| Бусад бүх шатамхай<br>бус хий | Хар          | Хийний нэр                 | Шар            |

Тайлбар:

1.1. Азот, хүхэрт устөрөгч, аргоны зориулалттай баллоныг тойруулж зураас татна. Үүнд: азот-хүрэн, хүхэрт устөрөгч-улаан, техникийн аргон-хөх, цэвэр аргон-ногоон.

1.2. Том хэмжээний /12 л-ээс их/ баллоны бичээсийг баллоны тойргийн уртын гуравны нэгээс багагүй хэмжээнд тойруулж бичнэ. Үсгийн өндөр нь 60 мм-ээс багагүй, харин зураасны өргөн нь 25 мм байна. Бага хэмжээний /12 л хүртэлх/ баллоны зураас, бичээсний хэмжээг тухайн баллоны гадаргууны байдлаас тодорхойлох нь зүйтэй.

1.3. Автомашин, бусад тээврийн хэрэгсэл дээр байгаа суурин баллоныг тухайн машины өнгөөр будаж болно.

1.4. Тусгай төхөөрөмжид хэрэглэдэг, эсхүл тусгай зориулалтын хий шахахад зориулагдсан баллоны будгийн өнгө, бичээсийг улсын мэргэжлийн хяналтын газраас тогтооно.

2. Устөрөгч болон бусад шатамхай хий шахдаг баллоны цорго нь зүүн тийшээ, хүчилтөрөгч, агаар болон бусад шатамхай бус хий шахдаг цорго нь баруун тийшээ резьбатай байна.

Ацетилений зориулалтын баллоны цорго нь зүүн тийшээ резьба бүхий штуцертэй байхаас гадна тойрсон сувагтай штуцер, эсхүл баруун тийшээ резьба бүхий хоолой залгадаг нүхтэй байж болно.

3. Баллоны хүзүүний, эсхүл зарцуулагч шахагч штуцерын ойролцоо дараах өгөгдөхүүнийг тэмдэглэсэн байна. Үүнд:

- үйлдвэрлэгч-бэлтгэгчийн марк;
- баллоны маяг /стандартын баллонд/;
- баллоны дугаар;
- баллоны жин кг-аар;
- бэлтгэсэн /шалгасан/ он, сар, өдөр, дараагийн

баталгаажуулалтын хугацаа;

- ажлын даралт (кгс/см<sup>2</sup>);
- сорилтын шингэний даралт (кгс/см<sup>2</sup>);
- баллоны багтаамж, литр;
- үйлдвэрлэгч-бэлтгэгчийн техникийн хяналтын хэлтсийн тэмдэг, 10 мм-ийн диаметртэй, дугуй хэлбэртэй.

Бага хэмжээний баллоны тэмдгийн бичээсийн өндөр нь 6 мм-ээс багагүй, харин 55 л-ээс их багтаамж бүхий баллоных 8 мм-ээс багагүй байна.

4. Үечилсэн баталгаажуулалтын хугацаа дууссан, тогтоогдсон тэмдэггүй, цорго нь бүрэн, бүтэн бус, их бие нь эвдрэл, гэмтэлтэй /цавтай, их зэврэлттэй, хэлбэр дүрс нь мэдэгдэхүйц өөрчлөгдсөн/, будаг болон бичээс нь шаардлагын дагуу бус байвал тухайн баллоныг ашиглах, хий шахахыг хатуу хориглоно.

5. Хийтэй баллоныг байранд халаагуур болон бусад халаагч хэрэгсэл, пийшингээс 1 м-ээс багагүй зайд, хийн пийшин, халаагуур, бусад ил галтай дулааны эх үүсвэрээс 5 м-ээс багагүй зайтай байрлуулна.

Хүчилтөрөгчтэй болон шатамхай хийтэй баллоныг нэг байранд хадгалахыг хориглоно.

Хий шахсан ивээс бүхий баллоныг босоо байдалд хадгална. Баллоныг унахаас сэргийлж, тусгай тоноглогсон үүрэнд байрлуулан хамгаалалт хийнэ.

Ивээсгүй баллоныг модон суурь, эсхүл тавиур дээр хэвтээ байрлалд хадгалж болно.

Задгай талбайд баллоныг хадгалахдаа олс, модон хөндлөөр хийсэн жийргэвчтэй, эсхүл резинэн зөөлөвчтэйгөөр 1,5 м-ээс өндөргүй хураахыг зөвшөөрнө.

Баллонуудыг хураахдаа бүх цорго нь нэг зүгт харсан байхаар байрлуулна.

6. Хийгээр дүүргэсэн баллонуудыг хооронд нь заавал жийргэвчтэйгээр, хэвтээ байдлаар зөөвөрлөх ёстой.

Жийргэвчийг баллонд зориулсан үүр бүхий модон хөндөл болон 25 мм-ээс багагүй зузаантай олс, резинэн цагираг мэтийн баллоныг доргилтоос хамгаалсан зүйлээр хийнэ. Баллон бүр 2 цагирагтай байна. Баллоныг зөөвөрлөх үед бүх цоргыг нь нэг зүгт харуулж байрлуулна.

Баллонуудын хооронд жийргэвч хийсэн, унахаас хамгаалсан хашилттай тохиолдолд босоо байдлаар зөөвөрлөхийг зөвшөөрнө.

Баллоныг хадгалах, тээвэрлэх болон ачаалах, буулгах ажлын үед тэдгээрийн бохирдолт, гэмтэлт, унагаахаас сэргийлсэн арга хэмжээг авсан байх ёстой.

12 л-ээс илүү багтаамжтай нэг загварын баллоныг тээвэрлэх, хадгалах үед тэдгээрийн урьдчилан хамгаалах таглааг хийсэн байх ёстой.

Хорт хий бүхий баллоныг тээвэрлэх, хадгалах үед хажуугийн хошуу/штуцер/-ны бөглөөг хийсэн байх ёстой.

Хийгээр дүүргэсэн баллоныг тээвэрлэх, хадгалах үед тэдгээр нь нарны үйлчлэлээс хамгаалагдсан байх ёстой.

7. Онгоц /нисдэг тэрэг/-нд байрлуулсан өндөр даралтын бүх баллон болон техникийн хяналтын хэрэгслийн шалгалтыг тусгай сургалтаар бэлтгэгдсэн, хэмжил зүйн албаны эрх бүхий хүмүүс гүйцэтгэх ёстой.

**Онгоц /нисдэг тэрэг/-ны хөдөлгөөнийг газар дээр удирдах,  
хөдөлгүүр асаах болон ачаа ачих, буулгах үед  
өгөх дохио /134 дүгээр зүйл /**

1. Аэродром дээр хөдөлгүүр асаах болон онгоц /нисдэг тэрэг/-ны хөдөлгөөнийг удирдах дохио

Дохионууд нь онгоц /нисдэг тэрэг/-ны бүхээгт байгаа нисгэгч /техникч/, газарт байгаа техникч /механикч/-д зориулагдана. Бүх дохиог өдөр гарын хөдөлгөөнөөр, шөнө гар чийдэнгээр гүйцэтгэнэ.

А. Тийрэлтэт хөдөлгүүртэй онгоцны хувьд:

| Тушаал  | Дохио  |  |
|---|--|--|
|   | өдөр   | шөнө   |
| Анхаар /ерөнхий дохио/  | Баруун гар дээш өргөгдсөн байна.   | Гар чийдэнгийн гэрлийг урагш чиглүүлэн дээш өргөнө.  |
| Хөдөлгүүр асаахад бэлтгэ /бүхээгнээс өгөх/                      | Хажуу тийш нь сунгасан зүүн /баруун/ гараараа урагш хойш нь давтсан хөдөлгөөн хийнэ. | Аэронавигацийн гэрлийг залгана. ”Асаалт явуулах бэлтгэл бэлэн” хариу авмагц, аэронавигацийн гэрлүүдийг унтраана. |
| Унтраасан, сэнсээ эргүүл /ерөнхий дохио/                        | Гараа зөрүүлж, толгой дээрээ өргөсний дараа асаах хөдөлгүүрийн зүг сунгаж эргүүлнэ.  | Гар чийдэнгийн гэрлийг урагш хандуулж, эргэлдэх хөдөлгөөн хийнэ. Аэронавигацийн гэрлээ үе үе анивчуулна.         |
| Сэнснээс холд, хөдөлгүүрээс холд /бүхээгээс өгөх/               | Асаах хөдөлгүүрийнхээ зүг гараа хаялна.  | Суулт/явгалалт/-ын гэрлээ /фар/ түр зуур залгана.  |
| Ивээсээ ав /бүхээгээс өгөх/                                     | Гараа толгойныхоо түвшинд авчирч салгах хөдөлгөөнөө давтана.                         | Аэронавигацийн гэрлүүдээ байнга анивчуулна.  |
| Явгалахыг зөвшөөрнө үү, чирэхийг зөвшөөрнө үү /бүхээгнээс өгөх/ | Зүүн гараа дээш өргөнө.  | Суулт/явгалалт/-ын гэрлээ /фар/ түр зуур залгана.  |

|  |   |   |
|--|---|---|
| Явгалахыг зөвшөөрнө, чирэхийг зөвшөөрнө /газраас өгнө/ | Баруун гараа малгайдаа хүргэж явгалах тал руу /чирэх/ нь сунгана.   | Гар чийдэнгээ дээш өргөж явгалах /чирэх/ зүг рүү нь дээрээс доошлуулсан хөдөлгөөн хийнэ.                                  |
| Чигээрээ явгал, чигээрээ чир /газраас өгнө/            | Хоёр гараа дээш өргөж бага зэрэг салгана. Урагш хойш нь давтсан хөдөлгөөн үйлдэнэ.  | Гар чийдэнгээ дээш өргөж /чийдэнгийн гэрэл дээшээ чиглэсэн байх ёстой/ урагш хойш давтсан хөдөлгөөн үйлдэнэ.              |
| Баруун тийшээ эргэ /газраас өгнө/                      | Баруун гараа өргөж зүүн гараа буулгана. Баруун гараараа урагш хойш давтсан хөдөлгөөн үйлдэнэ.                               | Эргэх зүг гэрлийг хандуулсан чийдэнг мөрний хэмжээнд өргөж, хэвтээ хавтгайд давтсан хөдөлгөөн үйлдэнэ.                    |
| Зүүн тийшээ эргэ /газраас өгнө/                        | Зүүн гараа өргөж, баруун гараа буулгана. Зүүн гараараа урагш хойш давтсан хөдөлгөөн үйлдэнэ.                                | Эргэхдээ гэрлийг нь хандуулсан чийдэнг мөрний хэмжээнд өргөж хэвтээ хавтгайд давтсан хөдөлгөөн үйлдэнэ.                   |
| Явгалах болон чирэх хурдаа багасга /газраас өгнө/      | Хоёр гараа буулгаж хажуу тийш нь бага зэрэг салгасан байна. Гараа дээш доош болгож давтсан хөдөлгөөн үйлдэнэ.               | Чийдэнтэй гараа буулгаж, хажуу тийш үл мэдэг болгоно. Чийдэнгээрээ дээш доош давтсан хөдөлгөөн үйлдэнэ.                   |
| Зогс /ерөнхий дохио/                                   | Гараа толгой дээрээ өргөн зөрүүлж, салган хөдөлгөөнөө давтана. Улаан дарцаг дээш нь өргөх буюу улаан пуужин буудна.         | Дээр өргөсөн чийдэнг баруун зүүн тийш нь болгож давтан хөдөлгөнө.   |
| Хөдөлгүүрээ унтраа /газраас өгнө/                      | Гараа толгой дээрээ өргөж зөрүүлнэ.   | Чийдэнгээ онгоц руу чиглүүлж анивчуулна.  |
| Ухраа /газраас өгнө/                                   | Хоёр гараа буулгаж, алгануудаа онгоц руу харуулна. Гараа урагш нь мөрний хэмжээнд хүртэл өргөх хөдөлгөөнийг давтан үйлдэнэ. | Чийдэнгийн гэрлийг доош анивчуулна. Чийдэнгээ мөрнийхөө түвшинд хүртэл доороос дээш нь болгох хөдөлгөөнөө давтан үйлдэнэ. |
| Чирээд /газраас өгнө/                                  | Доош буулгасан баруун гараа биеийнхээ өмнө савлана.   | Гэрлийг нь доош хандуулсан чийдэнгээ биеийнхээ өмнө савлана.  |

## Б. Нисдэг тэрэгний хувьд:

| Газрын үйлчилгээний техникийн хэсгийг удирдаж байгаа хүмүүст өгөх дохио |                                   |   |
|---|-----------------------------------|---|
| 1.  | Хөдөлгөөн үйлдэхэд бэлэн          | Газрын үйлчилгээний техникийн хэрэгслийг удирдаж байгаа хүн рүү хандаж 2 гараа толгой дээрээ эгц дээш өргөнө. |
| 2.  | Хөдөлгөөн эхлүүлэх                | 2 гарыг урагш сунган тохойгоор нугалж, гарын алгуудыг мөрөндөө ойртуулна.                                     |
| 3.  | Баруун эргэлт                     | Баруун гараа “Хөдөлгөөн эхлүүлэх” үйлдлийг хийж, зүүн гарыг хажуу тийш хөндлөн барина.                        |
| 4.  | Зүүн эргэлт                       | Зүүн гараа “Хөдөлгөөн эхлүүлэх” үйлдлийг хийж, баруун гарыг хажуу тийш хөндлөн барина.                        |
| 5.  | Зогс, Хөдөлгүүр унтраа            | 2 гарыг өргөж толгой дээрээ зөрүүлнэ. Гэрлийг толгой дээр зөрүүлнэ.   |
| 6.  | Ухрах                             | 2 гараар цээжнээс урагш түлхэх хөдөлгөөн хийнэ.   |
| 7.  | Хөдөлгүүр асаа                    | Баруун гарыг өргөн хуруугаар хөдөлгүүрийн дугаарыг заана.   |
| 8.  | Буух талбайд нисдэг тэргийг угтах | Хоёр гараа дээш өргөнө.   |
| 9.  | Зам талбай чөлөөтэй               | Баруун гарыг тохойгоор нугалан өргөж, эрхий хурууг гозойлгоно.  |
| 10.   | Висение хийх                      | Хоёр гарыг мөрний түвшинд алдлана.  |
| 11.   | Доошил                            | Хоёр гарыг мөрний түвшинд алдлан гарын алгыг доош нь харуулж, гарыг доош хөдөлгөнө.                           |
| 12.   | Дээшил                            | Хоёр гарыг мөрний түвшинд алдлан гарын алгыг дээш харуулж, гарыг дээш нь хөдөлгөнө.                           |
| 13.   | Алгуур газард                     | Гарын алгыг тэнийлгэж доош харуулан хоёр гарыг хагас алдлан доош унжуулж гараа дээш доош хөдөлгөнө.           |
| 14.   | Над руу яв                        | Хоёр гарыг тохойгоор нугалан өргөж гарын алгыг хойш нь харуулан гараа цааш нааш нь хөдөлгөнө.                 |
| Агаарын хөлгөөс газар руу өгөх дохио                                    |                                   |   |
| 1.  | Газрын холбоог залгах             | Нисгэгч холбоо барихад бэлэн бол 2 гараа чихэнд ойртуулж дохино.  |
| 2.  | Гадны цахилгаан үүсгүүр холбох    | Нисгэгч баруун гарынхаа хуруунуудыг зүүн гарынхаа алга руу ойртуулан тулгаж дохино.                           |

|    |                                |   |
|----|--------------------------------|---|
| 3. | Гадны цахилгаан үүсгүүр салгах | Нисгэгч баруун гарынхаа хуруунуудыг зүүн гарынхаа алганаас холдуулж дохино. |
| 4. | Хөдөлгүүр асаах                | Техникчийн адил үйлдэл хийнэ.   |
| 5. | Тоормос бариулсан              | Хоёр гарыг атгана.  |
| 6. | Тоормос сулласан               | Хоёр гарын алгыг тэнийлгэнэ.  |
| 7. | Ивээс ав                       | Нисгэгч хоёр гарыг тохойгоор хагас нуглан дээш доош хөдөлгөнө.              |

Жич:

1.1. Газраас дохио өгөх үед техникч /механикч/ нь нисгэгчийн хараа хүрэх талбайд онгоц руу харж зогсоно.

1.2. "Асаалтад бэлэн", "Сэнснээс холдлоо", "Хөдөлгүүрээс холдлоо", "Ивээс авлаа" тушаалын биелэлтийг дараах байдлаар орлуулж илтгэнэ. Үүнд: өдөр-гараа малгайдаа хүргэнэ, шөнө-чийдэнгийн гэрлээ онгоц руу чиглүүлнэ.

1.3. Гар дохиог шөнийн цагт үйлдэхдээ хоёр гартаа гэрэлтдэг дохиур барих ба хэрэв дохих орчин гэрэлтүүлэг сайтай бол өнгөт дохиураар дохиж болно.

1.4. Аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллыг хангах үүднээс дохигч техникч нь гэрэл цацруулагч хантааз буюу бүс, гэрэлтдэг болон өнгөт дохиур, дуу намсгагч чихэвчтэй байна. Дээрхээс гадна хамгаалалтын нүдний шилийг хэрэглэнэ.

## 2. Дохио өгөх дэс дараалал, журам, тэдгээрийг биелүүлэх

### А. Онгоц /нисдэг тэрэг/-ыг чирэгчээр чирэх болон онгоцны ангараас гаргах /оруулах/

2.1. Онгоц /нисдэг тэрэг/-ыг чирэгчээр чирэх, ангар болон зогсоол, техникийн байрлалаас гаргах /оруулах/ ажлыг удирдаж байгаа албан тушаалтан дараах үүрэгтэй. Үүнд:

- уг ажилд оролцож байгаа бие бүрэлдэхүүнд энэ ажлыг гүйцэтгэх техникийн аюулгүйн заавраар зааварчилгаа өгөх, зааврыг мөрдөж байгаад тогтмол хяналт тавих;

- ажил эхлэхийн өмнө хүн бүрийн гүйцэтгэх үүргийг хуваарилах, техникийн аюулгүйн заавар, түүнчлэн дохионы ач холбогдол, өгөх арга болон биелүүлэх журмыг сануулах;

- ажлын үед дохиог өөрийн биеэр өгөх бие бүрэлдэхүүн техникийн аюулгүйн зааврын шаардлагыг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;

- дохио өгөх бүрт бие бүрэлдэхүүний аюулгүй байдал болон онгоц /нисдэг тэрэг/-ыг гэмтээхгүй байхад анхаарах;

- чирэх хэрэгслийн бүрэн бүтэн байдал ба түүнийг онгоц /нисдэг тэрэг/-нд болон чирэгчид зөв холбосон эсэхийг шалгах;

- онгоц /нисдэг тэрэг/-ыг чирэгчээр чирэх, ангараас гаргах /оруулах/ үед ашиглахгүй байгаа газрын үйлчилгээний бүх техник, хэрэгслийг онгоц /нисдэг тэрэг/-ноос салгасан, онгоц /нисдэг тэрэг/-ны хөдөлгөөн үйлдэх бүсээс гаргасан эсэхийг шалгах;

- онгоц /нисдэг тэрэг/-н дээрх бүх нээхийнүүдийн тагнууд хаагдсан, найдвартай бэхлэгдсэн эсэхийг шалгах;

- онгоц /нисдэг тэрэг/-ны тоормосны системийн даралтыг шалгах;

- дохио өгөх холбооны техник хэрэгслийн найдвартай ажиллагааг шалгах.

2.2. 40-80 кг-аас илүү жинтэй чирэх хэрэгслийг онгоц /нисдэг тэрэг/, эсхүл чирэгчид холбоход хоёроос доошгүй хүн байна.

2.3. Онгоц /нисдэг тэрэг/-ыг гаргах /оруулах/-ын өмнө уг ажлыг удирдаж байгаа албан тушаалтан "Байр байрандаа" дохио өгнө. Энэ дохиогоор онгоц /нисдэг тэрэг/-ыг гаргах /оруулах/ ажиллагаанд оролцогч бүр онгоцны хажууд өөр өөрийн байрыг эзэлнэ.

2.4. Онгоц /нисдэг тэрэг/-ны хөдөлгөөнийг "урагшаа", эсхүл "эргээд" дохиогоор эхэлнэ.

Онгоц /нисдэг тэрэг/-ыг чирэгчээр чирэх, ангараас гаргах (оруулах)-д онцгой тохиолдол үүсвэл тоормослохоор онгоц /нисдэг тэрэг/-ны бүхээгт нисгэгч эсхүл онгоцны техникч байна.

Чирэх хэрэгсэл дээр байгаа албан тушаалтан "эргээд" дохиогоор онгоц /нисдэг тэрэг/-ыг шаардлагатай зүг рүү нь эргүүлнэ. Онгоцны бүхээгт сууж байгаа албан тушаалтан шаардлагатай үед дугуйны тоормосоор эргэлт үйлдэхэд нь тусална.

2.5. Хөдөлгөөний хурдыг "хурдаа багасга" дохиогоор багасгах бөгөөд онгоц /нисдэг тэрэг/-ны бүхээгт сууж байгаа албан тушаалтан дугуйны тоормосны ажиллагааг удирдана.

2.6. Онгоц /нисдэг тэрэг/-ыг зогсоохдоо ”Зогс” дохио өгнө. Бие бүрэлдэхүүн болон онгоц /нисдэг тэрэг/-нд ямар нэгэн осол, гэмтэл гарч болзошгүй байдлыг урьдчилан харсан хүн “Зогс” дохиог өгөх үүрэгтэй.

“Зогс” дохиогоор онгоц /нисдэг тэрэг/-ыг гаргах /оруулах/ ажилд оролцогсад хөдөлгөөнөө больж, онгоцыг зогсоох бөгөөд бүхээгт байгаа албан тушаалтан дугуйны тоормосны ажиллагааг удирдана.

Тоормосны систем ажиллагаагүй, эсхүл тоормосны системд даралтгүй байхад онгоц /нисдэг тэрэг/-ыг чирэгчээр чирэх, ангараас гаргах /оруулах/-ыг хориглоно.

#### Б. Онгоц /нисдэг тэрэг/-ыг чирэгч машинаар чирэх

2.7. Чирэх ажлыг удирдагч нь чирэх хэрэгслийг онгоц /нисдэг тэрэг/-нд залгасны дараа ”Байр байрандаа” дохио өгнө.

2.8. Онгоц /нисдэг тэрэг/ чирэх ажилд оролцогсад өөр өөрсдийн байраа эзэлснийг мэдмэгц удирдагчаас ”чирэлтэд” дохиог өгнө. Энэ дохиогоор жолооч чирэгч машиныг онгоц /нисдэг тэрэг/ руу зөөлөн ухраана. Чирэгч машины дэгээ төмрийг чирэх хэрэгсэлтэй холбож болохуйц зайд ойртмогц удирдагч ”Зогс” гэж дохиод холбох заалт өгнө. Энэ дохиогоор чирэгчийн жолооч машинаа зогсоох ба харин шаардлагатай тохиолдолд хуваарилж гаргасан хүн машины хойд дугуйн дор ивээс тавьж, онгоц чирэгч машины холболтыг хийнэ.

2.9. Чирэх ажиллагааг удирдагчийн ”байр байрандаа” дохиогоор нисгэгч /техникч/ онгоцны бүхээгт орж суугаад дугуйн тоормосыг тавьж, чирэгч машины жолоочтой найдвартай холбоо тогтооно.

Механикч, эсхүл өөр хуваарилж гаргасан хүн онгоц /нисдэг тэрэг/ болон чирэгч машины дугуйн ивээсийг авч, жолооч нисгэгч /техникч/ хоёрын хооронд холбооны хэрэгсэлгүй үед жолоочид дохио дамжуулахын тулд чирэгч машин дээр байрлан, улмаар онгоц чирэх ажиллагааны аюулгүй байдлыг ажиглана.

2.10. Онгоц /нисдэг тэрэг/-ыг чирэхэд бэлэн болоход бүхээгт байгаа нисгэгч /техникч/ чирэх ажиллагааг удирдагчаас чирэлт үйлдэх зөвшөөрөл авна.

Чирэх ажиллагааг удирдагч, чирэлтэд бүх зүйл бэлэн, онгоцны хөдөлгөөн үйлдэх замд саад байхгүй үед чирэх зөвшөөрөл өгнө.

Онгоцыг чирэх чирэгчийн хурд:

- хатуу холбоосоор чирэхэд 15 км/цаг,
- зөөлөн /төмөр татлага/ холбоосоор чирэхэд 5 км/цаг байна.

Харин нисдэг тэргийг хатуу хучилттай буюу бетонон талбай дээр 8 км/цаг, шороон буюу хөрсөн талбай дээр 5 км/цаг, хойшоо 3 км/цагаас илүүгүй хурдтай чирнэ.

2.11. Чирэх зөвшөөрөл авмагц бүхээгт байгаа нисгэгч /техникч/ ”урагшаа” дохио өгнө. Энэ дохиог чирэгч машин дээр байгаа механикч /эсхүл өөр хуваарилж гаргасан хүн/ жолоочид дамжуулна.

Онгоц /нисдэг тэрэг/-ыг чирэгчээр чирэх үед огцом, ширүүн эргэлт, угзралт болон гэнэтийн зогсолт хийхийг хориглоно. Байрлалаас хөдлөх, аэродром дээрх хөдөлгөөн, эргэлт, тоормос болон зогсолтыг зугуухан үйлдэнэ.

Онгоц /нисдэг тэрэг/-ыг зогсоол дээр байхад урд дугуйг эргүүлэхийг хориглоно.

Нисдэг тэргийг чирэгчээр чирэх, ангараас гаргах /оруулах/ үед сэнсний алганууд нь сүүлийн дам нуруу /балк/ болон тогтворжуулагчийн дээр байх ёсгүй.

Нисдэг тэргийг хойш нь чирэхдээ тусгай зориулалтын төмөр татлага хэрэглэх ба үндсэн хоёр дугуйн тулгуураас оосорлосон байна.

Чирэх үед төмөр татлаган дээгүүр гарахыг хориглоно.

Чирэгч дээр байрлаж байгаа механикч онгоц /нисдэг тэрэг/-ны бүхээгт байгаа хүний дохиог ажиглаж, жолоочид дамжуулах ба онгоц /нисдэг тэрэг/-ны хөдөлгөөний аюулгүй байдалд ажиглалт хийнэ.

2.12. Онгоц /нисдэг тэрэг/-ыг зогсоохын тулд жолоочид ”Зогс” дохиог өгнө. Энэ дохиогоор жолооч чирэгч машинаа зугуухан зогсоож, харин бүхээгт байгаа нисгэгч /техникч/ дугуйны тоормосны ажиллагааг удирдана.

Хөдөлгөөний чиглэлийг өөрчлөх шаардлагатай үед ”Баруун тийш эргэ”, ”Зүүн тийш эргэ” дохиог өгнө.

2.13. Онгоц /нисдэг тэрэг/-ыг чирэгчээр чирэх, ангараас гаргах /оруулах/ ажилд оролцож байгаа бие бүрэлдэхүүн, эсхүл онгоц /нисдэг тэрэг/-нд заналхийлж буй аюул /ямар нэгэн осол, гэмтэл

гарч болзошгүй байдал/-ыг урьдчилан харсан хүн “ЗОГС” дохиог өгнө. Энэ дохиогоор онгоц /нисдэг тэрэг/ болон чирэгч машины хөдөлгөөнийг нэн даруй зогсооно.

В. Онгоц /нисдэг тэрэг/-ны хөдөлгүүрийг асаах үед

2.14. Онгоц /нисдэг тэрэг/-ны хөдөлгүүрийг асаах үед нисгэгч /техникч/ ”Хөдөлгүүр асаахад бэлтгэ” дохиог өгнө. Энэ дохиогоор техникч /механикч/ асаахын өмнөх бүх бэлтгэл ажлыг /дугуйн ивээсийн тавилтыг шалгах, газрын цахилгаан агрегатын кабель залгах г.м./ гүйцэтгэсний дараа асаах гэж буй хөдөлгүүр бүрэн харагдахуйц аюулгүй бүсэд байраа эзэлж, ”Асаалтад бэлэн” илтгэлийг хийнэ.

Хөдөлгүүр асаах гэж байгаа нисгэгч /техникч/ зөвхөн ”Асаалтад бэлэн” гэсэн илтгэлийн дараа тухайн загварын онгоцны ашиглалтын зааварт заасан хөдөлгүүрийг асаалтад бэлтгэх ажиллагааг гүйцэтгэнэ.

2.15. Тийрэлтэт болон турбин сэнст хөдөлгүүрийг асаалтад бэлтгэсний дараа /турбин сэнст онгоцон дээр сэнсийг нь эргүүлэх г.м./ асаагч ”Хөдөлгүүрээс холд” дохиог өгнө. Энэ дохиогоор газар дахь асаалтыг хангаж байгаа техникч асаалт аюулгүй гэдгийг мэдмэгц ”Хөдөлгүүрээс холдлоо” гэсэн илтгэлийг хийнэ.

Илтгэлийг авмагц нисгэгч /техникч/ хөдөлгүүрийг асаана.

2.16. Поршент хөдөлгүүрийг асаах үед ”Хөдөлгүүр асаахад бэлтгэ” дохио, ”Асаалтад бэлэн” илтгэлийн дараа асаалт үйлдэгч шаардлагатай тоноглолыг хөдөлгүүрийн асаалтад бэлтгэх ба асаах түлхүүрийг салгаж ”Сэнс эргүүл” дохио өгнө.

2.17. Уг дохиог авмагц газар дахь асаалтыг хангаж байгаа техникч ”салгасан уу” гэж асуугаад ”салгасан” хариу авмагц ”сэнс эргүүлэхэд бэлэн” гэж илтгэн, сэнс эргүүлэх дохио өгнө.

2.18. Поршент хөдөлгүүрт цутгалт /түлш/ хийсний дараа, асаалт үйлдэгч ”Сэнснээс” дохио өгнө. Энэ дохиогоор асаалт хангаж байгаа техникч сэнсний дор хэн ч байхгүй, асаалтад юу ч саад болохгүй байгааг мэдмэгц ”Сэнснээс холдлоо” гэж илтгэнэ.

Асаалт үйлдэгч ”Сэнснээс холдлоо” илтгэлийг авмагц техникийн ашиглалтын зааврын дагуу хөдөлгүүрийг асаана.

Г. Зогсоолоос онгоц /нисдэг тэрэг/-ыг явгалуулах үед

2.19. Явгалахын өмнө нисгэгч хөдөлгүүрийн эргэлтийг бага дээр нь болгож, ”Ивээс ав” дохио өгнө. ”Ивээс ав” дохиогоор техникч мөн хамгаалах тор, чагт болон явгалахын өмнө авах ёстой бусад хэрэгслийг авах ажиллагааг гүйцэтгэнэ.

Уг дохиог биелүүлмэгц техникч ”Ивээс авлаа” гэж хариулаад гараа малгайдаа хүргэнэ.

2.20. “Ивээс авлаа” хариуг авмагц нисгэгч явгалах зөвшөөрөл авна.

Техникч онгоц явгалахад аюулгүй гэж мэдмэгц гараа малгайдаа хүргэж, явгалах зүг рүү нь сунгана.

3. Онгоц /нисдэг тэрэг/-нд ачаа ачаалах /буулгах/ үед өгөгдөх дохионууд

”Анхаар”- гараа дээш өргөнө. ”Өргө”-өргөгч ажиллуулагч руу гараа сунган сарвууг /алгаар нь гадагш/ дээш өргөнө. Ачааг шилжүүлэн хөдөлгөх дохиог сарвууны хөдөлгөөнөөр заана.

”Буулга” дохиог хэрэглэхдээ мөн адил хөдөлгөөн хийх бөгөөд харин гарын /алга дотогш/ сарвуу доошоо чиглэгдсэн байна.

”Зогс” хоёр гарыг зөрүүлнэ.

**НИА-ны орон тооны тусгай зориулалтын автомашин,  
чиргүүлд хийх хяналтын үзлэгийн хэм хэмжээ /152 дугаар  
зүйл/**

| Албан тушаалтан  | Тусгай зориулалтын чиргүүл,<br>машины тоо                                      | Үзлэг хийх хугацаа |
|--|--|--------------------|
| Ерөнхий инженер, төрөл<br>мэргэжлийн инженерүүд            | Тусгай зориулалтын машин,<br>чиргүүлийн 20-иос доошгүй<br>хувь                 | Хагас жилд 1 удаа  |
| ТАА-ийн дарга, пуужин<br>урьдчилан бэлтгэх<br>байрын дарга | Салбарын тусгай зориулалтын<br>автомашин, чиргүүлийн 20-<br>иос доошгүй хувийг | Сард 1 удаа        |
| Бүлгийн дарга нар  | Бүлгийн тусгай зориулалтын<br>бүх автомашин, чиргүүл                           | Сард 1 удаа        |

**Түлхүүр, багаж хэрэгслийг тэмдэглэх /155 дугаар зүйл/**

Түлхүүр, багаж хэрэгслийг дараах журмаар тэмдэглэнэ. Үүнд:

- түлхүүр, багаж хэрэгслийн металл хэсгийн ажлын бус гадаргуу дээр цоолтуур, эсхүл цахилгаан химийн аргаар;
- хэрэв түлхүүр, багаж нь задардаг /олон хэсгээс бүрддэг/ бол тус бүр дээр;
- металл бус багаж хэрэгсэл /үстэй сойз ... г.м./ дээр түлж , төөнөх аргаар;
- түлхүүр, багаж хэрэгсэл бүрд тэмдэглэгээг /клеим/ сайн харагдахуйц, тодорхой тавина;
- шинээр тэмдэг тавих шаардлага гарвал хуучныг арилгасан байна;
- тус бүрийн ашиглалттай түлхүүр, багаж хэрэгслийг онгоц, онгоцоор нь, эсхүл үйлчилгээний болон хэвшүүлэх ажлын бүлгээр тэмдэглэсэн байна.

Үйлчилгээний болон ТАА-ийн хэвшүүлэх ажлын бүлгийн нэг бүрийн хэрэглээний түлхүүр, багаж хэрэгслийн тэмдэглэгээ нь зүүнээс баруун тийш байрласан үсэг, тооноос бүрдэнэ. Эхний хоёр тоо нь байгууллагын дугаарын сүүлчийн тоог, түүний дараах үсэг нь хэвшүүлэх ажлын, үйлчилгээний бүлгийн томьёолсон тэмдэг /хүснэгт №1/, дараах нэг тоо нь эскадриль /хэсэг/-ийн дугаар, дараах хоёр тоо онгоц/нисдэг тэрэг/-ны хажуугийн болон багажны хайрцагны гаднах дугаар /хүснэгт №2/, сүүлчийн тоонууд нь түлхүүр багажны дансанд бүртгэсэн дэс дугаар /хүснэгт №3/-ыг заана.

Түлхүүр багаж хэрэгслийг хэрхэн тэмдэглэх тухай дараах жишээнд үзүүлэв.

## Хүснэгт № 1

| Бүлгийн нэр   | Томьёолсон тэмдэг |
|---|-------------------|
| Онгоц/нисдэг тэрэг/-ны хөдөлгүүрийн үйлчилгээний бүлэг      | ОХ/НТХ/           |
| Радиоэлектрон тоноглолын үйлчилгээний бүлэг                 | РЭТ               |
| Нисэхийн цахилгаан, тусгай тоноглолын үйлчилгээний бүлэг    | НЦТТ              |
| Нисэхийн зэвсэглэлийн үйлчилгээний бүлэг                    | НЗ                |
| Онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийн хэвшүүлэх ажлын бүлэг    | ОХХ /НТХХ/        |
| Радиоэлектрон тоноглолын хэвшүүлэх ажлын бүлэг              | РЭТХ              |
| Нисэхийн цахилгаан, тусгай тоноглолын хэвшүүлэх ажлын бүлэг | НЦТТХ             |
| Нисэхийн зэвсэглэлийн хэвшүүлэх ажлын бүлэг                 | НЗХ               |
| Слесарь-механикчийн бүлэг                                   | СМБ               |
| Пуужин урьдчилан бэлтгэх байрын бүлэг                       | ПУББ              |
| Өндрийн хэрэглэл, тоноглолын бүлэг                          | ӨХТБ              |

## Хүснэгт № 2

**Радиоэлектрон тоноглолын үйлчилгээний болон хэвшүүлэх ажлын бүлгийн бие бүрэлдэхүүний бүртгэл /загвар/**

| Д/д | Албан тушаал    | Цол, овог нэр | Түлхүүр багажны хайрцаг,дүнхний гадна дугаар | Тайлбар |
|-----|-----------------|---------------|--|---------|
| 1.  | РЭТ–ын механикч | а/ч З.Дорж    | 1  |         |
| 2.  | РЭТ–ын механикч | а/ч С.Баяр    | 2  |         |
| 3.  | РЭТ–ын механикч | а/ч Г.Сүрэн   | 3  |         |

БҮЛГИЙН ДАРГА \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
/Цол, гарын үсэг/

Тайлбар:

1. Бүлгийн бие бүрэлдэхүүний бүртгэлийг бүлгийн албан байранд байрлуулна.

2. Механикч/техникч/-ийг шилжсэн /халагдсан/ тохиолдолд бүртгэлийн тайлбарт "Халагдсан" гэж тэмдэглэн, он, сар, өдрийг тавина.

3. Шинээр ирж байгаа механикч/техникч/-ийг дэс дугаарын

дагуу бүртгэн авч, халагдсан хүний түлхүүр, багажтай хайрцаг, цүнхийг хариуцуулж өгнө.

Хүснэгт № 3

Тавиурт хадгалагдах түлхүүр, багаж хэрэгслийн

данс

Хайрцагны № \_\_\_\_\_

Цүнхний № \_\_\_\_\_

/загвар/

| Түлхүүрийн дугаар | Түлхүүр,багажны нэр | Үйлдвэрийн номер | Тоо | Тэмдэглэгээ | Тайлбар |
|-------------------|---------------------|------------------|-----|-------------|---------|
| 1                 | Түлхүүр 9x11        | 314115-0         | 1   | 37ОХ2НХ1    |         |
| 2                 | Түлхүүр 14x17       | 447564-6         | 1   | 95НТХ2НХ2   |         |
| 27                | Түлхүүр 19x27       | 538475-9         | 2   | 95ОХ2НХ27   |         |

БҮЛГИЙН ДАРГА \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

/цол, гарын үсэг/

Үйлчилгээний болон хэвшүүлэх ажлын бүлгийн нийтийн хэрэглээний түлхүүр, багаж хэрэгслийг нэг бүрийн хэрэглээнийхтэй ижил тэмдэглэх боловч тухайн хүний бүртгэлийн дэс дугаарын оронд НХ-нийтийн хэрэглэгээний гэсэн үсэг тавина.

1. Нэг бүрийн хэрэглэгээний түлхүүр, багажийг тэмдэглэх жишээ

А. Үйлчилгээний онгоцны бүлэг 37ОХ20112 гэсэн тэмдгийг дараах байдлаар тайлна.

- 37- ангийн дугаарын сүүлчийн тоо
- ОХ/НТХ/ – онгоц /нисдэг тэрэг/, хөдөлгүүрийн үйлчилгээний

бүлэг

- 2 - 2 дугаар эскадриль /хэсэг/
- 01- онгоц /нисдэг тэрэг/-ны хажуугийн дугаар
- 12 – түлхүүр, багаж нь дансны 12 дугаарт бүртгэгдсэн.

Үйлчилгээний тусгай бүлгүүдийн 37РЭТ30115 гэсэн тэмдгийг дараах байдлаар тайлна.

- 37- ангийн дугаарын сүүлчийн тоо
- РЭТ – радиоэлектрон тоноглолын үйлчилгээний бүлэг

- 3 - 3 дугаар эскадриль /хэсэг/
- 01- РЭТ-ын бүлгийн багажны хайрцагны гаднах дугаар
- 15 – түлхүүр, багаж нь дансны 15 дугаарт бүртгэгдсэн.

Б. ТАА-ийн бүлэг 37РЭТХ024 гэсэн тэмдгийг дараах байдлаар тайлна. Үүнд:

- 37- ангийн дугаарын сүүлчийн тоо
- РЭТХ- радиоэлектрон тоноглолын хэвшүүлэх ажлын бүлэг
- 02- РЭТХ бүлгийн багажны хайрцагны дугаар
- 4 – түлхүүр, багаж нь дансны 4 дүгээрт бүртгэгдсэн.

2. Нийтийн хэрэглээний түлхүүр багажийг тэмдэглэх жишээ

- 37ОХ2НХ27 гэсэн тэмдгийг дараах байдлаар тайлна. Үүнд:
- 37- ангийн дугаарын сүүлчийн тоо
- ОХ- онгоц, хөдөлгүүрийн үйлчилгээний бүлэг
- 2 - 2 дугаар эскадриль /хэсэг/
- НХ- нийтийн хэрэглээний түлхүүр, багаж
- 27- түлхүүр, багажийг бүртгэсэн дансны дугаар.

3. Тээврийн онгоц болон нисдэг тэрэгний бүхээгийн түлхүүр, багажны тэмдэглэгээ нь зүүнээс баруун тийш байрласан цифрүүдээс бүрдэх ба эхний 2 тоо нь онгоц/нисдэг тэрэг/-ны серийг, дараагийн 2 тоо нь онгоц/нисдэг тэрэг/-ны хажуугийн дугаарыг, сүүлчийн тоо нь түлхүүр, багажны дансанд бүртгэсэн дугаарыг заана.

081621 гэсэн тэмдгийг дараах журмаар тайлна. Үүнд:

- 08 - онгоцны серийн дугаар,
- 16 - онгоцны хажуугийн дугаар,
- 21 - түлхүүр багажийг дансанд бүртгэсэн дугаар.

4. Тусгай үйлчилгээний автомашины түлхүүр, багажны тэмдэг нь арал ангийн дугаарын сүүлчийн гурван тоо болон түлхүүр багажийг дансанд бүртгэсэн дэс дугаараас бүрдэнэ. Жишээ нь 42715 гэсэн тэмдгийг дараах байдлаар тайлна:

- 427- тусгай тоноглолын автомашины бүртгэлийн дугаар
- 15- түлхүүр багажийг дансанд бүртгэсэн дугаар

**Цувааны бүрэлдэхүүн дэх автомашины хөдөлгөөний  
зохион байгуулалт /526 дугаар зүйл/**

1. Аяны цуваанд гарсан автомашины байрлал нь өдөр, шөнийн нөхцөлд хөдөлгөөний шаардлагатай хурдаар, цувааг удирдлагаар хангах нөхцөл нь бүрдсэн, гэнэтийн халдлагаас хамгаалагдсан, бэлэн байдал хангагдсан байна. Үүнд:

- Аяны цувраанд техник хэрэгслийг байрлуулах;
- толгойн сэргийлэх;
- тусгай автомашины бүлгүүд;
- техникийн эд хогшилтой автомашин;
- түлш тээвэрлэгч;
- тусгай зориулалтын автомашины бүлэг;
- чирэгч болон техникийн тусламж үзүүлэх машин;
- ар талын сэргийлэх.

2. Шилжин байрлах үед толгойн болон ар талын сэргийлэхийг гаргана.Тэдгээр нь цувааг гэнэтийн довтолгооноос хамгаалах үүрэг хүлээнэ. Толгойн сэргийлэх нь цуваанаас 5 км-ийн өмнө, ар талын сэргийлэх нь 3 км-ийн хойно явна.

3. Хөдөлгөөн үйлдэх маршрутыг 1:200000–1:500000-ны газрын зураг дээр тэмдэглэх буюу түүнээс хуулбар хийж авна.

Шилжин байрлах шийдвэр гаргасан ахлах дарга хөдөлгөөн үйлдэх маршрутын өгөгдөхүүнийг мэдэгдэж, толгойн сэргийлэх бүлгийг тодотгоно.

4. Автомашинд ачаа ачаалах үед дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- ачааны өргөн нь 3м-ээс, өндөр нь 4 метр /замын гадаргаас дээш/-ээс хэтрээгүй байх;
- ачаа тэвшнээс арагш 2м-ээс ихгүй гарсан байх;
- арал ангид ноогдож буй ачаалал нь тухайн автомашинд тогтоогдсон хэм хэмжээнээс хэтрээгүй байх.

5. Авто цувааны хөдөлгөөний хурдыг дараах байдлаар тогтооно. Үүнд:

- засмал замд 50 км/цаг хүртэл;

- эвдрэлгүй сайжруулсан замд 35 км/цаг хүртэл;
- шороон замд /хуурай цаг агаартай үед/ 25 км/цаг хүртэл.

Шөнө машины гэрлийг бүрэн хэмжээгээр тавьсан үед өдрийнхтэй харьцуулахад хөдөлгөөний хурд 25 хувь, харин өнгөлөн далдлалт бүхий гэрэлтэй үед 50 хувь хүртэл буурна.

Бүх тохиолдолд цувааг тухайн нөхцөлд аль болох өндөр хурдаар үйлдэнэ.

Аяны цуваанд хөдөлгөөн үйлдэж байгаа машины хоорондын хэмжээ 25-50м байна.

6. Хоногт явах хэмжээ нь аян үйлдэж байгаа тухайн нөхцөл байдлаас шалтгаалах бөгөөд хэвийн аялалын үед дунджаар 200–250 км, түргэвчилсэн аяны үед 250–350 км, заримдаа түүнээс ч их байж болно.

7. Бие бүрэлдэхүүнийг амраах, хооллох ундлах, эвдрэл гэмтлийг арилгаж, автомашиныг түлшээр цэнэглэх, цувааны журмыг анхны байдалд нь сэргээхийн тулд их, бага амралтыг тогтооно.

Бага амралтыг 2-3 цаг тутамд, харин өвөл их хүйтэн үед 1-1.5 цаг тутамд 20-30 минутын үргэлжлэлтэй байхаар тогтооно.

Бага амралтаар цувааны зохион байгуулалтыг эвдэхгүйгээр автомашиныг замын баруун хажуу талаар хооронд нь 10м-ээс багагүй зайтай /эсхүл цувааны даргын тогтоосон зайгаар/ зогсооно.

Их амралтыг 2-3 цагийн үргэлжлэлтэйгээр голдуу хоногийн шилжилтийн хоёрдугаар хагасын эхэнд тогтооно. Өвөл их хүйтэнд шөнө хөдөлгөөн үйлдэж байгаа үед хоногийн шилжилтээс бага зайд их амралтыг тогтоохгүй.

Их амралт хийхийн тулд бие бүрэлдэхүүний өнгөлөн далдлалт, үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах зорилгоор, мөн усны эх булагтай эсэхийг харгалзан тохиромжтой нөхцөл бүхий газар орныг сонгон авна.

Бие бүрэлдэхүүн, автомашиныг тараан байрлуулахдаа байнгын бэлэн байдал, цуваанд оруулах хамгийн бага хугацааг хангахуйц журмаар байрлуулна.

8. Цувааны дарга хөдөлгөөн үйлдэх маршрутын дагуу зааг, эсхүл зохицуулах байртай бол /2-3 цагийн хооронд/ толгойн сэргийлэхийг

тогтоосон хугацаанд тухайн зааг /байр/-ийг нэвтрэн өнгөрөх бүх арга хэмжээг авсан байна.

9. Цувааны доторх автомашины хөдөлгөөнийг удирдахдаа Монгол Улсын цэргийн жагсаалын дүрмийн хавсралтад заасан харааны томъёочилсон дохионуудыг хэрэглэнэ.

Томъёочилсон дохионы дагуух хөдөлгөөнийг цаг тухайд нь зөв үйлдэхийг жолооч хариуцна.

10. Шөнийн цагт шаардлагатай зайг бариулах, баримжааг хөнгөвчлөхийн тулд автомашины куперийг цагаанаар будаж, автомашин(чиргүүл)-ы тэвшний ар талын зүүн хагаст 25-30см-ийн диаметртай цагаан өнгөтэй битүү цагираг зурна.

11. Хүснэгт №1-д зааснаас гүнзгийгүй усан саадтай таарвал гүүр байхгүй тохиолдолд гарам хийнэ.

Хүснэгт № 1

| Автомашины хүнд, тн | Усны урсгалын хурдны үед гарамны зөвшөөрөгдөх гүн, м |                |              |
|---------------------|--|----------------|--------------|
|                     | 1 м/с хүртэл   | 1-2 м/с хүртэл | 2 м/с-ээс их |
| 1,5-2               | 0,6  | 0,5            | 0,4          |
| 3-4                 | 0,8  | 0,7            | 0,6          |
| 5 түүнээс их        | 0,9  | 0,8            | 0,7          |

12. Хөлдүү мөсөн заагийг гаталж гарахдаа мөсний зузаанаас хамаарч зохион байгуулалтыг хийнэ. Нимгэн мөсийг банз, дүнз болон бусад гарын доорх материалаар бэхжүүлж болно. Резинэн дугуйтай автомашинаар мөсөн дээгүүр гатлалт хийх үед зөвшөөрөгддөг хоорондын зай болон мөсний зузааныг хүснэгт № 2-т үзүүлэв.

Хүснэгт № 2

| Бүх жин, тн | Сүүлийн гурав хоногийн агаарын дулааны дундаж хэм, мөсний хамгийн бага зузаан, см |     |    | Автомашины хоорондох хамгийн бага зай, м |
|-------------|---|-----|----|--|
|             | -10С  | -5С | 0С |  |
| 3.5         | 21  | 23  | 26 | 15                                       |
| 6           | 27  | 30  | 34 | 20                                       |

|      |    |    |    |    |
|------|----|----|----|----|
| 10   | 35 | 39 | 44 | 25 |
| 15   | 43 | 47 | 54 | 30 |
| 22,5 | 60 | 64 | 69 | 40 |

13. Ууланд хөдөлгөөн үйлдэх маршрутыг газар орны онцлогийг бодолцон зохион байгуулна. Өгсөх, уруудах хөдөлгөөний үед автомашинуудын хоорондын зайг 100м хүртэл ихэсгэнэ.

Уулархаг нөхцөлд тээврийн хэрэгслийн ачаалалтыг 15-20 хувиар багасгахыг зөвшөөрнө.

**Онгоцны зогсоол болон аэродромын техникийн  
барилга, байгууламжийн галын хэрэгслийн хэм хэмжээ /601  
дүгээр зүйл /**

| Объектын нэр   | Объектын тоо ширхэг / талбай/                     | Гал унтраагчийн тоо |                           |         |
|--|---|---------------------|---------------------------|---------|
|  |   | хөөс                | нүүрсхүчил                | аэрозол |
| Онгоцны нуувч  | Агрегатын   |                     |                           | 1       |
|  | Нисэхийн хөнөөх хэрэгслийг хадгалах байр /хөндий/ | 1                   |                           |         |
|  | Төвлөрсөн сумлалтын                               | 1                   | 1                         |         |
| Ангар  | 200 м 2   | 1                   |                           |         |
| Онгоц асаах талбай   | Талбайд   | 2                   |                           |         |
| Шатахуун олгох газар   |   | 1                   |                           | 1       |
| Автомашинны задгай зогсоол   | 10 автомашинд                                     | 1                   |                           |         |
| Нисэхийн техник дээр ажил хийхэд зориулагдсан лаборатори                                 | 100 м2–аас ихгүй талбайтай тасалгаанд             | 1                   |                           |         |
| Хонгилын системтэй албан байр  | 30 метр хонгил, 400 м2                            | 1                   |                           |         |
| Трансформатор, генераторын дэд станц / байгууламж/ хураалттай нисэхийн хөнөөх хэрэгслүүд | Нэг бүтээгдэхүүнд Нэг хураалтгайд                 | 1                   |                           |         |
| Онгоцны зогсоолын бүс  | Бүсэд   |                     | Зөөврийн гал унтраагч хор |         |

Талбайд гал унтраагч хорноос гадна галын автомашин байлгах ёстой.

## ХУРААНГУЙЛСАН ҮГ

| Монголоор хэвшсэн хураангуйлсан үгс |  | Оросоор хэвшсэн хураангуйлсан үгс |   |
|-------------------------------------|--|-----------------------------------|---|
| НИА                                 | - нисэхийн инженерийн алба                   | ИАС                               | -инженерно-авиационная служба                 |
| ИТБ                                 | -инженер техникийн бүрэлдэхүүн               | ИТС                               | -инженерно-технический состав                 |
| ОХ/НТХ/                             | - онгоц, хөдөлгүүр /нисдэг тэрэг, хөдөлгүүр/ | СД /ВД/                           | - самолёт и двигатель / вертолёт и двигатель/ |
| РЭТ                                 | - радиоэлектрон тоноглол                     | РЭО                               | - радиоэлектронное оборудование               |
| НЦТТ                                | - нисэхийн цахилгаан, тусгай тоноглол        | АО                                | - авиационное оборудование                    |
| НЗ                                  | - нисэхийн зэвсэглэл                         | АВ                                | - авиационное вооружение                      |
| ТАА                                 | - техник ашиглалтын анги                     | ТЭЧ                               | -технико-эксплуатационная часть               |
| НЗГ                                 | - нисэхийн засварын газар                    | ВАРМ                              | - войсковая авиационная ремонтная мастерская  |
| ПУББ                                | - пуужин урьдчилан бэлтгэх байр              | ПППР                              | - позиция предварительной подготовки ракет/ы/ |
| ООУОС                               | - онгоцыг ослын үед орхих систем             | САПС                              | - система аварийного покидания самолетов      |
| АДХА                                | - агаарын даралт хүлээн авагч                | ПВД                               | - приемник воздушных давлений                 |
| ХТЦС                                | - хүчилтөрөгчөөр цэнэглэх хөдөлгөөнт станц   | АКЗС                              | - автомобильная кислородно-зарядная станция   |
| ЦТТС                                | - цахилгааны тэжээлийн төвлөрсөн систем      | ЦСЗ                               | - централизованная система электроснабжения   |
| АХЦА                                | - аэродромын хөдөлгөөнт цахилгаан агрегат    | АПА                               | - аэродромный передвижной агрегат             |
| ХХЗС                                | - хөдөлгөөнт хяналт засварын хэрэгсэл        | ПКРС                              | - подвижное контрольно-ремонтное средство     |
| ОХН                                 | - ослын халдашгүй нөөц                       | НАЗ                               | - неприкосаемый аварийный запас               |

|      |                                     |     |   |
|------|-------------------------------------|-----|---|
| ШТМ  | - шатах тослох материал             | ГСМ | - горюче-смазочный материал                   |
| ББК  | - байлдааны бэлтгэлийн курс         | КБП | - курс боевой подготовки                      |
| ФН   | - фронтын нисэх                     | ФА  | - фронтовая авиация                           |
| ЦТН  | - цэргийн тээврийн нисэх            | ВТА | -военно-транспортная авиация                  |
| НАС  | - нисэхийн анги, салбар             | АЭ  | - авиационная эскадрилья                      |
| АОЗЖ | - ангийн онгоцны зогсоолын жижүүр   | ДСЧ | -дежурный по стоянкам самолетов части         |
| СОЗЖ | - салбарын онгоцны зогсоолын жижүүр | ДПС | -дежурный по стоянкам самолетов подразделения |
| ТХХ  | -техник хяналтын хэлтэс             | ОТК | - отдел технического контроля                 |

## АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ